



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-26
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	27-171

1.	<i>Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/</i>	33-34
2.	<i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</i>	34-35
3.	<i>Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</i>	35-55
4.	<i>“Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	55-68
5.	<i>“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэн яаралтай, хэлэлцэх эсэх/</i>	68-100
6.	<i>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	100-104
7.	<i>Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголын тайланг сонсох</i>	104-142
8.	<i>Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох асуудал</i>	142-143
9.	<i>Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох</i>	143-168
10.	<i>Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа</i>	168-171

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 14 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар, Г.Ганболд, Х.Ганхуяг, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Б.Чойжилсүрэн, Б.Энх-Амгалан;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ц.Мөнхцэцэг, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, С.Батболд, Д.Батлут, Б.Баярсайхан, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Ц.Сэргэлэн, Ч.Ундрэм;

Хоцорсон: С.Амарсайхан – 10 минут, С.Ганбаатар – 53 минут, Ц.Даваасүрэн – 8 минут, Ц.Мөнх-Оргил – 25 минут, Н.Наранбаатар – 38 минут, Д.Сарангэрэл – 14 минут, Б.Саранчимэг – 19 минут, Д.Цогтбаатар – 1 цаг 02 минут, Н.Энхболд – 10 минут, Ж.Эрдэнэбат – 2 цаг 05 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо. /10:15/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Баттөмөр, Ш.Адъяаа нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Баттөмөр, Ш.Адъяаа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулах талаар Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагаас ирүүлсэн горимын саналыг танилцуулав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 38
Бүгд: 45

15.6 хувийн саналаар горимын санал дэмжигдээгүй тул уг асуудлыг хэлэлцэхээр ТОГТОВ.

Нэг.Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон батлах санал хураалтыг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Цэрэнсамбуу, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн мэргэжилтэн Д.Номингэрэл, Т.Энхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв. /10:40/

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулалтын системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 21

Бүгд: 47

55.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, мөн газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал Б.Эрдэнэхуяг, Монголбанкны Ерөнхийлөгчийн ажлын албаны Санхүүгийн зах зээлийн асуудал хариуцсан ахлах референт Н.Батсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./10:40/

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Г.Амартүвшин, Д.Бат-Эрдэнэ, С.Чинзориг, О.Цогтгэрэл /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн гарчиг, төслийн Хоёр, Гуравдугаар бүлгийн гарчгийн “оруулалтын” гэсний дараа “төрөлжсөн” гэж тус тус нэмж, Хоёрдугаар бүлгийн гарчгаас “эрхлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 27
Бүгд: 47
42.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Төслийн гарчиг, төслийн Хоёр, Гуравдугаар бүлгийн гарчгийн “оруулалтын” гэсний дараа “төрөлжсөн” гэж тус тус нэмж, Хоёрдугаар бүлгийн гарчгаас “эрхлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээ, удирдлага, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 11
Бүгд: 41
73.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Банкны тухай хуульд заасны дагуу банк байгуулах тусгай зөвшөөрөл авсан банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

3.3.Энэ хуульд тусгайлан зааснаас бусад хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаатай холбогдох харилцааг Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

3.4.Монгол Улсын Хөгжлийн банктай холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 11
Бүгд: 41
73.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк” гэж төслийг дунд, урт хугацааны тогтвортой хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн төлөө хуулийн этгээдийг;

4.1.2.“төсөл” гэж санхүүгийн хөрөнгийн дунд, урт хугацаатай эх үүсвэр шаардлагатай, уг эх үүсвэрийг орлогоороо нөхөх боломжтой эдийн засгийн үйл ажиллагааг;

4.1.3.“харилцагч” гэж хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас санхүүжүүлж байгаа төсөл санаачлагч, хэрэгжүүлэгч хуулийн этгээд болон Монголбанкнаас төслийн оролцогч гэж үзсэн бусад хуулийн этгээдийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хэлбэр, хувь нийлүүлсэн хөрөнгө

5.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь хаалттай хувьцаат компани эсвэл хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байна.

5.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтын түвшин, улсын төлбөрийн тэнцлийн үзүүлэлт, төгрөгийн ханшийн өөрчлөлт, банкны төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалтын банкны эрхлэх үйл ажиллагааны онцлог, банкны салбар дахь төслийн санхүүжилтийн хэмжээ,

шаардлагатай бусад хүчин зүйлсийг харгалзан Монголбанк тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагаа

6.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжих зөвхөн төсөл санхүүжүүлэхэд чиглэсэн дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

- 6.1.1.зээл олгох;
- 6.1.2.төлбөр тооцоо;
- 6.1.3.баталгаа, батлан даалт;
- 6.1.4.үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах;
- 6.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, арилжих;
- 6.1.6.андеррайтер;
- 6.1.7.кастодиан;
- 6.1.8.санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;

6.2.Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5-д заасан үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанк, энэ хуулийн 6.1.6, 6.1.7, 6.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгоно.

6.3.Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 6.2-т заасан зөвшөөрлийг олгохдоо тухай бүр Монголбанкны саналыг урдчилан авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Зээл олгох

7.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчид зээл олгож болно.

7.2.Төсөлд олгох зээлийн хэмжээ, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг банкны системд нөлөө бүхий банкнаас хуулийн этгээдэд олгосон зээлийн хэмжээ, бусад хүчин зүйлсийг харгалзан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран тогтооно.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан зээлийн хугацаа 2 жилээс доошгүй байна.

7.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны барьцаалсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах бол Ашигт малтмалын тухай хуулийн 7.1-д заасан нөхцөлийг хангасан эрх бүхий этгээдэд зөвхөн дуудлага худалдааны үндсэн дээр шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл шинээр нэмэх:

“8 дугаар зүйл.Төлбөр тооцоо

8.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь энэ хуулийн 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.1.6-д заасан үйл ажиллагаанд шууд хамаардаг харилцагч болон Монголбанк, банкны төлбөр тооцоо гүйцэтгэж болно.

8.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг холбогдох хуульд заасны дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 9 дүгээр зүйл шинээр нэмэх:

“9 дүгээр зүйл.Баталгаа, батлан даалт

9.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14.1-д заасан хязгаарлалтын хүрээнд дангаар болон бусад этгээдтэй хамтран төсөл санхүүжүүлэхтэй холбогдуулан харилцагчийн хүлээсэн үүрэгт гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргаж болно.

9.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас гаргах баталгаа, батлан даалтад тавих шаардлага, нөхцөлийг Монголбанкнаас баталсан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 15

Бүгд: 42

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг 10 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл. Үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах

10.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын хүрээнд гадаад улс, дотоодын үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргаж болно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар дотоодын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаас нь зөвхөн хаалттай хүрээнд байна.

10.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, мөнгөн хөрөнгийн нөөцийг удирдах зорилгоор мөнгөний зах дээр богино хугацааны үнэт цаас гарч болно.

10.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчийн үнэт цаасны зах зээл, мөнгөний зах дээр арилжаалагдах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг худалдаж, худалдан авч болно.

10.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк компанийн хувьцааг тав хүртэлх жилийн хугацаанд эзэмшиж болно.

10.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч, түүний холбогдох этгээдийн гаргасан хувьцааны 20 хүртэл хувийг эзэмшиж болох бөгөөд эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна.

10.7.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах харилцааг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран баталсан журмаар зохицуулна.”

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Г.Занданшатар: 12.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 11 дүгээр зүйл шинээр нэмэх:

“11 дүгээр зүйл.Гадаад валют худалдах, худалдан авах, арилжих

11.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь энэ хуулийн 6.1.1, 6.1.6-д заасан үйл ажиллагааны хүрээнд харилцагчийн төлбөр тооцоог гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэхэд үүсгэж болох гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах зорилгоор гадаад валют худалдах, худалдан авах, түүнтэй холбоотой валют арилжааны бусад хэлцлийг хийж болно.

11.2.Энэ зүйлийг 11.1-д заасан үйл ажиллагааг Валютын зохицуулалтын тухай болон холбогдох бусад хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 23
Бүгд: 41
43.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл шинээр нэмэх:

“12 дугаар зүйл.Андеррайтер, кастодиан, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа

12.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас төсөл санхүүжүүлэхтэй холбоотойгоор энэ хуулийн 6.1.6, 6.1.7, 6.1.8-д заасан үйл ажиллагааг эрхлэх харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 13 дугаар зүйл шинээр нэмэх:

“13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын банканд хориглох үйл ажиллагаа

13.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

13.1.1.энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх;

13.1.2.мөнгөн хадгаламж, хүү төлөх нөхцөлтэй харилцах данс нээх, тэдгээртэй адилтгах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх;

13.1.3.хараат болон охин компани үүсгэн байгуулах;

13.1.4.банк, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээдийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг худалдан авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ц.Цэрэнпунцаг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 14 дүгээр зүйл шинээр нэмэх:

“14 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт, шаардлага

“14.1.Аливаа этгээд, түүний холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгох хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлтэй адилтган тооцох хөрөнгийн хэмжээ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг гурав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.2.Зээл, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг арав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.3.Баталгаа, батлан даалт, эзэмшиж байгаа үнэт цаасны нийт дүнгийн нийлбэр нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.4.Энэ зүйлд зааснаас бусад шаардлага, үйл ажиллагааны хязгаарлалтын журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлж, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 23

Бүгд: 45

59.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг 15 дугаар зүйл болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах

15.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах зөвшөөрлийг Монголбанк олгоно.

15.2.Гадаад улсын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах, эсхүл хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нийт гаргасан хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас, эсхүл өр төлбөрийн эх үүсвэрийн хөрөнгийн 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг холбогдох хуульд заасны дагуу урьдчилан авсан байна.

15.3.Гадаад улсын хуулийн этгээд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тухайн хуулийн этгээд нь зөвхөн банк, санхүүгийн байгууллага байх бөгөөд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь тухайн хуулийн этгээдийн охин компани байна.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан этгээдийн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагаа эрхлэх эх үүсвэр нь эдийн засгийн харьяат бус этгээдээс гарал үүсэлтэй гадаад валют байх буюу тухайн этгээдийн эзэмшиж байгаа Монгол Улсын мөнгөн тэмдэгтээр бүрдүүлээгүй байна.

15.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг бусдад худалдах, шилжүүлэхийг хориглоно.

15.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьцаа эзэмшигч нь тус банкны нийт гаргасан хувьцааг дангаар эзэмшиж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 26
Бүгд: 46
43.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын “дэмжсэн” 15, 16 дахь саналууд техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтуудыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 14
Бүгд: 47
70.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 15.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 14 дүгээр зүйл шинээр нэмэх:

“14 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт, шаардлага

“14.1.Аливаа этгээд, түүний холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгох хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлтэй адилтган тооцох хөрөнгийн хэмжээ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг гурав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.2.Зээл, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг арав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.3.Баталгаа, батлан даалт, эзэмшиж байгаа үнэт цаасны нийт дүнгийн нийлбэр нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.4.Энэ зүйлд зааснаас бусад шаардлага, үйл ажиллагааны хязгаарлалтын журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 13
Бүгд: 47
72.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг 15 дугаар зүйл болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах

15.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах зөвшөөрлийг Монголбанк олгоно.

15.2.Гадаад улсын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах, эсхүл хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нийт гаргасан хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас, эсхүл өр төлбөрийн эх үүсвэрийн хөрөнгийн 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг холбогдох хуульд заасны дагуу урьдчилан авсан байна.

15.3.Гадаад улсын хуулийн этгээд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тухайн хуулийн этгээд нь зөвхөн банк, санхүүгийн байгууллага байх бөгөөд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь тухайн хуулийн этгээдийн охин компани байна.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан этгээдийн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагаа эрхлэх эх үүсвэр нь эдийн засгийн харьяат бус этгээдээс гарал үүсэлтэй гадаад валют байх буюу тухайн этгээдийн эзэмшиж байгаа Монгол Улсын мөнгөн тэмдэгтээр бүрдүүлээгүй байна.

15.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг бусдад худалдах, шилжүүлэхийг хориглоно.

15.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьцаа эзэмшигч нь тус банкны нийт гаргасан хувьцааг дангаар эзэмшиж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 14

Бүгд: 47

70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 10 дугаар зүйлийг 16 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулагчид тавих шаардлага

16.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулагч нь Банкны тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, 23.1-д заасан шаардлагыг хангасан байна.

16.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах гадаад улсын банк, санхүүгийн байгууллага нь энэ хуулийн 16.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

16.2.1.гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд байх;

16.2.2.хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг зөрчсөн тохиолдолд өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах хэмжээний хөрөнгийг хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд оруулах үүрэг хүлээсэн байх;

16.2.3.үүсгэн байгуулагч улсын банк, санхүүгийн байгууллагын хяналт шалгалт, зохицуулалтад олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт мөрдөгддөг байх;

16.2.4.сүүлийн таван жилийн хугацаанд өөрийн улсын болон бусад улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөнөөс үүдэн банк, түүний нэгж байгуулах зөвшөөрөл нь хүчингүй болж, төлбөрийн чадварын болон санхүүгийн хүндрэлд орж байгаагүй;

16.2.5.үүсгэн байгуулагч хуулийн этгээд, хүний удирдлага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

16.2.6.Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа нийцүүлэх чадвартай байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 16

Бүгд: 47

66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг 17 дугаар зүйл болгон, доор дурдсан бүхэлд нь өөрчлөн найруулах:

“17 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулагчид бүрдүүлэх баримт бичиг

17.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч нь Банкны тухай хуулийн 20.1-д болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.1-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

17.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах гадаад улсын банк, санхүүгийн байгууллага нь Банкны тухай хуулийн 20.1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

17.2.1.харьяалах улсын эрх бүхий зохицуулагч байгууллагаас Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн шийдвэр;

17.2.2.хуульд заасан бол Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу авсан зөвшөөрөл.

17.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах болон өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, эзэмшихэд тавих нөхцөл, шаардлагыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	19
Бүгд:	47

59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Б.Пүрэвдорж, Ц.Цэрэнпунцаг нар үг хэлж, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван тайлбар хийв.

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дараагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар үргэжлүүлэн хэлэлцүүлэхээр хойшлуулав.

Уг асуудлыг 11 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, П.Анужин, Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн, Ц.Туваан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Н.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.3-т заасны дагуу тогтоолын төслийг буцаах тухай горимын саналаар санал хураалтыг явуулав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын гаргасан, “Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг буцаах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 13

Бүгд: 49

73.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул тогтоолын төслийг буцаахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэн яаралтай, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт Ч.Дондогмаа, Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хот байгуулалтын хэлтсийн дарга Б.Одбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Нийслэлийн хот төлөвлөлт, судалгааны институт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн ерөнхий менежер Т.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Ц.Туваан, Д.Ганбат, Ж.Бат-Эрдэнэ, Н.Ганибал, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

Ж.Мөнхбат, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хот байгуулалтын хэлтсийн дарга Б.Одбаатар, Нийслэлийн хот төлөвлөлт, судалгааны институт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн ерөнхий менежер Т.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 58 минут үргэлжилж, 13 цаг 12 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 24 минутад эхлэв.

“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ё.Баатарбилэг, Т.Энхтүвшин, Г.Мөнхцэцэг, Б.Бейсен нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ж.Мөнхбат нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3.Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогыг байгууллагын нийтийн мэдээллийн дэд бүтэц, түүнийг ашиглах, хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн нэгдүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.1 дэх хэсгийг 41.1, 41.2 дахь хэсэг болгон өөрчлөн найруулсан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 3 дугаар зүйлийн ““41.8.4 гэж” гэсний дараа ““41.9.” гэснийг “41.10.” гэж, “41.10.” гэснийг “41.11.” гэж, “41.11.” гэснийг “41.12.” гэж, “41.12.” гэснийг “41.13.” гэж, 41.11 дэх хэсгийн “41.9-д” гэснийг “41.10-т” гэж, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “41.1-д” гэснийг “41.3-т” гэж” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийн “41.13.” гэснийг “41.14.” гэж, “41.14.” гэснийг “41.15.” гэж, “41.15.” гэснийг “41.16.” гэж, “41.16.” гэснийг “41.17.” гэж, “41.17.” гэснийг “41.18.” гэж, “41.18.” гэснийг “41.19.” гэж, “41.19.” гэснийг “41.20” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томёоллоор санал хурааж дууслаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголын тайланг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Үндэсний аудитын газрын дарга, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадагва, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Ашигт малтмал, газрын тосны Уул уурхайн хэлтсийн дарга М.Мэндбаяр, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал, Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын дарга Б.Сүхбаатар, Гаалийн ерөнхий газрын Статистикийн газрын дарга Э.Лхагвасүрэн, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Батсуурь, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Ганчулуун, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа П.Сандагсүрэн, “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ачаа тээврийн хэлтсийн дарга О.Энхбат, “Монголын төмөр зам” компанийн гүйцэтгэх захирал П.Ганхүү, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн бүрэн эрхт төлөөлөгч Н.Мягмар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Тайланг хэлэлцсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ш.Адъяа, Н.Ганибал, Б.Пүрэвдорж, Г.Тэмүүлэн, Ц.Идэрбат, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадагва, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын дарга Б.Сүхбаатар, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Гаалийн ерөнхий газрын Статистикийн газрын дарга Э.Лхагвасүрэн, “Монголын төмөр зам” компанийн гүйцэтгэх захирал П.Ганхүү, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 17 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн танилцуулав.

Нэр дэвшигч болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Занданшатар: Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Лхагвын Мөнхбаатарыг сонгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	34
Татгалзсан:	12
Бүгд:	46

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд даргаар Лхагвын Мөнхбаатарыг сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:39/

Уг асуудлыг 17 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Ц.Туваан, Ш.Адьяа, С.Одонтуяа, Б.Бейсен, Г.Амартүвшин, Б.Пүрэвдорж, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Боомтын сэргээлтийн Үндэсний хорооны даргад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга хот байгуулалтын сайдад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцууллаа.

Хуралдаан 18 цаг 58 минутад түр завсарлаж, 19 цаг 42 минутаас үргэлжлүүлэн хуралдав.

Арав.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа

Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт Ч.Дондогмаа нар оролцов.

Ёслолын ажиллагаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газрын дарга Э.Одмөнх, мөн газрын референт Д.Батжаргал, шинжээч Б.Мөнхбилгүүн нар зохион байгуулав.

Танхимын зүүн хойд дэлгэцэн дээр “Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” гэсэн Засгийн газрын гишүүний тангарагийн үг гарч байв.

“Их хуралдай” танхимын индрийн баруун талд Төрийн далбаа, танхимын голд Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт, түүний урд Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэсэн индрийг байрлуулж, Төрийн сүлдний баруун талд хүндэт харуул зогссон байлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын 10-т заасны дагуу шинээр томилогдож буй Засгийн газрын гишүүдийн нэрийг дуудав.

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар;

2.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Хүрэлбаатарын Булгантуяа;

3.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн;

4.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг.

Нэр дуудагдсан Засгийн газрын гишүүд суудлаасаа босож индрээс “Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн тангараг өргөв.

Тангараг өргөсний дараа Засгийн газрын гишүүд Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын 4 гишүүнд үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг чуулганы танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд баяр хүргэж, үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Улсын Их Хурлын дарга болон Улсын Их Хурлын гишүүдэд хандан мэхийн ёслол.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа 19 цаг 55 минутад өндөрлөв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 46 минут үргэлжилж, 76 гишүүнээс 56 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 19 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 14 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцүүлнэ.

Дөрөвдүгээрт, Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт түргэн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг

үргэлжлүүлэн явуулна. 34 саналтай байгаа.

Тавдугаарт, Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Зургадугаарт, “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Долоод, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 2 саналтай.

Наймдугаарт, Ерөнхий хяналтын сонсголын тайланг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-т хууль, тогтоолын төслөө хэлэлцүүлгийн аль ч шатанд хууль санаачлагч татан авч болох бөгөөд татан авах тухай үндэслэл бүхий санал бичгээ Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж танилцуулснаар хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө эргүүлэн татсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр хуулийн төсөл татан авах тухай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг татан авч байгаагаар үүгээр мэдэгдэж байна.

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргав. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд хуулийн төслийг татан авахаар тогтсон юм байна.

Хуулийн төсөл. Хууль санаачлагч хуулийн төслөө татан авсан тул өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хасагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу 17.00 цагаас өмнө хэлэлцэхээр тогтсон асуудлын дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Дашдондогийн Ганбат, Баагаагийн Баттөмөр, Ширнэнбандийн Адьшаа нараас үг хэлэхээр албан бичиг ирүүлсэн байна.

Ингээд эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат үг хэлнэ.

Д.Ганбат: Баярлалаа. Эрхэм Их Хурлын даргад.

Эрхэм Их Хурлын гишүүдийн шинэ жилийн шинэ долоо хоногийн анхны хуралдааны, чуулганы анхны хуралдааны энэ өдрийн мэндийг хүргэе.

Иргэд, сонгогчид, Монголын ард түмэн хараад сууж байгаа байх. Улсын Их Хурал маань өнөө өглөө аль хөл дээрээсээ босоод ямаршуухан ажил амжуулах нь вэ гээд.

Бид байнга сайн сайхан юм яриад байх ийм боломж ч алга, байгаа нөхцөл байдал ч гэсэн тийм байна.

Өнөө өглөө гэхэд л Монголбанкны албан ханшийг харлаа л даа, би. Америкийн Нэгдсэн Улсын доллар 3450 төгрөг 52 мөнгөтэй тэнцэж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын юань 500 төгрөг 72 мөнгөтэй нь тэнцэж байна. Энэ маань 2020 онд би зүгээр л удахгүй манай Хятад урд хөрш маань хилээ нээх гэж байна.

2020 онд л энэ юань чинь 400 хүрэхгүй байсан шүү дээ. 2016 онд энэ Монгол Ардын намын 65 суудалтай болохын өмнө намайг Улсын Их Хуралд байхад энэ мөнгө 200 гарантай л байсан юм.

Хүмүүс маш их сайн санадаг. Нэг доллар тэгэхэд 17 боодол нэгжтэй тэнцэж байсан.

Тэгээд би оны өмнө бас иргэд сонгогчидтойгоо уулзаад ирлээ л дээ. Нутаг оронд.

Тэгээд шинэ жилээр нэлээн их өр чөлөөлөх байх. Дансанд тэр нүүрсний хулгайгаас авсан мөнгө. Нөгөө Монгол Улсын баялаг ард түмний өмч байна гэсний дагуу баялагтаа эзэн монголчуудад багагүй тэр их мөнгөний, тэр их баялгийн жаахан нь ч болтугай орж ирнэ гээд хүлээлттэй байсан. Гэтэл манай төрийн гурван өндөрлөг энэ талаар юу ч дуугарсангүй.

Бөхийн өргөөн дээр энэ засаг төрийн том дарга нар орж ирэхэд маш их дургүй байна. Шат шатандаа ингээд нэр хүнд уначихжээ. Энэ ийм ажлыг хийж байгаа хүмүүс манай Улсын Их Хурал юм.

Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид маш буруу хийлээ.

Тухайлбал, одоо энд оройлон явсан Одонгийн Цогтгэрэл, охин намын Т.Доржханд, энэ С.Одонтуяа нар хамгийн түрүүнд гүйж байгаад л Ардын намынханд тэр суудал, сандалынх нь хуулийг баталж өгсөн. Маш яаралтай горимоор. Хууль зөрчиж.

Тэгээд үүнээс болоод нөгөө Үндсэн хуулийн суурь үзэл санаа байхгүй болчихлоо. Нөгөө харилцан бие биеэ хяналттай байх, 2019 онд энэ Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын бас оройлон хийсэн та нөхдийн хийсэн хамгийн том сайхан ажил энэ ямар ч үр дүнгүй болчихлоо.

Бид өөрөө өөрсдөдөө зориулж сандал, ширээний тийм хууль батлах ёсгүй л дээ.

Тэгээд нэг их олон Улсын Их Хурлын гишүүд давхар дээлтэй болчихлоо. Ийм давжаа парламентад.

Ахиад ч дээл нөмрөх юм шиг байна. Тэгээд Улсын Их Хурал нь хаанаа байгаа юм. Засгийн газар хаанаа байгаа юм. Засгийн газар нь Улсын Их Хурлын толгой дээр гараад суучихсан. Тэгээд сөрөг хүчин ч гэж байхгүй. Кнопоо багцалж наймаалцдаг ийм юмтай болчихлоо.

Үүнээс гадна Ардчилсан нам арай гэж эмхэрч цэгцрээд 2020 оны Улсын Их Хурлын сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, ингээд нөхөн сонгуулиуд хууль дүрмийнхээ дагуу явагдсан. Гэхдээ тэр хар машин бол бас үнэхээр баталгаагүй байсан шүү гэдэг зүйлүүдийг ярьж байна.

Тэгээд бид төр засгийн ямар ч байсан тогтворгүй байдалд оруулчихгүй, үймээн самуунд оруулчихгүйн тулд энэ

дээрээ бид бас анхаарал хянамжтай ажиллах ёстой юм байна гэсэн бодол төрж байгаа.

Тэгэхгүй бол нөгөө л гэмт хэрэгтнүүд гэдэг юм уу, эсвэл гэмт хэрэгт гүтгэгдээд байгаа хүн ч юм уу, одоо жангийнхан л гэж яриад байгаа л даа. Ингээд л нөгөө жангийн хуруу хумснууд нөгөө эздээ өмөөрсөн энэ хулгай зэргийг даамжруулсан ийм ажлуудыг хийх гээд байна.

Одоо Монгол Ардын намын гарзгүй 5 гэсэн үү. Монголын ард түмэн чинь нэрийг их оновчтой өгөх юм даа. Энэ 5 нөхөр маань гарч ирээд жинхэнэ хулгайг илрүүлнэ гээд л ингээд л явсан. Ийм юм алга байна.

Би одоо Улсын Их Хурлын гишүүдээс янз бүрийн байдлаар гэмт хэрэгт холбогдчихсон юм уу, тийм юм нь сэрдэгдсэн, 01 сарын 01-нээс үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн энэ тэр гээд хуулиуд хэрэгжиж байгаа.

Одоо манай Ардчилсан намын нэр дээр сонгогдсоноос авхуулаад бүгдээрээ гишүүдээсээ татгалзаад сайн дураараа шалгуулчихмаар байгаа юм. Бусад улс оронд ингээд байна л даа. Үнэхээр ёс суртахуун.../минут дуусав/

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлнэ.

Б.Баттөмөр: Өчигдөр Улсын Их Хурлын нэр бүхий 7 гишүүн энэ хулгайтай тэмцэх лобби бүлгээс хамтарч Эрдэнэс Тавантолгой компанийн 40 хүртэлх хувийг Монголын ард түмэнд эзэмшүүлье гэсэн ийм тогтоолын төслийг Улсын Их Хурлын даргад өргөн барьсан.

Энд 2012 оноос хойш төрсөн хүүхдүүд хувь эзэмшил байхгүй байгаа. Үүнийг өгье. Тэгээд 40 хүртэл хувийг нь эзэмшүүлье гэж. Энэ хоёр ач холбогдолтой.

Нэгдүгээрт нь, Эрдэнэс Тавантолгой болон бусад төрийн өмчийн компаниуд дээр нүүрлэхсэн байгаа хулгайг таслан зогсооход энэ бол том гарц болж өгнө.

Ер нь цаашдаа Эрдэнэт, энэ Салхит, тэгээд цаашаагаа, Монросцветмет нэгдэл, одоо Салхит, Асгат гээд энэ том том байгуулагдсан болон байгууллагдах компаниуд дээр олон нийтийн оролцоог болгох асуудлыг нь, хулгайтай тэмцэх маш том гарц болж өгөх юм. Ийм ач холбогдолтой.

Нөгөөдөх нь юу гэхээр Монголын нийт ард түмний 42.5 хувь нь, хоёр хүний нэг нь ядуурчихсан байна. Газар доорх баялаг болон дээрх баялгаараа Монголын ард түмэн дэлхийд эхний 12-т орно гэж байгаа шүү дээ. Гэтэл ингээд ядуураад байдаг. Баян хоосны ялгаа Монголд асар хүчтэй болчихсон. Үүнийг бид мэдсэн ч, мэдээгүй ч юм шиг ингээд л яваад байгаа.

Тэгээд ард түмний ядуурлыг бууруулах их онцгой ач холбогдолтой юм. Үүнийг хэлэлцэж, баталж таарна гэдгийг би гишүүддээ хэлье гэж бодож байгаа юм.

Өнөөдөр энэ legalinfo руу орохоор зэрэг Монгол Улсад 838 хууль үйлчилж байгаа. 2177 Улсын Их Хурлын тогтоол байна. 4996 Засгийн газрын тогтоол байна. 2547 Захиргааны арга хэмжээний акт байгаа. Үндсэн хуулийн цэцийн 291 тогтоол байна. Олон улсын одоо 603 акт байна.

Энэ хууль дүрэм маань Монголд үнэхээр хэмжээнээсээ хэтэрчихжээ. Хэрэгжилтийг нь яадаг юм бэ. Хэрэгжилтийг нь хянадаг, үздэг, тооцдог ийм юм байна уу, үгүй юу. Хууль батлаад л байдаг, батлаад л байдаг.

Одоо сүүлийн үед бидний баталж байгаа хууль бол дандаа нийгмийн шинж чанартай юм баталж байна шүү дээ.

Улс орны хөгжлийн асуудал орхигдчихсон. Тэр Шинжлэх ухаан технологийн хуулийг одоо би бас хэсэг нөхдийн өмнө гурав, дөрвөн жилийн өмнө өргөн барьсан. Өнөөдөр хэлэлцдэггүй.

Засгийн газар нэг юм оруулж ирнэ гэсэн. Тэр нь орж ирдэггүй.

Улс орнууд чинь шинжлэх ухаандаа мөнгө хаяж, шинжлэх ухаан нь буцаад мөнгө өгч байна шүү дээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хүртэлх хувийг шинжлэх ухаандаа зарж байна шүү дээ.

Тэгтэл Монголд 0.1 хувь. Энэ хөгжилтэй орнуудад дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувийн нэг доллар маань зуун доллар, мянган доллар, арван мянган доллар болж өсөж орж ирж байна шүү дээ.

Мөнгө мэдлэгийг бий болгодог. Мэдлэг буцаад инновацыг бий болгодог. Инновац нь буцаад мөнгө бий болгодог.

Тэгээд энэ гол гол юмнуудаа яримаар байна. Тэгээд үүнийг та нар үзээч ээ гэж. **“Алсын хараа-2050”** гээд нэг хуулийн баримт бичиг баталсан. Хөгжлийн загвар гэж үзсэн. Энэ маань хуучирчихжээ, бас. Үүнийгээ шинэчлэх ийм шаардлага байна.

Цаашаагаа санхүүгийн зах зээлд одоо энэ “банк”, “хөрөнгийн зах”, “даатгал” гээд гурван салбар байдаг. Яах вэ, нөгөө хоёр нь ингээд явж байна.

Даатгалын салбарын шинэчлэл хийгдэх шаардлагатай болчихсон байна шүү дээ. Энэ чинь зах зээлд маш их том байр суурь эзэлдэг салбар шүү дээ. Үүнийгээ үзмээр байна.

Дараагийн асуудал энэ төрийн албаны шинэчлэл. Үүнийг хийсэн судалгаагаар Монголын хөгжлийн хоцрогдол бол монголчууд өөрсдөө бий болгосон л гэсэн ийм судалгааны дүн гарсан байдаг шүү дээ.

Төрд бэлтгэгдээгүй хүмүүс төр байх гэж оролддог. Хямралын үндсэн шалтгаан хүн байна. Хүчирхэг хүмүүс төрд гарч байж улс хөгждөг ийм жамтай. Энэ Төрийн албаны хуулиа шинэчлэх ийм шаардлага бас үүссэн байна. Төрийн албаны зөвлөл гэж одоо нэг тийм нэг нэр төдий байгууллага. Ийм болчихсон байгаа юм.

Дараагийн яригдаж асуудал энэ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга гээд. Энэ дээр суурилсан Олборлох үйлдвэрлэлийн тухай хууль, Ил тод байдлын тухай хуулиа гаргах хэрэгтэй. Баялгийн сангийн хуулиа гаргах ёстой.

Энэ худалдааны хуулиа гаргах ёстой. Хил дээр 240 доллар хүрч байгаа нүүрсийг аман дээрээс нь 60 доллароор худалдаалдаг. 4 дахин хямдхан үнээр худалдаад л явж байна шүү дээ. Ийм гол гол юм руугаа орохгүйгээр бид хэтэрхий өөр юм.../минут дуусав/

Г.Занданшатар: Эдийн засгийн байнгын хороо нөгөө тогтоолоо Б.Баттөмөр гишүүн нарын гаргасан тогтоолын төсөл энэ тэртэй хамт хэлэлцээд явчихвал.

Тэр тогтоол дээр чинь нөгөө Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хууль, Үндэсний баялгийн сангийн хууль гээд Б.Баттөмөр гишүүн нарын гишүүд бас нэлээн идэвх санаачилгатай ажиллаж байсан. Тэр хууль их чухал байгаа юм даа. Тийм ээ. Тэр хуулиудаа яаравчлах хэрэгтэй байна. Одоо тэгэхдээ өргөн баригдаагүй учраас хэлэлцэх боломжгүй байна.

Одоо Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Та бүгдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлаас нэг асуудлыг хойшлуулъя гэсэн ийм байр суурьтай байна.

Өнөөдөр нийгэмд үүсээд байгаа нөхцөл байдал, Монгол Улсын нийгэм, улс төрийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор Улсын Их Хурлын ажлын хэсэг гарч зөвлөлдөх санал асуулга явуулах тухай асуудлыг Улсын Их Хурал онцгой анхаарч, өдөр шөнөгүй энд анхаарлаа хандуулж байгааг бид ойлгож байгаа.

Тэгэхдээ Зөвлөлдөх зөвлөл байгуулах хүмүүсийн тухай өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэх гэж байгаа юм байна. Энэ 11 хүнийг бид судалж үзлээ. Үнэхээр зөвлөлдөх санал асуулгыг явуулж, энэ нийгэмд үүсээд байгаа бугшсан энэ бузар булхай зүйлийг өөрчилье гэж байгаа бол ингэж нэр төдий, өөрсдийнхөө үзэл бодлыг,

өөрсдийнхөө явуулж байгаа энэ асуудлыг хамгаалдаг ийм хүмүүсийг оруулж ирж болохгүй. Болохгүй. Үнэхээр зөвлөлдөх санал асуулга явуулж, ард түмнээсээ саналыг нь авах гэж байгаа бол тэр санал асуулгын тухай хууль бусад хуулиараа нийт ард түмнээс асуу.

Өнөөдөр Монгол Ардын намын хамгийн том дарга энэ хэвлэлүүдэд ярилцлага өгөөд байгаа юм.

2022 оны 8 сарын 15-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дээр Үндсэн хууль зөрчсөн асуудлыг хэлэлцэх үеэр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс үүрэг даалгавар өгсөн гэж. Тогтолцооны өөрчлөлт хий гэж.

Өнөөдөр хууль тогтоох эрх мэдэл цэцэд байна уу, эрх барьж байгаа улс төрийн намын бодлого байна уу, Улсын Их Хуралд хадгалагдаж байна уу гэдгийг би эргэлзэж байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц яахаараа ийм үнэлэлт дүгнэлт өгсөн гэж эрх баригч намын хамгийн том дарга ийм юм ярьдаг юм. Тэгвэл цэцийн шийдвэр чинь бүгд улс төрийн намын даалгавраар явдаг гэдэг нь нотлогдож байгаа шүү.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц өнөөдөр Улсын Их Хуралд тогтолцоо хий, ингэ тэг гэдэг ийм чиглэл өгөх хууль хаана байна. Үүнийг ингэж бариад байгаа, барьж ярих эрх өнөөдөр энэ эрх барьж байгаа намд яагаад байдаг юм. Энэ байдлаас чинь дүгнэлт хийгээд Зөвлөлдөх зөвлөл гэдэг энэ зөвлөлийнхөө хүмүүсийг бүр өөр шалгуураар оруулж ир.

Үнэхээр бид тогтолцооны өөрчлөлт хийе. Өнөөдөр энэ улс нийгэмд учраад байгаа, бугшаад байгаа энэ хулгай

луйвар Үндсэн хуулиас болсон юм уу, болоогүй юм уу гэдэг юман дээр бид өнөөдөр маш болгоомжтой, маш зөв бодлоготой явах ёстой.

Зүгээр нийгэмд ийм асуудлыг шуугиулаад, ийм байдлаар өөрчлөлтийг хийнэ гэвэл их том эндүүрэл болно шүү. Их эндүүрэл болно шүү.

Ийм учраас энэ Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг хойшлуулах саналтай байна. Хойшлуулах саналтай байна.

Яагаад гэхээр жинхэнэ тэр ард түмний төлөөлөл, зөвлөлдөх санал асуулгыг онлайнаар авч, бүр ард түмний жинхэнэ төлөөлөл оролцох боломжийг нь бид хангая.

Ийм байдлаар өнөөдөр нэг хуурамч юм хийсээр байгаад бид өнөөдөр ийм гажигтай, ийм хууль зөрчигдсөн, хулгай луйвар үүрлэсэн ийм 30 жилийн том гаж тогтолцоо бий болсон шүү дээ.

Ийм учраас энэ Зөвлөлдөх зөвлөл байгуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг хойшлуулах саналыг оруулж байгаа юм.

Тэгэхдээ би өнөөдөр Монголд үүсээд байгаа хулгай луйвар, хууль зөрчдөг гажуудсан асуудлыг цэгцлэхийн төлөө байгаа. Энэ бол ард түмний эрх ашиг, ард иргэдэд шаардаж байгаа энэ шаардлага мөн. Үүнийг бид ийм байдлаар шийдэхгүй ээ.

Үнэхээр шийдье гэж байгаа бол тэр ард түмнээсээ санал асуулга явуулж шийдье л дээ. Энд төлөөлөл болсон хэдэн хүн орж ирээд тэрийг нь баталсан маягаар ийм байх нь улам энэ асуудлыг

гааруулж, улс эх орны эрх ашиг хохирно л гэсэн ийм одоо байр суурьтай байна.

Г.Занданшатар: Ш.Адьяшаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг хэлэлцэх тухай тэр тав дахь тогтоолын асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын жагсаалтаас хасъя гэсэн санал гаргаж байгаа юм байна. Тийм үү? Ард түмэнтэйгээ зөвлөлдөх шаардлагагүй гэж үзэж байгаа юм байна.

Тийм учраас Ш.Адьяшаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт

явуулна. Гишүүд анхааралтай. Ш.Адьяшаа гишүүний саналыг дэмжиж байгаа гишүүд. Санал хураалт.

Ш.Адьяшаа гишүүний цэцэд гаргасан. Ш.Адьяшаа гишүүн цэцэд давхар дээл өмсөе гэсэн санал гаргаад. Тэрийг хэлэлцсэн. Тэр дагуу цэцийн дүгнэлт. Ш.Адьяшаа гишүүн цэцэд тийм өргөдөл гаргасан юм биш үү.

Санал хураалтад 45 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, Ш.Адьяшаа гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэнгүй. 75.0 хувиар.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Одоо байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Дэгийн тухай хуульд заасны дагуу нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд нийт гишүүдийн олонх дэмжсэнээр хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Байнгын хорооны саналаар зээлийн хэлэлцээ соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулна.

Энэ чинь 100 сая доллароор валютын нөөц нэмэгдэх гэж байгаа төсвийн дэмжлэгийн шинж чанартай зээлийн асуудал юм байна гэж Засгийн газраас тайлбарласан. Валютын нөөцөд 100 сая долларын нэмэлттэй.

39 гишүүн дэмжиж байж хууль эцэслэн батлагдана. Д.Тогтохсүрэн дарга аа. Санал хураалтад бэлтгэнэ үү.

Валютын нөөц оны эцсээр 3 тэрбум 368 орчим сая доллар болж оны дундуур 2.3 тэрбум хүртэл буурч байсан нөөц 1 тэрбум доллароор нэмэгдэж, оны эцэст валютын нөөц өссөн. Тэгэхдээ валютын нөөцийг бид 4 тэрбум долларт хүргэх шаардлагатай.

Тэр чинь одоо Цэцийн дээд суудлын 9 гишүүний 100 хувийн саналаар хүчингүй болгоод л. Тэгээд Ш.Адьяшаа гишүүн санал гаргаад л,

тэгээд цэц 100 хувийн саналаар шийдээд л.

Цэцийн шийдвэр эцсийн шийдвэр юм чинь тэгээд л бид хүлээж авахаас өөр замгүй болсон шүү дээ. Энэ чинь. Хууль зүйн хувьд бол.

Хүлээж авахгүй байлаа ч гэсэн цэцийн шийдвэр эцсийн шийдвэр гээд

Үндсэн хуульд биччихсэн юм чинь яах вэ. Тийм асуудал.

Энэ хууль санаачлагч байхгүй учраас. Хууль санаачлагч, Засгийн газрын гишүүд байхгүй учраас энэ асуудлыг хойшлууллаа.

Дараагийн асуудалд орёё.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр уг асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл ажлын 3 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан О.Цогтгэрэл үг хэлэх үү. Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах хууль дээр Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан гол үндэслэл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэлэлцэгдэж байгаа.

Тэгэхээр дарааллын хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль эхлээд батлагдчихсаны дараа тэр өмчийн хөрөнгөөр нь үйлчилгээ үзүүлэх тухай

хууль нь хэлэлцэгдэж эхлэх нь зүйтэй юм гэдэг ийм зарчмын байр суурьтай байгаа.

Тэгэхээр энэ үндэслэлийг харгалзаж энэ хэлэлцүүлгээ үргэлжлүүлэхийг хүсье.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцээд дараа нь Ардчилсан намын бүлгийн саналтай холбогдуулаад ажлын хэсэг гаргаад явъя гэж тохирсон байна.

Ингээд Байнгын хорооны саналаар Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулалтын системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Эхлээд өнөөдрийн анхны санал учраас бүртгэлийн санал хураалт явуулья. Санал хураалт. Ширнэнбаньдын

Гурав.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

2012 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын 3 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна.

Адъяаа гишүүн суудалдаа сууя. Санал хураалт явуулахад дандаа ингэж үймүүлж явдгаа больё. Санал хураалт. Бүртгэлийн санал хураалт.

59.6 хувийн саналаар 19 гишүүн бүртгэлд ороогүй байна. Бүртгэлд орохыг сануулья.

Ингээд Байнгын хорооны саналаар хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулж үг хэлэх үү. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Гишүүддээ шинэ өглөөний мэнд хүргэе.

Монгол Ардын намын бүлэг Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр завсарлага авсан.

Энэ хууль 2016 онд өргөн баригдсан. Хоёр парламент дамжиж яваа

ийм хууль байгаа. Банкны тухай хууль. Тийм гадаадын хөрөнгө оруулалтын банкны тухай хууль.

Тэгээд энэ хууль дээр хоёр парламент дамжиж байгаа учраас бас саналаа нэгтгэх ийм зайлшгүй шаардлага байсан. Ийм учраас завсарлага авч саналаа нэгтгэсэн.

Тийм учраас завсарлагын хугацаа дуусаж, чуулганыг үргэлжлүүлэх саналтай байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Дунхүүгийн Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Бат-Эрдэнийн Эрдэнэхуяг Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал, Намхайн Батсайхан Монголбанкны Ерөнхийлөгчийн Санхүүгийн зах зээлийн асуудал хариуцсан ахлах референт, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Баттулгын Дөлгөөн нар байна.

Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явагдана. Зарчмын зөрүүтэй 34 санал байна.

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн гарчиг, төслийн Хоёр, Гуравдугаар бүлгийн гарчгийн “оруулалтын” гэсний дараа “төрөлжсөн” гэж тус тус нэмж, Хоёрдугаар бүлгийн гарчгаас “эрхлэх” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг, Ганибалын Амартүвшин, Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ, Содномын Чинзориг, Одонгийн Цогтгэрэл. Цаашид “Ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт. /алх цохив/

Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Сая би дэмжсэн санал өгсөн. Арай хоцроод дарчихлаа. Дарга аа.

Саяын саналаа хүчингүй болгож өгөөд санал хураалгаж өгнө үү гэж горимын санал гаргаж байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Т.Аубакир гишүүн санал хураалт. Суудалд суу.

Ч.Хүрэлбаатар сайд аа. Энэ сайд нарыг дуудъя. Санал хураалт. Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. /алх цохив/

60.5 хувийн саналаар Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас нэгдүгээр асуудлаарх Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. /алх цохив/

69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээ, удирдлага, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулахад оршино.”

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

73.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Банкны тухай хуульд заасны дагуу банк байгуулах тусгай зөвшөөрөл авсан банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

3.3.Энэ хуульд тусгайлан зааснаас бусад хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаатай холбогдох харилцааг Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

3.4.Монгол Улсын Хөгжлийн банктай холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

30 гишүүн дэмжиж, 73.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк” гэж төслийг дунд, урт хугацааны тогтвортой хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн төлөө хуулийн этгээдийг;

4.1.2.“төсөл” гэж санхүүгийн хөрөнгийн дунд, урт хугацаатай эх үүсвэр шаардлагатай, уг эх үүсвэрийг орлогоороо нөхөх боломжтой эдийн засгийн үйл ажиллагааг;

4.1.3.“харилцагч” гэж хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас санхүүжүүлж байгаа төсөл санаачлагч, хэрэгжүүлэгч хуулийн этгээд болон Монголбанкнаас төслийн оролцогч гэж үзсэн бусад хуулийн этгээдийг.”

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хэлбэр, хувь нийлүүлсэн хөрөнгө

5.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь хаалттай хувьцаат компани эсвэл хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байна.

5.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтын түвшин, улсын төлбөрийн тэнцлийн

үзүүлэлт, төгрөгийн ханшийн өөрчлөлт, банкны төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалтын банкны эрхлэх үйл ажиллагааны онцлог, банкны салбар дахь төслийн санхүүжилтийн хэмжээ, шаардлагатай бусад хүчин зүйлсийг харгалзан Монголбанк тогтооно.

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагаа

6.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжих зөвхөн төсөл санхүүжүүлэхэд чиглэсэн дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

6.1.1.зээл олгох;

6.1.2.төлбөр тооцоо;

6.1.3.баталгаа, батлан

даалт;

6.1.4.үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах;

6.1.5.гадаад валют

худалдах, худалдан авах, арилжих;

6.1.6.андеррайтер;

6.1.7.кастодиан;

6.1.8.санхүү, хөрөнгө

орруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;

6.2.Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5-д заасан үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанк, энэ хуулийн 6.1.6, 6.1.7, 6.1.8-д заасан үйл ажиллагаа

эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгоно.

6.3. Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 6.2-т заасан зөвшөөрлийг олгохдоо тухай бүр Монголбанкны саналыг урдчилан авна.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

61.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл. Зээл олгох

7.1. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчид зээл олгож болно.

7.2. Төсөлд олгох зээлийн хэмжээ, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг банкны системд нөлөө бүхий банкнаас хуулийн этгээдэд олгосон зээлийн хэмжээ, бусад хүчин зүйлсийг харгалзан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран тогтооно.

7.3. Энэ хуулийн 7.1-д заасан зээлийн хугацаа 2 жилээс доошгүй байна.

7.4. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны барьцаалсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах бол Ашигт малтмалын тухай хуулийн 7.1-д заасан нөхцөлийг хангасан эрх бүхий этгээдэд зөвхөн дуудлага худалдааны үндсэн дээр шилжүүлнэ.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл шинээр нэмэх:

“8 дугаар зүйл. Төлбөр тооцоо

8.1. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь энэ хуулийн 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.1.6-д заасан үйл ажиллагаанд шууд хамаардаг харилцагч болон Монголбанк, банкны төлбөр тооцоо гүйцэтгэж болно.

8.2. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг холбогдох хуульд заасны дагуу зохицуулна.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10. Төсөлд доор дурдсан агуулгатай 9 дүгээр зүйл шинээр нэмэх:

“9 дүгээр зүйл. Баталгаа, батлан даалт.

9.1. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14.1-д заасан хязгаарлалтын хүрээнд дангаар болон бусад этгээдтэй хамтран төсөл санхүүжүүлэхтэй холбогдуулан харилцагчийн хүлээсэн үүрэгт гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргаж болно.

9.2. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас гаргах баталгаа,

батлан даалтад тавих шаардлага, нөхцөлийг Монголбанкнаас баталсан журмаар зохицуулна.

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 8 дугаар зүйлийг 10 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах

10.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын хүрээнд гадаад улс, дотоодын үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргаж болно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар дотоодын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаас нь зөвхөн хаалттай хүрээнд байна.

10.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, мөнгөн хөрөнгийн нөөцийг удирдах зорилгоор мөнгөний зах дээр богино хугацааны үнэт цаас гарч болно.

10.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчийн үнэт цаасны зах зээл, мөнгөний зах дээр арилжаалагдах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг худалдаж, худалдан авч болно.

10.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк компанийн хувьцааг тав хүртэлх жилийн хугацаанд эзэмшиж болно.

10.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч, түүний холбогдох этгээдийн гаргасан хувьцааны 20 хүртэл хувийг эзэмшиж болох бөгөөд эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна.

10.7.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах харилцааг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран баталсан журмаар зохицуулна.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Цэрэнпилийн Даваасүрэн, Баттөмөрийн Энхбаяр нарын гишүүдээр үг тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Энэ одоогийн байгуулагдаж байгаа банкийг зүгээр Хөгжлийн банк болгохгүй байхыг эхнээс нь бодох хэрэгтэй шүү.

Ялангуяа түрүүн ярьсан. Баталгаануудын асуудал. Мөн энэ гадаад зах зээл дээр үнэт цаас гаргана гэж байгаа юм. Энэ дээр маш анхааралтай, хяналттай хандахгүй бол Монголбанк өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банкн дээр тэр хяналтаа маш муу тавьсан. Баталгаа нь ямар байсан юм. Ирээдүйн хөрөнгөөрөө барьцаална гэсэн баталгаатай зээлүүд байсан шүү дээ.

Тийм учраас та нар ингээд холбогдох журмаар зохицуулна гээд л ингэчихэж байгаа юм. Тэгээд холбогдох журмаар зохицуулж байсан юм бол яагаад Хөгжлийн банкн дээр ирээдүйн хөрөнгө орлогоороо барьцаалж ингэж зээл авч байсан юм.

Энэ мэтийн асуудлыг дараагийн хэлэлцүүлэг дээр сайн анхаарахгүй бол баахан гадагшаа үнэт цаас гаргаад хаячихсан, улсаа ерөнд оруулаад хаячихсан. Ирээдүйн хөрөнгөөр баталгаажуулчихсан гээд ингээд баахан хөрөнгө оруулалтын зээл болчихсон байх ийм юм гарах вий гэдгийг саяын энэ өнгөрсөн батлагдаж, саяын санал хураагдсан заалт, одоогийн хураах гэж байгаа заалт хоёр дээр хэлэлцүүлгийн явцад анхаарахгүй бол болохгүй шүү. Дахиад Хөгжлийн банк болгож болохгүй шүү үүнийг.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Би яг Ц.Даваасүрэн гишүүнтэй яг адилхан бодсон байна.

Одоо энэ хураах гэж байгаа 10.7 дахь заалт. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах харилцааг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмаар зохицуулна гэж байгаа юм.

Энэ харилцаа бол журам биш, хуулиар зохицуулагдах ёстой. Үнэт цаасны хуулиар зохицуулагддаг. Угаасаа.

Тэгэхээр үүнтэй холбоотой хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах харилцаатай онцлог харилцаа, үнэт цаасны хуулиас онцлог харилцаа бол Үнэт цаасны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар л зохицуулах ёстой. Үүнийг журмаар зохицуулж болохгүй.

Одоо би бол их олон удаа ярьж байгаа. Хууль тогтоох эрх мэдэл зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдаж байгаа.

Энэ хууль тогтоох эрх мэдэл хоёр янзын аргаар Засгийн газар болон энэ асуудал руу шилжээд байгаа юм. Одоо булааж авч байгаа юм.

Нэг нь, энэ Засгийн газар болон сайд нар ийм журмыг нь зохицуулна гээд хууль тогтоох эрх мэдлээ хэрэг дээрээ булааж аваад байгаа юм. Тэгээд хариуцлагыг нь хэн үүрдэг вэ гэхээр Их Хурал үүрдэг юм.

Тэгэхээр энэ боломжтой харилцааг ерөөсөө л хуульчлах ёстой. Тэгээд энэ журмын цаана нөгөө эрх олж авч байгаад л тэгээд л хулгайгаа хийдэг. Одоо жишээлбэл, үүний өмнөх заалт дээр баталгаа, батлан даалттай холбоотой гол асуудал байгаад байгаа юм.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас гарах баталгаа, батлан даалт тавих шаардлага нөхцөлийг Монголбанк журмаар зохицуулна. Ингээд л нэг ерөнхий ганц үг.

Энэ хуульчлагдах ёстой байхгүй юу. Ямар шаардлага тавигдах юм, ямар нөхцөлд баталгаа гаргах юм, хүрээ хязгаар нь ямар байх юм. Тийм. Яагаад гэхээр энэ Улсын Их Хурал чинь Үндсэн хуульд зааснаар төрийн мөнгөний бодлого, зээлийн бодлогыг Улсын Их Хурал тогтооно гэдэг Үндсэн хуулийн заалт байгаа шүү дээ. Энэ чинь. Улсын Их Хурлын хуваалцаагүйгээс эрх байхгүй юу. Үндсэн хуульчилчихсан.

Энэ бүрэн эрхийг Монголбанк шууд журам гаргаад л авах гээд байгаа байхгүй юу. Одоо үүнийг нарийвчлах шаардлага байгаа юм байна гэдэг. Би бол Хөгжлийн банкны түр хороон дээр урьдчилсан байдлаар анзаарсан. Яагаад гэхээр энэ арилжааны банкуудын удирдлагууд хувь хүнээрээ, эсвэл өөрийн

үүсгэн байгуулсан хамаарал бүхий компаниараа баталгаа гаргадаг. Өөрийн банкнаас гаргаж байгаа зээл дээр өөрөө иргэнээрээ юм уу, өөрийн компаниараа баталгаа гаргаж байгаад мөнгө угаасан ийм асуудлууд их олон тохиолдлууд илэрч байгаа. Энэ асуудал тодорхой болж яригдах байх. Түр хорооны 16-нд эхлэх сонсгол дээр энэ асуудал их тодорхой яригдана. Фактаар. Нотлох баримтаар яригдана.

Тэгэхээр энэ бол нэгд судлаад үзэхээр энэ дээр бас Монголбанк өөрөө оролцдог, өөгшүүлдэг, хуйвалддаг ийм нөхцөл байдлууд бас тогтоогдож байгаа.

Тийм учраас би үүнийг Монголбанканд одоо зүгээр журам хэлбэрээр олгохыг би итгэхгүй байна. Энэ хуульчлах ёстой харилцаа.

Тийм учраас эцсийн хэлэлцүүлэг дээр энэ журмаар зохицуулсан энэ энэ асуудлуудыг гүйцээн боловсруулж хуульчилж тодорхой болгох дээр бас чиглэл өгөөч гэсэн ийм л одоо хүсэлт, итгэл үнэмшил гаргах гээд байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Үүнийг холбогдох ажлын хэсгийн дүгнэлттэй холбогдуулаад гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Тэр хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк хувьцааг тав хүртэл. Компанийн хувьцаа эзэмшиж болно энэ тэр гэдэг чинь компанийн үйл ажиллагаанд оролцож болох. Тэр үнэт цаасны баталгаа гаргах журам, хязгаарлалт энэ тэрийг тэдэн хувиас гаргаж болохгүй энэ тэр гээд. Өөрийн хөрөнгийн тэдэн хувь гээд нарийвчилсан зохицуулалтууд байх ёстой байх. Ингээд

гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. /алх цохив/

Дараагийн асуудалд орё.

12.Төсөлд доор дурдсан агуулгатай 11 дүгээр зүйл шинээр нэмэх:

“11 дүгээр зүйл.Гадаад валют худалдах, худалдан авах, арилжих

11.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь энэ хуулийн 6.1.1, 6.1.6-д заасан үйл ажиллагааны хүрээнд харилцагчийн төлбөр тооцоог гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэхэд үүсгэж болох гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах зорилгоор гадаад валют худалдах, худалдан авах, түүнтэй холбоотой валют арилжааны бусад хэлцлийг хийж болно.

11.2.Энэ зүйлийг 11.1-д заасан үйл ажиллагааг Валютын зохицуулалтын тухай болон холбогдох бусад хуулиар зохицуулна.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Энэ бол Төрийн банк биш. Хувийн хөрөнгө оруулалтын банк л даа. Тэгэхдээ тэр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын банк ч гэсэн тэр компанийн хувьцаа эзэмшинэ, үнэт цаасны юу энэ тэр дээр нь хязгаарлалтуудыг нь анхаарах. Хувийн банк.

Хөөш. Юу вэ. Энэ санал чинь дэмжигдсэнгүй байна шүү дээ.

13.Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл шинээр нэмэх:

“12 дугаар зүйл.Андеррайтер, кастодиан, санхүү, хөрөнгө

оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа

12.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас төсөл санхүүжүүлэхтэй холбоотойгоор энэ хуулийн 6.1.6, 6.1.7, 6.1.8-д заасан үйл ажиллагааг эрхлэх харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төсөлд доор дурдсан агуулгатай 13 дугаар зүйлд шинээр нэмэх:

“13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын банканд хориглох үйл ажиллагаа

13.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

13.1.1.энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх;

13.1.2.мөнгөн хадгаламж, хүү төлөх нөхцөлтэй харилцах данс нээх, тэдгээртэй адилтгах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх;

13.1.3.хараат болон охин компани үүсгэн байгуулах;

13.1.4.банк, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээдийн

хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг худалдан авах.”

Санал гарсан ажлын хэсэг.

Цэрэнпилийн Даваасүрэнг гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Энэ хувийн банк гээд тэгээд сайн болчихно гэсэн юм бас байдаггүй байхгүй юу.

Баахан иргэдийн хөрөнгө цуглуулчхаад байдаг юм уу, үнэт цаасаар баахан юм босгочихоод дараа нь тэгээд асуудал үүсвэл хэн хариуцах юм. Төр л хариуцна шүү дээ. Гаднаас авч байгаа зээлийг нь хэн хариуцах юм. Монгол Улс л хариуцна шүү дээ.

Тийм учраас анхааралтай байхгүй бол болохгүй. Хувийн гээд хаячхаж болохгүй. Монгол Улсынх байх юм бол. Үгүй ээ, үгүй. Мөнгө босгох гээд байна шүү дээ. Би тэрийг яриад байна. Нөгөө талаараа саяын тэр хориглож байгаа дотор одоо энэ арилжааны банкнуудад нэг сул тал байгаа байхгүй юу. Ерөөсөө бүх төрлийн бизнес рүү ордог. Бүх төрлийн бизнес рүү ордог. Гуанз ч байсан ордог. Нөгөө бусад гуанзууд нь дампуурдаг.

Ер нь хамгийн. Одоо ингээд 65 тэрбумын нэг зээлийн хүүгийн хөнгөлөлт өгч байгаа шүү дээ. Үүнийг тэд нар эдэлж байгаа. Тэгээд бусдын бизнесийг булааж авч байгаа. Дэлгүүр, одоо энэ найман нэрийн барааны дэлгүүр энэ тэр дампуурч байгаа чинь энэ шүү дээ.

Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын банкин дээр энэ дээр энэ хязгаарлалтыг маш сайн нарийн тавьж өгөхгүй бол хамгийн бага хүүтэй зээл аваад хамаг бизнесийг нөгөө хөрөнгө оруулсан гэсэн

нэртэй нөхдүүд чинь яах вэ, өөрийнхөө компаниудаар дамжуулаад дуусгана шүү дээ. Яаж 3 хувийн зээлтэй арван хэдэн хувийн зээлтэй хүн өрсөлдөх юм бэ.

Тийм учраас энэ асуудлыг маш анхааралтай хандаж, наана чинь шийдэхгүй бол яг ийм заваан юм болно шүү. Одоо тийм л байгаа шүү дээ. Төмөр зам хүртэл байна. Юу л бол юу барьж байгаа шүү дээ. Одоо манай банкнууд чинь. Тийм биз.

Тийм учраас найман нэрийн барааны дэлгүүрийг нь хүртэл булааж аваад л байж байгаа шүү дээ.

Тэгэхээр наад дээрээ жоохон анхааралтай хандаад. Хувийн гэвэл бүх юм гоё байдаг юм гэж бас ингэж тайлбарлаж болохгүй. Бүгд хуулийн дорр эмхтэй журамтай байх тухай л би ярьж байна. Зарчимтай. Бие биеийнхээ бизнесийг булаахгүй, улс орноо өрөнд оруулахгүй байх тухай л би ярьж байна.

Г.Занданшатар: Энэ заалт бол хориглох заалтууд байна. Тийм ээ. Санал хураалт явуулъя.

Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Ц.Даваасүрэн гишүүний тэр болгоомжлоод байгаа зүйл дээр бас нэг тайлбар өгье.

Энэ хамгийн гол нь хадгаламж авахгүй. Одоо иргэдийн болон аж ахуйн нэгжүүдийн хадгаламж авахгүй учраас тэр эрсдэл бол байхгүй. Нэгд.

Хоёрт, энэ банк чинь өөрөө хөрөнгө оруулалтын банк. Том дүнтэй санхүүжилт хийх төслүүдийг санхүүжүүлнэ. Тэгээд төслүүд эрсдэлтэй

байвал энэ банк чинь тэр төсөл дээрээ тодорхой хэмжээний хувь хэмжээ авах. Бас 20 хүртэлх хувь авч болно гэсэн нэг ийм боломжийг нь нээж өгсөн юм.

Яагаад гэвэл. Тэгэхдээ нэг төсөл дээр 20 хүртэлх хувь авахдаа 5 жилийн хугацаанд гарна. Саналын эрхгүй ийм хувь авч болно л гэсэн юм байгаа юм. Түүнээс биш бусад бизнесүүд рүү хөрөнгө оруулах тэр боломжуудыг нь энэ хууль дээрээ тодорхой заалтуудаар хааж өгсөн байгаа шүү.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлэх учраас.

Цаашаа санал хураалт явуулна. Энэ заалт бол хөрөнгө оруулалтыг хориглох үйл ажиллагаа байна шүү дээ. Тийм. Банкны хувьцаа авч болохгүй, хараат охин компани байгуулж болохгүй, хадгаламж, харилцах данс нээж бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлж болохгүй. Энэ чинь өөрийн эх үүсвэрээрээ үйл ажиллагаа явуулна. Өөрийнхөө хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа явуулна гэсэн ийм агуулгатай заалт байна. Санал хураалт. /алх цохив/

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төсөлд доор дурдсан агуулгатай 14 дүгээр зүйл шинээр нэмэх:

“14 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт, шаардлага

“14.1.Аливаа этгээд, түүний холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгох хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл,

зээлтэй адилтган тооцох хөрөнгийн хэмжээ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг гурав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.2.Зээл, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг арав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.3.Баталгаа, батлан даалт, эзэмшиж байгаа үнэт цаасны нийт дүнгийн нийлбэр нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.4.Энэ зүйлд зааснаас бусад шаардлага, үйл ажиллагааны хязгаарлалтын журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ хуулийг 2016 онд өргөн барихад анхны хуулийн төсөл дээр 500 тэрбум төгрөгөөс доошгүй өөрийн хөрөнгөтэй байна гэж заасан байгаа.

Тэгээд энэ нь тухайн үеийн ханшаар 200 орчим сая доллар байсан юм л даа. Тэгээд өнөөдрийн ханшаар бол 140 рүү унаж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр өөрийн хөрөнгөөс гурав дахин нэмэгдүүлэхгүй гэхээр би 500 тэрбум байна гэж бас нэг санал гаргасан боловч тэр нь уначихсан юм. Тэгэхээр энэ юу гэж байна вэ гэхээр 500 байх юм бол хүн орж ирэхгүй. Банкнууд орж ирэхгүй гэж байгаа юм.

Тэгэхээр түрүүний заалтын дагуу Монголбанк өөрөө тогтоохоор болчихлоо шүү дээ. Тэгэхээр 200 тэрбум гэж заах юм бол энэ банк чинь 600 тэрбумаас дээш зээл олгохгүй болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр банкууд өнөөдөр яаж байна. Жишээ нь, Худалдаа хөгжлийн банк. Би банкны нөгөө хувьцаа гаргах тухай хууль дээр би хэлж байсан. Банкууд нэг тэрбум төгрөгийн үнэтэй барилгаа 50 тэрбум төгрөгийн үнэлгээгээр барьцаалаад өөрийнхөө банкнаас нөгөө хамаарал бүхий компаниуддаа мөнгө гаргадаг байхгүй юу.

Тэгээд Худалдаа хөгжил нийтдээ намайг тэгж Банкны тухай хууль дээр ярьж байхад нэг их наяд төгрөгийн цоорхойтой байсан байхгүй юу. Худалдаа хөгжлийн банк. Янз янзын, нөгөө Эрдэнэтийг хувьчилж авахын тулд янз янзын компаниуд дээр зээл гаргаж байгаад гаргачихсан. Тэгэнгүүт түүнийхээ барьцааг маш багаар тавьдаг.

Тэгээд нэг их наяд төгрөгийн цоорхойтой байсан. Одоо үүнийгээ буцаагаад төртэй тохирчихсон учраас тэр цоорхой нь багасаж байгаа байх.

Яг тэр үед би бас Голомт банк 700 тэрбум төгрөгийн цоорхойтой. Хий бичилттэй гэж хэлж байсан. Одоо Голомтынхон бүр нэмэгдсэн. Яагаад гэвэл тэд нар түүнээс хойш энэ төмөр замын санхүүжилтээрээ мөнгө өөрийнхөө банкнаас гаргах замаар ингээд хий бичилт бичээд байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр энэ том төслийг явуулъя гэж байгаа энэ банк чинь өөрөө 200 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй гэвэл түүнийгээ гурав дахин үржүүлээд

600 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг л гаргах нь байна шүү дээ. Зээлийг л гаргах нь байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь нөгөө Хөгжлийн банкнаас долоон доор болж байна шүү дээ. Хөгжлийн банк чинь өнөөдөр 800 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй. Түүнийгээ найм дахин гаргах тийм хуулийн заалттай байхгүй юу. 6.4 их наяд төгрөгийг нэг төсөл дээр гаргах боломжтой.

Гэтэл хөрөнгө оруулалтын банк гэж оруулж ирчхээд үүнийгээ Монголбанканд тэр өөрийн хөрөнгийг хэд байхыг мэдүүлчхээд 500 хүртэл тавьчих юм бол банкнууд орж ирэхгүй гэсэн мөртлөө ийм маягаар явах юм бол наадах чинь ямар ч хөрөнгө оруулалтын банк болохгүй шүү дээ.

Ийм учраас нэг бол тэр дүрмийн санг миний гаргасан саналын дагуу тэр 500 тэрбум гэж тавих хэрэгтэй. Аль эсвэл энэ 14.1-д байгаа өөрийн хөрөнгийг гурав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна гэдэг энэ заалтаа нэг зээлдэгчид олгох зээлээ. Үүнийгээ ихэсгэх хэрэгтэй шүү дээ.

Хөгжлийн банк найм дахин байж байхад энэ одоо ингээд гурав дахин бага байна гэдэг чинь Хөгжлийн банкнаасаа долоон доор хөрөнгө оруулалтын банк болчихлоо шүү дээ.

Тэгээд Их Хурлын гишүүд одоо ингээд зарим нь ингээд санаатай ингэдэг юм уу, тоон дээрээ ингээд будилуулдаг юм уу, энэ нэг тийм боомилсон. Тэгээд л дараа нь та нар гурав дахинаас илүү нэг зээлдэгчид зээл олгочихсон байна. Тэгээд бас нэг өөр харилцан хамаарал бүхий компаниуд зээл олгоод түүнийхээ барьцаа хөрөнгийг нь бас бага тавьж

байгаад зээл огдсон байна. Тэгээд нөгөө Монголбанкны дарамт шалгалтыг л их болгох тийм дэгээ тавьж байна гэсэн үг гэж би ойлгож байна.

Тийм учраас энэ асуудал дээр Их Хурлын дарга энэ харьцааг нь бодоод энэ гурав дахин гэдгийг бас арай өөрөөр шийдэх, нэмэгдүүлэх, аль эсвэл тэр дүрмийн санг нэмэгдүүлэх, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ийм чиглэл Байнгын хороонд өгөөч гэсэн ийм саналтай байна.

Г.Занданшатар: Ажлын хэсэг тайлбарлая.

Г.Энхтайван: Б.Пүрэвдорж гишүүний асуултад тодруулъя.

Эхлээд тэр 500 тэрбум төгрөгийн дүрмийн сангийн доод хязгаартай холбоотой асуудалд нь тодруулчихъя.

2016 онд анх Б.Жавхлан гишүүн, З.Нарантуяа гишүүн нарын өргөн барьсан Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн анхны төсөл дээр 500 тэрбум төгрөг гэдэг дүрмийн сангийн доод хэмжээг тогтоосон байсан.

Ажлын хэсэг дээр дахиж ярилцаад энэ 500 тэрбум төгрөг гэж хатуу тогтоох нь нэг талаасаа буруу юм. Нөгөө талаасаа яг өдөр тутам, цаг, минут тутам хувьсан өөрчлөгдөж байгаа дэлхий нийтийн эдийн засгийн үед дүрмийн сангийн хэмжээг хууль дээр хатуу тогтоочихоод дараа нь бид бүхэн энэ хуулиа эдийн засгийнхаа нөхцөл байдлаас хамаараад байн байн өөрчлөх хэрэг гарна. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа 500 тэрбум төгрөгийг энэ чинь дан ганц гадаадын хөрөнгө оруулагчид зориулсан хууль биш

шүү дээ. Энэ чинь дотоодын аж ахуйн нэгжүүд бас Хөрөнгө оруулалтын банк байгуулж болно. Дотоодын хөрөнгө оруулагчтай байж болно.

Мөн дэлхийн маш олон байгууллагаас бизнесийн орчин болон хөрөнгө оруулалтын орчин гээд маш олон төрлийн индексүүд гаргадаг. Дийлэнх индексээр манайх ер нь дандаа 110-аас хойш байранд байгаа.

Тэгээд хэрвээ бид бүхэн ингээд хөрөнгө оруулалтынхаа орчныг муутгаад нэг хадмал тоо тавьчихаад гадаадын хөрөнгө оруулагчийг ингээд хатуу нэг тоогоор айлгаад ингээд байгаад байх юм бол энэ хөрөнгө оруулалт ерөөсөө орж ирэхгүй шүү дээ.

Аль болохоор нөхцөл байдлаа бодитойгоор үнэлээд гадаад төлбөрийн тэнцэл ийм хүнд байгаа үед гадаад валютын албан нөөц дээр дэмжлэг болох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, банкны салбарт гадаадын сайн туршлагыг нэвтрүүлэх үүднээс л ийм хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хуулийн төслийг нь ингээд өөрчлөөд явсан.

Яг энэ хүрээндээ тэр 500 тэрбум төгрөг гэдгийг Монголбанк дээрээ делекац аваад хэрэв үүнийг тухайн үеийнхээ цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулаад тогтоодог болъё гэж байгаа юм.

Зээлтэй холбоотой асуудал дээр бол яг одоогийн нөхцөл байдал дээр хамгийн том өөрийн хөрөнгөтэй ХААН банк 1.5 их наядын өрийн хөрөнгөтэй байгаа. Үүнийхээ 20 хувь дээр гэхээр 300 тэрбумын л зээл гаргаж байгаа юм.

Тэгэхээр яг энэ хүрээнд бид бүхэн өөрийн хөрөнгийг гурав дахин гэдэг чинь нэг зээлдэгчид оногдож байгаа хэлбэр шүү дээ.

Б.Пүрэвдорж гишүүн энэ дээр яг нийт зээл дээр гэж андуураад байх шиг байна. Энэ бол нэг зээлдэгч дээр оногдож байгаа. Нэг зээлдэгч дээр бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Банкны тухай хуулиар дээд талд нь 300 тэрбум төгрөгийн л зээл гарч байгаа.

Хэрвээ одоо энэ хуулийн төслөөр Төв банкнаас 300 тэрбум төгрөгөөр тогтоолоо гэхэд нэг зээлдэгчид энэ хуулийн дагуу л 900 тэрбум төгрөгийн зээл дангаараа очих боломжтой. Бодит байдалтайгаа нийц л гэж хэлмээр байна.

Г.Занданшатар: Энэ хуулиасаа ойлгохгүй бол энэ чинь Төрийн банк биш, төрийн хөрөнгө оруулалттай банк биш, гадаадын хөрөнгө оруулалттай банк. Зээлийн хүүг бууруулах зорилгоор арилжааны банк.

Тэгээд бусдаас, дотоодоос эх үүсвэр татан төвлөрүүлэхгүйгээр тэгээд энэ том хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлэх зорилготой төрөлжсөн банкиг байгуулаад.

Тэгээд тэр нь өөрсдөө эрсдэлээ хүлээгээд явах тийм тухай л хууль гаргаж, зээлийн хүү бууруулахад чиглэсэн л хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилготой л банкны тухай хууль гэж ойлгоод явж байгаа юм.

Санал хураалт явуулъя. Тухайн энэ зарчмын зөрүүтэй саналаар л дэмжиж, дэмжээгүй үг хэлнэ. Санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй.

Дэмжигдээгүй бол төслөөрөө үлдэхээр бүр хатуу болно. Тэгээд тэрүүгээр Монголбанк тогтоогоод л явчихна биз. Энэ заавал хэмжээг нь тогтоох хэрэггүй.

16.Төслийн 9 дүгээр зүйлийг 15 дугаар зүйл болгон доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах

15.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах зөвшөөрлийг Монголбанк олгоно.

15.2.Гадаад улсын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах, эсхүл хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нийт гаргасан хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас, эсхүл өр төлбөрийн эх үүсвэрийн хөрөнгийн 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг холбогдох хуульд заасны дагуу урьдчилан авсан байна.

15.3.Гадаад улсын хуулийн этгээд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тухайн хуулийн этгээд нь зөвхөн банк, санхүүгийн байгууллага байх бөгөөд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь тухайн хуулийн этгээдийн охин компани байна.

15.4.Энэ хуулийн 15.3-г заасан этгээдийн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагаа эрхлэх эх үүсвэр нь эдийн засгийн харьяат бус этгээдээс

гарал үүсэлтэй гадаад валют байх буюу тухайн этгээдийн эзэмшиж байгаа Монгол Улсын мөнгөн тэмдэгтээр бүрдүүлээгүй байна.

15.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг бусдад худалдах, шилжүүлэхийг хориглоно.

15.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьцаа эзэмшигч нь тус банкны нийт гаргасан хувьцааг дангаар эзэмшиж болно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Ажлын хэсэг, Байнгын хороон дээр ярьж байхад яадаг юм бэ.

Төслөөрөө үлдэхээр энэ чинь яаж байгаа билээ? Ажлын хэсэг. Банкны хуулиараа л явчихна шүү дээ. Олгох зээлийн хэмжээ нь бүр багасах л юм байна. Ингээд унаад л байвал.

Тэр чинь байнгын хороон дээрээ ярьдаг юм л даа. Энэ банкны салбарын либералчлалыг дэмжихгүй юм байна л даа. Эд нар. Тэрийг чинь ингээд тэнгэрээс аваад тавьчихдаггүй. Мэргэжлийн тоонууд байгаа шүү дээ. Б.Пүрэвдорж гишүүн ээ.

Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд ээ, энэ хуулийг жоохон дэмжээд өгмөөр байгаа юм. Энэ хуулийг дэмжихгүй байгаа гишүүд бол одоо янз бүрийн банктай

холбоотой лоббид нь ороод байдаг юм биш биз дээ.

Энэ чинь банкны салбарт өрсөлдөөн оруулж ирэх, зээл бага гарч байгаа тохиолдолд Хөрөнгө оруулалтын банк орж ирснээр төслүүд дээр арилжааны банкаас гарч яваад байгаа эх үүсвэрүүд арилжааны банк дээрээ үлдээд, энэ хувь хүмүүс хэрэглээнийхээ зээлийг, бизнесүүд бас энэ богино хугацаатай зээлүүдийг арилжааны банкаас авах тэр эх үүсвэр суларч гарч ирэх ийм давуу талууд үүсгэнэ шүү дээ.

Тэгээд энэ хуулийг явуулахгүй гээд байгаа нь өдий олон жил энэ банкууд л энд явуулахгүй. Яг хууль яригдаад л эхлэхээр зэрэг Банкны холбоо гээд л банкууд орж ирээд л энэ асуудал үүсгээд л ингээд л гацдаг байсан юм билээ. Үүх түүхийг нь харахад.

Тэгээд энэ гишүүд бол одоо ингээд дэмжихгүй байгаа нь бол энэ ард түмэнд шаардлагатай байгаа тэр бага хүүтэй зээл гаргах тэр нөхцөл бүрдэх ёстой. Тэр өрсөлдөөнийг банкны салбарт оруулж ирэх гэхээр л дэмжихгүй байгаа юм гэж харагдана шүү дээ.

Тэгээд манай сонгогчид хэн нь эсэргүүцэж байна, хэн нь эсрэг өгч байна, банкны талд хэн нь үйлчлээд байгаа юм. Одоо энэ санал өгч байгаагаас харагдах байх л гэж бодож байна.

Г.Занданшатар: Таны нэр алга байна. Т.Доржханд гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Дээрээс нь Б.Пүрэвдорж гишүүн ээ, энэ нэгдүгээрт та доод талын хязгаарыг ингээд чанга. Хөөш. Б.Пүрэвдорж гишүүн ээ, амьдрал байна шүү дээ, өдөр хоног, сар болгоноор өөрчлөгдөөд байдаг юм.

Г.Занданшатар: Т.Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Нэгдүгээрт миний төхөөрөмж ажилласангүй ээ.

Тийм болохоор энэ саналыг хүчингүй болгох хэрэгтэй байна. Тэгэхдээ Их Хурлын дарга аа, зөвхөн энэ санал биш өмнөх дээр нь би бас үг авъя гээд бас төхөөрөмж ажиллаагүй байхгүй юу. Хөөе. Та нар жаахан чимээгүй байж бай л даа.

Тэгэхээр өмнөх санал нь бас чухал юм. Өнөөдөр Монгол Улсад хөрөнгө оруулалт оруулах банк байхгүй шүү.

Г.Занданшатар: Ц.Цэрэнпунцаг гишүүн суу. Тайван байцгаа. Б.Пүрэвдорж гишүүн суу. Яах гэж та нар ингэж үймүүлж байдаг юм.

Т.Доржханд: Би үгээ. Өнөөдөр Монгол Улсын гадаа очерлоод хөрөнгө оруулалт хийе гэсэн банк байхгүй ээ.

Тэгээд манайх ингээд нэг хязгаарласан, боомилсон байдлаар хандаж болохгүй ээ. Эдийн засгаа тэлье гэх юм бол гурван суваг л байгаа.

Нэг нь болохоор экспортоо нэмэгдүүлэх. Хоёр нь болохоор зээл авах. Гурав дахь нь гаднын хөрөнгө оруулалт.

Тэгээд санхүүгийн хөрөнгө оруулалтаа оруулж ирэх энэ замаа л бид нээхгүй бол эдийн засаг чинь тэлэхгүй шүү.

Тэгээд энэ санхүүгийн салбарын либералчлал, банкны салбарын либералчлал гэдэг юмыг бол одоо энэ

Хөрөнгө оруулалтын банкаар бид хийх ёстой юм. Тэгээд тийм болохоор үүнийг зүгээр алх тогшоод тогшоод санал уначихлаа гэсэн байдлаар явчихмааргүй байна шүү. Их Хурлын дарга аа.

Өмнөх саналыг хүртэл дахиж цуцалж байгаад санал хураалтыг дахиж явуулья гэдэг ийм хүсэлтэй байна. Хууль дээр нь миний төхөөрөмж ажиллаагүй байхгүй юу. Өмнөх хоёр асуудлын саналыг хүчингүйд тооцож дахин санал хураалт явуулж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явна. Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулна.

Одоо тайван байцгаа. Одоо эхлээд горимын саналаараа санал хураалт явуулчихъя. Тайван амгалан, эрүүл ухаанаар хэлэлц л дээ. Энэ чинь. Тоог тэгээд л дээшээ нэг.

Гаргасан саналаас өөр санал. Дэмжих, дэмжихгүйгээс өөр санал хураалт явуулахгүй шүү дээ. Б.Пүрэвдорж гишүүн ээ.

Ингээд сүүлийн хоёр санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулна.

Гишүүд анхааралтай байгаарай. Тайван амгалан байцгаа. Эрүүл саруул ухаанаар бодож шидэцгээ. Ингээд санал хураалт явуулна. Тийм. Санал хураалт явуулья.

Б.Пүрэвдорж гишүүн ээ, та жаахан тайван байлгаад энэ санал хураалт явуулаад өгөөч. Санал хураалт явуулья.

Т.Доржханд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулж байна.

70.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас горимын саналтай холбогдуулж үг хэлнэ гэж байхгүй. Горимын санал дэмжигдсэн учраас. Тэрийг гүйцээн боловсруулах. Тэр унаагүй юм. Тэр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

14.Төсөлд доор дурдсан агуулгатай 13 дугаар зүйл шинээр нэмэх гэсэн.

Энэ чинь юу билээ. Хөрөнгө оруулалтын банканд хориглох үйл ажиллагаа дэмжигдчихсэн шүү дээ.

15 дугаар. Төсөл доор дурдсан агуулгатай 14 дүгээр зүйлд шинээр нэмэх гэсэн энэ санал хураалтыг дахиж явуулья. Санал хураалт. /алх цохив/

72.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Пүрэвдорж гишүүн ээ, Байнгын хороон дээрээ тоогоо ярь л даа. Тэр чинь дээш доош болох чинь энд хэлэлцэхгүй шүү дээ. Энэ чинь. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, дэмжээгүй санал явуулна шүү дээ.

Энэ санал 72.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо 16 дугаар саналыг. Төслийн 9 дүгээр зүйлийг 15 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах гэсэн 16 дугаар саналыг дахин санал хураалт явуулна. /алх цохив/

70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тайван амгалан байцгаа.

17.Төслийн 10 дугаар зүйлийг 16 дугаар зүйл болгон. Энэ сая дэмжигдчихсэн.

Одоо 18. Төслийн 11 дүгээр. 17 сая хураачихсан шүү дээ.

17.Төслийн 10 дугаар зүйлийг 16 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулагчид тавих шаардлага

16.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулагч нь Банкны тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, 23.1-д заасан шаардлагыг хангасан байна.

16.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах гадаад улсын банк, санхүүгийн байгууллага нь энэ хуулийн 16.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

16.2.1.гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд байх;

16.2.2.хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг зөрчсөн тохиолдолд өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах хэмжээний хөрөнгийг хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд оруулах үүрэг хүлээсэн байх;

16.2.3.үүсгэн байгуулагч улсын банк, санхүүгийн байгууллагын хяналт шалгалт, зохицуулалтад олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт мөрдөгддөг байх;

16.2.4.сүүлийн таван жилийн хугацаанд өөрийн улсын болон бусад улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөнөөс үүдэн банк, түүний нэгж байгуулах зөвшөөрөл нь хүчингүй болж, төлбөрийн чадварын болон санхүүгийн хүндрэлд орж байгаагүй;

16.2.5.үүсгэн байгуулагч хуулийн этгээд, хүний удирдлага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

16.2.6.Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа нийцүүлэх чадвартай байх.”

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Одоо тайван бай. Битгий ингээд үймүүлээд бай л даа.

66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 11 дүгээр зүйлийг 17 дугаар зүйл болгон, доор дурдсан бүхэлд нь өөрчлөн найруулах:

“17 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулагчид бүрдүүлэх баримт бичиг

17.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч нь Банкны тухай хуулийн 20.1-д болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн

тухай хуулийн 16.1-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

17.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах гадаад улсын банк, санхүүгийн байгууллага нь Банкны тухай хуулийн 20.1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.2-г зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

17.2.1.харьяалах улсын эрх бүхий зохицуулагч байгууллагаас Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн шийдвэр;

17.2.2.хуульд заасан бол Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу авсан зөвшөөрөл.

17.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах болон өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, эзэмшихэд тавих нөхцөл, шаардлагыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран тогтооно.”

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Байнгын хороон дээр цөөнх болоогүй байна.

59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Түүний хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, эзэмшихэд тавих нөхцөл шаардлагыг хуулиар зохицуулчихаар бүгдийг нь яачихдаг байх л даа. Энэ чинь нөгөө тоонууд тавьдаг байхгүй юу. Тоонууд өөрчлөгдөж болдог.

19.Төслийн 12 дугаар зүйлийг 18 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох

18.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл, бусад баримт бичгийг Монголбанк хянахдаа дараах шаардлагыг хангасан эсэхийг тогтооно:

18.1.1.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан шаардлага;

18.1.2.Банкны тухай хуульд заасан банкны хяналт шалгалт, албадлагын арга хэмжээг аливаа саадгүй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжтой эсэх.

18.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг Монголбанк хүлээн авахдаа энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан шаардлага, 17 дугаар зүйлд заасан баримт бичгийн бүрдлийг хянах бөгөөд хэрэв нэмэлт баримт бичиг шаардлагатай бол уг нь нэмэлт баримт бичгийг бүрдүүлж өгсөн өдрийг өргөдөл хүлээж авсан өдөрт тооцно.”

Санал гаргасан ажлын хэсэг.
Нямаагийн Энхболд, Бөхчулуун
Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.

Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Энэ саналыг нь бол дэмжиж үг хэлж байгаа юм. Дэмжиж байгаа юм.

Түрүүн тэр 11.1 гээд заалт. 11.1 байсан уу, 1.1 байсан уу. Гадаад валютаар арилжаа хийж болохгүй, худалдаж авч, зарж борлуулж болохгүй гээд. Ийм банкаар тэгвэл яах юм бэ, бид нар. Тэр санал чинь уначихлаа шүү дээ.

Зөвхөн Монгол төгрөгөөр үйл ажиллагаа явуулдаг дотоод, гадаадын банкуудын тухай юм боллоо шүү дээ. Энэ хэнд хэрэгтэй юм. Тэр санал чинь уначихсан шүү дээ.

Харин тийм. Тэгвэл энэ хуулийг болих хэрэгтэй, бүр. Хөрөнгө оруулалт татъя, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг ирүүлъя, татъя гэсэн бол одоо наадах заалтгүйгээр энэ хууль чинь ямар ч утгагүй хууль боллоо. Дарга аа. Тийм.

11.1.бүх банкны үйл ажиллагаа зөвхөн төгрөгөөр. Төгрөг маань өнөөдөр ямар нэр хүндтэй, ямар ханштай байгаа билээ. Хэн Монголд хөрөнгө оруулж зөвхөн төгрөгөөр үйл ажиллагаа явуулдаг банк байгуулах юм бэ. Ямар Монгол хүн зөвхөн төгрөгөөр үйл ажиллагаа явуулдаг банк Монголд байгуулж хөрөнгө оруулж ажиллах юм бэ.

Тэгэхээр та тэр түрүүн Т.Доржханд хэлээд байх шиг байна. Хоёр юман дээр. Кноп ажиллаагүй гээд. Түүгээрээ дахиж горимын санал гаргуулж санал хураалгаад одоо нэг мөсөн энэ асуудлаа шийдээд явсан нь дээрээ. Чиглэл гэж ярьж яах юм.

Г.Занданшатар: Ер нь хуулийнхаа эх дээр 6.1.6-д нь хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ гэдэг дотор валютын ажил, үйлчилгээ орох л юм байна л даа.

Тэгэхээр энд заавал тэр валютын арилжааг тусад нь оруулсан нь. Тэгээд Валютын зохицуулалтын тухай хуулиараа зохицуулчхаж болохгүй юу.

Ажлын хэсэг 83 хариулья.

Г.Энхтайван: Хуулийн төслийн 11.1 дээр энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь энэ хуульд заасан үйл ажиллагааныхаа хүрээнд зөвхөн харилцагчийн төлбөр тооцоог гүйцэтгэх үйл ажиллагаа эрхлэхэд үүсэж болох гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах зорилгоор гадаад валют худалдах, худалдан авах, түүнтэй холбоотой валют арилжааны бусад хэлцлийг хийж болно гэсэн заалт байсан юм.

Энэ сая чуулган дээр уначихлаа. Тэгэхдээ энэ 11.1 бол зөвхөн тухайн төрөлжсөн банк өөрийнхөө хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, тухайн төсөл, хөтөлбөрт оролцогч, харилцагчийн гадаад валютын төлбөр тооцоо, ханшийн эрсдэлийг удирдах зорилгоор валютын зах дээр ажиллана гэсэн ийм заалт байсан юм.

Хэрвээ энэ заалт байхгүй бол одоо Валютын зохицуулалтынхаа хуулиар яваад нийт дэлгэрэнгүй задгай л болчихно л доо.

Тэгэхээр энэ 11.1 бол зайлшгүй байх ёстой заалт л гэж үзэж байна.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би тэр 14.1 дээр Ц.Цэрэнпунцаг гишүүний хэлсэн дээр тайлбар хийхгүй бол болохгүй юм байна.

Тэгэхээр би хэлээд байгаа шүү дээ. Том том төсөл хэрэгжүүлэхийн тулд, жишээ нь Худалдаа хөгжлийн банк Эрдэнэтийг авахын тулд баахан өөрийн хамаарал бүхий компаниуд дээр зээл аваад хий бичилт бичээд байдаг юм.

Голомт банк одоо бүр 700 тэрбум хий бичилттэй байж байсан. Одоо бүр тэндээсээ нэмэгдээд явчихсан.

Тийм учраас нэг том төсөл байлаа гэж. Одоо жишээ нь, Богд хаан төмөр зам гэхэд 1.5 тэрбум долларын төсөл байгаа л даа. Энэ чинь бараг 5 их наяд төгрөгийн төсөл, хөтөлбөр байхгүй юу. Үүнийг нэг компани авлаа гэхэд түүн дээрээ зээл одоо ингээд дотоодын хөрөнгө оруулалтын банкнаас авахаар дээд тал нь жишээ нь 200 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй бол гурав дахин нэмэгдүүлээд 600 тэрбумыг л авах болчихоод байгаа байхгүй юу даа.

Тийм учраас эрх чөлөөг нь жоохон нэмэгдүүлээд нэг төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх тэр боломж нь тэртээ тэргүй тэр өөрсдөө эрсдэлээ үүрээд өөрийнхөө хөрөнгөөр байгуулж байгаа тэр компанид тэр зээлжих зэрэглэлийг нь, зээлжих тэр боломжийг л нэмэгдүүлж өг гэж.

Яах вэ, Г.Амартүвшиний хэлээд байгаа бас эрсдэлд орох магадлал өндөр гэж ярьж байгаа. Тэгэхдээ энэ нэг төсөл, хөтөлбөрт нэг зээлдэгчид олгох тэр зээлийг нэмэгдүүлж өгөөч л гэдэг зүйлийг би хэлсэн чинь энэ Г.Энхтайван гэж нэг нөхөр энэ Их Хурлын гишүүдэд буруу хэлээд тийм буруу ойлголт төрүүлээд ингээд яваад байна л даа.

Тэгэхээр энэ дээр л би хэлсэн юм.

Тэгэхээр ер нь тодорхой хэмжээгээр энэ Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль, Bank of China-гийн лоббигоор орж ирж байгаа. Тэр дээр нь зарим нэгэн гишүүн байна гэсэн. Тэр нь бас тодорхой болоод байх юм шиг санагдаад байх юм.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн үг хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Б.Пүрэвдорж гишүүн ээ, та энэ ярьж байгаа нэг сэдвээ бас жоохон ойлгох хэрэгтэй байгаа юм.

Энэ хөрөнгө чинь хөрөнгө оруулагчид өөрийнхөө хөрөнгийг 200, 300 тэрбумаар юм уу ирээд хөрөнгө оруулалтын банк байгуулж байгаа тэр өөрийнхөө хөрөнгөөр тэр хөрөнгө оруулалтын банк байгуулж байгаа нь хөрөнгө оруулалтаа санхүүгийн, энэ банкны салбарт хийчхэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр нэгэнт хөрөнгө оруулалт хийчихсэн юмныхаа үр шимийг авна уу гэхээс биш арилжааны банкн дээр байдаг шиг тэр хадгаламж эзэмшигчдийн мөнгийг авангуутаа тэрийгээ буцаад зээлдэх ёстой байтал тэрнийгээ өөрөө хөрөнгө оруулалт болгочхож байгаа хоёр чинь ялгаатай хоёр зүйл байхгүй юу даа.

Тэгэхээр энэ дээр гарсан тэр Худалдаа хөгжлийн банк, Голомт дээр гарсан тэр алдаа дутагдлууд бол энэ банкн дээр давтагдахгүй. Энэ чинь өөр юм.

Г.Занданшатар: Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн онц ноцтой асуудал ярьсан учраас. Тэгээд хууль санаачлагч байхгүйтай холбогдуулаад энэ асуудлыг шалгатал энэ асуулыг хойшлууллаа.

Ийм байдлаар хуульд хандаж болохгүй. Ийм эргэлзээтэй хууль гаргаж болохгүй.

Дараагийн асуудалд орёе. Тийм. Дараагийн асуудалд орёе.

*Дөрөв. “Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

“Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай 80 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу “Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас улс орон, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотойгоор тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гарах шийдвэрийн талаар иргэддээ зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг явуулахаар

Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолыг баталсан билээ.

Уг тогтоолд Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох ажлын хэсгийг байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд үүрэг болгосны дагуу Байнгын хорооны 2022 оны 16 дугаар тогтоолоор ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн миний бие ахалж, гишүүдэд Ж.Батсуурь, С.Ганбаатар, Т.Доржханд, Ж.Мөнхбат, С.Одонтуяа, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, Н.Энхболд болон Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан билээ.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт шийдвэр гаргах эрх бүхий этгээд Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах тухай бүрд уг санал асуулгыг зохион байгуулах Зөвлөлдөх зөвлөлийг 5-аас 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. 8.3 дахь хэсэгт Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн асуудлаар мэргэшсэн хараат бус, мэдлэг, туршлага бүхий 21 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн болон төрийн, хувийн хэвшлийн болон мэргэжлийн холбоод, иргэнийг нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагаас, эсхүл өөрөө нэр

дэвшүүлэн санал болгоно гэж заасныг үндэслэн Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшигчдийг бүртгэх ажлыг 2022 оны 12 дугаар сарын 23-наас 30-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл өдөр тутмын сонин хэвлэл, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз, парламентын цахим хаяг болон бусад цахим хаягуудаар нээлттэй байршуулж, зарим их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад албан бичиг хүргүүлсний дагуу их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас 13, төрийн бус байгууллагаас 73, аж ахуйн нэгжээс 4, иргэнээс 72, нийт 160 хүний материал ирүүлсэн байна.

Ажлын хэсэг нэр дэвшигчийн ерөнхий шаардлагад заасан материалын бүрдэл хангасан эсэх, Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль, Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд улс төрийн болон жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилохгүй гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөл болон Монгол Улсын Дээд шүүхээс хүн тус бүрээр лавлагаа гаргуулан хянан үзэж, 136 хүнээр нэр дэвшигчдийн жагсаалтыг гаргасан байна.

Баримт бичгийн бүрдэл дутуу 23, тогтоосон хугацаанаас хойш 3, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан шаардлага хангаагүй 3, нийт 26 нэр дэвшигч байсныг жагсаалтад оруулаагүй болно.

Ажлын хэсгийн хуралдаанд оролцсон гишүүд нууц санал хураалт явуулж, 136 нэр дэвшигчээс хамгийн олон санал авсан Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимаас нэр дэвшсэн эдийн засагч О.Амартүвшин, Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын

холбооноос нэр дэвшүүлсэн эдийн засагч Ө.Ганхуяг, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос нэр дэвшүүлсэн инженер, технологич, Монгол Улсын зөвлөх инженер Х.Ганбаатар, Монгол Улсын Шинжлэх ухааны академиас нэр дэвшүүлсэн гүн ухаан, нийгмийн ухааны багш, академич Г.Чулуунбаатар, төрийн бус байгууллагаас нэр дэвшүүлсэн улс төрийн эдийн засагч, эрх зүйч Л.Төр-Од, хувь иргэнээр нэр дэвшсэн зураг, хөдөлмөрийн багш Г.Галбадрах, радио, электроникийн инженер Д.Моондой, Шинжлэх ухаан, технологийн их сургуулиас нэр дэвшүүлсэн улс төр судлаач Д.Мягмарсүрэн, багш, математикч И.Цэрэн-Онолт, Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгээс нэр дэвшүүлсэн судлаач О.Мөнхсайхан, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэн Хөдөлмөрийн эдийн засагч С.Эрдэнэбат нарын 11 нэр дэвшигчийг Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлж, тогтоолын төслөө боловсруулсан болно.

Тогтоолын төсөлд “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.12 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлж, санал асуулгын дүнг нэгтгэж зөвлөмж гарган Улсын Их Хуралд танилцуулахыг Зөвлөлдөх зөвлөлд даалгахаар тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн дагуу ард

нийтийн санал асуулга явуулах нь зүйтэй талаар саналаа илэрхийлж, зөвлөлдөх санал асуулга явуулах гэж буй үндэслэл, шаардлага, Зөвлөлдөх зөвлөлийн гаргах шийдвэрийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд Зөвлөлдөх санал асуулга нь ардчилсан нийгэмд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар зохион байгуулж, төрийн үйл хэрэгт зөвлөлдөх арга хэлбэрээр иргэдийн оролцох оролцоог хангах арга тул уг асуудлыг дэмжиж байгаа талаар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхыг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Надад зарчмын нэг санал байгаа.

Энэ зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах зөвлөл гэж байгаа.

Тэгээд энэ зөвлөлийн онцлог нь болохоор иргэдийн төлөөлөл байх ёстой.

Тэгээд нийгмийн бүх давхаргуудыг төлөөлж чадахуйц ийм зөвлөл байгаад тэгээд энэ маань өөрсдөө цаашаага ямар хүмүүс зөвлөлдөх санал асуулгад оролцох юм бэ гэдэг тэр ажлыг зохион байгуулна гэж ойлгож байгаа.

Гэтэл ингээд та бүгд маань хараарай. 11 гишүүн байна. 11 гишүүн дотор эмэгтэй хүн байхгүй байна. Гэтэл Монгол Улс нийт хүн амын 50-иас дээш хувь нь эмэгтэйчүүд байдаг.

Тэгэхээр энэ маань өөрөө төлөөлж чадах уу гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр зарчмын асуудал нь ядаж энэ 11 дотроо эмэгтэй хүмүүсийн төлөөллийг бүгдээрээ оруулж ирэх нь зүйтэй байна гэдэг нэг ийм санал байна.

Хоёр дахь нэг асуулт байгаа юм. Одоо энэ Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын холбоо гэж нэг холбоо байна. Холбооны төлөөлөл гээд Ө.Ганхуяг гэж хүн байна.

Гэтэл надад ирсэн мэдээллээр холбооны гишүүн. Тэгэхдээ хувь иргэнээрээ орж ирсэн Радио, электроникийн инженер Д.Моондой гэдэг хүн байгаа юм байна.

Тэгээд нэг байгууллагаас хоёр хүн. Нэг нь иргэнээрээ, нөгөөдөх нь албан ёсоор ингээд орж ирээд явж байгаа нь өөрөө зарчим нь зөв үү гэдэг ийм асуулт байгаа.

Тэгэхээр аль нэгийг нь татгалзуулаад оронд нь эмэгтэй хүний төлөөлөл оруулж ирмээр байгаа юм.

Гурав дахь нь, шулуухан хэлэхэд энд намын төлөөллүүд биш шүү дээ. Ардын намын төлөөллүүд байна. Ардчилсан намын төлөөлөл байна. Би буруутгаж байгаа юм биш шүү.

Тэгвэл ийм бол бусад намын төлөөллөөс бас оруулах байдлаар хандаад явах нь зарчимтай байх гэдэг.

Тэгээд эмэгтэйчүүдийн төлөөллүүдийг бид санал болгоё. Сөрөг хүчний зүгээс. Ингээд үүнийгээ зөвшилцлөөр нийт иргэдийнхээ дундаас ижил тэгш оролцоог хангасан байдлаар Зөвлөлдөх санал асуулгаа явуулахын тулд зөвлөлийнхөө бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүд маань анхаараад, тэгээд төлөөллүүдийг нь хангах байдлаар өнөөдөр саналаа өгөөд явъя гэдэг хүсэлтэй байгаа юм.

Тэгэхээр зарчмын ийм хоёр санал байна. Нэмэх нь нэг асуулт байна. Хариулж өгөөрэй. Баярлалаа.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Ажлын хэсгийн дарга хариулъя.

Д.Тогтохсүрэн: Эхлээд Т.Доржханд гишүүн ээ, та эхлээд хуралдаа суумаар байгаа юм.

Та энэ ажлын хэсгийн гишүүн. Бид энэ Улсын Их Хурал парламент суудалтай бүх намуудыг энэ ажлын хэсэгт орсон юм байна лээ. Та 2-нд 3-нд уржигдар хуралдсан. Та хуралдаа ирээгүй. Чөлөө ирээгүй байна.

Тийм учраас уг нь хуралдаа оролцоод энэ саналаа ярьж тусгуулсан хүн бол сайн байсан.

Нэгдүгээрт, энэ бол улс орон даяар 12 сарын 23-наас 30-ны хооронд нээлттэй зарласан. Ингээд 163 хүний нэр ирсэн. 30 орчим хүний хуулийн шаардлага хангахгүй болон хугацаа хожимдсон гээд санал хураалтад оролцуулаагүй. Ингээд 133 хүнд санал хураалтад оролцсон юм.

Санал хураалтад оролцох гол журам нь бол санал хураалтыг нууцаар явуулах юм байна лээ. Ажлын хэсгийн 12 гишүүнээс 8 гишүүн оролцсон. Саналаа 133 хүн дээр саналаа нууцаар өгсөн. Тэгээд нууц санал хураалтаар шийдчихсэн юм.

Тэгээд үнэндээ нэг дутагдал нь энэ эмэгтэйчүүд ороогүйд бид дотроо анхаарах ёстой асуудал мөн үү гэвэл мөн. Гэхдээ нөгөө нууцаар ингээд санал хураачихаар аягүй хэцүү. Гараад ирчихдэг. Тэгээд нууцаар гараад ирчихсэний дараа нь засъя гэж хэчнээн үзэхээр болохгүй. Ингээд дандаа нууц хариуцсан байхгүй юу. Тэгээд нууц санал хураалт явчихсан учраас.

32 эмэгтэй нэр дэвшиж ирсэн. Гэхдээ 32 дотроо бид нууц санал хураалтаар л шийдсэн. Нууц санал хураалтаар орж ирээгүй юмыг оруулна гээд байх аягүй хэцүү байхгүй юу.

Нэр дэвшилт хуультай. 32 эмэгтэй байсан. Нууц санал хураалтаар явчихсан учраас одоо тэгээд аягүй хэцүү болчхож байгаа байхгүй юу. Нэг дэх асуудал энэ.

Хоёрдугаарт нь, энд 3 төлөөлөл байгаа.

Нэгдүгээрт, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл байгаа. Монголд үйл ажиллагаа явуулдаг томоохон төрийн бус байгууллагын төлөөллүүд бий. Монголын Үйлдвэрчний

эвлэл, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим гээд улс орон дээр үйл ажиллагаа явуулдаг олон гишүүнтэй төрийн бус байгууллагуудын төлөөлөл орж ирсэн.

Хоёр дахь нь, иргэний төлөөлөл байгаа. Хэд хэдэн иргэн. Энэ 11 хүний 3 нь өөрөө нэрээ дэвшүүлж орж ирсэн хүмүүс байна лээ. Г.Галбадрах түрүүн ярьсан. И.Цэрэн-Онолт. Нэг нь хэн байв. Ингээд. Бусад бас одоо төрийн бус байгууллагын төлөөлөл байгаа.

Тийм учраас төрийн бус байгууллагын төлөөлөл байгаа. Иргэний төлөөлөл. Дээр нь энэ байгууллага судална, тодорхой сэдэв боловсруулах учраас судлаач нарын баг байгаа. Эрдэмтдийн төлөөлөл байгаа.

Тийм учраас ийм гурван төлөөллөөс бүрдсэн гэдгээ хэлье гэж бодож байна.

Хяналтын зөвлөл гэж байх юм байна лээ. Одоо энэний дараа байгуулагдах юм. Ирэх долоо хоногт. Бид бас ажлын хэсэг дээрээ ярьсан. Энэ хяналтын зөвлөлд нь эмэгтэйчүүдийн нэр нь ирсэн.

Түрүүний нэр нь ирсэн 32 эмэгтэйчүүдээсээ аль болохоор Хяналтын зөвлөлд түлхүү оруулж, тэднийг Хяналтын зөвлөл, Зөвлөлдөх зөвлөл хоёр бол одоо Зөвлөлдөх зөвлөл зохион байгуулна. Хяналтын зөвлөл нь үйл ажиллагаанд нь хяналт тавина.

Тийм учраас Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд нь нэр ирүүлсэн эмэгтэйчүүдийн төлөөллийг аль болохоор түлхүү оруулах.

Мөн цаашдаа энэ манай Баян-Өлгийн гишүүдэд санал тавьсан. Гэхдээ энэ 163 хүн дотор нэр нь ирээгүй юм. Бас үндэсний цөөнхийн төлөөллийг оруулах энэ чиглэлд нь анхааръя гэсэн ийм бодол байгаагаа би хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууя.

Т.Доржханд: Д.Тогтохсүрэн гишүүн ээ, яг үнүүнийг хэлэхэд бол энэ Улсын Их Хурал өөрийн дэгтэй байдаг байлгүй дээ. Улсын Их Хурлын даргаас чөлөө хүсээд нэг. Албан ёсоор чөлөө хүссэн. Нэг.

Хоёрдугаарт, цахимаар орьё гээд С.Одонтуяа гишүүн бид хоёр бас саналаа илэрхийлсэн шүү. Тэрийг хангаж өгөөгүй. Тэгээд одоо ингээд та хуралдаа суугаагүй юм чинь хамаагүй шүү дээ гэсэн байдлаар хандахаа болиорой.

Тэгээд ярья гэх юм бол асуудлууд бол зөндөө л байгаа шүү дээ. Тэгээд яах вэ ингээд зөв зүйлийнхээ төлөө ингээд явъя гэхээр өөдөөс ингээд та өөрөө чулуу шидэж байгаа шүү. Тэрийгээ би зүгээр анхааруулчихъя.

Хоёрдугаарт, энэ эмэгтэйчүүдийн төлөөлөл байх ёстой. Уучлаарай, одоо яалтай билээ гээд нэг гөлөг төөрүүлж байгаа юм шиг Та нэг ийм байдлаар хариулдагаа одоо болих хэрэгтэй. Эмэгтэйчүүдийн төлөөллөө оруул, залуучуудын төлөөллөө оруул.

Дахиж ингэж байж явъя. Би одоо ажлын хэсэг дээрээ суугаад ажиллая. Дахиж сонгон шалгаруулалтаа хийе. Энэ төлөөллүүдээ хар л даа.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн асууна.

П.Анужин: Баярлалаа. Монголын нийгэм дэх болох бүтэхгүй асуудлуудаа ард түмнээ оролцуулж байгаад хэлэлцэж тодорхойлж гаргаж ирье гэж энэ одоо үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Тэгээд энэ Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүн болохгүй байна. Үнэхээр. Санал нэг байна. Яагаад Монголын нийгмийн асуудлыг бүхэлд нь тодорхойлох энэ чухал үйл ажиллагаанд нэг ч эмэгтэй хүний төлөөлөл байхгүй байгаа юм. Эрчүүд давамгайлсан улс төр л өнөөдөр Монголын нийгмийг ийм хэмжээнд авчирчихлаа шүү дээ. Бид бүгд харж байна.

Тэгэхээр ийм чухал зөвлөлийг байгуулахдаа эмэгтэйчүүдийн квот гэдэг энэ бодлогыг анхнаас нь харж, тооцож баримтлаагүйд бол маш их харамсалтай байна. Эмэгтэйчүүдийн квот гэдэг чинь нэг их эрчүүдтэйгээ өрсөлдөөд арсалдаад байдаг юм биш шүү дээ. Квот гэдэг энэ зүйлийг бодлогоор л оруулж ирэхгүй бол яг л ийм зүйл болдог.

Тэгэхээр Монголын хүн амын 51 хувийг бүрдүүлдэг эмэгтэй улсуудгүйгээр яаж та нар Монголын нийгмийн асуудлыг хэлэлцэх гэж тодорхойлж гаргаж ирэх гэж байгаа юм бэ? Нэг.

Хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөл хаана байна. Эмзэг бүлгийг төлөөлөх давхаргынхан хаана байна. Хөр цасанд энэ хүйтэн өвлөөр өчнөөн жагссан нөгөө залуучуудын чинь дуу хоолой хаана байна аа. Өнөөдөр. Бүтцийг нь бас хараад үзэх хэрэгтэй. Насны ангиллыг нь аваад үзэх хэрэгтэй.

Тэгэхээр ийм байдлаар энэ Зөвлөлдөх зөвлөл бол цаашдаа явж болохгүй ээ. Бүтцэд нь заавал эмэгтэйчүүдийн төлөөлөл болоод сая дурдсан төлөөллүүдийг заавал тусгах ёстой гэсэн ийм байр суурьтай байна.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Ажлын хэсэг хариулья.

Д.Тогтохсүрэн: Гишүүд нэг зүйлийг ойлгоорой. Энэ Зөвлөлдөх санал асуулгын хууль гэж 2017 оны 02 дугаар сарын 17-нд батлагдсан хууль байгаа. Энэ хуулийг нь уншмаар байгаа юм.

Энэ 11 хүн чинь эрх мэдэл байхгүй. Зөвхөн зохион байгуулах үүрэгтэй хүмүүс байхгүй юу. Зөвлөлдөх санал асуулгыг л улсын хэмжээнд зохион байгуулах үүрэгтэй хүмүүс. Нэг дэх асуудал нь ийм. Ажил хийх л хүмүүс байхгүй юу.

Хоёрдугаарт, манай ажлын хэсэг журамтай юм байна лээ. Зөвлөлдөх зөвлөлөөс сонгон шалгаруулах журамтай. Тэр нь нууц санал хураалтаар гэж байгаа байхгүй юу. Тэгээд ажлын хэсгийн 8 гишүүн сууж байгаад л 136 нэртэй саналын хуудас өгөөд л нууцаар санал хураачихсан байхгүй юу.

Тэгээд нөгөө санал хураалтаар гараад ирчихсэн юмыг одоо тэгээд яах вэ. Шуудхан хэлэхэд. Тийм. Чи байсан бол яг тухайн үед нь хүн чинь ороогүйгээс л. Чи цахимаар орьё гэж хэлээгүй ээ. Ирээгүй. Тийм санал. Чи гадаадад зугаацаж явсан байх. Тийм. Нэг дэх асуудал.

Тийм учраас ингээд нууц санал хураалгаар шийдчихсэн асуудал дээр жөндөр аягүй хэцүү байхгүй юу. Яах вэ,

зүгээр тэр журамд нь эмэгтэйчүүдийн квот гэж байдаг байсан бол хамаа байхгүй ээ. Тийм юм байхгүй. 163 хүнийг нэг жагсаалтад оруулаад явуулахаар чинь одоо бид яах юм.

Тийм учраас энэ нууц санал хураалтаар шийдсэн асуудал. Түүнээс биш ажлын хэсэгхэн ярьж байгаад эмэгтэй хүн оруулахгүй гээд оруулаагүй асуудал байхгүй шүү. Бид аль болохоор журам баримтлахгүй бол болохгүй шүү дээ.

Залуучуудын төлөөлөл байгаа. Энэ дотор. Бодвол тэр анкет материалыг нь би тараасан юм болов уу гэж бодож байна. Ахмадын төлөөлөл ч байгаа, залуучуудын төлөөлөл байгаа, аль аль нь.

Үндсэн хууль тогтоогчдын холбоо гэдэг байгууллага. Яагаад яагаад энэ байгууллага оруулсан юм бэ гэж түрүүн асуулаа. Энэ ийм учиртай юм. Энэ зөвлөлдөх санал асуулгын сэдэв гаргахдаа Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудал яригдахыг үгүйсгэхгүй. Нэг гол сэдэв нь болохыг.

Гэтэл 1992 онд батлагдсан Үндсэн хууль тогтоогчдын холбооныхныг энэ үйл ажиллагаанд бид оролцуулах ёстой гэж ярьсан юм.

Тийм учраас тэр албан ёсоор ирсэн нэр нь гурав, дөрвөн хүний нэр байсан. Тэр Ө.Ганхуяг гэдэг хүн сонгогдсон. Д.Моондой гэдэг хүн бол зүгээр хувь иргэний хувьд нэрээ дэвшүүлж оролцсон юм байна лээ. Тийм. Өөрөө тэгж ирсэн юм. Хувь хүний нэрээр ирсэн. Д.Моондой гэдэг хүн бол. Тэр агуулгаараа сонгогдсон гэж ингэж бодож байгаа.

Та нарт энэ анкетууд нь байгаа даа. Энэ чинь ийм шүү дээ. Нэрийг чинь 23-аас 30-ны хооронд аваад нэр хаагдчихсан. Тийм л зүйл. Нээлттэй сонгон шалгаруулалтаар явсан. Тэгээд л Их Хурал өөрөө шийднэ биз дээ.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн ажлын хэсгээс нэмж хариулья.

Н.Энхболд: Би сая Д.Тогтохсүрэн даргын хэлсэн дээр нэмээд хоёрхон зүйл хэлчихье.

Эмэгтэйчүүдийн талаар бид бас ярьж байсан юм. Тэгээд одоо санаж байгаагаар жишээ нь Оюунгэрэл гэж нэр орж ирсэн. Тийм ээ. Ямар намын дарга билээ. Нэг шинэ. Тийм. Тэр боломжийн бас нэг төлөөлөх хэмжээний хүмүүс юм байна даа гэж бодож байсан хүмүүс дотроос ялангуяа эмэгтэйчүүд дотроос нөгөө материалууд нь нэгдүгээрт дутуу. Хоёрдугаарт, намын дарга учраас гээд бас тодорхой хэмжээгээр санал солилцож хасагдсан нэг ийм юм байгаа.

Д.Тогтохсүрэн дарга сая хэллээ. Энэ хүмүүс бол зохион байгуулах л хүмүүс. П.Анужин гишүүний яриад байгаа нөгөө нийгмийн давхарга, бүлэг. Энэ төлөөллүүд бол бүгдээрээ орно. Нөгөө санал хүмүүс дотор орно. Тэр нь өөрөө тусгай журмаар. Одоо ер нь шинжлэх ухааны үндэстэй боловсруулсан тийм аргачлал байдаг юм билээ. Хүн амын дундаас бүлэг, нас, одоо бүх л төрлөөр нь. Эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу бүгдийн төлөөлөл орох тийм аргачлалаар багцаагаар 600 орчим хүн сонгож тэр хүмүүсийг л Статистикийн газраас гаргасан зөв тэр аргачлалын дагуу сонгох ажлыг нэгдүгээрт энэ хүмүүс хийх ёстой.

Хоёрт, одоо энэ урьд нь явж байгаа ярилцлага хэлэлцүүлгийн үед сэдэв гаргана. Сүүлд нь гарсан сэдвээр ирсэн асуултуудыг тэр нь дүн шинжилгээ хийгээд Улсын Их Хуралд танилцуулах энэ зүйлүүдийг нь л хийх юм.

Түүнээс одоо яг энэ хүмүүсийн хувьд бүлэг юмыг төлөөлөх, бүгдийг нь хамруулах ийм шаардлага угаасаа тэр дүрэм журамд нь ч байхгүй. 2017 онд явахдаа ч гэсэн бас нэг ийм байдлаар яваад л.

Одоо саяын бид нарын ажлын хэсгийн ажил бол үндсэндээ ингээд энэ хүмүүсийг сонгуулснаар гүйцэж байгаа юм. Энэ хүмүүс бол тэр санал асуулгыг зохион байгуулаад явуулаад дүнг нь гаргаад Улсын Их Хуралд эцсийн дүнг нь гаргаж өгөөд л бас ажил нь дуусах ийм хүмүүс байгаа.

Түүнээс эд нар өөрсдөө мэдээд одоо хэнийг оруулах вэ, ямар байдлаар үүнийг өөрсдийнх нь хувийн зүгээс нөлөөлөх юмнууд бол байхгүй. Яг 2017 онд явсан шиг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тэр дүрэм, журам, заавруудыг л хэрэгжүүлж ажиллах ийм л хүмүүс юм байгаа юм л даа.

Тэгээд нууцаар санал хураасан болохоор зарим хүмүүсийг нь эрэгтэй, эмэгтэйг нь ч яг үнэнийг хэлэхэд анзаарагүй. Эмэгтэй нэртэй ч хүн харагдаж л байсан. Дотор нь. Тэгээд гараад ирсэн чинь бүгдээрээ ингээд эрэгтэй болчихсон байна лээ. Тэгээд энэ бас нэг ийм асуудал үүсгээд байгаа юм. Яах ёстой юм. Одоо чуулган шийдэх байх даа.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн тодруулж асууя.

П.Анужин: Баярлалаа. Нууц санал асуулгаар эмэгтэйчүүд гарч ирээгүй, дүрэм журмаа барьсан гэдэг асуудлыг бол ойлголоо.

Тэгэхдээ нийгэм энэ бүрэлдэхүүнд сэтгэл ханамжтай биш байгаа гэдгийг би энд заавал хэлэхийг хүсэж байна.

Түрүүн Д.Тогтохсүрэн дарга бас үгэндээ энэ хяналтын зөвлөл байгуулагдана. Чухал үүрэг бүхий. Энэ хяналтын зөвлөлд бас тусгай бодлогыг баримтлан эмэгтэйчүүд. Миний хэлсэн, бас түрүүн дурдсан нийгмийн давхаргуудыг тусгана гэдэг хариултыг хэлсэн учраас энэ дээрээ бас цаашдаа нэгд анхаараад явчихна биз дээ.

Гэхдээ өнөөдөр энэ Зөвлөлдөх зөвлөл болоод, одоо удахгүй энэ хэлэлцэгдэж байгаа асуудал дээр нийгэм анхаарал тавьж ач холбогдол өгч байгаа.

Тэгээд үүн дээр хуульдаа, журамдаа ийм байсан учраас гээд зүгээр л ажил хийх хүн шүү дээ. Тэгээд энэ дотор эмэгтэй хүн байсан ч адилхан, байгаагүй ч адилхан гэдэг хариултад нийгмийн сэтгэл зүй ханахгүй гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Алга байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Тэгэхээр Үндсэн хуулийн асуудлаар зөвлөлдөх санал асуулга гээд байгаа юм.

Тэгэхээр ард түмнийг төлөөлөх эрх зөвхөн Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүнд Үндсэн хуулиараа байдаг байхгүй юу. Энэ улсуудад бол байхгүй.

2019 онд бас ингээд хийсэн. 2019 онд хийсэн Үндсэн хууль маань одоо эрх зүйн хувьд бүрэн төгс хэрэгжиж дуусаагүй. Баялгийн сангийн хууль гараагүй. Өмчийн тухай хууль гараагүй. Тэгээд ингээд 2019 онд орсон өөрчлөлтүүд маань бүрэн хэрэгжиж эхлээгүй байхад дараагийн ахиад асуулга явуулах тухай яриад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ юу хэлж байна вэ гэж. Одоо ингээд өөрчиллөө гэхэд дараагийн гарч ирэх Их Хурал, дараагийн гарч ирэх улс төрчид бас дахиад л тэгнэ. Дахиад л нэг ийм хэдэн хүн цуглуулна. Ард түмнийг төлөөлж чадахгүй улсуудыг. Ерөөсөө байна шүү дээ, хэнд ч таалагдахгүй. Хэн нэгний хийсэн юм.

Тийм учраас бусад улс орнууд Үндсэн хуулиа өөрчилдөггүй байхгүй юу. Одоо ингээд өөрчиллөө. Би хэлээд байна шүү дээ. Дараагийн нөхөр дахиад тэгнэ. Аягүй бол буцаана. Тэр ёстой болохгүй юм байна лээ. Дордуулчихсан байна лээ. Дордохын хэдэн өөрчлөлт. Ингээд буцаана. Тэрний дараагийн гарч ирсэн нөхөр дахиад буцаана. Ингэсээр байгаад Үндсэн хууль цэг болно.

Тийм учраас би энэ Үндсэн хуулийн асуудал дээр бид бүлэг дээр хэлсэн шүү дээ. Ард нийтийн. Бүр эцэстээ тулбал ард нийтээсээ л асууя гээд байгаа шүү дээ. Ард нийтээсээ. Эд нараас биш. Эд нараар төлөөлүүлж биш. Тэгээд энэ хэвээрээ юу. Бүлэг дээр би тэгж шийдсэн гэж ойлгосон шүү дээ. Ард нийтийн санал асуулга бол одоо эцсийн дүндээ хийнэ гэж би ингэж ойлгосон шүү.

2019 онд бас тэгсэн юм. Үгүй ээ, одоо л боломж байна. Үүнээс өөр ерөөсөө өөрчлөх боломж байхгүй гэсэн. Ахиад

боломж гаргаад ирж байгаа байхгүй юу. Тэгээд дараа бас л ингэнэ л дээ.

Одоо олон намууд ороод ирсэн байна. Одоо ёстой гоё боломжтой боллоо. Одоо ингээд олон намууд зөвшилцөж байгаад дахиад Үндсэн хуулиа өөрчилнө гээд л ингээд л яваад байх юм байна шүү гэдгийг би одоо протокол тэмдэглүүлж үлдээе. Тэгнэ. Хэнд ч таалагдахгүй.

Дараагийн гарч ирсэн нөхөр дахиад л тэгнэ. Миний хүч дутаад байна гээд л тэгнэ. Аль эсвэл энэ нь болохгүй байна гээд л тэгнэ. Их Хурлын тоо ихэдчихлээ гэнэ. Аягүй бол Их Хурлын гишүүдийнхээ тоог нэмчихвэл ёстой баларсан юм боллоо. Одоо больё. Буцаая гээд л. Ингээд л. Амьдрал бидний 30 жил яг ийм л байна лээ шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ дахиад үргэлжилж байна. Тэгэхээр стратегийн тийм том бодлого гэдэг юм бол Монголд байхгүй болчихсон байгаа байхгүй юу. Хэн нэг хүний дураараа ярьсан яриагаар улс орон нь хөдөлдөг болчихсон. Хөгжлийн стратеги, улс төрийн стратеги, аюулгүй байдлын стратеги гэдэг юм Монгол оронд байхгүй болчихсон.

Үндсэн хууль бидний амьдрах дүрэм байхгүй юу. Амьдрах хамгийн том дүрмээрээ тоглож эхэлж байна гэдэг бол улс орон эцэстээ тусгаар тогтнол нь эргэлзээтэй байдалд орно гэсэн үг. Ийм л зүйлийг би хэлье.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн хариулъя.

Д.Тогтохсүрэн: Ц.Даваасүрэн гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын 80 дугаар тогтоол Зөвлөлдөх санал асуулга явуулах

тухай шийдвэр гарсан. Энэ шийдвэрт Үндсэн хуульд өөрчлөлт оруулах зөвлөх санал асуулга явуул гэж шийдвэр гараагүй байхгүй юу. Нийгэмд тулгамдсан асуудал юу байна. Тэр асуудлаар зөвлөлдөх санаачилга явуул гэж гарсан. 80 дугаар тогтоол ерөөсөө яг ингэж байгаа.

Тийм учраас нэгдүгээрт Үндсэн хуульд өөрчлөлт оруул гэж гаргаагүй ээ. Тулгамдсан асуудал юу байна. Түүнийг гаргаж ир. Тэгээд энэ асуудлаар санал асуулга явуул гэсэн юм. Нэг дэх нь.

Хоёр дахь асуудал нь, энэ Зөвлөлдөх зөвлөл бол зөвлөмж л гаргана. Тэр зөвлөлдөх санал асуулгаа зохион байгуулаад, хоёр үе шаттай зохион байгуулаад хуулийн дагуу тэгээд л зөвлөмж гаргана. Тэр зөвлөмж нь Их Хурал, Засгийн газар, хаана байдаг юм гээд зөвлөмжөө гаргана. Энэ зөвлөмжийн асуудлыг дараа нь Их Хурал мэдээж яах вэ Их Хурал л дараа нь шийдэх асуудал.

Тэгэхээр Зөвлөлдөх санал асуулгын хууль бол иргэдээсээ иргэдийнхээ оролцоотойгоор л тэдний саналыг авч шийдвэр гаргах түвшиндээ авч байгаа ийм л үе шат. Түүнээс энэ юм шийдэж байгаа, томоохон асуудлыг шийдэж байгаа ийм үе шат гэж би ойлгохгүй байгаа.

Ард түмний санал асуулга бол шал өөр ойлголт. Тэртээ тэргүй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулиар шийддэг хоёр л гарц байна. Эсвэл Их Хурал шийддэг. Эсвэл ард түмнээрээ шийдүүлдэг ийм л хоёр гарц бий.

Монгол Ардын намын бүлэг. Ц.Даваасүрэн гишүүн түрүүн асуугаад байна. Ард түмэн, сонгогчид дэмжиж байгаа тийм асуудлыг л бид Үндсэн

хуулийн өөрчлөлт хийнэ л гэж ийм л байр суурьтай байгаа. Энэ дээрээ ч одоо ч байж л байгаа. Иргэдийн дэмжлэггүйгээр Үндсэн хуулийн өөрчлөлт өөрөө явдаггүй.

Тийм учраас иргэний дэмжлэгтэй л Үндсэн хуулиа өөрчилж ярих ёстой гэдэг энэ байр суурь хэвээрээ байгаа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн дагуу явж байгаа асуудал юм байна гэж ингэж ойлголоо.

Тэгэхдээ энэ дээр мордохын хазгай гэдэг шиг юм болох гээд байна. Бүрэлдэхүүнээс нь эхлээд. Сая Улсын Их Хурлын гишүүд хэлж байна. Эмэгтэйчүүдийн төлөөлөл алга гээд. Энэ үнэн шүү дээ. Зөв. Монголчуудын хүн амын 52 хувь нь эмэгтэйчүүд.

Тэгээд бид тэр зохион байгуулаад санал асуулга, хураалт явах юм бол тусад нь ялгаж байгаад санал асуулгад Их Хурлын квот, орон нутгийн сонгуулийн квот хүртэл 20 хувиар квот тавьж байгаад хүмүүсээ оруулж болдог шүү дээ. Энэ зарчмаар явбал яасан юм бэ.

Хоёрдугаарт, бүр болохгүй бол энэ Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль дээрээ энэ эмэгтэйчүүд нь санал оруулаад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл оруулаад ир л дээ.

Тэгээд тэр квотынх нь журмыг квотлоод дахиад хэлчихээд л явъя. Бид шаардлагатай хуулийг хэлэлцээд хурдан шийдвэр гаргахаараа Үндсэн хуулийн асуудал хүртэл 6 минутад шийдэгддэг гээд ингээд асуудал яригддаг шүү дээ.

Тэгэхээр ийм байдлаар явсан нь зөв байх гэж ингэж бодож байна. Энэ квотын төлөөлөлгүй яваад, тэгээд энэ асуудлаа хэрвээ ард нь гаръя гэж байгаа бол эмэгтэйчүүдийн маш том эсэргүүцэлтэй тулахаар шинжтэй байна.

Тэгэхээр энэ асуудлаа шийдэж явсан нь дээр байх. Жендэрийн тухай нөгөө хууль ч яалаа. Тийм ээ.

Тэгээд өмнө нь энэ Зөвлөлдөх зөвлөл, Зөвлөлдөх санал асуулга гээд энэ юм чинь яг ний нуугүй хэлэхэд 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлт дээр нэр хүндээ барчихсан. Ямар юм зохион байгууллаа. Очоод хэдэн бүх төлөөллийг оролцуулахгүйгээр төрийн албан хаагчид голцуу, намын төлөөлөл голцуу хүмүүс оруулж байгаад ингээд санал асуулга нэртэй юм зохион байгуулаад явуулсан. Үүнийг одоо болтол хүмүүс шүүмжилдэг.

Сая бид Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар яалаа даа. Бүгдээрээ долоо хоног бүгдээрээ томилолт аваад орон нутагт ажилласан шүү дээ. Маш их эсэргүүцэлтэй саналууд хэлсэн. Дээрээс нь тэр өмнөх зөвлөлдөх санал асуулгын асуудал чинь бантан болсон шүү гэдгийг маш олон хүн хэлсэн.

Тэгэхээр энэ дээрээ хэдүүлээ нэг консесуст хүрч байж асуудлаа явуулахгүй бол энэ мордохын хазгай гэдэг юм болох вий. Тэгээд ер нь үүнийг хэдүүлээ. Одоо сая Д.Тогтохсүрэн дарга хэлж байна. Ер нь Үндсэн хуулийн өөрчлөлт рүү л юмнууд явж байгаа. Тэрийг бол бид мэдэж байгаа. Дээрээс нь яах вэ, тулгамдсан асуудлууд гэдэг халхавч л байх.

Тэгэхээр энэ дээр ард нийтийн санал асуулга руугаа одоо явсан нь зөв

байх. Одоо ард түмэн бүх юман дээр маш их одоо тийм хүлээлттэй, маш их уур ундууцал ихтэй байна.

Тэгэхээр энэ үед нь тэр хүмүүсийн саналыг авч асуудлыг шийдэхгүй бол болохгүй байх.

Хоёрдугаарт, нэг асуудал нь энэ өмнөх Үндсэн хуулийн явуулсан зөвлөлдөх санал асуулгад яг гар бие оролцож байсан хүн энэ дотор байгаа юу? Тийм хүмүүс байвал одоо больсон нь дээр шүү гэдгийг бас.../минут дуусав/

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Эмэгтэйчүүдийн квот л яриад байна. Журамд нь квот гэж байхгүй. Нэр дэвших нь бол чөлөөтэй. Тэгээд л ингээд л олонхоороо шийдсэн.

Мэдээж олон санал ирсэн байсан. Гэхдээ нөгөө 11-тээ л багтаагүй л болохоос биш. Тийм. Тэгээд нууц санал хураачихсан юмыг чинь нууц санал хураалтын дараа эмэгтэй орсонгүй, Доржийг болиулья гэж хэлэх ямар ч аргагүй байхгүй юу.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Ц.Туваан гишүүний урд талын Зөвлөлдөх санал асуулга яаж явагдсан талаар ямар ч оролцоогүй. Оролцох ч боломжгүй байсан.

Юу болж өнгөрснийг мэдэхгүй байна. Ингэж худлаа таамгаар хөдөө явж амтай хүнтэй уулзахад ингээд бантан болсон гэдэг яриа болж байна гэж худлаа ярьж болохгүй.

Энэ хууль нь гараад үүнийг чинь зүгээр тэр хэдэн хурлын төлөөлөгч юм уу, хэдэн намын төлөөлөгч хийгээгүй юм. Статистикийн газраас гаргасан аргачлалын дагуу ёстой тохиолдлын аргаар, ёстой янз бүрийн давхарга, бүлэг, нас, сонирхлын бүлгүүдийн оролцсон тийм шинжлэх ухааны үндэстэй аргачлал байдаг юм билээ. Тэр дагуу л сонгосон улсууд саналаа өгсөн. Түүнээс урьд нь ийм санал асуулга болох гэж байна гэж явсан, уулзсан юмнууд дээр янз бүрийн уур амьсгал байсан. Үнэн. Яг саналаа өгсөн, эцсийн сэдэв гаргасан хүмүүс нь тэр тусгай аргаар намын оролцоогүй сонгож авсан хүмүүс байхгүй юу.

Тэгээд мэдээж бид ардчилсан нийгэмд амьдарч байгаа улсууд янз бүрийн санал бодолтой байна. Хүлээн зөвшөөрөхөөс өөр арга байхгүй. Тэр нэг хэсэг хүмүүсийнх нь юмыг хэлээд тэр ажил бүхэлдээ бантан болсон гэж ярьж болохгүй. Тэгвэл одоо энэ явах гэж байгаа ажил чинь ч гэсэн бантан болох гэж байна л гэсэн юм л ярина шүү дээ.

Зүгээр үүний хамгийн том цаад дэвсгэр нь юу вэ гэхээр бид төлөөллийн ардчиллын зарчмын дагуу сонгогдоод үйл ажиллагаа явуулж байгаа Улсын Их Хурал.

Нөгөө талд нь нөгөө шууд ардчилал гээд бас нэг ойлголт, зарчим байж байгаа. Энэ рүү ингээд улс орнууд алхам алхмаар чадах нь түрүүчийн алхмууд хийгээд явж байгаа юм билээ. Үүний завсрын нэг алхам нь энэ “зөвлөлдөх ардчилал” гээд нэг юм.

Тэр зөвлөлдөх ардчиллыг хэрэгжүүлж байгаа цөөхөн ч гэсэн оронд ер нь хууль гаргаад хэрэгжүүлээд зарим нь оролдож явж байгаа улсуудын нэг нь Монгол. Ийм хууль гарсан. Үүний дагуу

хууль 2016 онд гарсан уу, 2017 онд үүнийг зохион байгуулаад, тэгээд энэ гарсан сэдвүүдээр санал аваад ард түмний дэмжлэг аваагүй саналууд нь бүгдээрээ унасан.

Үүнийг нь цаашдаа үргэлжлүүлж явуулж, дахиад хоёр шатныхаа санал асуултад орж болох юм. Улсын Их Хуралд орж шийдүүлж болох юм гэсэн саналууд нь үлдсэн. Тэр дагуу Их Хуралд ороод зарим нь бас дахиад үлдчихсэн. Ингээд бүгдээрээ бүх асуултууд яваагүй. Үлдсэн дотроос нь Их Хурал шүүж байгаад сүүлд Ерөнхийлөгч хорьдог гэсээр байгаад 2019 оны нэмэлт, өөрчлөлт гарсан.

Тэгэхээр үүнийг бүр зүгээр огт утга учиргүй зохион байгуулалт муутай, зөвхөн одоо нэг нам ч юм уу, хэсэг хүмүүс зохион байгуулаад явчихсан гэж хэлэхэд бас хэцүү шүү. Ц.Туваан гишүүн маань үүнийг та бас ойлгоорой.

Одоо энэ удаа ч гэсэн адилхан. Сэдэв гарна. Түүрүн 6 том сэдвээр дотроо хоёроос гурван асуултуудтай ийм юмнууд яваад тэгээд сэдвүүдээс нь ч хасагдсан, асуултуудаас нь ч хасагдсан юм бий.

Одоо ч гэсэн ингээд энэ зөвлөл зохион байгуулаад сэдэв юмнууд гараад ирэхэд тэр дагуу асуултууд явагдаад, тэгээд ард түмний тэр сонгогдсон хүмүүсийн шалгуурыг давахгүй бол тэгээд л тэр асуудлууд тэндээ зогсоод зогсоод л явна.

Тэр уначихсан асуудлуудыг нь оруулж ирэх боломж байхгүй. Тэрийг нь харин унасныг нь унаснаар нь, дэмжигдсэнийг дэмжигдсэнээр нь гаргах ажил нь энэ Зөвлөлдөх зөвлөлийн маш

том ажлын нэг хэсэг байгаа юм гэдгийг л хэлье.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Асуулт, үг бүгд ингээд явчихлаа.

Тэгэхээр ер нь ардчилалын үнэт зүйл, ардчиллын хүсэл тэмүүлэл бол ард иргэдэд бид ард түмэн гэдэг үзэл бодлоо илэрхийлэх дуу хоолой, эрх чөлөөг өгдөг энэ үнэн зүйл нь байдаг.

Тэгээд үүндээ бид бүх ард иргэдийг оролцуулна гэж боддог. Бүх ард иргэдийн дуу хоолойг сонсох ёстой гэж боддог.

Тэгэхээр дуу хоолойг нь сонсохдоо тухайн асуудлаар ард иргэдийг бас мэдлэг мэдээлэлтэй, суурь мэдээлэлтэй, тэнцвэртэй мэдээлэлтэй байх ёстой гэж үздэг.

Ардчиллын өнөөдрийн тэр хүндрэл нь бүх ард иргэдийг бүгдийг нь мэдээлэлжүүлээд бүгдийг нь оролцуулаад асуудал шийдэх арга зам, бололцоо алга байна.

Шууд ардчилал гэдэг зүйл бол дэлхийд төлөвшиж тогтоогүй. Референдумаар шийдэж байгаа асуудлууд дандаа эсрэг үр дүнтэй гардаг. Хүндрэлтэй асуудлуудын шийдэл гарч болж чадахгүй байна гэж ардчиллын онолд үздэг болсон.

Тийм учраас энэ ард түмнийхээ фокус группийн судалгаа шиг ард түмнийхээ санал бодол, дуу хоолойг нийгмийн бүх мэргэжил, сонирхол, бүлгийг төлөөлж чадахуйц их олонлогоос бага олонлогийг бүрдүүлж, их ард түмнээс бага ард түмнийг төлөөлж чадахуйц тэр малчдын 300 малчин байгаа

бол нийт сонгогчдын 10 хувь бол яг тэрийг нь нас хүйсээр нь төлөөлөөд ингээд дуу хоолойг нь сонсож, том фокус группийн судалгаа ард түмнээ сонсох бол огт буруу зүйл биш.

Үүнийг бол манай ардчиллын үнэт зүйлийг ойлгодог хүн болгон дэмжинэ гэж итгэж байна.

Ер нь өнөөдрийн Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа нь ардчилал.

Төлөөллийн ардчиллыг хэдийгээр хүлээн зөвшөөрөхгүй үгүйсгэх хандлага байдаг боловч энэ нь өнөөдөр хүн төрөлхтний бодож олсон хамгийн сайн засаглалын хэлбэр хэвээрээ байна.

Ардчилал төгс төгөлдөр зүйл биш боловч үүнээс илүү сайн засаглалын хэлбэрийг хүн төрөлхтөн бодож олж чадаагүй байна.

Ийм учраас ард түмэнтэйгээ уулзаж, зөвлөлдөхөөс ухрах арга байхгүй.

Харин тэгэхдээ өнөөдрийн энэ бүх гишүүд бараг хэлж байгаа энэ үзэл бодлыг эхнээсээ мордохын хазгай гэдэг юм уу санал зөрөлдөөнтэй хүлээн зөвшөөрөгдөх **ЛЕГИТИМ**_[хууль ёсны, хуульчлагдсан] чанар алдагдахгүй байхын тулд энэ төлөөллийн зарчмыг хангаж, ер нь болж өгвөл бид консенсусаар энэ зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнээ баталбал их сайн байгаа юм.

Ийм учраас ажлын хэсгийн дарга Д.Тогтохсүрэн даргатай би зөвлөлдөөд энэ асуудлыг түр завсарлуулж эргэж хэлэлцээд. Манай зөвлөлдөх зөвлөлийнхөн маань ч гэсэн үүнийг гүнээ ухамсарлан ойлгоод. Энэ бас

эмэгтэйчүүдийн төлөөлөл, олон өнгө төлөөлөл байх энэ зарчмыг үндэслэл болгоод гишүүдийн саналыг хэлж байгаад ингээд бас бид их хүлээцтэй, ухаалаг ийм нийгмийн зөвшилцлийг, үндэсний зөвшилцлийг хангах гэж байгаа гэсэн үнэт зүйл зарчимдаа үнэнч байгаад тэгээд Зөвлөлдөх зөвлөл маань нэг ярилцаад, ажлын хэсэг маань ярилцаад тогтоолын төслөө дахиж оруулж ирэхийг хүсэж байна.

Ингээд энэ асуудлыг санал хурааж хойшлуулах уу? Ингээд Байнгын хороо өнөөдөр дахиж хуралдаад өнөөдөртэй асуудлыг шийдье. Консенсусаар шийдье. Ойлголцол зөвшилцөлд хүрье.

Ийм учраас санал хураалт явуулъя. Санал хураалтаар тэгээд буцаах санал хураалтыг дэгийн тухай хуулиар оруулж болно. Тийм ээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93.3-т заасны дагуу нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно гэж заасны дагуу Байнгын хороонд буцаачихъя.

Ер нь энэ хувийн хэвшлийн төлөөлөл, танхим. Д.Ганбат гишүүн ээ,

тайван бай, та. Тайван амгалан байцгаа. Энэ асуудлыг эрүүл саруулаар ярьж хэлэлцгээе.

Тэгээд Байнгын хороон дээр та орж сайн яриарай.

Ингээд байнгын хороонд буцаая гэсэн горимын саналаар санал хураалт явуулах уу? Ингээд би ийм горимын санал гаргаж байна.

Дэгийн тухай хуулийн 93.3-т заасны дагуу Байнгын хороонд буцаах горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдье. Гишүүд тайван байгаарай.

Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

73.5 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, Байнгын хороонд Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг буцааж байна.

Байнгын хороо энэ цаг хугацааны шаардлагыг харгалзаж үзээд өнөөдөр хуралдаад.

Дараагийн асуудалдаа оръё.

Тав. “Орхоны хөндийд хот байгуулах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2023.01.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэн яаралтай, хэлэлцэх эсэх/

“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвгийн Амарбаясгалан танилцуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвгийн Амарбаясгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны тогтоолын төсөл нэн яаралтай хэлэлцүүлэх тухай Улсын Их Хурлын даргын 02 дугаар захирамжийн дагуу төслийн хэлэлцэх эсэх асуудлыг өргөн барьж байна.

Монгол Улсын 2021 оны хүн амын статистикийн мэдээллээс үзэхэд хотжилтын түвшин нь хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хурдацтай нэмэгдэж 72 хувьд хүрч, өнөөгийн байдлаар нийслэл Улаанбаатар хотод манай улсын хүн амын 50 орчим хувь нь төвлөрч, төрийн байгууллагууд 100 хувь, их, дээд сургуулиудын 90 хувь нь, худалдаа, үйлчилгээний 86 хувь нь, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна.

Тиймээс хүн амыг нутаг дэвсгэрээ тэнцвэртэй нутагшуулан суурьшуулах, нийслэл Улаанбаатар хотоос бусад хот сууринг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн гэж Засгийн газрын зүгээс үзсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024

оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хавсралт 3.7.5-д Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 дүгээр хавсралтад 3.6.6-д хүн амын нутагшил, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийх зорилтуудыг тус тус дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2015 онд “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030”-ийг баталж, ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих буюу хот суурин газруудыг нийт иргэдэд зориулж аюулгүй, даван туулах чадвар сайтай, тогтвортой болгох тухай 11 дүгээр зорилтыг дэвшүүлсэн билээ.

Энэхүү агуулгад тусгагдсаны дагуу хотжилтыг тогтвортой хөгжлийн зорилтуудын харилцан уялдах боломж хэлбэрээр хангах, хөгжлийн багаж, хөдөлгөгч хүч болгохын үүднээс 2016 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага Хабитат III их хурлаас баталсан хотжилтын шинэ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд гишүүн улс орнуудын Засгийн газрууд анхаарч, хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Монголчууд бид уламжлалт нүүдэлчин ахуй соёлтой ард түмэн учраас эх газрын эрс тэс уур амьсгалтай, уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагт хүн амыг нутагшуулж, суурин газрыг хөгжүүлж ирсэн түүх нь дэлхийн

бусад орнуудаас өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг.

Судлаачдын судалж ирүүлснээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Хүннү гүрний буюу манай эриний өмнөх III зууны үеэс XX зууны эхэн үе хүртэлх хугацаанд хамаарагдах 300 гаруй хот суурин дурсгалыг бүртгэн тэмдэглэсэн байна.

XIII зууны Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотыг байгуулсан үеэс тал нутаг, суурин газрын соёл нэвтэрч эхэлсэн бөгөөд түүнээс хойш нийгмийн хөгжлийн үе шатуудад үндэсний уламжлал, баялаг, өв соёлдоо түшиглэн тухайн нөхцөл байдалтай уялдсан архитектур, хот байгуулалтыг хөгжүүлж ирсэн түүхтэй.

XX зууны дунд үеэс Монгол Улсад аж үйлдвэрийн шинэ салбаруудыг хөгжүүлснээр хүн амын суурин амьдрал, хотжилт руу хурдацтай шилжих үеэ эхэлж орчин үеийн хот, тосгоныг олноор байгуулсан.

Өнөөдрийн байдлаар нийслэл Улаанбаатар хотод манай улсын хүн амын 50 орчим хувь нь төвлөрч, төрийн байгууллагууд нь 100 хувьтай, их, дээд сургуулиуд нь 90 хувьтай, худалдаа, үйлчилгээний 86 хувь, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж байна.

Дэлхийн улс орнуудын хэмжээнд сүүлийн жилүүдэд иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг тэгшитгэх, хэт төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах зорилгоор хүн ам хэт төвлөрсөн томоохон нийслэл

хотуудыг бүхэлд нь болон хэсэгчилсэн нүүлгэх төр захиргааны байгууллагуудыг байршлыг шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, улсын нийслэл хотоо нүүлгэн шилжүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улс, Малайз Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бразил Улс зэрэг гадаад орнуудын туршлагаас үзэхэд хуучин нийслэл дэх хэт төвлөрөл тодорхой хэмжээнд буурсан, хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит үр нөлөө үзүүлсэн жишээ байна.

Барилга, хот байгуулалтын яамнаас Орхоны хөндий орчимд хот байгуулалтын судалгааг үе шаттай хийж ирсэн бөгөөд 2005 онд шинэ хотын байршлыг урьдчилсан байдлаар тогтоох судалгаа, 2006 онд нийслэлийн баримжаатай жишиг хотын экологи, хот байгуулалтын үнэлгээ, 2009 онд Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, 2012 онд Хангайн бүсийн тулгуур төв, Хархорин хотын ирээдүйн төлөв, архитектур, хот төлөвлөлт, судалгааны ажил, 2022 онд Орхоны хөндийд шинэ хот суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг тус тус боловсруулсан.

Мөн Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын техник туслалцааны хүрээнд Барилга, хот байгуулалтын яам болон Үндэсний хөгжлийн газартай хамтран 2019-2021 онд хэрэгжүүлсэн Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах төслийн тайланд нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлтийг оновчтой болгох, шинэ нийслэл хотыг Хангайн бүсийн тулгуур

төв, Хархорин хот, эсвэл улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт байрлуулах саналыг дэвшүүлсэн байна.

Түүхэн ач холбогдлын хувьд Орхон голын сав нутагт Орхоны хөндийн газар нь нүүдлийн соёл иргэншлийн газар зүйн гол зангилаа нутаг төдийгүй байгаль дэлхийтэй энгийн арга хэлбэрээр зохицон амьдарч байгааг харуулсан нүүдлийн ахуйг өдгөө ч хадгалсаар байгаа газар нутгийн төлөөлөл юм.

Үүний зэрэгцээ хүн төрөлхтний нэн эртний түүхийг гэрчлэх чулуун зэвсгийн үеийн дурсгал газрууд болон нүүдэлчдийн анхны төрт улс үүссэн эртний нүүдэлчдийн төрт улсууд үе залгамжлан оршин тогтнож, өрнө дорнын харилцааны түүхэн төв болж байсныг гэрчлэх археологи, архитектурын дурсгалуудыг өнөөг хүртэл хадгалж ирсэн газар нутаг.

Мөн Их эзэн Чингис хааны үндэслэн байгуулсан Монголын эзэнт гүрний нийслэл Хархорин хот, Монгол дахь бурхан шашны бэлгэ тэмдэг болсон Эрдэнэзуу, Төвхөн, Шанхын хүрээ зэрэг олон хот, суурин газруудыг байгуулж байсан түүхтэй өлгий нутаг юм.

2004 онд ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвд Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг бүртгэн авсан байдаг.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагад үндэслэн дэлхийн жишигт хүрсэн тогтвортой, ногоон, ухаалаг шинэ Хархорум хотыг байгуулан хөгжүүлэх зорилгоор Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т хотыг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах бүрэн эрхийг Улсын Их Хуралд хэрэгжүүлэхээр заасны дагуу Орхоны

хөндийд хот байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилгод нийцүүлэн хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоог бүрдүүлэх, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндий шинэ Хархорум хотыг байгуулахаар тогтоож, Орхоны хөндийд шинэ хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоон холбогдох хууль тогтоомжийн дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, шинэ Хархорум хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төсөвлөн үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгах, мөн тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо тус тус даалгахаар тусган боловсруулсан болно.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Жамъянгийн Мөнхбат танилцуулна.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны тогтоолын төсөлд нэн яаралтай хэлэлцүүлэх тухай Улсын Их Хурлын даргын 02 дугаар захирамжийн дагуу төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын 2021 оны хүн амын статистик мэдээллээс үзэхэд хотжилтын түвшин нь хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хурдацтай нэмэгдэж 72 хувьд хүрч, өнөөгийн байдлаар нийслэл Улаанбаатар хотод манай хүн амын 50 орчим хувь нь төвлөрч, төрийн байгууллагууд 100 хувь, их, дээд сургуулиудын 90 хувь, худалдаа, үйлчилгээний 86 хувь, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна.

Тиймээс хүн амыг нутаг дэвсгэртээ тэнцвэртэй нутагшуулан суурьшуулах, нийслэл Улаанбаатар хотоос бусад хот сууринг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Түүнчлэн хүн амын нутагшил, суурьшил, бүс нутаг, хот байгуулалтын тэнцвэрт хөгжлийг бий болгох Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотыг дэлхий дахинд шинээр таниулж, соёл, аялал жуулчлалыг хөгжүүлэх, улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг

татаж, шинжлэх ухаан, технологи, инновацид тулгуурласан ажлын байрыг бүс, орон нутагт шинээр бий болгох, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ Хархорум хот байгуулахаар төлөвлөж, Орхоны хөндийн нутаг дэвсгэрийг байршлын хувьд аялал жуулчлалын бүс нутаг бөгөөд газар зүй, түүхэн дурсгалын цогц нутаг тул шинэ нийслэл болоход тохиромжтой гэж үзэж Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Тогтоолын төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын **D-Parliament.mn** цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн шинэ Хархорум хот байгуулахтай холбогдуулан хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг нэн яаралтай боловсруулах, шаардагдах төсвийг 2023 оны улсын төсвөөс гаргаж шийдвэрлүүлэх арга хэмжээг нэн тэргүүнд авах талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд эртний Хархорум хотын үүсэл, түүхэн эх сурвалжийг оновчтой тогтоож, үндэслэлтэй тайлбарлах, харьцуулж хэрэглэх, хожим нь хотын түүхийн асуудлаар маргаан гарахаас сэргийлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Хархорум хотыг сэргээн байгуулах тухай 230 дугаар зарлиг гарсан талаар дурдаад Их эзэн Чингис хааны үндэслэн байгуулсан Монголын эзэнт гүрний

нийслэл хот Хархорум хот, Орхон голын хөндий нь нүүдэлчдийн анхны төрт улс болох Хүннү гүрний нийслэл Луут хот, Сяньби, Жужан буюу Их Нирун Улсын тахилын байгууламж болох талын 3 хэрэм, Түрэгийн хаант улсын Билгэ хааны онгон, Уйгарын хаант улсын Хар балгас, Тахай балгас болон Их Монгол Улсын нийслэл Хархорум хот зэрэг хот байгууллауд сүндэрлэж байсан манай улсын түүх, соёл, төрт ёсны голомт нутаг байсан тул Хархорум хотыг үндэсний түүх, соёлын уламжлалыг хадгалж, олон улсын менежментэд нийцүүлэн хот ололтыг бүсчлэн хувааж, зам тээвэр, цахилгаан дулааны асуудал, орчин үеийн эко системийг нэвтрүүлэх, түүх соёлын үнэт олдворуудыг түшиглэсэн түүхэн соёл, аялал жуулчлалыг шинэ инновацад тулгуурлан хөгжүүлэхэд анхаарч, улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн дагуу бүтээх нь зүйтэй хэмээн саналуудыг тус тус илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашзэвгийн Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт Чулуунбаатарын Дондогмаа, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хот байгуулалтын хэлтсийн дарга Батсүхийн Одбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Дагвадоржийн Бэлэгсайхан, Нийслэлийн хот төлөвлөлт, судалгааны институт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн ерөнхий менежер Тулгаагийн Ганзориг.

Хууль санаачлагч илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү.

Буланы Бейсен гишүүнээр тасаллаа. Хавдисламын Бадельхан гишүүн асуулт асууна.

Х.Баделхан: Баярлалаа. Их чухал тогтоолын төсөл оруулж ирж байгаа юм байна. Дэмжиж байгаа. Ер нь энэ тогтоолыг бид аль эрт ярьсан бол бүр сайн байсан.

Өнөөдөр ер нь Улаанбаатар хотод хүн багтахаа байсан. Энэ түгжрэлийн асуудал, утааны асуудлыг бид шийдэх боломжгүй гэдгээ сүүлийн 20, 30 жилд авсан арга хэмжээний үр дүнг харуулж байна.

Тийм учраас бид шинээр хот байгуулж байж бид энэ асуудлыг шийднэ. Шийдэх шийдэхдээ би Хархорум хотыг ер нь Монгол Улсын нийслэл болгох нь

зүйтэй. Цаашдаа. Ингэж бодоод төлөвлөх нь зүйтэй гэсэн би бодолтой байгаа.

Өнөөдөр Улаанбаатар хотод. Ер нь дэлхийн хэмжээгээр хотжилтын процесс явагдаж байгаа. Өнөөдөр манай улсын нийт хүн амын 50 орчим хувь нь Улаанбаатар хотод байгаа. Хүн сайн сайхан амьдрахын төлөө эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ авахын тулд ингээд хот бараадаж байгаа юм. Энэ үзэгдэл цаашдаа ч гэсэн явагдана.

Тийм учраас Улаанбаатар хотын түгжрэл, утааны асуудлаа шийдэхийн тулд бид энэ Хархорум хотыг байгуулах нь маш зүйтэй санал байна гэж дэмжиж байгаа.

Энэ Хархорум бол ерөөсөө хамгийн гол нь энэ бол түүхэн дурсгалтай газар. Монгол Улсын эзэнт гүрний нийслэл. Хамгийн гол нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт байрлалтай. Мөн Мянганы зам дагуу байрласан байрлалтай. Маш оновчтой газар учраас энэ дээр ер нь цаашдаа Хархорум хотыг Монгол Улсын нийслэл хот болгохоор орчин үеийн хот байгуулах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна.

Ер нь хот байгуулахын тулд эхлээд эрүүгийн төлөвлөгөө гаргаад хамгийн гол асуудал бол тэр инженерийн дэд бүтцийн асуудлаа шийдэх ёстой. Дулаан, цахилгаан, тээвэр, зам бүх асуудлаа.

Тийм учраас үүний төлөвлөлтийг маш сайн хийх хэрэгтэй. Сая Д.Амарбаясгалан сайд хэллээ. Жинхэнэ орчин үеийн эко ногоон хот болгоно гэж. Энэ саналыг бүрэн дэмжиж байна. Асуулт бол хоёр асуулт байгаа.

Нэгдүгээрт, энэ Улаанбаатар хотод яг төлөвлөсөн норм ёсоор хэчнээн хүн амьдрах ёстой юм бэ? Өнөөдөр хэчнээн хүн амьдарч байгаа. Нэг.

Хоёрт, тэр шинээр байгуулах гэж байгаа шинэ Хархорум хотыг одоо ер нь яг урьдчилан төлөвлөсөн байдлаар ямар хэмжээний хот болох юм? Хэчнээн хэмжээний хүн ам суурьшихаар хот байлгах аар ер нь төлөвлөж байгаа юм бэ гэсэн ийм нэг хоёр асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 83. Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Х.Бадалхан сайдын асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам. С.Магнайсүрэн.

Би хоёр дахь асуултад нь хариулчихъя. Эхний асуултад нь манай хотынхон хариулъя.

Хархорумтой холбоотой энэ Орхоны хөндийд хот байгуулахтай холбоотой асуудлаар Барилга, хот байгуулалтын яам мөн Боловсрол, шинжлэх ухааны яам хэд хэдэн удаагийн судалгаанууд хийлгэсэн.

Ингээд өнөөдөр Хархорум хот Хангайн бүсийн тулгуур төв хот гэж ингэж явж байгаа. Ингээд 2022 буюу энэ онд Барилга, хот байгуулалтын яамнаас 400 орчим сая төгрөг зарцуулаад Нийслэлийн хот байгуулалт, зураг төслийн хүрээлэн, Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнтэй гэрээ байгуулаад хот байгуулах асуудлын эхний ээлжид хот байгуулах байршлын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж танилцуулах ийм гэрээ хийгээд ажиллаж байгаа. Одоо үндсэндээ

тайланг нь аваад манай холбогдох мэргэжлийн зөвлөл болоод Шинжлэх ухаан, технологийн зөвлөл бүтцийн нэгжүүдээр оруулж эцэслэн батлах асуудлууд хийгдэхээр хүлээгдэж байна.

3 сарын 01-н гэхэд бид энэ бүх асуудлыг шийдэж байршлаа эцэслэн тогтох энэ асуудлаа шийдэхээр ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар гурван байршилд санал орж ирсэн байж байгаа. Манай ажлын даалгаварт гурваас доошгүй байршлыг судалж танилцуул гэсэн ийм хувилбаруудаар үүрэг даалгавар өгөгдсөн.

Ингээд нэгдүгээр хувилбар нь Тоглохын тал гэж энэ нутагт 40.4 мянган га газар. Хоёрдугаар хувилбар нь Өгий нуур орчимд 168.6 мянган га. Гуравдугаар хувилбар нь Онгоцон хөндий гээд энэ Хархорумын зүүн хэсэгт 41.4 мянган га.

Ингээд нийтдээ бүгдийг нь нийлүүлээд 250.5 мянган га ийм байршлууд одоо эхний ээлжид бид нарт санал болгоод судлагдаад ингээд ороод ирсэн байж байгаа.

Эхний асуултад Б.Одбаатар хариулна.

Г.Занданшатар: 82.

Б.Одбаатар: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар Б.Одбаатар Х.Баделхан гишүүний асуултад хариулья.

Улаанбаатар хотод өнөөдрийн байдлаар 1.4 сая хүн амьдарч байгаа. 2020 оны Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголоор 1.5

сая хүн хүртэл амьдрах боломжтой байхаар ингэж батлагдсан.

Өмнө нь 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө одоо ингээд боловсруулагдаж байгаа. Энэ ерөнхий төлөвлөгөөгөөр ойролцоогоор 1.7 сая хүний багтаамжтай байхаар. Мөн хаяа дагуул шинэ хотуудыг байгуулж үүн дээрээ нэлээн ачааллуудыг нэмж Шинэ Зуунмод хот буюу Хөшигийн хөндий, мөн Багануур, Налайх гэх мэт хаяа дагуул хотуудыг илүү хөгжүүлж, зарим бүсүүдийг энд гаргах гэсэн төлөвлөлттэй явж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ тодорхой асуултууд байна. Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр Орхоны хөндийд хот байгуулах тухай гээд орчихсон. Энэ шинэ Хархорум хотын тухай асуудал яригдаж байна уу, шинэ нийслэлийн тухай асуудал яригдаж байна уу? Энэ дээр тодорхой хариулт арья.

Монгол Улсын хүн амын 50 хувь нь суурьшиж байгаа гээд танилцуулгад явж байгаа энэ олон хүн амын асуудал.

Тэгээд дээрээс нь ёстой монголчуудын бүх хүмүүсийн эрх ашиг хөндөгдөх энэ асуудлыг чинь харин саяын тэр Зөвлөлдөх санал асуулга гэдэг шиг ийм юм даа үүнийгээ оруулахгүй юм уу? Энэ чинь одоо бүх хүний л эрх ашиг, бүх бизнесмэн, хувийн хэвшлийнхэн, ард иргэдийн амьдралтай холбоотой асуудлууд энэ дээр хөндөгдөнө шүү дээ.

Тэгэхээр хамгийн түрүүнд үүнийгээ шинэ нийслэл үү? Эсвэл шинэ Хархорум уу гэдгийг тодорхой хариулт авмаар байна.

Тэгээд бид хэд бас энэ санал гарч ирээд энэ дээр судалгааг ер нь яаж хийсэн юм бэ? Тухайлах юм бол яг энэ нийслэл хотыг бүслэн оршиж байгаа нийслэл хотын хүнсний хангамж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хангаж байгаа манай Төв аймагчуудын хувьд бол энэ нэлээн төлөвлөлтийг хийгээд, хөрөнгө оруулалт хийгээд, бизнесээ төлөвлөөд ингээд төлөвлөлт хийж байгаа.

Тэгэхээр энэ Төв аймгийнхнаас санал авсан юм байна уу?

Дээрээс нь Улаанбаатар хотоос баруун тийшээ 360 километрт нүүх юм байна. Шинэ нийслэл маань.

Тэгэхээр нөгөө тийшээгээ алсарч байгаа хүмүүсийн асуудлууд нь ер нь яаж орж байгаа юм. Зүүн 3 аймаг, говийн аймаг, энэ хойд талын бүсийн хүмүүсийн асуудал яаж орж байгаа юм. Энэ дээр ямар судалгаа хийж энэ асуудлыг оруулж ирж байгаа юм бэ гэдэг тодорхой асуултыг асууя.

Нийслэл гэж ороод байна шүү. Сая Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын үгэнд хүртэл шинэ нийслэл гэж ороод байна шүү.

Тэгэхээр харин үзэл баримтлал дээр чинь ч гэсэн бас тийм үг орсон байна шүү. Тэрийг хараарай.

Тэгээд хэдэн хүнтэй, ямар хэмжээтэй, ямар хот байгуулахаар төлөвлөж байгаа юм бэ? Энэ шинэ Хархорум, шинэ нийслэл хот маань. Тэгээд энэ хөрөнгө нь энэ төлөвлөж байгаа яг энэ хотод чинь хэдий хэмжээний хөрөнгө орж энэ хот босох юм бэ? Дэд бүтэц нь яах юм, зам харгуй нь

яах юм? Бодвол нийслэл юм чинь төмөр зам энэ тэр гээд юм орох байх.

Тэгэхээр үүний хөрөнгийн эх үүсвэрийг ер нь хэд гэж тооцоолж байгаа. Тэгээд яаж босгохоор тооцож байгаа юм? Бид Дарханы 220 километр зам дээр сая юу болов оо. Одоо хотоо тойруулаад ярьчихсан байгаа энэ Майдар, шинэ Зуунмод. Энэ хотууд өнөөдөр яг ямар шатандаа явж байна? Хөрөнгө мөнгөнийх нь асуудал хүнд л байгаа шүү дээ. Тэгэхэд чинь тэр шинэ, бүр нийслэлийн хэмжээнд яригдах хэмжээний хотын хөрөнгө оруулалтын асуудлаа ер нь яаж шийдсэн юм? Төсөв ямар байгаа билээ. Дээрээс нь гаднын хөрөнгө оруулалт ямар байгаа билээ, мөнгө ер нь ямар байгаа билээ.

Бид энэ хүнсний хангамж, аюулгүй байдлаа ярья гээд 100 хувь 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр хангая гэхэд хүртэл нэг их наядын зээл олдохгүй байгаа шүү дээ. Яг бодитойгоороо.

Тэгэхээр энэ дээр ийм ийм хүндрэлүүдийг ер нь яаж тооцсон юм бэ? Ямар судалгаан дээр энэ асуудлаа шийд гаргаад өнөөдөр энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл оруулж ирж байна.

Ажлын хэсгээс тов тодорхой хариулт авъя.

Г.Занданшатар: 83. Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга хариулья.

С.Магнайсүрэн: Ц.Туваан гишүүний асуултад хариулья.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлд бид шинэ Хархорум хотыг Орхоны хөндийд байгуулах тухай

ийм асуудал концепц оруулж ирсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн чиглэл болгосон зарлиг бас ийм агуулгаар гарсан байж байгаа.

Тэгэхээр энэ дээр нийслэл биш энэ шинэ Хархорум хотыг эхэлж байгуулах энэ асуудлыг Улсын Их Хурлаар Хот байгуулалтын тухай хуульд заасны дагуу шийдүүлэхээр ингэж орж ирж байгаа.

Судалгааг Барилга, хот байгуулалтын яам болоод хуучнаар Үндэсний хөгжлийн газар, мөн Боловсрол, шинжлэх ухааны яам хэд хэдэн удаа хийгдсэн.

Ер нь Хангайн бүсийн тулгуур төв Хархорум нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2004 онд боловсруулаад 2005 онд Засгийн газрын тогтоолоор баталсан байгаа. Энэ ерөнхий төлөвлөгөөний үйлчлэх хугацаа ер нь 20 жил байдаг гэдэг утгаараа одоо тодотгох цаг нь болчихсон. 2025 онд шинэчилж тодотгох ийм шаардлага бас тулсан байж байгаа.

Шинэ хотын байршлыг урьдчилсан байдлаар тогтоосон судалгааг 2005 онд холбогдох яамд, Шинжлэх ухааны академи, орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл судалсан байдаг. Тэгээд 2006 онд энэ судалсан юу бол арай боломжгүй байна гэсэн ийм дүгнэлт гарсан байдаг.

Ингээд одоо бид нийслэлийн Хот байгуулалт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнтэй гэрээ байгуулаад Орхоны хөндийд хот байгуулах байршлын ТЭЗҮ-г эхлээд оруулж ирэх ийм даалгаврын дагуу гэрээ байгуулж ажиллуулаад, тэгээд өнөөдөр энэ ажлын тайлан манай яам дээр тавигдаад холбогдох мэргэжлийн зөвлөлүүд,

Шинжлэх ухаан, технологийн зөвлөлүүдээр хэлэлцэгдэх бэлтгэл ажлыг хангаад ингээд байж байгаа.

Хотын тухайд одоо бид ингээд Улсын Их Хурлаас хот байгуулах шийдвэр гаргасан тохиолдолд бид нэгдүгээрт энэ ТЭЗҮ-г боловсруулна. Хот байгуулах ТЭЗҮ боловсруулна. Ингэж хот байгуулах ТЭЗҮ боловсруулахын өмнө саяын орж ирсэн энэ байршлуудаас сонгоод аль байршил дээр хэчнээн га газар дээр хийгдэх юм гэдэг энэ шийдлээ гаргах ёстой.

Ингэж шийдэхийн тулд тухайн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Засгийн газар дээр шийдвэрлээд авсан одоо тэр байршил бүхий газар дээрээ ТЭЗҮ боловсруулах ийм ажлыг 2023 оны улсын төсвийн зураг төсөлд ТЭЗҮ-г боловсруулах хөрөнгө оруулалтын хүрээнд оруулж батлуулахаар бид тооцоолоод ажиллаж байгаа.

Энэ ТЭЗҮ гарсны дараа хот байгуулахад ямар хэмжээний хөрөнгө оруулалт орох вэ, ямар хэмжээний дэд бүтцүүд, хангамжууд тавигдах вэ, хэдэн хүн амтай хот байх ёстой вэ гээд энэ бүх зүйлүүд тодорхой болж ингэж орж ирэх үед илүү тодорхой мэдээлэл өгөх боломж бүрдэх юм.

Өнөөдөр Майдар хот, шинэ Зуунмод хот гээд өмнө нь гаргасан шийдлүүдийн дагуу эхний ээлжид шинэ Зуунмод хоттой холбоотой инженерийн дэд бүтцийн хангамжийн ажлууд хийгдэж байгаа. Бүх төрлийн зураг төслүүд хийгдээд дууссан.

2023 оны төсөвт инженерийн эхний ээлжийн хангамжийн байгууламжуудыг байгуулахаар улсын

төсвийн хөрөнгө оруулалтууд шийдэгдсэн байж байгаа. Энэ ажлууд хийгдэхээр хүлээгдэж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Ц.Туваан гишүүн 1 минут тодруулья.

Ц.Туваан: Тэгээд “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын үзэл баримтлал гэсэн юман дээр би шинэ нийслэл гэж хоёр, гурван газар уншаад байх юм.

Сая Төрийн байгуулалтын байнгын хорооны гаргасан Ж.Мөнхбат даргын уншсан дотор мөн шинэ нийслэл гэдэг үг би сонсоод сууж байх юм.

Тэгэхээр энэ цаас дээрээ бас яаж оруулсан юм бэ? Үүнээс бас нэлээн асуудал яригдаад байна.

Хоёрдугаарт, Г.Занданшатар дарга аа, энэ шинэ нийслэл ч бай, шинэ хот ч бай энэ чинь одоо ийм жижиг асуудал юм уу? Оруулж ирж байгаа сайд, Байнгын хорооны дарга нар нь байж энэ асуудлаа ярьдаггүй юм уу? Энэ чинь Монгол Улсын бараг хүн амын 70, 80 хувийнх нь эрх ашиг хөндөгдөх гэж байгаа ийм асуудал яригдаж бана шүү дээ.

Тэгэхээр ийм бүрэлдэхүүнтэй ийм ажлын хэсэгтэй ингээд энэ асуудал одоо хэлэлцэгдээд явж байгаад би хувьдаа гайхаж байна. Бараг түрүүн тэр Д.Тогтохсүрэн дарга хэлээд байсан зөвлөлдөх санал асуудал.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ. Байнгын хороон дарга хариулна. Байнгын хороон дарга Жамъянгийн Мөнхбат гишүүн асуултад хариулья.

Ж.Мөнхбат: Ц.Туваан гишүүний Засгийн газрын оруулж ирсэн төсөл дээр ч болон Байнгын хорооны санал, дүгнэлт дээр ч шинэ нийслэл гэсэн юм бол байхгүй.

Ерөнхийлөгчийн гаргасан зарлиг дээр ч байхгүй, энд түүхэн дурсгалын цогц нутаг тул шинэ хот барихад тохиромжтой гэсэн ийм л асуудлууд ингээд яригдсан.

Тэгээд Ерөнхийлөгч зарлиг гаргаж, тэгээд дээрээс нь Монгол Улсын Засгийн газрын зүгээс ийм шинэ хот барья. Түүхэн аялал жуулчлалын ийм хот барья л гэсэн. Ц.Туваан гишүүн ээ, ийм л зүйл яригдаж байгаа юм л даа.

Ер нь төвлөрлийг сааруулья, түгжрэлийг бууруулья. Ер нь Орхон голын хөндий бол эртнээсээ Хүннүгийн нийслэл, Сяньби, Жүжан, Нируны хот балгад байсан. Түрэг, Уйгар, Их Монгол Улс. Дөнгөж Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг.../минут дуусав/

Г.Занданшатар: Жамъянгийн Мөнхбат гишүүн гүйцээж хариулья. Байнгын хороон дарга.

Ж.Мөнхбат: Орхоны хөндийгөөс 40, 50-хан километр зайтай Дашинчилэнгийн Киданы хар балгас гээд ийм Монголын төрт улсуудын гал голомт байсан энэ нутагт л шинэ хот байгуулья л гэсэн ийм асуудал.

Тэгээд энэ аялал жуулчлал, түүх соёлын ийм эко шинэ хот болох юм.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн нэр татлаа. Эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат асуулт асууна.

Д.Ганбат: Бид нарын энэ хэлэлцэж байгаа асуудал яг ийм хоолой тулсан ийм чухал асуудал мөн билүү, үгүй бил үү. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт юу байна шүү. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд сая энэ танилцуулгыг хийлээ. Тэгээд энэ хүн маань одоо юу юу. Нөгөө нам, засгаа хамтран барьж байгаа юу, эсвэл нөгөө хууль хуульдаа нийцүүлээд нэг ажлаа өгчихсөн байгаа юу? Одоо харагдахгүй байх юм.

Тэгээд энэ нэг ажил дээрээ тогтож ажиллахгүй бол манай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ч гэсэн энэ давхар дээлтэй, тэгээд нөгөө Үндсэн хуулийн цэцийн нь хууль тогтоогоод, ингээд ийм гажуудлууд явчихсан.

Ийм алдаа завхарлаа засахгүй бол энэ өнөөдрийн Улсын Их Хурал ч гэсэн энэ хуралдаж байгаа байр байдал, энэ Засгийн газрын оруулж ирж байгаа асуудлууд ч гэсэн зүгээр л ард түмний бодол саналыг нэг төөрүүлэх, цаг хугацаа хожих гэсэн ийм зүйл нуугдаад байна.

Өмнө нь бас нөгөө Майдар хот маань хаана байна аа? Өмнө байсан нөгөө Хөшигийн хөндийд Аэросити ч билүү, юу ч билээ. Тэр хотууд хаана байна аа? Дархан, Эрдэнэтээ бид өөд татаж чадал уу? Улаанбаатар хотоо бид өөд нь татаад чадсан уу? Энэ чинь одоо хүхэртийн хөндий болчихоод байна аа. Энд ажиллаж байгаа хүмүүсийн хариуцлагаас л шалтгаална шүү дээ.

Ахиад л нөгөө сайхан эрүүл сайхан хөндий тэр Орхон готыг бас бузарлах. Тэндээс мөнгө төгрөг цавчих

ийм л хулгайнхаа юмыг хийх гээд байна уу, яах гээд байна. Та нар.

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо тэр Үндсэн хуулийнхаа алдаа завхралыг засах тэр ажлыг хийхийнхээ оронд юун шинэ хот вэ.

Нэг л Чингис хааны музей энэ тэр юм барьсан улсууд. Тэр нь ашиг орлогоо хэзээ өгөх ч юм. Ард түмний амьдрал ахуйг яаж дээшлүүлээд байгаа юм. Бүү мэд. Энд тэндгүй хөшөө дурсгал хийчихсэн. Тэр нь ч гүйцэд болсон юм алга.

Өнөөдрийн хүнд хэцүү нөхцөлд ийм юм яриад байх нь зүгээр л ингэдэг л дээ. Ард түмнийг улам ядуу байлгаад л, урд талын XII зууны өмнө сайхан амьдарч байсан тэр амьдралыг нь санагалзуулаад л. Тэгж төөрүүлдэг.

Өмнө нь байсан урдах түүхээр нь хүмүүсийг хуурахаас биш өнөөдрийн амьдралыг сайхан болгох гэсэн ийм бодол байдаггүй юм. Яг л тэр юмыг давхцуулж хийгээд байна л даа.

Нүүх үү, суух уу. Хархорум хотыг ийм болгохгүй гэдэг асуудлыг ярьж байсан. Энэ ард түмнээсээ санал асуулга аваач ээ.

Тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ ч гэсэн ард түмний санал асуулгыг аваагүй ээ. Тэрийг нөхөж, хамтруулж хийх ёстой.

Тэгээд дарга даамлууд өөртөө зориулж хууль баталчхаад өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн гэдэг албыг давхцуулж хийгээд. Ингэж болохгүй ээ. Иж бүрнээр нь янзлаад бид 2024 оноос л эхэлж

мөрдөх нь зүйтэй. Тэрийг бол дэмжиж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо яагаад тийм юмаа хийдэггүй юм. Хаа хамаагүй ийм юм руу халтираад явж байдаг.

Энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нь хаачив. Тэр намаа ямар нэгэн луйврын аргаар ялуулъя гээд явж байна уу.

Тэр Орхоны хөндийд амьдарч байсан Чингис хааны алтан ургийнхныг энэ Монгол Ардын Хувьсгалт Нам, манжууд бүгд хядсан шүү дээ. Тэрийг тогтоосон уу? Юу болсон.

Нөгөө өмнө нь байсан Хархорум хотын суурийг иж бүрнээр нь ухаж чадсан уу? Тэгээгүй байж л дээр нь баахан мөнгө төгрөг нэмнэ. Ээлжит нөгөө хулгайнхаа юмыг л бэлдээд байх юм. Одоо энд чинь хэн итгэх юм бэ? Өмнө нь байгаа хоолойд тулсан асуудлаа шийд ээ.

Энэ эмнэлгээр чинь дүүрэн хүүхдүүд хэвтэж байна. Ард түмний амьдрал маш хүнд байна. Маш хэцүү байна. Энэ нүүрсний хулгайчдаа янзалъя. ЖДҮ-гээ янзалъя. Хөгжлийн банкны хулгайчтай янзалъя. Энэ баялаг бүтээгчдээ дарамтлахаа больё. Та нар энэ төрөөр дамжуулж луйвар, хулгай хийдгээ боль оо.

Г.Занданшатар: Жамъянгийн Мөнхбат гишүүн. Байнгын хороон дарга хариулья.

Ж.Мөнхбат: Энэ уг нь хэлэлцэх эсэх дээрээ төсөл санаачлагч хариулах ёстой байгаа юм л даа. Засгийн газар. Хоёрдугаар хэлэлцүүлэг дээр Байнгын хороо хариулах ёстой.

Тэгээд Д.Ганбат гишүүн ээ, энэ Төрийн байгуулалтын байнгын хороо бол Засгийн газраас өргөн барьсан асуудлыг л хэлэлцэж байгаа юм.

Тийм учраас энэ Байнгын хорооны одоо юу гэдэг юм, тийм юмыг нь хэлэлцэнэ, ийм юм нь хэлэлцэхгүй гэдэг асуудал байхгүй. Өргөн барьсан асуудлыг нь л хэлэлцэж байгаа ийм асуудал байгаа гэдгийг хэлье.

Хоттой холбоотой асуудлыг бол олон жил ярьсан ийм асуудал юм билээ. Зөвхөн энэ жил бид яриад байгаа биш. 2001 онд Монгол Улсын Их Хурлаас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлахдаа энэ үзэл баримтлал, Орхон голын хөндийд Хангайн бүсийн тулгуур төвийг 2020 он гэхэд барина гэдэг ийм асуудал орсон байдаг. Их Хурлаар бид 20 гаруй жилийн өмнө батлагдсан байдаг. “Алсын хараа-2050” дээр бид энэ асуудлыг Хангайн бүсийн тулгуур төв ийм шинэ аялал жуулал, түүх соёлын хот барина гэдэг асуудлыг оруулсан байдаг.

2020 оны Улсын Их Хурлаар баталсан 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр бид бас баталчихсан байдаг. Энэ дагуу 10, 20 жил ажлын хэсэг гараад ажилласан байдаг. Ийм л асуудал юм билээ.

Тэгээд энэ асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж, Засгийн газарт чиглэл өгч, энэ дагуу Засгийн газар тогтоолын төсөл боловруулж асуудлыг Улсын Их Хуралд өргөн барьсан.

Төрийн байгуулалтын байнгын хороо бол энэ Засгийн газраас өргөн барьсан асуудлыг чиг үүргийнхээ хувьд л

бид авч хэлэлцэж, одоо энэ асуудлыг нэгдсэн чуулганд оруулж ирж байгаа юм.

Энэ бол 20 гаруй жил яригдсан ийм асуудал юм билээ.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Дашдондогийн Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Баярлалаа. Би сая Засгийн газраас би асуулт асуусан юмсан. Тэгээд яасан намынхаа ажил хийгээд явчихсан юм уу, яасан юм. Энэ дээр байлгаж байх ёстой шүү дээ.

Би ард түмнийхээ элчийн хувьд, би ард түмнийхээ эрх ашгийн үүднээс ард түмний дуу хоолой болоод энд асуулт асууж байна. Хариулт өгөх үүрэгтэй шүү дээ. Та нар.

Тэгээд тийм болохгүй болохоор л энэ ард түмэн энэ талбай дээр гарч ирээд байгаа шүү дээ. Цээжээ нүцгэлээд байгаа шүү дээ. Тэрийг яасан ойлгодоггүй улс вэ.

Тэгээд иймэрхүү маягаар л ард түмэнд, ард түмний элчид ингэж хандаж байна шүү дээ. Би ер нь хувийн юм та нараас юу ч гуйхгүй, юу ч ярих ч үгүй, надад тийм шаардлага байх ч үгүй. Би ард түмний өмнөөс л дуугарна. Ард түмний дуу хоолой болно. Одоо цаашдаа бол бүр сайн ажиллая гэж бодож байгаа шүү би ер нь.

Тэр археологийнхоо юмыг янзалсан юм уу? Урьд урьд өмнө хийсэн хотууд чинь юу болсон. Баахан цавчаа болсон. Тэрний хариултыг өгч байгаа юм та нар алга байна шүү дээ.

Г.Занданшатар: Үг хэлж байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Хархорины хөндийд шинэ хот байгуулахаар нэлээн эртнээс яригдаж ирсэн. Асуудлыг дэмжиж байгаа.

Сая хууль санаачлагчийн хэлсэнчлэн түүх, соёлын нэлээн тийм сайхан. Ер нь бол эдийн засгийн шинэ полис бүс бий болно.

Ер нь бид бүсчилсэн хөгжлийн дагуу энэ Улаанбаатар хотынхоо төвлөрлийг ер нь сааруулъя гэсэн ийм бодлогыг барьж байгаа шүү дээ. Энэ зөв бодлого.

Зүгээр эдийн засгийн хүчин чадал өнөөдөр үү, маргааш уу гэдэг асуудал л яригдах байх. Гэхдээ олон жил ярьсан энэ шийдвэрээ гаргаад явах нь зүйтэй гэж харж байгаа.

Хот байгуулалтын чиглэлээр хэдэн асуудлууд л анхаарал татаад байгаа юм л даа. Одоо жишээ нь, миний бие Зам тээвэр, барилга хот байгуулалтын яаманд ажиллаж байхад. Та бүхэн ч бас надтай хамт ажиллаж байсан хүмүүс энэ дотор, ажлын хэсэг дотор байж байх шиг байна.

Бид Нисэхийн хөндийд хот барих гээд хотынхоо газрыг хэдэн ч га билээ, нэлээн хэдэн га газрыг. 100 гаруй га-тай санагдаад байх юм. Тусгай хэрэгцээнд авч байсан. Засгийн газрын тусгай хэрэгцээнд хамгаалалтад авч байсан. Тэгээд хоёр, гурван жилийн дараа тэр газарт нь баахан хүмүүс очоод тэр сумын Засаг даргатай нь ярьж байгаад ингээд газар авчихсан.

Тэгээд дараа нь шүүхдээд. Одоо зарим нь тэнд шүүхийн шийдвэр нь нөгөө талдаа гараад. Өөрөөр хэлбэл тэнд газраа жишээ нь тэр нь миний газар, энэ нь миний газар гээд ингээд тавьж өгөхгүй нэг ийм байдалд орчхоод байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нарын тэр хуулийнхаа дагуу яамныхан яг яаж харж байна? Одоо баг бүрдээд цаана чинь техник, эдийн засгийн үндэслэл энэ тэр ч юм уу, судалгаа ингээд гараад явж байх шиг байна.

Ер нь тэгэх ёстой. Тэгж байж тодорхой хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл гараад. Тэгээд түүнийхээ дагуу хэдэн га-д ямар хэмжээний хот байгуулагдах юм гээд.

Одоо жишээ нь гишүүд асуугаад байх шиг байна. Ер нь хэдий хэмжээний га талбайд байх ёстой юм гэж асууж байх шиг байна. Хэдий хэмжээний хөрөнгө оруулалт орох ёстой юм гэж байх шиг байна.

Тэгэхээр үүнтэйгээ уялдсан техник, эдийн засгийн үндэслэл гаргасан тэр ажлын хэсэг чинь гарах байх. Энэ ажлын хэсгийн үйл ажиллагаан дотор хэдий хэмжээний га талбай ер нь гарах юм байна гэдэг эхний тодорхойлсон том анхан шатны үзүүлэлт байна уу?

Тэр га, талбайтайгаа уялдуулаад хэдий хэмжээний га, талбайг улсын тусгай хамгаалалтад, тусгай хэрэгцээнд авах вэ?

Хоёрдугаарт, энэ тусгай хэрэгцээнд авч байгаа хууль эрх зүй чинь тэгээд яг үндсэндээ болж байгаа юу? Яг нисэхийн хөндийтэй адилхан дахиад нөгөө газраа алдчихаад нэг жилийн дараа, хоёр жилийн дараа баахан шүүхдсэн

асуудалтай болж байгаа юу? Энэ яг юунаас болоод өгчихсөн юм? Тэр хуульд чинь болохгүй байгаад байгаа юм уу? Эсвэл тэр орон нутгийн засаг дарга, дарга нар чинь хуулиа зөрчөөд байгаа юм уу? Яг юу болсон бэ гэдэг дээр нэг тайлбар хэлээдхээч.

Тэгээд үүнийгээ тусгай хэрэгцээнд баталгаатай авч гарч чадах уу, үгүй юу гэдэг талаас нь нэг сайн хараадахаач гээд.

Хоёрдугаарт, төлөвлөлтийн асуудал, устай холбоотой, дэд бүтэцтэй холбоотой асуудлууд, хөрсний шинжилгээтэй холбоотой асуудлууд урьд өмнө нь хот байгуулагдаад явж байсан. Тэнд арай гайгүй болов уу гэж бодож байна.

Гэхдээ тэр байдлаасаа одоо жишээ нь усны хангамжийн асуудлууд нь ямар хэмжээнд байгаа юм. Инженерийн дэд бүтэц талаасаа ямаршуу байдлаар харж байгаа юм? Хот байгуулахад зарим газар өндөрлөг нам гэсэн асуудлууд чинь бас байдаг шүү дээ. Хот байгуулалтын. Та нар бол геодези, судалгаа талаасаа болон харж байгаа байх.

Энэ судалгаа талаасаа эхний гарсан дүгнэлтүүд чинь ямар байгаа вэ гэсэн ийм хоёр дахь асуулт байна.

Ерөнхийдөө эдийн засгийн үндэслэл дээр хэдий хэмжээний төрийн захиргааны байгууллагуудын наад зах нь байгуулах, бий болгох, төрийн үйлчилгээ үзүүлэх барилга байшин, зам харгуй, дэд бүтэц барихад ер нь хэдий хэмжээний хөрөнгө оруулалт ер нь орох ёстой вэ гэсэн нэг тийм төсөөлөл байна уу? Энэ гурван асуултыг хариулж өгөөч. Баярлалаа.

Г.Занданшатар: 83.
С.Магнайсүрэн дарга хариулъя.

С.Магнайсүрэн: Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам. С.Магнайсүрэн.

Эхний асуудал дээр би хариулъя. Ус, хөрс, инженерийн дэд бүтцийн судалгаатай холбоотой асуудлыг манай Хот төлөвлөлт, зураг төслийн хүрээлэнгийн ерөнхий инженер бэлдэж байя.

Хөшигийн хөндийд бид 30 мянган га газрыг, 30 гаруй мянган га газрыг тусгай хэрэгцээнд авсан. Давхцал бол сүүлд бид 19-ийг нэмээд ингээд 30 гаруй хувь болсон. Энэ хооронд бас давхцлууд үүссэн. 2 мянга орчим нэгж талбарын давхцалууд бий болсон.

Бид ажлын хэсэг гарч ажиллаад өөр газраар солих ийм асуудлуудыг нь бас нэлээд дээр нь тохироод. Тэр тохирсон улсуудынх нь өөр газар солих тэр сумуудтай нь яриад, газар зохион байгуулалтынх нь төлөвлөгөөнд суулгах замаар тэр асуудлуудыг нь шийдэж нэгдүгээрт өгч байгаа.

Зарим үл хөдлөх хөрөнгө барьчихсан, гарцаагүй нөхөн төлбөр, олговор шаардаж байгаа ийм хэсэг байна. Үүнийг нь бид бас ялгаж салгаад, ингээд эцсийн байдлаар ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанд оруулж танилцуулна гэж тооцож байгаа.

Бид аль болох хөрөнгө мөнгө, төсвөөс бага гаргах замаар асуудлыг шийдэх нь зүйтэй гэдэг ийм зарчим бариад манай агентлагийн даргаар ахалсан ажлын хэсэг ажиллаж байгаа юм.

Яг үүнтэй холбогдуулаад бид өмнөх туршлагаасаа үзээд өчигдөр Байнгын хороогоор энэ хот байгуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэхэд бас чиглэл болгосон. Бас ийм асуудал гарахаас урьдчилан сэргийлэх дээр цаг алдалгүй анхаарах нь зүйтэй гэдэг ийм чиглэл гараад сая Байнгын хорооны дүгнэлтэд уншигдлаа.

Тэгэхээр бид энэ дээр холбогдох чиглэлүүдийг өгнө. Ер нь сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнүүд батлагддаг. Энэ оны эхээр.

Тэгэхээр энэ дээр бид энэ асуудлыг нь онцгойлон анхаарч энэ асуудлыг шийдэж өгнө гэсэн ийм тооцоотой байгаа. Өнөөдрийн байдлаар бидэнд гурван хэсэг байршил судлаад нийтдээ бид 250.5 мянган га газрыг нийт талбайг нь судлаад энэ дээрээ барилгажих талбай нь 24 мянган га орчим байх бололцоотой юм байна гэсэн ийм урьдчилсан байдлаар байршлуудаа судалж оруулж ирсэн байж байгаа юм.

Тэгээд энэ хэсгүүд дээрээ бид холбогдох таны болгоомжилж байгаа шиг холбогдох арга хэмжээг аваад ингээд яачих бололцоотой гэж ингэж үзэж байгаа юм.

Хөрөнгө оруулалттай холбоотой бусад асуудлуудыг одоо ТЭЗҮ эцэслэн шийдэгдээгүй байгаа учраас бид нарийвчилж хэлж болохгүй байгаа. Эхлээд газраа тогтонгуут тусгай хэрэгцээнд авна. Тусгай хэрэгцээнд авсны дараа тухайн тусгай хэрэгцээнд авсан газар дээрээ хот байгуулах ТЭЗҮ-гээ боловсруулна. Тэгээд ерөнхий төлөвлөгөө. Тэгээд холбогдох эхний шатны зураг төслүүд хийгдээд ингээд

ажлууд үе шаттайгаар явах учраас урьдчилсан байдлаар хөрөнгө оруулалтын асуудлаар тоо хэлж боломжгүй байна.

Ус, хөрстэй холбоотой, ер нь усны тухайд их бололцооны. Хөрсний тухайд өмнө нь хот байгуулж байсан ийм газрууд байдаг.

Ер нь энэ бүсийн нэг онцлог бол ЮНЕСКО-д бүртгэгдсэн 180 мянга орчим га газрын соёлын өвд бүртгэгдсэн ийм дурсгалт газрын 180 мянган га газар байдаг. Энэ га газрууд дээр орохгүйгээр үүнээс залгаж л энэ газруудаа бид судалж, ингэж байршлуудаа судалж оруулж ирж байгаа.

Хуулиар болоод олон улсын нөгөө конвенцоор энэ соёлын өвд бүртгэгдчихсэн ийм газрууд дээр хот байгуулах болоод бусад инженерийн дэд бүтцийн хангамж барих ийм бололцоо нь бас хаагдмал байдаг.

Тийм учраас үүнээс бусад ийм гурван байршил судлагдаж байгаа гэдгийг хэлэх гэсэн юм.

Хоёр дахь асуудал дээр. Ус, хөрсний тухай тодруулаад хэлчих үү.

ЗАВСАРЛАГА

С.Одонтуяа: Үдээс хойш хуралдаанаа эхлүүлье.

Үдээс хойших хуралдаан “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж байсан. Үдээс өмнө. Ингээд үргэлжлүүлээд хэлэлцье.

Г.Занданшатар: 84.

Т.Ганзориг: Хот төлөвлөлт, судалгааны институтийн ерөнхий инженер Т.Ганзориг. Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Хотын байршлыг тогтоох судалгааны ТЭЗҮ-гийн хүрээнд нэгдсэн үнэлгээг гаргасан. Нэгдсэн үнэлгээний газрын суурь нөхцөлийн үнэлгээ, байгаль орчны нэгдсэн үнэлгээ, архитектур, түүх соёл, археологийн дурсгал, ландшафтын нэгдсэн үнэлгээ, дэд бүтцийн нэгдсэн үнэлгээ гэсэн үнэлгээнүүдийг гаргаад ус, хөрсний хувьд тохиромжтой, тэгээд үнэлгээнүүдээ нэн тохиромжтой, тохиромжтой, хязгаарлагдмал, тохиромжгүй, хориглох нөхцөлтэй гэсэн ангиллуудын үндсэн дээр манай сонгосон 24 мянган га талбай тохиромжтой болон хязгаарлагдмал тохиромжтой гэсэн талбайнуудад орж байгаа учраас энэ хот байгуулахад боломжтой гэсэн үзүүлэлтүүд гарсан. Баярлалаа.

Г.Занданшатар: 13.00 цаг болсон учраас 14.00 цаг хүртэл чуулган завсарлалаа. /алх цохив/

Ц.Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Орхоны хөндийд хот байгуулах асуудлаар Их Хурлын тогтоол гаргах юм байна. Тэгээд Ерөнхийлөгчийн зарлиг гарсан. Зарлиг гарах нэг хэрэг. Тэгээд зарлигийг хэрэгжүүлэх чиглэлээр Их Хурал, Засгийн газраас ийм байдалтай асуудалд хандаж болохгүй.

Оруулж ирж байгаа салбарын сайд нь байхгүй. Бүхэл бүтэн хот байгуулагдаж байхад Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам. Ингээд гол гол яамдууд бас байх л ёстой гэж бодож байна.

Яагаад гэхээр энэ чинь цаанаа дандаа төсөв мөнгөтэй холбоотой асуудал яригдана шүү дээ. Тэгээд энэ төсөв мөнгийг хаанаас олох юм. Зүгээр нэг тогтоол гаргаад тэгээд цаасан дээр буулгаад мартчих биш байлгүй дээ. Хамгийн гол нь энэ төсөв мөнгийг нь хаанаас олох юм, ямар эдийн засгийн чадавх, санхүү, мөнгийг хаанаас босгох вэ гэдэг асуудал яригдах учраас асуулт асуувал уг нь энэ сайд нараас нь асуумаар байх юм. Тэгээд одоо дэд сайд, Төрийн нарийны хэмжээнд асуудал яриад ингээд байх юм.

Нөгөө талаар би бас одоо үүнийг ингээд нэг тогтоол гаргаад ингээд хаягдчих вий дээ л гэж эмээж байна. Учир нь 2008 онд бас л Улаанбаатар хотын төвлөрлийг саармагжуулах чиглэлээр Улсын Их Хурлаас Улаанбаатар хотоос их, дээд сургуулиудыг гаргах, нийслэлийн Багануур дүүрэгт оюутны хотхон байгуулах ийм Улсын Их Хурлын тогтоол гарсан шүү дээ. 2008 онд. Одоогоос хэд юм. 15, 16 жилийн өмнө. Тэгээд л энэ Боловсролын сайдын, үе үеийн сайд нарын ширээнд ингээд тоосонд дарагдаад л байж байгаа юм.

Тэр бол бүхэл бүтэн ашиглалтын өмнөх захиргаа байгуулаад, 10, 20 инженер, архитектуруудыг бүрдүүлээд техник, эдийн засгийн үндэслэл хийгээд, нэг тэрбум төгрөгийн техник, эдийн засгийн үндэслэл хийчхээд байж байгаа

шүү дээ. Тэгээд ямар ч ашиглалтгүй, ямар ч хэрэглээгүй ингээд л хаягдсан.

Тэгээд араас нь ахиад л Орхоны хөндийд хот байгуулна гээд. Ахиад л баахан техник, эдийн засгийн үндэслэл гээд хөөцөлдөж байгаа. Ингээд нэг улс төрийн шоу гэдэг юм уу, ингээд нэг асуудал болоод хаягдчих вий дээ. Бид нар чинь одоо ер нь олон л хот байгуулах юм яриад байгаа. Шинэ нисэх онгоцны буудлаа дагасан хот асуудал ярьж байгаа. Тэрний дэд бүтэц ямар байгаа билээ.

Тийм учраас хэрэгждэггүй баахан тогтоолууд гаргаад, баахан уриалга гаргаад ингээд өнгөрөх вий л гэж ингэж эмээгээд болгоомжлоод байна. Ийм байлгахгүйн тулд. Энэ чинь одоо байгуулахын тулд 5, 10 жилийн төлөвлөлт хэрэгтэй байлгүй дээ. Төлөвлөлт. Өнөөдөр Орхоны хөндийд хот байгуулах техник, эдийн үндэслэл байгаа юу? Боловсрогдсон уу? Боловсрогдсон бол ямар хэмжээнд, ямар хүчин чадалтай, ямар дэд бүтэцтэй, ямар хөрөнгө оруулалт шаардлагатай ийм хот байгуулах юм? Үүнийгээ нэг тодорхой хэлж өгөөч.

Хэдэн хүн амтай байх юм? Ингэснээр гарах үр дүн нь Улаанбаатар хотын өнөөдрийн энэ төвлөрөл хэдэн хувиар саарна гэж үзэж байгаа юм? Ямар төрийн байгууллагуудыг төвлөрүүлнэ гэж үзэж байгаа юм? Эдийн засгийн хувьд ямар чадавхтай байх юм? Аялал жуулчлалын хот байх юм уу, банк санхүүгийн хот байх юм уу? Өөр ямар чиглэлийн хот байх юм, ер нь. Ямар эхний байдлаар төлөвлөж байгаа юм? Барилга, хот байгуулалтын яам.

Бидэнд ер нь хот байгуулсан түүх ер нь хэр байгаа билээ? Яг одоо бодлогоор төлөвлөлтөө хийгээд.

Төлөвлөлтөө барьж чаддаг бил үү, үгүй бил үү. Хийсэн төлөвлөлтийн дараагийн нэг Засгийн газар гарч ирээд л ингээд л үгүйсгээд л, шал өөр юм яриад л, ингээд л явчихдаг л байгаа шүү дээ.

Гаргасан бодлогын залгамж чанар, төрийн ажлын залгамж чанар гэж ерөөсөө байхгүй. Нэг Засгийн газар, нэг Их Хурал нь юм санаачилна. Нөгөөдөх нь дараа нь гарч ирсэн засаг, Их Хурал нь үгүйсгээд мартаад л ингээд л хаягдаад л явсаар байгаад энэ төрийн ажлын залгамж чанар чинь.../минут дуусав/

Г.Занданшатар: Дэд сайд Э.Золбоо хариулна. 81.

Э.Золбоо: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж байна. Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Шинэ хот байгуулах. Аливаа хот байгуулахад бид гаднын улс орнуудын туршлагыг нэлээн судалсан. Тэгээд яг энэ хот байгуулалтын барилга бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө цаасан дээр хот байгуулах бэлтгэл ажлыг хангахад үндсэн ажлын бараг 30 хувь нь гэж гаднын улсууд үздэг юм билээ.

Тэгээд нийтдээ хот байгуулахад сүүлийн үеийн туршлагаар үзэхэд 20 орчим жил зарцуулдаг. Тэгээд бэлтгэл ажил нь үүнийгээ аваад үзэх юм таван жил зарцуулдаг гэдгийг Ц.Сандаг-Очир гишүүн ч гэсэн сая хэлж байна.

Тэгээд бид энэ Орхон шинэ Хархорум хотыг байгуулах энэ цаасан дээрх бэлтгэл ажлуудыг л одоо хийгээд явж байгаа. Өнгөрсөн хугацаанд Барилга, хот байгуулалтын яамны зүгээс бид бүхэн хот байгуулах боломжтой байршлын судалгаануудыг хийсэн. Нийтдээ хоёр аймгийн 8 орчим сум дээр

1.8 сая газар нутаг дээр судалгаа хийж байгаад яг хот байгуулах боломжтой юм байна гэдэг дээр 24 мянган га талбай буюу 3 байршлыг сонгочихсон тогтоосон байгаа.

Энэ байршлыг тогтоохын тулд бас нэлээн мэргэжлийн ажлуудыг хийнэ. Байгаль орчны үнэлгээ хийнэ, газрын үнэлгээг хийнэ, бусад дэд бүтцийн үнэлгээ энэ тэр гээд олон үнэлгээнүүдийг хийж байгаад энэ байршлыг оруулж ирж байгаа.

Одоо цаашдаа бид яах вэ гэвэл Улсын Их Хурлын тогтоол гарах юм бол бид бүхэн Засгийн газар дээр энэ байршлаа бүр нарийн тогтоогоод энэ байршлууд дээрээ яг судалгаануудыг нь, инженер, дэд бүтцийн судалгааг хийнэ, ТЭЗҮ боловсруулна, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлуудыг зохион байгуулна.

Энэ дээрээс яг инженер дэд бүтэц буюу дулаан нь яаж шийдэгдэх вэ, цахилгаан нь яаж шийдэгдэх вэ, ямар боломж байна гэдэг дээр энэ байршлууд дээрээ үзээд мөн цаашдаа яг энэ инженер дэд бүтцийн хангамжийн хүрээнд хэдэн хүнтэй хот байгуулагдах вэ гэдэг энэ тооцоо судалгаа нь тэр үед гарч ирнэ.

Энэ хэдэн хүнтэй хот байгуулагдах, хотын үндсэн концепц дээр тулгуурлаад ер нь ТЭЗҮ нь ямар өртөгтэй, ямар санхүүжилт хэрэгтэй вэ гэдэг нарийн асуудлууд гарч ирж байж тухайн цаг үед нь бид бүхэн энэ санхүүжилтийн асуудлаа ярих төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Товчхон хариулахад ийм байна.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

Ц.Сандаг-Очир: Би тэр 2008 онд Улсын Их Хурлаас тогтоол гаргаад Багануур дүүрэгт их дээд сургуулиудын оюутны хотхоныг байгуулах шийдвэр гараад техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн. Тэр хаана байгаа вэ? Барилга, хот байгуулалтын яамныхан мэдэж байгаа юу?

Улсын төсвөөр нэг тэрбум төгрөгийн техник, эдийн засгийн үндэслэл юм хийгдсэн. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дэргэд ашиглалтын өмнөх захиргаа гэж бүхэл бүтэн алба байгуулагдаад төсөв, санхүү аваад цалинжаад ажиллаж байсан. Энэ ажлыг Барилга, хот байгуулалтын яам ер нь цаашдаа ажил болгох юм уу, болохгүй юм уу? Энэ Улаанбаатар хотын түгжрэл чинь хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу?

Бүхэл бүтэн 10 мянган га газар тэнд баталчихсан байгаа шүү дээ. Дүүргийн иргэдийн хурал. ТЭЗҮ хийчхээд байгаа. Тэгээд ийм дэд бүтэцтэй, инженерийн шугам сүлжээтэй, цахилгаан холбоотой, ус дулаантай ийм газар хот байгуулах, өргөжүүлэх асуудал ярьж байгаа юм. Түүнээс огт хоосон газар дээр юм биш.

Тэгээд энэ дээр та бүхэн цаашдаа ер нь энэ Улаанбаатар хотын төвлөрлийг саармагжуулах хүрээнд ер нь одоо зөв.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Э.Золбоо сайд хариулъя. 81.

Э.Золбоо: Тэгээд 2008 оны оюутны хотхоны асуудлыг яг хот байгуулалт талаасаа биш болохоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам үүнийг хариуцаад явж байгаа юм.

Товчхондоо мэдээлэл өгөхөд ийм байна.

Г.Занданшатар: Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн асуулт асууна.

Ё.Баатарбилэг: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 сарын 20-ны өдрийн зарлигаар Хархорум хотыг шинээр байгуулах энэ зарлигийн дагуу Засгийн газраас “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байна.

Энэ хот байгуулах тогтоолын төслийг дэмжиж байгаа. 1220 онд Чингис хааны зарлигаар Хархорум хотыг анх байгуулж, үүнээс хойш Эзэнт гүрний төв Орхоны хөндийд байсан, Монгол газар нутагт байсан эртний төрт улсуудын нийслэлүүдийн одоо өлгий нутаг болох Орхоны хөндийд шинэ хот байгуулах цаг нь болсон гэж үзэж байгаа.

Үнэхээр энэ Орхоны хөндийд шинэ хот байгуулах асуудал сүүлийн 20 гаруй жил яригдаж байгаа. 2000-аад оноос хойш бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал Улсын Их Хурлаар батлагдсан. Тэр үед зэрэгцүүлээд ер нь Орхоны хөндий, Хархорин хавьцаа шинээр хот байгуулах асуудал маш олон түвшинд эрдэмтэд, судлаачид, мэргэжлийн байгууллагууд, энэ Барилга хот байгуулалтын яам гээд маш олон газрууд дээр ажлын хэсгүүд ажиллаж, судалгааны ажлууд олон жил үргэлжилж хийгдсэн юм билээ.

Тэгэхээр үнэхээр энэ 800 жилийн өмнөх энэ хотыг сэргээж, шинээр байгуулах энэ асуудал өнөөдөр цаг нь болсон гэж үзэж байгаа.

Яах вэ, ЮНЕСКО-гийн соёлын өвийн бүсийн заагаас гадуур. Өнгөрсөн

зун Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын Байнгын хороодын дарга нар, тодорхой Улсын Их Хурлын гишүүд газар дээр нь үзэж, тэр ажлын хэсгийн судалгааны ажлуудтай танилцаж, яг тэр хот байгуулахаар товлож, төлөвлөж байгаа газруудтай нь танилцсан.

Үнэхээр тээвэр, ложистик, аялал жуулчлал, одоо тийм төв болохоор хангайн бүсийн тулгуур төв болж ингэж хөгжиж болохоор ийм хот байгуулахад зохимжтой газар байна. Дээр нь байгаль цаг уур. Дээр нь тэр бүхий л эдийн засгийн үзүүлэлтүүдээрээ энэ газар нутаг боломжтой байна гэдгийг эрдэмтэд, судлаачид, мэргэжлийн байгууллагууд дүгнээд гаргачихсан юм билээ.

Тэгэхээр өнөөдөр энэ дээр Барилга, хот байгуулалтын яам маш сайн ажилласан. Өнгөрсөн хугацаанд. Одоо С.Магнайсүрэн дарга, Э.Золбоо сайд, ажлын хэсгүүд үнэхээр сайн ажилласан. Мэргэжлийн байгууллагууд энэ дээр бүх талаар нь судалгааны ажлууд хийгээд гараад ирсэн.

Одоо бид нарт энэ тогтоол хамгийн гол нь ингээд Их Хурлаас батлагдлаа. Засгийн газарт тодорхой үүрэг чиглэлүүд өгөгдөнө.

Тэгэхээр би ажлын хэсгийнхнээс өнгөрсөн хугацаанд Та бүхэн одоо энэ Их Хурлын тогтоол батлагдаад Засгийн газарт очлоо гэхэд яг цаг хугацааны хувьд та бүхэн яг хэдэн үе шаттай ажлууд явахаар ерөнхий төлөвлөлтүүд явж байна вэ? Хот байгуулах ерөнхий ТЭЗҮ ямар хугацаанд бэлэн болох вэ? Тэр ТЭЗҮ боловсруулах тэр төсөв, санхүүгийнх нь асуудал шийдэгдсэн гэж би ойлгосон.

Тэгээд энэ хот байгуулах ажлууд ямар үе шаттай, ямар хугацаанд

үндсэндээ бид нарын энэ эхний яриад байгаа энэ төлөвлөлтөөр энэ хотын асуудал босож ирэх вэ гэдэг нэг тийм маш тодорхой тийм мэдээллийг одоо энэ асуултын хариулт болгоод энэ олон нийтэд, нийт ард түмэнд бас мэдээлэл өгөөсэй гэж бодож байна. Сая бол зүгээр ерөнхий тойм төлөвлөлтийн юмнууд ярьж байгаа.

Тэгэхээр яг 2000 тэдэн он гэхэд Хархорум хот одооны төлөвлөлтөөрөө 300 мянган хүнтэй хангайн бүсийн тулгуур төв. Дээр нь тээвэр ложистик, аялал жуулчлалын бүс болж ингэж босож ирсэн байх юм гэсэн ийм хэдэн үе шаттай ажлууд явах нь вэ гэдэг дээр тодорхой хариулт авъя.

Г.Занданшатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн асуулт. Хариулт. Уучлаарай. Э.Золбоо. 81. Энхтүвшингийн Золбоо дэд сайд.

Э.Золбоо: Ё.Баатарбилэг гишүүний асуултад хариулъя.

Одоо Улсын Их Хурлын тогтоол гараад Засгийн газарт үүрэг өгөгдөөд энэ шинэ хот байгуулах ажил ингээд албан ёсоор үргэлжлээд явна гэсэн үг. Тэгээд цаашдаа ямар ажлууд хийх вэ гэхээр хамгийн түрүүнд бид бүхэн тухайн байршилд тогтоогдсон оноогдсон байгаа газрыг улсын тусгай хэрэгцээнд авна.

Ингэсний дагуу техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулаад Засгийн газраа батлуулах энэ нь ер нь хамгийн гол ажлууд гэсэн үг.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа тухайн хотын концепцдоо тааруулаад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулаад явна.

Тэгээд бид бүхэн урьд нь хот байгуулж байсан туршлага гэх юм бол хамгийн сүүлд 1980 онд Багануур хотыг байгуулж байсан. Тухайн үед Оросын Холбооны Улсын дэмжлэгтэйгээр хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээд хот байгуулалтууд баригдаад явж байсан.

Энэ удаа бид яг өөрсдөө зохион байгуулж байгаа. Бага зэргийн туршлага байгаа гэж хэлж болно. 2020 оны 05 дугаар сард Улсын Их Хурлын тогтоол гаргаад Хөшигийн хөндийд шинэ хот байгуулах тогтоолын дагуу бид өнгөрсөн хоёр жил хагасын хугацаанд ажилласан.

Энэ өнгөрсөн хоёр жил хагасын хугацаанд ажиллахад газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө боловсруулах энэ ажлуудыг хоёр жилийн хугацаанд багтаад зохион байгуулж чадсан.

Тийм учраас яг энэ туршлага дээрээ үндэслээд танд хариулт болгоод хэлэхэд бид бүхэн Улсын Их Хурлын тогтоолын дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө боловсруулах, ТЭЗҮ-гээ гаргах зэрэг ажлыг яг энэ хурдаараа явах юм бол хоёр жилийн дотор зохион байгуулж чадна гэж бодож байна.

Тэгээд энэ хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсаны дараа яг нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, тоо, санхүүжилтийн тоо баримтууд нь гарч ирнэ. Тэр дээр санхүүжилтээ хэрхэн яаж шийдвэрлэхээс эхлээд энэ хот байгуулалтын хурд нь тодорхойлогдох юм билээ.

Ер нь хотын хамгийн чухал ажил бол нэгдүгээрт төлөвлөлт. Энэ төлөвлөлтөө бид бүхэн зохион байгуулна.

Хоёрдугаарт, санхүүжилт байж л энэ барилга, бүтээн байгуулалтын ажил нь эхлээд. Тэр санхүүжилт хэрхэн яаж шийдэгдэхээс эхлээд л энэ хотын хурд нь тодорхойлогдох юм билээ.

Г.Занданшатар: Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ё.Баатарбилэг: Тийм. Тэгэхээр энэ Орхоны хөндийн шинэ Хархорум хот бол Архангай аймгийн нутаг дэвсгэр дээр энэ бүтээн босголтын ажил явах ийм төлөвлөлттэй явж байгаа юм билээ.

Тэгэхээр яах вэ, зүгээр саяын миний асуугаад байгаа юм. Яах вэ, ТЭЗҮ бол нэг, хоёр жилийн дотор ингээд бүрэн хийгдээд тодорхой ТЭЗҮ боловсрогдоно гэж үзэж байгаа.

Зүгээр та бүхний төлөвлөж байгаагаар ТЭЗҮ боловсруулж байх явцтай хамт одоо нөгөө санхүүжилтийн асуудлуудыг Та бүхэн судалж байгаа юмнууд байна уу? Гадна, дотнын санхүүжилтүүд, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд.

Дээр нь улсын төсөв, энэ байгалийн баялаг гээд маш олон эх үүсвэрүүдээс л төвлөрүүлэх л юм бодох л байх л даа.

Тэгэхдээ шинэ хотын асуудал. Энэ нэг, хоёр байшингийн асуудал биш. Шинэ хот байгуулж байгаа асуудал учраас яг одоогоор Та бүхэн олон улсын байгууллагуудтай гэдэг юм уу, ингээд төлөвлөсөн том хэмжээний төсөл боловсрогдож хийгдэж байгаа юмнууд байна уу?

Г.Занданшатар: Э.Золбоо сайд хариулья. 81.

Э.Золбоо: Яг санхүүжилтийн хувьд энэ Орхоны шинэ хөндийд шинэ хот байгуулах тал дээр гаднын байгууллагуудтай ярьсан юм, эхэлсэн юм бол байхгүй байгаа.

Түрүүн би хэлсэн. Яг энэ санхүүжилтыг гаднын байгууллагуудтай ярихын тулд гаднын байгууллагууд, гаднын улсууд юу гэдэг вэ гэхээр хөгжлийн ерөнхий төлөвлөгөө чинь хаана байна, яг хэдэн хүнтэй хот юм, ямар ямар бүтээн байгуулалтууд явах юм, ТЭЗҮ чинь хаана байна гэдэг асуудлыг тавьдаг.

Тийм учраас дарааллаараа явах ёстой эдгээр асуудлуудыг ТЭЗҮ боловсруулагдсаны дараа яригдаад явна.

Г.Занданшатар: Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн асуултаа асууна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Энэ Улсын Их Хурлын тогтоолоор Орхоны хөндийд хот байгуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байна.

Тэгээд техник, эдийн засгийн үнэлгээ, зураг төсөл, хотын ерөнхий төлөвлөгөө гээд 2023 ондоо эхэлж чадах уу? 2023 онд ер нь улсын төвлөрсөн төсөвт хэдэн төгрөг суусан бэ? 2024, 2025 онд хэдэн төгрөгөөр суулгахаар бэлтгэл ажлыг хангаж байна вэ гэдэг ийм асуулт байж байна.

Хоёр дахь асуудал. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа бид яаралтай явуулах хэрэгтэй байна.

Энэ чинь одоо улсын зэрэглэлтэй хот байх ёстой юм уу? Монгол Улсын

нийслэл одоо хот байх ёстой юм уу гэдэг энэ нэг зааг ялгааг хэлээд өгөөч.

Одоо Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар улсын зэрэглэлтэй болгох хоёр л хотын асуудал яриад байгаа шүү дээ. Дархан, Эрдэнэт гээд. Тэгээд энэ Орхоны хөндийд байгуулах энэ хот маань өөрөө улсын зэрэглэлтэй хот байх ёстой юм уу, яваандаа Монгол Улсын нийслэл шилжиж очих ийм ирээдүйг харсан ийм хот суурин газрууд бий болгох юм уу гэдэг дээр хариулт хэлж өгөөч.

Дээр нь түрүүн Ц.Сандаг-Очир гишүүн бас хэлээд гарах шиг боллоо.

Ингээд Улсын Их Хурлын тогтоолоор олон шийдвэрүүд гардаг. Тэгээд орхигдоод хэрэгждэггүй ийм зүйлүүд зөндөө байж байна. Тухайлбал, одоо юу гэдэг юм “Хэрлэн-тооно” төсөл гээд Хэрлэнгээс одоо юу гэдэг юм Дорноговь аймгийн дамжуулаад Өмнөговь аймаг руу татах усны асуудал одоо бараг 20 гаруй жилийн өмнө тогтоол гарсан. Засгийн газрын шийдвэр гарсан. Одоо хүртэл хэрэгжээгүй. Техник, эдийн засгийн үнэлгээ нь хийгдээгүй хаягдчихдаг.

Тэгээд энэ маань юу хэлэх гээд байна гэхээр энэ төрийн алба чинь өөрөө залгамж халаагүй болчихсон юм биш үү.

Нэг тогтоол гардаг. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт ордог. Улсын Их Хуралд ч гэдэг юм уу, ингээд өөрчлөлт гарахаар гаргасан тогтоолууд маань ингээд хэрэгждэггүй орхигддог ийм зүйлүүд яваад байх юм.

Энэ дээр та хэд ямар байр суурь бодож байгаа вэ? Нэгэнт л гаргасан тогтоол юм чинь үүнийгээ хэрэгжүүлэх

чиглэлээр нэлээн дорвитой ажил зохион байгуулаад явах нь зөв болов уу гэсэн бодолтой байна.

Хот болгох асуудлыг түрүүн би дэмжиж байна гэж хэлсэн.

Ер нь энэ түүх, соёлын эртний энэ нийслэлийг дагалдуулсан Орхоны хөндийн хот зайлшгүй байх ёстой. Монгол Улсыг одоо юу гэдэг юм, гадна дотнын иргэд юу гэдэг юм энэ Хархорум хотоор, Орхоны хөндийд байгаа энэ түүх дурсгалын зүйлээр их сайн мэддэг. Аялал жуулчлал ч нэлээн хөгжих. Соёлын дурсгалт зүйлүүдийг үзэх гэж очих. Аялал жуулчлал бас тодорхой хэмжээгээр нэмэгдэх байх гэсэн ийм бодолтой байж байна. Тэгээд дэмжиж байгаа.

Хамгийн гол нь л энэ тогтоолоо бид хэрэгжүүлээд явах нь их чухал. Нөгөө газрын асуудал байж байна. Газраа бид яаралтай тусгай хэрэгцээнд авахгүй бол нөгөө тогтоол гарчихдаг. Сум, орон нутгийн иргэд маань одоо ингээд газар олголт хийгээд явчих вий.

Одоо юу гэдэг юм энэ газар дээр чинь өвөлжөө, хаваржаа ч гэдэг юм уу, эсвэл тэр айлууд газар аваад байшин барилга барьчихсан ийм зүйлүүд байгаа юу гэдэг дээр ийм асуулт тавья. Баярлалаа.

Г.Занданшатар: 83. Сандагийн Магнайсүрэн. Барилга хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулья. Барилга, хот байгуулалтын яам. С.Магнайсүрэн.

2023 оны төсвийн тухай хуульд зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах багц хөрөнгө

Эдийн засгийн хөгжлийн сайдын багцад туссан байгаа. 40 орчим тэрбум төгрөг суучихсан байж байгаа.

Тэгээд энэ хүрээнд бид Орхоны хөндийд хот байгуулах энэ шийдлийг үндэслээд тэгээд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах хөрөнгийнхөө асуудлыг шийдвэрлүүлэх нь манай яамнаас явах эхний эрэмбийн ээлжийн ийм ажил гэж бид харж байгаа.

Ингээд энэ ТЭЗҮ-гээр үндсэндээ хөрөнгө оруулалт, бусад чиг баримжааны багцаа хэмжээ ер нь их тодорхой болно гэж нэгдүгээрт харж байгаа.

Үүний өмнө бид ойрын хугацаанд энэ гурван сард тогтоож хийх ёстой асуудал бол энэ газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудал. Өөрөөр хэлэх юм бол манай Нийслэлийн хот төлөвлөлт, зураг төслийн хүрээлэнгийн гурван байршлыг судлаад ирсэн 24 мянган га барилгажих талбай, нийт 250 мянган га энэ судлаад ирсэн гурван байршил дээр үзээд тэгээд байршлаа тодорхой болгож нарийвчлангуутаа улсын тусгай хэрэгцээнд ямар хэмжээний аль газрыг авах вэ. Мөн тэнд ямар хэмжээний давхцлууд байна гээд ингээд бусад асуудлуудыг хуулийн хүрээнд судалж шийдвэрлэх бололцоотой.

Өчигдөр Байнгын хороон дээр яригдаж өгөгдсөн нэг чиглэл бол яаралтай энэ чиглэлээр давхцлууд нэмэхгүй байх, чиглэлүүдээ анхаарах гэсэн ийм чиглэл өгөгдсөн. Бид үүнийг ойрын хугацаанд энэ чиглэлийг нэгдүгээрт өгнө.

Хоёрдугаарт, сумын болоод аймгуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнүүд одоо батлагдана. Энэ хүрээнд үүнийг бид урьдчилан сэргийлэх

арга хэмжээ авчих бололцоотой гэж ингэж харж байгаа.

Улсын Их Хурал дээр газрын багц 5 хууль дээр нэмэх нь Хот байгуулалтын тухай хуулийн төсөл нэгдүгээр хэлэлцүүлгийн шатанд хүлээгдэж байгаа. Одоо бид таны хэлсэний дагуу энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулах ажил манай яаман дээр бас явж байгаа юм.

Энэ дээр бид ойрын хугацаанд анхаараад орж ирэх бололцоотой гэж ингэж үзэж байна.

Ер нь өмнө нь гарсан Улсын Их Хурлын шийдвэрүүдийн дагуу ялангуяа хот байгуулалттай холбоотой шийдлүүдийг бид ажил хэрэг болгоод явж байгаа. Жишээлбэл, Шинэ Зуунмод хотыг байгуулах Их Хурлын 2020 оны шийдвэрийн дагуу бид хөгжлийн ерөнхий төлөвийг нь баталсан. Тусгай хэрэгцээнд газрыг нь авсан. Холбогдох инженерийн дэд бүтцийн байгууламжийн зураг төслийн ажлуудыг эхлүүлээд үндсэндээ хийгээд явж байна. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь хийгдсэн байж байгаа. Инженерийн дэд бүтцийн эхний ээлжийн төсөл, арга хэмжээний төсөв нь энэ жил 2023 онд суугаад энэ ажил эхлэхэд бэлэн болсон байх жишээний.

Тийм учраас бид тодорхой хугацаанд энэ ажил руу анхаарч төвлөрч ажиллах ийм бололцоотой байгаа.

Ер нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 20 жилээр төлөвлөдөг. Тэгээд эхний ээлжид бид энэ 2030 он хүртэлх энэ төлөвлөлтүүд дээр нь анхаарч ажиллахаар төлөвлөж байгаа.

“Алсын хараа-2050” нэгдүгээр үе шат буюу 2021-2030 онд Орхоны хөндийд шинэ хотын байршлыг сонгож, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулах, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ийм зорилт туссан. Энэ дагуу бид асуудлаа төлөвлөөд явна гэж ингэж харж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуулт асууна.

Г.Мөнхцэцэг: Орхоны хөндийд шинэ хот байгуулах төсөл яригдаж байна. Тэгээд Орхоны хөндий ер нь монголчуудын төдийгүй Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншлийн асар их өв дурсгалыг хадгалсан ийм гал голомт байсан нутаг. Тийм. Бүс нутаг.

Дэлхийн өвд хоёр, гурав, дөрвөн ийм шаталбарыг давж байж одоо бас энэ соёлын өвд бүртгэсэн. Бүртгэхдээ Ази, Номхон далайн бүс нутгуудын өвд гээд ингээд бүртгээд авсан байгаа. 2004 онд ЮНЕСКО дэлхийн соёлын өв бүс нутгаа гээд ингээд тодорхойлчихсон байж байдаг.

Тэгэхээр үндсэндээ 180 мянган га орчим талбайг хамарч байгаа байх. Тэгээд энэ соёлын өвд бүртгэгдчихсэн энэ газар талбай дээр шинэ суурьшлын бүс байгуулах ч юм уу, хот байгуулах бол хуулиараа мэдээж хориотой.

Тэгэхээр магадгүй шинээр босгох гэж байгаа, энэ бий болгох гэж байгаа хот маань өөрөө хилийн заагаа хэрхэн тодорхойлсон байдаг юм бэ?

Ер нь магадгүй дагаад энэ хуучин 180 мянга га талбайд байгаа энэ соёлын

ховор өв талбай маань устаж үгүй болох, янз бүрийн хөлд талхлагдах гээд ингээд эрсдэлүүд үүсэх магадлал их байгаад байгаа юм.

Тийм учраас энэ талбайгаа хадгалах, хамгаалах тал дээр нь ер нь ямар ажлууд давхар явагдах юм бэ?

Дээр нь шинээр бий болох гэж байгаа нийслэлийн хил хязгаарыг нь хэрхэн тогтоосон юм?

Хот байгуулалтын яам 400 сая төгрөгөөр ТЭЗҮ хийгдээд ингээд явж байгаа юм байна. Энэ ажлууд дотор чинь төв суурьшлынхаа хуучин бүсээ одоо бас хадгалах, хамгаалах талынх нь чиглэлийн юмнууд тусгагдсан уу, үгүй юу?

Ер нь бид хот төлөвлөлтөө хэрхэн хийсэн юм? Энэ шинээр байгуулагдах хот маань хэчнээн хүн амтай байхаар ингээд төсөвлөгдсөн байгаа юм гээд ингээд олон зүйлийн асуултууд байгаад байна. Гэхдээ хамгийн гол нь энэ соёлын өв хадгалагдсан бүс дээр нь, тодорхойлогдсон байгаа энэ бүс нутагт мэдээж шинээр хот байгуулахад эрсдэл их үүснэ. Үүнийг тооцсон тооцоолол байна уу, үгүй юу гэдэг ийм асуултыг тавьж байна.

Г.Занданшатар: 81. Э.Золбоо сайд хариулъя.

Э.Золбоо: Тийм. Өнгөрсөн хугацаанд бид бүхэн хот байгуулах боломжтой байршлуудыг тогтоох чиглэлийн дагуу судалгаа хийгдсэн. Хот байгуулалтын нэгдсэн үнэлгээ хийгдсэн.

Энэ үнэлгээнүүд хийгдэхийн тулд маш олон төрлийн судалгаагаар хийдэг. Газрын суурь нөхцөлийн үнэлгээ, байгаль орчны нэгдсэн үнэлгээ, архитектур, түүх

соёл, археологийн дурсгал, ландшафтын нэгдсэн үнэлгээ, дэд бүтцийн нэгдсэн үнэлгээ гээд.

Тэгээд энэ үнэлгээнүүд дээр тулгуурласан судалгаануудыг хийж байгаад бид бүхэн гурван байршлыг сонгож хот байгуулах боломжтой юм байна гэж үзсэн. Энэ бол нэгдүгээрх нь Өгийнуур сум. Хоёр дахь нь Тоглохын тал. Гуравдугаарх нь, Онгоцон хөндий гэдэг ийм гурван байршлыг сонгосон.

Энэ гурван байршил нийлээд барилгажих боломжтой 24 мянган га юм байна гэж үзсэн.

Тэгээд энэ дээр яг хэдэн хүнтэй хот байгуулах вэ. Яг нөгөө хилийн цэс нь хаагуураа хязгаарлагдах вэ гэдэг нь дараагийн бид нөгөө техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах энэ үе шат дээр гарч ирнэ.

Яагаад энэ үе шат дээр гарч ирж байгаа вэ гэвэл инженер, дэд бүтцийн хангамж, дулаан, цахилгаан, холбоо дохиол, цэвэр ус гэх мэт зүйлүүдийн судалгааг хийж байгаад хэдэн хүнтэй хот болох вэ гэдэг энэ тоо нь гарч ирээд. Энэ тоон дээрээ улбаалаад дараа нь газар нутгийнхаа хилийн цэсийг тодорхойлоод явна.

Энэ гурван байршил дээр таны түрүүний асуусан асуулт буюу одоо түүх, соёлын зүйлүүд байх юм биш биз дээ гэдэг дээр бид бүхэн судалгаа хийсэн. Судалгаа хийсний үндсэн дээр яг тийм нарийвчилсан нарийн тийм археологийн дурсгалтай зүйлүүд энэ гурван байршил 24 мянган га талбай дээр байхгүй байгаа.

Энэний хажууд ЮНЕСКО-гийн 180 мянган га талбай байгаа. Энэ дээр бид ямар нэгэн хот байгуулах, барилга

байгууламж барих энэ ажлыг зохион байгуулах боломжгүй. Зохион байгуулахгүй гэж тооцож байгаа.

Г.Занданшатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн тодруулж асууя. 1 минут.

Г.Мөнхцэцэг: Мэдээж суурь судалгаа, байгаль орчны үнэлгээ гээд олон зүйлүүдийг мэдээж хийсэн байгаа байх.

Байгаль орчны яам ер нь ямар оролцоотой байгаа юм бэ? Энэ 180 мянган га талбайг мэдээж энэ рүү шинэ хот орохгүй. Мэдээж хадгалалт хамгаалалтыг нь сайжруулна гэдэг зүйлийг ярих л байх.

Гэхдээ 180 мянган га талбайн хадгалалт хамгаалалтыг нь ер нь сайжруулах тал дээр харилцан та бүгдээс ярьсан зүйл байна уу, үгүй юу? Тийм ээ. Энэ ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Энэ дээр яригдсан зүйл байна уу, үгүй юу гэдгийг бас нэмээд тодруулчихъя. Байгаль орчны яамнаас хүмүүс байхгүй байх шиг байна. Тийм.

Г.Занданшатар: 83. Сандагийн Магнайсүрэн. Барилга, хот байгуулалтын яам, Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Г.Мөнхцэцэг гишүүний асуултад тодруулж хариулъя. Барилга, хот байгуулалтын яам. С.Магнайсүрэн.

Орчны бүстэйгээ нийлээд 180 мянган га. Нийтдээ 121.9 мянган га энэ соёлын өвд бүртгэгдсэн газар дээр Соёлын өвийг хамгаалах тухай хуулиараа хот байгуулах, энэ бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл

явуулах гээд ингээд хориглосон үйл ажиллагаануудыг нэлээн хатуу нарийн заачихсан ийм хуулийн зохицуулалттай.

Тэгэхээр яг энэ дагуух л энэ 180 мянган га-тай холбоотой. Энэ рүү энэ хот байгуулахтай холбоотой ямар нэгэн үйлдвэрлэл, үйлчилгээ хамааралгүйгээр ингэж байршлуудыг сонгож байгаа.

Ер нь тэр палеонтологи, археологи, бусад тэр олдвор, соёлын дурсгалт зүйл, тэр хамгаалалтын асуудлыг Соёлын өөрийг хамгаалах тухай хуулийн дагуу Соёлын яам бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн. С.Чинзориг гишүүн нэрээ татлаа. Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Чингис хааны анх санаачлан байгуулсан Хархорум хотын буурин дээр Орхоны хөндийд хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоол болон Ерөнхийлөгчийн санаачилгыг дэмжиж байгаа юм.

Тэгэхдээ энэ цаг үеийн байдалтай холбоотой бас бэрхшээл, янз бүрийн шүүмж байдаг л байх. Жил болгон зуд болохгүй л байх. Энд хугацаа. Аль эрт байгуулах ёстой. Дэлхийн түүх, соёлын бас том хот.

Тийм учраас энэ дээр нэлээн анхаарч, ач холбогдол өгөх нь зөв байх гэж бодож байна. Одооноос хот төлөвлөлтөөр дахиад нэг түгжрэл, төвлөрөл ихтэй, утаа ихтэй хот биш. Ер нь хот байгуулалт дээр нь онцгой анхаарахгүй болохгүй.

Казахстан Улс Алматагаас нийслэл Астанад нүүлгэсэн. Гэтэл гадаадын хөрөнгө оруулалт маш их

ирсэн. Энд. Үүнийг бас тэр талын асуудлаар анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, хэд хэдэн их дээд сургууль, орон сууц барьж өгсөн гэх мэт.

Энэ хот байгуулалт дээр нь бас эхний ээлжид анхаарах асуудал их дээд сургууль, дэд бүтэц, сургууль, эмнэлгийн асуудлыг баривал айлууд их очих байх. Нөгөө талаар хот байгуулах сургаар зөндөө айлууд очоод газар авчихаж мэднэ. Энэ дээр бас анхаараад газар ололтын асуудал дээр анхаарахгүй бол сүүлдээ нүүлгэлт дээр дахиад л нэг мөнгө нэхсэн тийм асуудал гарчих вий. Энэ дээр баримталж байгаа бодлого байна уу ер нь.

Нөгөө талаар түүх соёлын дурсгалт газрууд байгаа. Барилга байшингууд байгаа. Үүнийг хамгаалалтад авах. Цааш нь бас шинэчилж, ирээдүйд тийм одоо ирээдүйн нийслэл шүү дээ. Нийслэл гэж болоод эртнээс нь орох нь зөв байх. Ер нь.

Нийслэлээ нүүлгэхэд ер нь буруудах юм байхгүй гэж бодож байна. Энэ хотын түгжрэл ийм байна. Одоо улсын хэмжээнд Дархан, Эрдэнэт, Улаанбаатар гуравхан хоттой байна шүү дээ.

Цаашдаа зөвхөн Орхоны хөндийн хотын асуудал биш. Цаашдаа бид аймгуудын төвд чинь сум статустай байгаа. Аймгуудын төвийг бас хот статустай болгох шаардлагатай байгаа. Яагаад гэвэл сум статустай болохоор газрын маргаан гараад нэлээн асуудал гарч байгаа.

Тийм учраас Монгол Улс гурав, дөрөвхөн хоттой биш. Ер нь 21 аймаг, 21 хот нэлээн олон хоттой болох нь зөв байх гэсэн санал хэлье.

Сая дэд бүтцийн асуудал дээр тухайн айл өрх орон сууц баригдана, их дээд сургууль очно, эмнэлгийн тэр байр, хүнсний үйлдвэрийн асуудал. Тэгээд бас аж ахуйн бусад хэрэгцээт бараа, бүтээгдэхүүний үйлдвэрүүд, үйлдвэрийн бүсийн бас тусдаа байгуулах тал дээр ямар юу баримталж байна?

Ер нь нүүрс, халаалтын асуудал байна. Цаашид энэ газрын асуудал байна шүү дээ. Оросоос ирж байгаа. Тэрийг чинь хүртэл яваандаа татах асуудал дээр анхаарахгүй бол. Турк Улсад бас энэ нүүрс түлж байсан байна. Газ очоод тэгээд одоо утаанаас салсан байна шүү дээ. Энэ тал дээр баримталж байгаа бодлого байна уу? Энэ талаар асууя.

Г.Занданшатар: 81. Дэд сайд Э.Золбоо хариулья.

Э.Золбоо: Б.Бейсен гишүүний асуултад хариулья.

Тухайн бид бүгдийн сонгосон гурван байршил дээр 24 мянган га орчим талбай дээр өнөөдөр хэрвээ Улсын Их Хурлын тогтоол гарах юм бол энэ газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг бид бүхэн зохион байгуулна.

Нөгөө талдаа тухайн байршлууд дээр шинээр газар олголтууд явагдахгүй гэж ойлгож болно. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар яг энэ хотын үндсэн концепцууд гарч ирнэ. Аялал жуулчлалын хот байх юм уу, аялал жуулчлалыг дагнасан хот байх юм уу, эко ногоон хот байх юм уу гэдэг дээр нэлээн олон судалгаануудыг хийж байж энэ концепц нь гарч ирнэ.

Ингэсний дагуу бид бүхэн тэр халаалт нь ямар байх вэ, нарны эрчим хүч хэрэглэх боломжтой байх уу, салхины эрчим хүч хэрэглэх боломжтой байх уу. Мөн газ хэлбэрээр явах уу гэдгийг тухайн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байх энэ цаг үед энэ асуудлууд нэлээн тодорхой болно.

Нэмж хэлэхэд хот байгуулалтын хууль дээр бид бүхэн Улсын Их Хурлын тогтоол гарахад л ер нь энэ газар олголтуудыг зогсоох эрх нь үүсээд зогсоогоод тухайн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулна.

Г.Занданшатар: Буланы Бейсен гишүүн тодруулж асууна.

Б.Бейсен: Энэ ирээдүйн нийслэл болоход Төрийн ордон байх ёстой. Бид нарт.

Төрийн ордон барих, хотын төвд том талбайтай түгжрэлгүй тийм зураг төсөв байна уу? Тийм юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ өндөр хөгжилтэй орнуудын архитекторуудаас зөвлөгөө аваад хамтарч ажиллах талаар бодлого баримталж байгаа юу? Энэ талаар асууя.

Дараа нь Их Хурлын дарга аа, Ж.Мөнхбат дарга. Энэ зүгээр нэг асуудал биш. Энэ дээр ер нь дараа нь Их Хурлын гишүүд ч ач холболдол өгөөд энэ холбогдох яамдын сайдуудыг оролцуулж байгаад нэг хамтарсан юу хийхгүй бол. Энэ зүгээр нэг бичиг цаас болоод үлдчих вий. Энэ талаар та юу бодож байна.

Г.Занданшатар: Э.Золбоо сайд эхлээд. 81. Дэд сайд Э.Золбоо эхлээд хариулья.

Э.Золбоо: Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө яг боловсруулж байж л бид тухайн хот дээр ямар барилга байгууламж байх вэ, тухайн хотын концепц нь ямар байх вэ гэдэг тодорхой болно.

Өнөөдрийн байдлаар бид нарт хийсэн ажил юу вэ гэхээр Орхоны хөндийд шинэ хот байгуулахад яг байршлын хувьд тохиромжтой байршлууд нь юу вэ гэдгийг бид өнгөрсөн хугацаанд тогтоож гаргаж ирж байгаа юм.

Тэгээд энэ байршлаа Улсын Их Хурлын тогтоолоор баталгаажуулж аваад тэгээд дараагийн ажлууд явагдана. Тэр нь нөгөө хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, ТЭЗҮ боловсруулах ажил явагдана.

Энэ дээр бид гаднын бусад улс орнуудын туршлагыг хуваалцах, гаднын улс орнуудтай хамтрах ажлыг зохион байгуулна гэж тооцож байгаа. Жишээлэх юм бол Хөшигийн хөндийд шинэ хот байгуулахад бид бүхэн нэлээн хэдэн гаднын улс орнуудтай хамтарч ажилласан. Солонгос Улс, Сингапур Улс гэх мэт.

Солонгос Улс сүүлийн 20 жилийн хугацаанд шинэ хот байгуулах тал дээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх гишүүн байна уу? Дэмжсэн, дэмжээгүй гурав хүртэл гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүн алга байна.

Жамъянгийн Мөнхбат гишүүнээр тасаллаа. Хоёр гишүүн үг хэлсний дараа, 8 минутын дараа санал хураалт. Асуулт хариултын цаг дуусч санал хураалт

явуулах тул гишүүд чуулганы танхимд цугларч санал хураалтад бэлтгэнэ үү.

С.Чинзориг: “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байна.

Бас бэлэгшээлтэй гэж бодож байна. Манай түүхчдийн хэлж ярьж байгаа энэ судалгааны ажлаас харахад 1220 онд Их эзэн Чингис хаан маань Хархорум хот байгуулах зарлиг гаргаж байсан гэж түүх сударт бичигдсэн байдаг.

Саяхан бас Японы эрдэмтдийн оролцоотойгоор судалгааны ажил хийгдэж бас тэр бичээсийг нь тайлсан ийм үйл явдлууд болсон.

Тэгээд Өгөөдэй хааны үед үндсэндээ энэ Хархорум хот байгуулагдаж дуусаж, үйл ажиллагаагаа явуулж байсан гэсэн ийм түүх сударт тэмдэглэсэн байдаг.

Тийм учраас Монгол Улсын эртний нийслэл болсон энэ Хархорумын хөндийд шинэ Хархорум хот байгуулах энэ тогтоолын төслийг дэмжиж байна.

Гэхдээ цаашдаа бид тогтоол гаргаад орхичхож болохгүй. Их Хурал, Засгийн газраас нэлээн хүчин чармайлт гаргах шаардлагатай гэж бодож байна. Өмнө нь яг ийм чиглэлээр хэд хэдэн Ерөнхийлөгчийн зарлиг ч гарч байсан байдаг. Их Хурлын ч шийдвэр гарч байсан байдаг.

Зарим Ерөнхийлөгч нар Хархорум хотод очиж, суманд очиж шав тавьж байсан. Соёмбот хөшөө босгож байсан ийм үйл явдлууд болж байсан. Ийм үйл явдлууд болж байсан боловч өнөөдрийг хүртэл Хархорим хот байгуулах асуудал

бодитой ажил болж хэрэгжихгүй яваад байгаа юм.

Тийм учраас өмнөх зүйлүүдийн хэлээд байгаа нь энэ шинэ Хархорум хот байгуулах ажил маань өмнөх шигээ ингээд нэг зарлиг гараад, нэг Их Хурлын шийдвэр гараад тэгээд их л бол нэг хөшөөтэй болоод ингээд үлдчихгүй байгаасай. Бодитой тодорхой ажил болоосой гэж бодож хүсэж байгаагаа хэлэхийг хүсэж байна.

Энэ бол багагүй хугацаа шаардана. Багагүй хөрөнгө хүч шаардана.

Тийм учраас манай Барилгын яам, Засгийн газар эхнээс нь энэ хот төлөвлөлтийнхөө ТЭЗҮ-г зөв, үндэслэлтэй хийлгэхээс эхлэх хэрэгтэй байна. Хэчнээн мянган хүний багтаамжтай хот байгуулах юм, инженерийн дэд бүтцийн асуудлыг яаж шийдэх юм.

Тэгээд дээр нь энэ чинь Улаанбаатар хотыг төвлөрлийг бууруулахтай холбоотой асуудал ч бас холбогдоно. Цаашдаа Их Хурал ч гэсэн яаж бодлогын туслалцаа үзүүлэх юм. Магадгүй төрийн байгууллагууд, төрийн институцүүдээс аль нь эхэлж Хархорум хотод байршиж үйл ажиллагаагаа явуулах вэ гээд ингээд маш эртнээс тооцож, судалж байж энэ ТЭЗҮ-г хийх ийм асуудлууд оролцох хэрэгтэй байх.

Магадгүй олон улсын тендер ч зарлаад ТЭЗҮ-г нь хийлгэх асуудал. Цаашдаа хот байгуулах асуудлыг ч гэсэн бас олон улсын тендер зарлаж гүйцэтгүүлэх ийм асуудлууд ч байхыг үгүйсгэхгүй гэж бодож байна.

Тийм учраас эхнээс нь хугацаатай, төлөвлөгөөтэй, судалгаатай, энэ ажлыг

бодит ажил болгоосой гэж найдаж байгаа гэдгийг хэлье.

Хамгийн чухал нь газрыг эхний ээлжинд байршлаа тогтоод газрыг нь улсын тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг маш эрт шийдэх хэрэгтэй. Тэгэхгүй бол өмнөх гашуун туршлага байна. Ингээд Ерөнхийлөгчийн зарлигаар Их Хурлын шийдвэр гараад үүнийг тусгай харилцаанд авах асуудлыг газрыг нь богино хугацаанд шийдэхгүй бол бас одоо нөгөө хувийн хэвшлийнхэн, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд баахан газар авчихсан. Дараа нь үүнийг нь буцааж авах хэцүү. Буцааж авчхаад байхгүй байх хэцүү. Ингээд маш одоо тийм олон жил зарцуулсан маргааны асуудал руу явчих вий гэсэн ийм болгоомжлол байгаа юм.

Тийм учраас энэ нэлээн одоо бас тийм судалгаатай, тооцоотой, шинжлэх ухааны үндэстэй ийм юмнууд хийх болов уу гэж бодож байна.

Их Хурлаас байгуулагдсан Д.Тогтохсүрэн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг хоёр жил нэлээн сайн ажилласан. Газартай холбоотой асуудал, байршилтай холбоотой асуудал үндсэндээ бид Их Хурлын даргын зун ажилласан хугацаанд тогтсон гэж үзэж байгаа.

Тийм учраас нэлээн.../минут дуусав/

Г.Занданшатар: Тооцоо судалгаатай ажиллахыг анхаарах хэрэгтэй гэж байна. Жамъянгийн Мөнхбат гишүүн. Төрийн байгуулалтын байнгын хороон дарга.

Ж.Мөнхбат: Орхон, Тамирын энэ ариун сав газар өвөг дээдсийн төрт улсын

өлгий нутагт энэ шинэ хот барих асуудал хамгийн нүдээ олсон чухал асуудал байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлж, өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэж, дэмжиж, өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж байна.

Тэгэхээр энэ бол эрт дээр үеэсээ энэ Орхон, Тамирын ариун хөндий, Хүннүгийн нийслэл Луут хотыг бид нээж илрүүлсэн.

Сяньби, Жужан буюу Их Нируны тахилын онгон бүхий талын 3 хэрэм энэ хөндийд байна.

Түрэгийн хаант улсын үеийн Түрэгийн Билгэ хааны бунхан, дурсгалын цогцолбор байна. Уйгарын хаант улсын нийслэл Хар балгас байна. Киданы үеийн том хот болох Чулуун хотын үлдэгдэл Хар бухын голын эрэг дээр энэ Орхон голоос 30, 40-хөн километрийн зайд байна.

Ингээд эзэн Чингис хааны зарлигаар байгуулагдсан Их Монгол Улсын нийслэл Хархорум хот байгаа.

Дараа нь монголчуудыг шашин, оюун санаагаар нь нэгтгэе гэсэн Эрдэнэзуу хийдийг энэ ариун хөндийд бас босгосон.

Монголын газар шороо нутаг дээр үүсэн байгуулагдсан энэ 7, 8 төрт улсын бүх нийслэлүүд нь бүх улс төр, эдийн засгийн том гол хотууд энэ Орхон, Тамирын хөндий, Хануй, Хүнүйн бэлчирт байсан.

Тийм учраас өнөөдрийн Ерөнхийлөгч маань Ерөнхий сайд байхдаа хоёр жилийн өмнө бас энэ газраар явж дурсгалт цогцолборуудтай танилцсан.

Улсын Их Хурлын дарга энэ зун явж бас энэ газар нутагтай танилцсан. Ингээд өнөөдөр 2001 оноос эхэлж Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, “Алсын хараа-2050”, 2000-2004 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан энэ ажил өнөөдөр ажил болж байгаад их баяртай байгаа.

Тэгэхээр хот барих газрыг тогтоосон шүү дээ. Архангай аймгийн Хашаат, Хотонд сумдын нутаг дэвсгэр Хашаат, Өгийнуур сумдын нутаг дэвсгэр. Хотонт, Хархорин, Өвөрхангай, Хархорин сумтай хаяа залгах энэ газар нутгийг сонгож ажлын хэсэг тогтсон байгаа.

Өнгөрсөн жил бид ярьж байгаад нэг тэрбум төгрөгийг Барилга, хот байгуулалтын яамны багцад тавьж, ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, зураг төслийн ажлыг нь эхлүүлсэн.

Энэ жил 4 орчим тэрбум төгрөг улсын төсвөөс энэ зураг төсөв, ерөнхий төлөвлөгөөн дээр тавина.

Нэгэнт Ерөнхийлөгч зарлиг гаргаж, Засгийн газар энэ саналыг өргөн барьж, Улсын Их Хурал баталж байгаа учраас цаашдаа олон улсын жишиг стандартад нийцсэн, Монголчуудын өвөг дээдсийнх нь түүхийн онцлогийг, соёлын онцлогийг харуулсан түүхэн аялал жуулчлал, байгалийн аялал жуулчлалыг хосолсон ийм том олон улсын хэмжээний жишигт нийцсэн хот болгох ёстой.

Тийм учраас үүнийг зөвхөн монгол инженерүүд гэхээсээ илүүтэй олон улсын хэмжээний зураг төсөв, төлөвлөгөө хийдэг, хот төлөвлөлт хийдэг энэ хүмүүс, олон улсын байгууллагыг урьж оролцуулж ингэж ажиллах нь их чухал байгаа.

Энэ бол усны ундарганы усны нөөц хамгийн сайн. Залуу Орхон, хөгшин Орхон, Тамирын гол, Өгий нуур гээд бүх усны ундрагууд энд байж байна.

Ер нь түүхэндээ энэ Орхон, Тамирын хөндий, энэ Хануй, Хүнүйн бэлчир Монголын ариун гал голомт байсаар ирсэн.

Тийм учраас энэ ариун гал голомт нь бүгдээрээ очиж хот барих нь зөв. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, өнөөдөр энэ бол ложистикийн том хот болно гэж бодож байгаа. Жишээлбэл, Баян-Өлгий, Увс, Ховд мянга гаруй километр явж байж Улаанбаатар хотод ирж байгаа. Эндээс бараа бүтээгдэхүүнээ татдаг. Орхоны хөндийд. Энэ Архангай аймгийн Хашаат, Өгийнуур, Хотонт, Өвөрхангай аймгийн Хархорин сум. Энэ дөрвөн сумын нутаг дэвсгэрийн хаяа залгаж дайрсан ийм хот барих юм бол баруун аймгийнхан бол мянга километр яваад л ирээд. Зүүн аймагт ч гэсэн мянга километрээс явж ирэх ийм ложистикийн хот болох боломжтой.

Тэгэхээр энэ олон талын ач холбогдол. Тэгээд 120, 130 километр, 30, 40 километрийн өргөнтэй том сайхан хөндий байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр олон улсын стандартад нийцсэн төлөвлөлт хийх ёстой шүү гэдгийг Барилга, хот

байгуулалтын яамныхандаа онцгойлж хэлье. Онцгойлж хэлье.

Дэлхий дээр Камберра гэж Австралийн хот байж байна. Бизнес, эдийн засгийн төв нь Сидней. Америкт Вашингтон Ди Си байхад бизнес, эдийн засаг, энтертаймент төв нь Нью-Йорк. Одоо Туркт Анкара гэж байхад бизнес, эдийн засгийн төв нь Станбул. Казахстан шинэ хот барьсан.

Яг энэ жишгээр бид шинэ хот барьж ингэж бизнес, эдийн засаг, энтертаймент, бүх юмных нь төв нь жишээлбэл Улаанбаатар хот байж төвлөрлийн бууралж, түгжрэлийг сааруулсан шинэ төлөвлөлт, төвлөрөл бол Орхоны хөндийд.../минут дуусав/

Г.Занданшатар: Дэмжиж үг хэллээ. Хоёр гишүүн дэмжиж үг хэлсэн. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцож анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Дараагийн асуудалд орно.

Зургаа.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Гадаад иргэнийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд

өргөн мэдүүлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хууль батлагдсанаар албан хаагчдын цалин ажиллах нөхцөл сайжирч байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 4.2.1-д заасныг баримтлан нэг санал хураалт явуулсан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураалгах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан нэг санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм шүү дээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд. Нэргүйн Ууганбаяр Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Даваасамбуугийн Мөнхбаатар Гадаадын иргэн, харьяатын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга, Жамсрангийн Солонгос тус газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Төмөрчөдөрийн Нарантунгалаг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Баттулгын Эрдэнэ Гадаадын иргэн, харьяатын газрын хуулийн мэргэжилтэн.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3.Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогыг байгууллагын нийтийн мэдээллийн дэд бүтэц, түүнийг ашиглах, хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Үг хэлэх хүн байна уу? Дэмжсэн, дэмжээгүй.

Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлэх үү, Ц.Цэрэнпунцаг гишүүн үг хэлэх үү. Санал хураалт явуулах уу? Энэ яах ёстой вэ? Б.Пүрэвдорж гишүүн ээ. Энэ санал яах ёстой юм. Үгүй. Үгүй. Одоо харин. Ямар учиртай санал юм.

Асуухгүй л дээ. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Сандагийн

Бямбацогт, Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Одоо санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

С.Бямбацогт: Байнгын хорооноос орж ирж байгаа санал дээр Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогыг байгууллагын нийтийн мэдээллийн дэд бүтэц, түүнийг ашиглах, хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулна. Дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ гэсэн байна л даа.

Тэгээд үндсэндээ Гадаадын иргэн, харьяатын байгууллагаас олж байгаа орлогуудаа улсын төсөвт төвлөрүүлэхгүй тэр чигээр нь буцаагаад байгууллагынхаа дэд бүтцийг сайжруулахад, хөгжүүлэхэд, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдэхэд зарцуулна гэсэн агуулгаар л орчихсон байх шиг байгаа юм. Энэ зөв юм уу? Энэ чинь бас улсын төсөвт тодорхой орлого орж байх ёстой биз дээ.

Урьд нь ямархуу орлого олдог байсан. Тэрний хэдийг нь улсын төсөвт төвлөрүүлдэг, хэдийг нь байгууллага өөрийнхөө дотоод үйл ажиллагаандаа зарцуулдаг байсан юм?

Тэгээд ингээд нэг байгууллага. Тэгээд ерөөсөө л орлого олдог. Олсон орлогоо буцаагаад л өөрсдөө зарцуулаад байх юм бол улсын төсөв чинь яаж мөрдөх вэ.

Энэ томьёолол яагаад дэмжигдсэн юм бол. Анхаарах л асуудал харагдаад байх юм.

Г.Занданшатар: Энэ дэмжээгүй утгатай үг хэллээ. Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би тэгэхээр энэ байгууллагад ажиллаж байсан хүн.

Тэгээд намайг ороход 86 дүрэм журамтай байсан юм. Түүний 44-ийг нь хүчингүй болгосон юм. Тэгээд тэр 44 дотроо энэ байгууллага одоогийн байдлаар дарга цэргээсээ эхлээд бүх хүмүүс бүгдээрээ ямар ч эрхгүй ажиллаж байгаа. Зөвхөн үүрэгтэй ажилладаг болсон.

Тэр дүрэм журмыг цэгцлэх хүрээнд яг тэр хуулийн дагуу, өөрөөр хэлбэл дандаа дарга нар луу эрх авчихсан тэр дүрэм журмыг цэгцэлсний хүрээнд энэ байгууллага 4 тэрбум төгрөгийн орлого 2012 онд ордог байж байгаад дараа жил нь гэхэд 13 тэрбум төгрөгийн орлого олдог болсон юм.

Тэгэхээр ямар их хүнд суртал энэ байгууллагын дарга нар авдаг байсны жишээ энэ л дээ.

Тэгэхээр энэ бол хөлс юм. Өөрөөр хэлбэл энэ байгууллага шимтгэл хураамжийг орон нутгийн төсөвт оруулдаг. Энэ үйлчилгээний хөлс бол өөр хэлбэр.

Энэ үйлчилгээний хөлсөөс 170 сая төгрөгийн орлогыг энэ жил олж байгаа. Энэ хөрөнгөө тодорхой хэмжээгээр энэ байгууллага өөрөө цахим виз олголт энэ тэр дээр, цахим шилжилтээр Засгийн газрын энэ хөтөлбөрийг маш сайн хэрэгжүүлж, одоогийн байдлаар 50 мянган цахим виз олгочихсон явж байгаа.

Тэгэхээр ийм сайн. Одоо өөрөөр хэлбэл аялал жуулчлалыг хөгжүүлэх,

бусад бүх энэ Монгол руу орж байгаа, урсаж байгаа тэр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд энэ байгууллагын үйлчилгээ маш сайн, дээрээс нь цахимжсан, хүн хаанаас ч хамаагүй очоод визийнхээ хүсэлтээ өгөөд хил дээрээ виз авчихдаг ийм сайн үйлчилгээтэй байх юм бол нөгөө Засгийн газрын хэрэгжүүлж байгаа тэр аялал жуулчлалыг хөгжүүлэх, мөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх энэ үйлсэд л маш чухал нэмэр болох юм.

Тэгээд энэ байгууллага намайг байхад л нийт зардлынх нь 86, 87 хувь нь цалинд зарцуулагддаг. Бусад нь бусад зардалд зарцуулагддаг. Энэ бол ийм бага хөрөнгө оруулалт ордог байгууллага байсан. Одоо яг л тэр хэвээрээ л байгаа.

Тийм учраас энэ үйлчилгээний хөлсөөс орж байгаа. Өөрөөр хэлбэл улсын, энэ орон нутгийн төсөвт орохгүй. Энэ үйлчилгээний хөлснөөс орж байгаа энэ мөнгийгөө тодорхой хэмжээгээр байгууллагынхаа үйл ажиллагаанд зарцуулах. Өөрөөр хэлбэл хуучин оршин суух үнэмлэхийн хөлс чинь хуучин нэг компани дээр оршин суух зөвшөөрлийн хэвлээд л тэр компани нь авчихдаг байсан. Энэ нь энэ хуулиар бас тодорхой хэмжээгээр тэр үйлчилгээгээ өөрөө хийж байгаа учраас тэр хөлсийг байгууллагад нь үлдээх тухай л асуудал яригдаж байгаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор. Санал хураалт. /алх цохив/

51.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн нэгдүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.1 дэх хэсгийг 41.1, 41.2 дахь хэсэг болгон өөрчлөн найруулсан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 3 дугаар зүйлийн “41.8.4 гэж” гэсний дараа “41.9.” гэснийг “41.10.” гэж, “41.10.” гэснийг “41.11.” гэж, “41.11.” гэснийг “41.12.” гэж, “41.12.” гэснийг “41.13.” гэж, 41.11 дэх хэсгийн “41.9-д” гэснийг “41.10-т” гэж, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “41.1-д” гэснийг “41.3-т” гэж” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийн “41.13.” гэснийг “41.14.” гэж, “41.14.” гэснийг “41.15.” гэж, “41.15.” гэснийг “41.16.” гэж, “41.16.” гэснийг “41.17.” гэж, “41.17.” гэснийг “41.18.” гэж, “41.18.” гэснийг “41.19.” гэж, “41.19.” гэснийг “41.20” гэж тус тус өөрчлөх.

Санал гарсан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томёоллоор санал хурааж дууслаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Дараагийн асуудалд орно.

Долоо.Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголын тайланг сонсох

Нүүрсний экспорт, тээвэрлэлтийн холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сансарын тайланг хэлэлцэнэ.

Тайланг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг танилцуулна.

Байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн танилцуулъя.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд нарын 15 гишүүнээс 2022 оны 12 сарын 05-ны өдөр Нүүрсний

олборлолт, тээвэрлэлт, экспортын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтийг Улсын Их Хуралд ирүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо нь 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах, ерөнхий хяналтын сонсголын тайланг сонсож дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу Эдийн засгийн байнгын хороо хуралдаж, 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 18 дугаар тогтоолоор нүүрсний экспорт, тээвэрлэлтийн холбоотой асуудлаар

холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах, ерөнхий хяналтын сонсголын товыг тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзоригийг сонгож, ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 8 гишүүний бүрэлдэхүүнтэй Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 190 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт даалгасны дагуу сонсголын бэлтгэл хангагдсан тул 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Төрийн ордны “Их Монгол” танхимд зохион байгууллаа.

Сонсгол тухайн сэдвээр мэдээлэл өгөх эрх бүхий байгууллагуудын удирдах албан тушаалтныг сонсгол дуудан мэдэгдэл хүргүүлсний дагуу нийт 110 албан тушаалтан сонсголд оролцох саналаа илэрхийлж, сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих, сонсголд өөрийн биеэр оролцох, тодорхой асуудлаар санал хэлэх, сонсголд зайлшгүй оролцох шаардлагатай сонсголд оролцох хүсэлт гаргасан нийт 225 иргэн, хуулийн этгээд бүртгүүлснээс 58 иргэн сонсголын үеэр санал хэлэх хүсэлтээ урьдчилж ирүүлсэн бөгөөд хэвлэл мэдээллийн 17 байгууллагын 43 ажилтан сонсголын үйл ажиллагааг сурвалжлах хүсэлтээ ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт Байнгын, дэд хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцсоноор тухайн сонсголыг хүчинтэй тооцно гэж заасан бөгөөд сонсголд Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Д.Бат-Эрдэнэ,

Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Ж.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, С.Чинзориг нар оролцсоноор сонсголын ирц хуульд заасан шаардлагыг хангасан болно.

Ерөнхий хяналтын сонсгол явуулахаар олон нийтэд зарласан үндсэн 4 сэдвийн хүрээнд холбогдох албаны хүмүүс сонсголд оролцогчдод хандан дэлгэрэнгүй мэдээлэл хийж, сонсголд Улсын Их Хурлын нийт 42 гишүүн оролцсоноос Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Э.Ганибал, Т.Доржханд, Ш.Раднаасэд, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл, Д.Цогтбаатар нарын 7 гишүүн асуулт асууж, үг хэлсэн бөгөөд сонсголд оролцож санал хэлэхээр урьдчилан хүсэлт гарган бүртгүүлсэн 55 иргэн саналаа илэрхийлж, холбогдох албаны хүмүүс давхардсан тоогоор 44 удаа тайлбар, мэдээлэл өгсөн.

Улсын Их Хурлын гишүүд болон сонсголд оролцогчдын гаргасан саналуудыг тоймлон авч үзвэл үндсэн 6 чиглэлээр дараах саналуудыг гаргалаа.

Нэг.Нүүрсний хулгайг ил болгох, олон нийтийн мэдэх эрхийг хангах чиглэлээр.

Засгийн газраас байгуулсан нүүрсний хэрэгтэй холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг буюу штабт ард түмний төлөөллийг оролцуулах, нүүрсний хулгайтай холбогдогч этгээдүүдийг зарлах, Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийг шалгах, шаардлагатай бол Улсын Их Хурлын гишүүдийг бүрэн эрхээс нь түдгэлзүүлэн шалгах, нэг километр төмөр замыг олон улсын жишгээс өндөр үнээр барьсан нь хулгай

хийх нөхцөлийг бүрдүүлсэн болон төмөр замтай холбоотой үүсээд байгаа авлига, хээл хахуулийн гэмт хэргийг шалган тогтоох offtake гэрээнүүдийг ил болгоод зогсохгүйгээр ажил гүйцэтгэх, туслан гүйцэтгэх гэрээнүүдийг ил болгох, 2010 оноос хойших 1072 хувьцаа эзэмшигчдийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын хурлын бүх тэмдэглэл, тушаал, шийдвэр, худалдах, худалдан авах гэрээнүүдийн хуулбар зэргийг ил болгох асуудлаар саналуудыг гаргасан.

Хоёр.Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр.

Төрийн өндөр албан тушаалтнуудтай хариуцлага тооцох, улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, байгалийн баялгийг олон нийтийн хяналтад оруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах хүрээнд Улсын Их Хурлаас төрийн өндөр албан тушаалтнууддаа хариуцлага тооцох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн ил тод байдлын тухай, Улс төрийн намын тухай бие даасан хуулиудыг батлах, Татварын тухай болон Сонгуулийн тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг олон нийтээр хэлэлцүүлэн шинэчлэх коронавируст халдварын цар дархлалаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай болон Засгийн газарт онцгой дэглэм тогтоосон хуулиудыг хүчингүй болгох саналуудыг гаргасан.

Гурав.Хяналт тавих, хариуцлагын тогтолцоог сайжруулах, олон нийтийн хяналтыг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх чиглэлээр.

Төрийн байгууллагуудын мэдээлэл өөр хоорондоо зөрүүтэй байгаад

дүгнэлт хийж, Монгол банк, Сангийн яам, Эдийн засаг, Хөгжлийн яам зэрэг холбогдох байгууллагуудаас тээвэрлэлттэй холбоотой статистик мэдээллийг үнэн зөвөөр гаргаж, нүүрсний үнийн зөрүүний асуудлыг тусад нь авч үзэж, нүүрсний хулгайд ямар нөлөөлөл үзүүлснийг судалж, дүгнэлт гаргах, ил тод болгох, offtake гэрээг нууцад хамруулсан шийдвэр гаргасан болон бүртгэлгүй нүүрсийг улсын хилээр гаргасан этгээдийг олон нийтэд зарлах, хариуцлага тооцох, хуулийн байгууллага хяналт шалгалт хийхдээ хөндлөнгийн нөлөөнд автахгүй, улс төрөөс ангид, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлэх саналуудыг гаргажээ.

Дөрөв.Төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр.

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах хүрээнд төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд иргэдийг оруулах, ард түмэнд ногдол ашиг хуваарилах, төрийн өмчийн засаглалыг өөрчлөх, хяналтыг сайжруулах, олон нийтэд нээлттэй болгох, Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн төрийн эзэмшлийн бүх хувьцааг иргэдэд үнэ төлбөргүй шилжүүлэх, том, жижиг Тавантолгой компанийг нэгтгэж Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлж, тус сангийн хөрөнгийг нийт аймгуудад тэгш хуваарилах, Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанид бүртгэлтэй байгаа “Зүүнбаян төмөр зам” хязгаарлагдмал хувьцаат компанийг “Монголын төмөр зам” төрийн өмчит компанид шилжүүлэх, Тавантолгойн орд ашиглалтын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд түүхий нүүрсийг боловсруулж

хилээр гаргах, Тавантолгойн орд газрыг хашаалж иргэдийн өмчийг хамгаалах, төмөр зам, цахилгаан эрчим хүчний бүтээн байгуулалтад анхаарах, Оюу Толгойн ашиглалттай холбоотой Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, Түр хороотой адил Тавантолгойн асуудлаар түр хороог байгуулж, мэргэжлийн экспертүүдийг татан оролцуулж үр дүнг Улсын Их Хуралд танилцуулах, Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн 30 хувийг маш хямд үнээр IPO хийн арилжаалах гэж байгаа бол түүнийг зогсоох зэрэг саналуудыг хэлсэн байна.

Тав.Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хэлбэрийг сайжруулах чиглэлээр.

Ерөнхий хяналтын сонсголын зохион байгуулах хамрах хүрээ, сонсголын үр дүнг тайлагнах хүрээнд Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа бүх нийтийн эрх ашгийг хөндсөн томоохон асуудлаар ерөнхий хяналтын сонсголд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдыг заавал оролцуулдаг байх, зөвхөн нүүрсний асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулаад зогсохгүй цаашид нефть, зэс болон уул уурхайн салбарын бусад бүтээгдэхүүнээр хил, гаалийн хяналтын асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулах, сонсголоос гарсан үр дүн, Монгол Улсын Ерөнхийлөгч болон Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлэх байх зэрэг санал гаргасан болно.

Зургаа.Төрийн байгууллагуудын тогтолцоог өөрчлөх чиглэлээр.

Төрийн байгууллагын харилцан хяналт тэнцлийг хангах хүрээнд Улсын

Их Хурал нь Засгийн газартаа тавих хяналтаа сайжруулах, шүүх, прокурорын байгууллагуудын томилгоог өөрчлөх, шинэчлэх, Улсын Их Хурлын гишүүдийн халдашгүй байдал, эрх мэдлийг бууруулах, ард түмний төлөөлөл сонгогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, сонгуулийн тогтолцоог өөрчлөх зэрэг саналуудыг гаргасан болно.

Сонсголын үеэр холбогдох байгууллагын удирдлагуудын хийсэн мэдээлэл болон оролцогчдын гаргасан саналд үндэслэн сонсголын үр дүнг дараах байдлаар дүгнэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох нь зүйтэй гэж үзсэн.

1.Энэ сонсголын үр дүнгээр Эдийн засгийн байнгын хороо болон Улсын Их Хурлаас нүүрсний хулгайн асуудалтай холбогдуулан шийдвэр гаргах. Цаашид ийм байдал гаргах үүд хаалгыг хаах боломжийг бүрдүүлж, олон нийтийн хяналтыг бий болгож, анхаарлын төвд оруулж чадлаа.

Цаашид баялгийн олборлолт, ашиглалт, экспортын асуудлыг ард түмний хяналтад нь авах нь зүйтэй гэж үзэж байна.

Шаардлагатай бол Улсын Их Хурал энэ асуудлаар холбогдох хууль тогтоомжийг нэн яаралтай дэгээр хэлэлцэж, Засгийн газар болон хуулийн байгууллагуудад бүхий л талаар дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

2.Улсын Их Хурлаас байгуулагдсан Хилийн боомтын асуудлаар хянан шалгах түр хороо, хилийн боомтуудаар нүүрс экспортлох, тээвэрлэх мэргэжлийн хяналт, хил, гааль зэрэг холбогдох төрийн байгууллага, аж

ахуйн нэгжийн үйл ажиллагаа, нүүрсний гаалийн бүрдүүлэлт, гэрээ, үнэ тариф болон олон асуудлыг хянан шалгаж олон нийтийн дунд үүсээд байгаа эргэлзээтэй олон мэдээллийг тодорхой болгох шаардлагатай гэж үзсэн.

3. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнийг олон улсын жишигт хүргэж, хил залгаа улсын хилийн үнээр худалдах, олон нийтийн хяналтад оруулах зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүн биржийн тухай анхдагч хуулийг шуурхай баталж, цаашид төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай анхдагч хуулийн төслийг мөн яаралтай горимоор хэлэлцэн баталж, энэ мэтээр улс орноо, ард олноо төсөв хөрөнгийг нь тонон дээрэмдэх хууль бус үйлдэлтэй Улсын Их Хурал ард түмнийхээ талд байж, хамтран тэмцэх шаардлагатай гэж үзлээ.

4. Монгол Улсын иргэдэд Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх, иргэдийн эзэмшиж байгаа хувьцааны тоог нэмэгдүүлэх замаар иргэдийн эзэмших хувьцааны хувийг нэмэгдүүлэх, ногдол ашиг хуваарилах асуудлыг судлан шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.

Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн засаглалыг сайжруулах хүрээнд компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

6. Цаашид төрийн өмчит Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийг олон нийтийн нээлттэй хувьцаат компани болгож иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах.

Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулж байгаа компаниудаас экспортод гаргах нүүрсийг Монголын хөрөнгийн бирж хувьцаат компаниар дамжуулан ил тод, нээлттэй худалдаалах зэрэг эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

7. Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан боомтын сэргэлтийн хүрээнд хилийн боомтуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, боомт дагасан суурьшлын бүсүүдийн дэд бүтэц, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх асуудлыг тусгасан Боомтын тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шаардлагатай байна.

8. Хууль хяналтын байгууллагуудад шалгагдаж байгаа нүүрсний хулгайтай холбоотой гэмт хэргүүдийн мөрдөн байцаах ажиллагааг хугацаа алдахгүй яаралтай шийдвэрлэх, олон нийтэд зарлах, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, цуглуулсан нотлох баримтуудыг шинжлэх, судлах замаар сонсголд гэрч, хэргийн холбогдогчийг оролцуулан хууль хяналтын байгууллагаас нүүрсний хэрэгтэй холбогдуулан явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах нь шаардлагатай байна.

Байнгын хорооны хуралдаанаар Ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Д.Батлут нар сонсгол хийснээр гарах үр дүнгийн талаар цаашид иргэдэд мэдээллийг ил тод, нээлттэй хүргэж, мэдээллээр хангах, Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх замаар компанийн засаглалыг сайжруулах, аж ахуйн нэгж, иргэдэд хувьцааг худалдах боломжийг нээж өгөх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Г.Дамдинням, Г.Ганболд нар нүүрсний олборлолт, тээвэрлэлт, Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн хувьцааны асуудлаар болон сонсголын үр дүнгийн талаар холбогдох байгууллагад үүрэг, чиглэл өгөх, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг санаачлан боловсруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголын тайланг сонссон талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж

асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Ганзоригийн Тэмүүлэн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүнээр тасаллаа. Дамдины Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Д.Цогтбаатар: Гишүүдийнхээ энэ гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Тэгэхээр Байнгын хорооны даргад нэг ийм асуулт тавимаар байна. Offtake гэрээ гээд. Энэ Монгол Улс даяараа нэг offtake гэрээ гэдэг юмыг хараагаад үзэн ядаад эхэллээ.

Offtake гэрээ гэдэг чинь энэ дэлхий дээр байдаг 7 миллиард хүн ашиглаж байгаа арилжааны гэрээний хэлбэр. Монголчууд үзэн яддаг боллоо гээд энэ гэрээний хэлбэр дэлхийн арилжааны бизнесийн эрх зүйн орчноос арилж алга болохгүй.

Бид дургүйцээд байгаа юм чинь хулгай байхгүй юу. Харин offtake гэрээг ашиглаад хулгай хийчихсэн байна гэдэг бол тэр хулгайтай нь тэмцэх ёстой. Жишээлбэл, хулгайн мөнгийг банканд байршуулаад байна гээд банкныг үзэн яддаггүй биз дээ. Газрын наймаа хийгээд газрыг нь тэр авлигынх нь мөнгө, барилга байшинд шингээд, дараа нь барилга байшингаар төлөгдөөд байна гээд барилгын бизнесийг муу гээд татан буулгадаггүй биз дээ.

Яг түүнтэй адилхан энэ offtake гэрээ гэдэг чинь дэлхий дээр байдаг. Ялангуяа түүхий эдийн борлуулалтын зах зээл дээр байдаг гэрээ. Одоо ингээд Монгол Улс үүнийгээ энэ хулгай, ердийн арилжааны гэрээ хоёроо ялгахгүй ярьсаар байгаад.

Сүүлдээ би юу ажиглаж байна гэхээр Монголд энэ offtake гэрээ гэдэг юмнуудыг хийхгүй бараг хорих тал руу юм ороод явчих юм бол энэ Монгол Улсын чинь гадаад худалдаа, борлуулалт, ялангуяа түүхий эдийн салбарт өөрөө аягүй хүнд байдалд орно.

Тэгэхээр үүнийг нэг ийм ялгааг нь гаргаж, хулгайгаас ердийн тэр гэрээг салгаж ойлгож явахгүй болохгүй бол байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр манай зүгээс, төрийн зүгээс, энэ чинь одоо юу хийх вэ.

Тэгэхгүй нэг юмыг ингээд үзээд ядахаар тэр хулгайтайгаа андуураад огт өөр юмаа бүр үзэн ядаад яваад өгч байгаа юм. Энэ offtake гэрээгүйгээр авлига, хээл хахууль зөндөө байгаа шүү дээ.

Тэгэхээр асуудал offtake гэрээндээ биш. Харин тэр offtake гэрээг үнийн бүрдэлт хийхдээ, үнийн бүрдэлт яаж хийж байна, үнийн тохиролцоогоо яаж хийж байна. Тэр гэрээг ямар шалтгаанаар нууцлаад байгаа юм. Нууцлах нэг шалтгаан байгаад байна шүү дээ. Энэ юмнууд чинь л асуудал болохоос тэр гэрээ нь өөрөө асуудал биш. Үүнийгээ бид нар ойлголцохгүй бол сүүлдээ дэлхийтэй худалдаа хийхэд хэцүү болно шүү. Би нэг их дэмжээд, үүнийг хийгээд байгаа гэж байгаа юм биш.

Зүгээр дэлхий дээр байдаг юмыг тэр хийх хэрэгцээтэй үедээ бусад компаниуд нь хийж барих юм байх л биз. Зүгээр хулгай хийхгүй л арилжааны бизнес тэр гэрээ контрактаа хийж байх ёстой. Энэ дээр юу анхаарч, энэ дээр танин мэдүүлж ойлгуулах тал дээр юу хийнэ гэж бодож байгаа вэ?

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Зам тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч Максимын Чинбат, Татварын ерөнхий газрын дарга Батжаргалын Заяабал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Баяраагийн Бямбадагва, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч.

Ж.Ганбат дарга та хэд ийшээ гол руу суугаарай.

Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Хожгорын Лхагвасүрэн, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Лхамсүрэнгийн Баярмандал, Ашигт малтмал, газрын тосны Уул уурхайн хэлтсийн дарга Мэлсчойгийн Мэндбаяр, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Даваагийн Баянжаргал, Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын дарга Болдын Сүхбаатар, Гаалийн ерөнхий газрын Статистикийн газрын дарга Эрдэнэхүүгийн Лхагвасүрэн, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа Баттөмөрийн Батсуурь, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Бэхбатын Ганчулуун, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга,

цагдаагийн дэд хурандаа Пунцагдашийн Сандагсүрэн, “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ачаа тээврийн хэлтсийн дарга Очирсүрэнгийн Энхбат, Жигжидийн Ганбат даргыг хэлчихсэн.

“Монголын төмөр зам” компанийн гүйцэтгэх захирал Пүрэвжавын Ганхүү, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн бүрэн эрхт төлөөлөгч Нэргүйн Мягмар.

Энэ асуултад хэн хариулах билээ. Offtake-тэй холбоотой асуудлыг.

Эхлээд Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Ж.Ганбат захирал байна уу? Ж.Ганбат захирал хариулаадахаарай. Д.Цогтбаатар гишүүний асуусан асуултад.

Г.Занданшатар: 92. Жигжидийн Ганбат.

Ж.Ганбат: Д.Цогтбаатар гишүүний асуултад хариулья.

Эрдэнэс Тавантолгой компани дээр нийтдээ 5 offtake гэрээ байсныг Засгийн газрын шийдвэрийн дагуу ил болгосон. Ер нь offtake гэрээ гэдэг маань сая Д.Цогтбаатар гишүүний ярьдаг үнэн. Дэлхий дээр байдаг л гэрээ. Үүнийг бид хэрэгжүүлэх дээрээ яах вэ, нууцлалын зэрэгт оруулсан. Далд хэлбэртэй, ил тод байлгаагүй нь алдаа.

Offtake бол зүгээр бизнесийн зарчмаар явдаг. Хоёр компаниудын хооронд. Эрсдэлээ зөв тооцоод ингээд л явдаг зүгээр л байдаг л гэрээ. Энэ дээр нэг айтгар яг энэ offtake гэдэг гэрээгээ яг

үндсээр нь буруутгах нь буруу байгаа юм.

Үүнийг ил тод, нээлттэй ингээд явуулаагүй дээр нь гол асуудал байна гэж ингэж үзэж байгаа.

Нөгөө талдаа яах вэ, offtake гэрээнүүдэд заавал нууцлаад байх шаардлага байна уу гэдэг ийм асуудал үүсэж байгаа юм. Гэрээний үндсэн нөхцөлүүд нь гэрээний хоёр тал мэдээж бизнесийн зарчмаар явж байгаа юм бол энэ асуудал дээрээ тодорхой бизнесийнхээ харилцаануудтайгаа үнэ өртгийг нь далд болон төсөлт өртгийн талаар мэдээллүүд хоёр бизнесийн байгууллагын хооронд байж болно. Үүнийг заавал ил тод, нээлттэй байлгах гэж байгаа юм.

Гэрээгээ үндсээр нь нууцлаад байгаад нь л гол асуудал үүсчихсэн. Яагаад үүнийг заавал нууцлалын зэрэглэлд оруулж энэ хэмжээнд хийх. Үнэхээрийн стратегийн ийм чухал объект гэдгээрээ нууцлаад байгаа юм уу. Бизнесийн зарчим нь нууцлаад байгаа юм уу гэдэг.

Үүнийгээ цаашдаа тодорхой болгоод яг offtake гэрээ гэдгээ бид хориглож болохгүй. Энэ бол бизнесийн зарчмаараа бусад оронд байдаг ийм жишээ учраас үүнийгээ улам сайжруулья. Ил тод, нээлттэй ингэж явах нь зөв гэдэг ийм байр суурийг Эрдэнэс Тавантолгой компани үзэж байгаа.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Энэ нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой ерөнхий хяналтын сонсгол болсон.

Хаана хаанаа бэлтгэлгүй, хаана хаанаа ойлголцоогүйн улмаас их олон бэрхшээлийг давж, ямар ч гэсэн өнөөдөр ард түмний анхааралд байгаа энэ нүүрсний хулгай, луйвар, энэ төрийн өмчит компанийн засаглалын асуудлаар ард иргэд, төрийн эрх барих дээд байгууллага бас тодорхой хэмжээний мэдээлэл авч ажилласан.

Үүний үр дүн гарах байх гэж бодож байгаа. Хамгийн гол үр дүн өнөөдөр ингээд хэрүүл маргаан, тэмцэл, шүүмжлэл, янз бүрийн ийм мэдээлэл гараад өнгөрөх биш. Ийм бузар булхай, луйврын схем, энэ төрийн өмчийг дагасан хулгай луйврыг цаашид Монголын төр яаж таслан зогсоох вэ, ямар бодлого боловсруулах вэ, энэ бузар булхайг далимдуулж их хэмжээний төрийн өмч хөрөнгийг завшсан гэмт этгээдүүд хүлээлгэх ял хариуцлагыг яаж болгох вэ гэдэг дээр л өнөөдөр төрийн эрх барих дээд байгууллага, хууль хүчний байгууллага бид анхаарлаа хандуулах ёстой.

Үүнээс гарах үр дагаврыг арилгах, цаашид гаргахгүй байхын талаар хууль эрх зүйн орчныг тодорхой болгох асуудал хамгийн чухал байгаа юм. Хамгийн чухал байгаа.

Сүүлдээ энэ нүүрсний хулгай гэдэг юм чинь бүр утгаа алдаад жолооч нар, тэнд ажил үүрэг гүйцэтгэдэг жирийн хүмүүс рүү хүртэл ороод. Сүүлдээ нэг нэгнээсээ өш хонзон авах ийм улс төрийн тийм хэрэгсэл болгож ашиглаж байна шүү дээ.

Олон нийтийн сүлжээ, цахим орчноор ерөөсөө нүүрсний хулгай луйвар гэдэг ард иргэдийн жигшил зэвүүцлийг төрүүлж байгаа энэ асуудлыг бүр өш

хонзон авдаг хэрэгсэл болгосон. Ийм байдлаар явбал энэ хоёр хортой.

Үнэхээр жинхэнэ хулгайч ард нь үлдэнэ. Цаашлаад үүгээр далимдуулж ард иргэдийн дунд өөр зорилготой үйл ажиллагаанууд яваад байна гэдэг ийм бодолтой явж байна.

Ингээд хоёр, гурван асуудал асууя. Тэр Тавантолгой төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулна. Тэгээд л хувьцаа гээд л олон асуудал ярилаа. Үүнийг хаана хаанаа бодож шийдэх ёстой.

Энэ Ц.Цэрэнпунцаг даргаас нэг юм асууя. Орон нутгийн өмчид Тавантолгойг том Тавантолгойтой нэгтгэнэ гэсэн нэг юм та сая ярьчихлаа. Энэ яаж нэгтгэх гэж байгаа юм. Улсын Их Хуралд ийм эрх байна уу? Энэ талаар нэг асуулт асууя.

Дээр нь энэ offtake гэрээний асуудал ярих ёстой. Ярих ёстой. Энэ нууцын зэрэглэлд үнэхээр дэлхий даяар зөв бодлого юм бол яахаараа нууцад оруулдаг юм. Өнөөдөр тэр төмөр зам барьж байгаа өртгүүд нь өөр өөр байгаа шүү дээ. Зарим нь 8 сая, зарим нь 5 сая, зарим нь 1 сая 400 мянга гээд. Энэ ялгааг чинь гаргахгүйгээр энэ offtake гэрээний асуудал яригдана. Үүнийг яг ямар үнэтэй байгааг нь төрийн өмчит компанийн Тавантолгойгоос асууя.

Дээр нь энэ хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар ямар хуулийн төсөл энд оруулж ирж байна гэдгийг Ц.Цэрэнпунцаг даргаас асууя.

Дээр нь энэ мөрдөн шалгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ гэж юм Их Хурал ярихгүй ээ. Энэ чинь өөрийн гэсэн хуультай, өөрийн гэсэн шалгах

ажиллагаатай. Харин тэнд хөрөнгө санхүүгийн асуудал дээр л яаж дэмжих вэ гэдэг тухай ярья.

Түүнээс биш бид өнөөдөр мөрдөн шалгах ажиллагаанд оролцоно, дэмжлэг үзүүлнэ гэж ийм хоосон юм ярьж ерөөсөө болохгүй шүү гэдэг ийм байр суурьтай байна. Ингээд асуулт асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Эхлээд бүрэн эрхт төлөөлөгч Жигжидийн Ганбат. Эхлээд Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Ш.Адъяаа гишүүний асуусан асуултад хариулья.

Нэгд, та тэр хоёр том толгойг нэгтгэх гээд ийм юм ярьж байна гээд байх юм. Энэ чинь нөгөө ирсэн саналуудыг нэгтгэсэн саналууд байхгүй юу. Янз бүрээр боссон иргэд маань энэ хоёрыг нэгтгэе гээд л ийм санал хэлсэн шүү.

Ш.Адъяаа гишүүн та түүн дээр. Нэг дэх.

Хоёр дахь нь, нөгөө хууль орчныг сайжруулах чиглэлд та саяхан мэдэж байгаа. Бид биржийн хуулиа гаргачихсан. Тийм ээ. Энэ бол нэг том хууль. Нөгөө нүүрсийг чинь ил тод, одоо энэ зах зээлийнх нь үнээр зарах энэ боломжийг бүрдүүлж байгаа биржийн хуулиа бид гаргачихсан.

Хоёрт, Эрдэнэс Тавантолгойгоо бид олон нийтийн хяналтад оруулах чиглэлээр биржийн хуулиа дагалдуулж Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр ажиллаж байгаа.

Энэ дээр гишүүд маань янз бүрийн саналтай байгаагаас болоод нэлээн удаашралтай явж байгаа. Дараагийн долоо хоногт чуулганаар орж ирэх байх гэж санаж байна.

Та ч гэсэн Байнгын хороон дээр орж энэ дээр тодорхой саналуудаа өгөөрэй гэж Ш.Адъяаа гишүүнд хэлье.

Тэгээд Ш.Адъяаа гишүүний дараагийн асуулттай холбоотой хэн хариулахаар байна. Дахиж нэмж ажлын хэсгээс хариулах. Байхгүй гээд байна. Д.Ганбат захирал хариулах уу. Бүрэн эрхт төлөөлөгч. Тавантолгой компанийн бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат дарга та нэг хариулаадах.

Г.Занданшатар: 92. Жигжидийн Ганбат. Бүрэн эрхт төлөөлөгч.

Ж.Ганбат: Ш.Адъяаа гишүүний асуултад хариулья.

Ер нь зүгээр яах вэ, offtake гэрээ бол бусад оронд байдаг. Энэ бол ингээд санхүүжилтийг нэг хэлбэр болгоод зарим орнуудад хөрөнгө оруулалтаа хийх байдлаар. Энэ бол ашигтай л явдаг гэрээ.

Гэрээг хамгийн гол асуудал нь бид яагаад нууцлаад байгаа юм гэдэг дээр л байгаа юм. Ер нь нууцлах шаардлагагүй. Нууцлахгүйгээр ил тод, үүнийгээ яваад ингээд энэ бол зүгээр байдаг л санхүүжилт.

Нөгөө талдаа гэрээний хоёр тал бол энэ гэрээнийхээ нөхцөл дээр яагаад л хэн эрсдэлээ хаагаад л зөв хийж чадсан нь хөрөнгө оруулалтаа босгоод л энэ төслөө хэрэгжүүлээд явах бүрэн бололцоотой ийм л гэрээ гэж үзэж байгаа.

Яах вэ, өнөөдрийг хүртэл Эрдэнэс Тавантолгой компани дээр байгуулагдсан Тавантолгой Гашуунсухайт чиглэлийн төмөр замын санхүүжилтийн төлбөрийг нүүрсээр барагдуулах 2 гэрээ, Богд хаан төмөр замын санхүүжилтийн төлбөрийг нүүрсээр барагдуулах 3 гэрээ гээд 5 гэрээг ил тод болгосон.

Ер нь цаашид иймэрхүү санхүүжилтийн гэрээнүүдийг бид үндсэн зарчим болон нөхцөл, энэ төслийнхөө асуудлыг бид ил тод ингээд явахад цаашдаа offtake гэрээ гээд яваад байх бүрэн бололцоотой шүү дээ. Энэ дээр яг байдаг л ийм санхүүжилтийн механизм. Үүнийгээ зөв голдирлоор нь ил тод нээлттэй ингээд л явахад болно.

Нөгөө талдаа энэ дээр яах вэ, худалдан авалтын тендерийн асуудал байгаа. Үүнийг бид нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтын зарчмаар нь сонгоод offtake гэрээнийхээ зарчмаар явах нь л чухал болчихоод байгаа юм.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууя.

Ш.Адьяа: Өнөөдрийн бид нарыг ч их хардлага төрүүлж байгаа асуудал энэ offtake гэрээ байгаа.

Яагаад нууцалдаг юм. Тэгээд энэ Хангимандалын чиглэлд нэг үнээр барьдаг. Гашуунсухайт Цогтцэцийгийн чиглэлд нэг үнээр барьдаг. Сүүлд нь энэ Богд хаан төмөр замын юмыг чинь үзсэн.

Тэр хүн итгэмээргүй юм байна лээ шүү дээ. Тэгээд үүнийг нь сүүлд нь бараг нэг хуулийн фирм ч юм уу, энэ социал цахим орчноор бараг л байдаг л асуудал шүү дээ гэсэн тийм юм хуульчид яриад явж байна лээ шүү дээ.

Энд хэн итгэх юм бэ. Байдаг асуудал байсан юм бол яахаараа улсын нууцад оруулдаг юм. Яагаад өнөөдөр тэр хүмүүс байдаг л юм байдаг юм бол тэгээд өнөөдөр ийм хулгай луйврын схем гарчихсан. Тэгээд өнөөдөр тэр **offtake гэрээ** байгуулсан эзэн нь олддоггүй. Тэр нь **зөв ч юм шиг, буруу ч юм шиг**. Энэ **хууль хяналтын байгууллага тэрийг барьж авах гээд ч байгаа юм шиг, барихгүй ч байгаа юм шиг**.

Энд том асуудал байгаа гэж ойлгож байна.

Г.Занданшатар: Ц.Цэрэнпунцаг гишүүн нэмж хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Ш.Адьяа гишүүнд иргэдээс болон тэр оролцогчдоос гаргасан бас нэг санал бол эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд ямар ямар санал гарсан юм бэ гэдгийг танд дахиад нэг уншаад өгчихье.

Төрийн албан өндөр албан тушаалтнуудаа хариуцлага тооцох, улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, байгалийн баялгийг олон нийтийн хяналтад оруулах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах хүрээнд Улсын Их Хурлаас төрийн өндөр албан тушаалтнуудтай хариуцлага тооцох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн ил тод байдлын тухай, Улс төрийн намын тухайбие даасан хуулиудыг батлах, Татварын болон Сонгуулийн тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг олон нийтээр хэлэлцүүлэн шинэчлэх, коронавируст халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон Засгийн газарт онцгой дэглэм тогтоосон

хуулиудыг хүчингүй болгох гэсэн ийм саналууд ирсэн.

Энэ чиглэлд нүүрсний экспорт, тээвэрлэлтэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан мэдээлэлтэй.../минут дуусав/

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Өнөөдөр иргэдээс анхааруулсан томоохон нүүрсний асуудлыг сонсголоо. Одоо тайлан мэдээллийг.

Тэгээд би ирээдүйн нүүрсний том хулгайчийн тэр хулгайг зогсоохыг хүсэж байна. Өнөөдөр.

Энэ бол хотын дарга Д.Сумъяабазар. Ямар хулгай вэ гэж. Өнөөдөрхөн хоёр хоногийн өмнө Улаанбаатар хот тендер зарлаж байна. Нүүрсний ордод хайгуул хийх гэж.

Энэ чинь ямар утга учиртай юм бэ? Нийслэлийн захирагч төсөв баталж байсан хурал дээрээ ярьж байна лээ. Бид нүүрсний бизнес эрхэлж, тэр шаардлагатай **LRT** [Light Rail Transit], **BRT** [Bus Rapid Transit] ГЭЭД төслүүдээ явуулна гэнэ.

Энэ стратегийн орд гээд Үндсэн хуульд оруулсан олон зүйл заалтууд чинь ер нь хамаарал байна уу? Энэ Улсын Их Хуралд.

Тодорхой ярья л даа. Энэ Эрдэнэс Баянбогд гээд компани Улаанбаатар хотын хөгжлийн корпорац 66 хувийг нь эзэмшдэг гэж байгаа юм. Тэгээд эд нар ер нь Дорноговь аймгийн Айрагт тэр муу хэлэгдээд байдаг **AREVA** уран хайж явж байгаад нүүрсний орд илрүүлсэн юм билээ.

Үүнийг Монгол Улсын Засгийн газар буцааж өгсөн. Тэр үед хотын захирагч, Уул уурхайн сайд байсан юм байлгүй дээ, бодвол. Тэгээд мэдээлэл арай давуу. Тэгээд тэр мэдээллийн давуу эрхээ ашиглаад тэр орд газрыг нийслэлийн өмчлөлд авчихсан юм уу даа. Ингэж болох юм уу?

Тэгээд энд хууль хүчнийхэн ч байна. Төрийн түшээд байж байна. Энэ асуудлыг зогсоо. Энэ эргээд Эрдэнэс Тавантолгойгоос илүү том хулгай болно. Эрдэнэс Тавантолгой дээр **offtake** гэрээг сайн муугаар хэлээд байна. Байх ёстой. Дэлхий дээр байх ёстой гэж байна. Байх ёстой байх аа.

Тэгэхдээ нууцаар хийсэн нийт **offtake** гэрээ чинь 18 их наяд 710 тэрбум төгрөг юм байна шүү дээ. 5 тэрбум 400 орчим сая доллар. Тавантолгой 2010 оноос хойш үйл ажиллагаа явуулаад. Эрдэнэс Тавантолгой нийтдээ хэд юм бэ. 86 сая тонн нүүрс л борлуулсан юм байна. Тэр нь 12 их наяд төгрөг шүү.

Тэгээд ингээд бодоод үзэхээр өнөөдөр олон сайхан юм яриад байгаа юм. Эрдэнэс Тавантолгойн 1072 хувьцааг баталгаажуулах асуудал. Энэ чинь ирээдүйд олох 6 жилийнхээ нүүрсний борлуулалтаа бид бүгдийг нь **offtake** гэрээ болгочихсон байна.

Эрдэнэс Тавантолгой жилдээ хамгийн дээд тал нь 15 сая тонн нүүрс экспортод гаргасан ийм л тоон үзүүлэлттэй байдаг юм билээ.

Тэгэхээр **offtake** гэрээг нууцалж байгаад хийсэн энэ төмөр зам. Дээрээс нь нэг сонин юм байгаа шүү дээ. Нефть дамжуулах хоолойн төслийг тэрбум орчим доллароор ингээд гэрээ хийчихсэн.

Тэр ер нь Эрдэнэс Тавантолгойд ямар хамаатай юм.

Яагаад өөрт нь. Төмөр зам нь ч яах вэ, эзэмшээд тэндээсээ орлого олоод л магадгүй тэр гэрээний дагуу төлбөрөө төлдөг юм байгаа биз. Үл хамаарах тэр бүх л төслүүдийг энэ төрийн өмчит компаниуд санхүүжүүлээд байгаа юм бэ. Үүнийг хэн мэдээд байна вэ? Энэ л хамгийн том асуудал нь байхгүй юу даа. Энэ чинь өөрөө бизнес юм уу, төсөв юм уу?

Г.Занданшатар: Ажлын хэсгээс хэн хариулах юм. Ажлын хэсэг байна шүү дээ. Ажлын хэсгээрээ хариулаарай.

Б.Бямбадагва. Индэрийн 1 номер. Баяраагийн Бямбадагва. Төрийн нарийн бичгийн дарга. 1 номер.

Б.Бямбадагва: Асуултад хариулья.

Тавантолгойтой холбоотой төслийн энэ асуудлууд 2022 оноос өмнө Засгийн газрын тогтоол шийдвэрээр хэрэгжээд явж байдаг. Цаашид экспорттой холбоотой асуудлыг биржийн журмаар зохицуулалт хийхээр ажиллаж байгаа.

Тэгээд түр журам болон Биржийн хууль өргөн баригдаад эцсийн хэлэлцүүлэг рүүгээ ороод явж байгаа.

Яг тэр яригдсан төсөлтэй холбоотой 34 хувийг Эрдэнэ Монгол компани дээр эзэмшлийн хувьтай байгаа гэсэн мэдээлэлтэй байгаа. Нийслэл дээр бүртгэлтэй байгаа. Тийм.

Г.Занданшатар: Жигжидийн Ганбат. 92.

Ж.Ганбат: Н.Ганибал гишүүний асуултад хариулья.

Эрдэнэс Тавантолгой компани дээр яг өөрийн үндсэн нийтдээ 11 төслийг энэ Эрдэнэс Тавантолгой компани санхүүжүүлэгчийн хувьд ингэж оролцож өнөөдрийг хүртэл явж ирсэн байгаа.

Үүн дээр тэр төмөр замтай Гашуунсухайт болон Богд хаан төмөр замтай холбоотой нийтдээ 5 төсөл, гэрээ байгаа. Тусдаа. Мөн өөрөөр яг энэ дээр тэр Тавантолгой Гашуунсухайт чиглэлийн төмөр замын санхүүжилттэй болон төлбөрийг нүүрсээр барагдуулах хоёр гэрээ, Богд хаан төмөр замын санхүүжилт болон төлбөрийг нүүрсээр барагдуулах 3 гэрээ гээд.

Мөн баяжуулах үйлдвэртэй холбоотой “Загийн усны хоолой” гээд. Тэгээд Тавантолгойн далд уурхайн хайгуул, судалгааны ажил гээд энэ нийтдээ 7 гэрээ ил болгосон.

Үүнээс гадна дахиад Тавантолгой компани дээр нийтдээ хэд хэдэн гэрээнүүд хэрэгжиж байгаа төслүүд байгаа. Үүнд гол төслүүд нь юун дээр байгаад байгаа юм.

Тавантолгойн дулааны станц байна. Газрын тос дамжуулах хоолой гэсэн ийм төслүүд. Тэгээд дээрээс нь Тавантолгой төмөр замын холбоо төмөр зам, Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв, Тавантолгой, Зүүнбаян чиглэлийн төмөр зам гээд ингээд нийтдээ 11 төслийг Эрдэнэс Тавантолгой компани зөвхөн санхүүжилтийн хувьд оролцож ирж байгаа юм.

Энэ төслүүдийн хувьд Эрдэнэс Тавантолгой компани захиалагчийн

хувьд төмөр замууд дээр нь “**Монголын төмөр зам**” болон “**Тавантолгой төмөр зам**”. Тавантолгойн станцын хувьд Эрчим хүчний яам газрын тос боловсруулах үйлдвэр, газрын тосыг дамжуулах хоолой дээр оролцоод явж байгаа юм.

Төрийн өмчит 100 хувь компанийн хувьд төр буюу засаг өөрсдөө шийдвэрээ гаргаад зөвхөн санхүүжүүлэгчийн хувьд Эрдэнэс Тавантолгой компаниар хариуцуулахаар ингэж засгийн шийдвэрүүд гараад хэрэгжээд явж байгаа.

Гэхдээ нүүрсээр болон бэлэн мөнгөөр энэ санхүүжүүлэх хэлбэрээр. Саяын төсвийг нэмэх нь Тавантолгой түлш дээр гэсэн ийм нийтдээ 11 төслийг санхүүжүүлж өнөөдрийг хүртэл болж ирсэн.

Үүнийг бодит байдлаар нь газар дээр нь харахад дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ гайгүй үед, мөнгөн хөрөнгийн хувьд асуудалгүй үед санхүүжүүлээд явчаж байна. Үнэ буурах болон сая энэ КОВИД-ын үеийн нөхцөл байдалтай уялдуулан яг үүнийг дагаад санхүүжилтийн хувьд хүндрэлүүд үүсэж байна. Дагаад л иймэрхүү байдлууд үүсчихдэг.

Тэгэхээр ер нь цаашдаа яг Тавантолгой компаниас гарч байгаа нэг төгрөг болгоныг эргээд үр ашгийг нь энэ компани өөрсдөө хүртээгээд бизнес зарчмаараа явдаг ийм голдрилд нь оруулж өгөх нь зөв юм байна гэдэг ийм байдлаар.

Өнөөдрийн байдлаар төмөр замд Гашуунсухайт төмөр зам, Зүүнбаян төмөр замдаа 3.4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт Эрдэнэс Тавантолгой компани хийчихсэн байгаа юм. Энэ

мөнгийг буцаагаад Монголын төмөр замаас бид тарифын болон хөнгөлөлтүүдээ эдэлнэ. Давуу байдлаа ашиглаад тарифын хөнгөлөлтөө авна. Ийм байдлаар нь оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөж, бизнесийн ийм зарчмаар л явах нь зүйтэй юм гэдэг ийм байдлаар.

Зарим нэг төслүүд нийгмийн шинж чанартай. Жишээ нь, Тавантолгой түлш энэ тэр дээр бид оруулсан хөрөнгө оруулалтаа хяналтаа тавиад, зарим нь нийгмийн хариуцлагын хүрээн дээрээ үүнийг санхүүжүүлээд явахад болохгүй гэсэн юм байхгүй гэдэг ийм байдлаар зарчим баримтлаад, зарим нэг төслүүд дээр хувь оролцоогоо нэмэгдүүлэх байдлаар хяналтаа тавиад оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөөд, өгснийхөө дараа жишээ нь ТУЗ-аас нь болон буцаад гараад явчих ийм санхүүжилтийн схемүүдийг зөв голдиролд нь оруулаад явъя гэдэг ийм байдлаар төслүүд дээрээ өөрчлөлтүүдийг хийгээд явж байгаа.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя.

Н.Ганибал: Уул уурхайн яамныхан ирчхээд байх шиг байна.

Энэ хувийн компани өөрийн хөрөнгөөр хайгуул хийгээд нөөцийг нь тогтоогоод улсад өгөөд тэр улс дараа нь тэр нөөц тогтоосон талбайг яг ямар хуулиар яаж зохион байгуулдаг юм бэ?

Хоёрт, нь төрийн өмчит орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд тухайн нутаг дэвсгэр дээрээ тэр хүмүүсийн ажил, амьдралыг сайжруулах тал дээр орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд байгуулагддаг байх.

Түүнээс бусдын нутаг дээр уурхай байгуулаад, тэгээд түүгээрээ ашиг олоод дэд бүтцийн ажил хийнэ гээд байгааг л сайн ойлгохгүй байгаа юм. Одоо Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газарт Өмнөговь аймагт нэг уурхай нээж өгвөл тэр мөнгөөрөө аймгийнхаа төв дээр зам барихтай л адилхан л асуудал яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр хариулт авмаар байна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Ж.Ганбат дарга хариулья.

Ж.Ганбат: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. Баяраагийн Бямбадагва. Төрийн нарийн бичгийн дарга.

Л.Баярмандал: Н.Ганибал гишүүний асуултад хариулья. Ашигт малтмал, газрын тосны дарга Л.Баярмандал байна.

“Эрдэнэс Баянбогд” төслийн хувьд Эрдэнэс Монгол компанид энэ ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн байгаа.

Тэгээд Эрдэнэс Монгол компани нийслэлтэй хамтарсан компани байгуулсан гэж ойлгосон. Тэгээд энэ компанийн 34 хувь нь Эрдэнэс Монгол эзэмшилтэй, 66 хувь нь нийслэлд эзэмшилтэй байгаа гэж ойлгож байгаа. Ийм хамтарсан компани гэж ойлгож байгаа.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: 41 их наяд төгрөгийн нүүрсний хулгай гэж яригдсан.

Тэгээд энэ 40 их наядаасаа ядаж 4 их наяд олж ирээрэй. 40 тэрбум авчирлаа гэсэн. Мянганы нэгийг нь ярьчихсан сууж байх вий гэдэг ийм болгоомжлол байна.

Тэгээд энэ хуулийнхан, эрх баригч нар хариуцлагатай ажиллаарай гэж хэлье.

Тэгээд цаашдаа энэ хулгайг цэгцлэх талаар гурван санал байна.

Нэгдүгээрт offtake гэрээний хулгай байгаа. Энэ offtake гэрээгээ ил болго. Үлдсэн гэрээнүүдийг. Тэгээд offtake гэрээнүүд бүгдээрээ 60 долларын амны үнээр гэрээ хийгдсэн байгаа.

Тэрийг өнөөдөр Эрдэнэс Тавантолгой 100 доллар, 109 доллароор борлуулалт хийж байгаа. Ядаж 100 доллар луу авчрах тэр ажлыг ойрын хугацаанд хийх хэрэгтэй.

Дээрээс нь төмөр замын мухар зам баригдсан тэр мухар замуудыг холболт нь хийж дуустал тэр дээгүүр нь тээвэр хийж явах хүртэл нь төмөр замын offtake гэрээнүүдийг бүгдийг нь цуцал. Төмөр замаа холбочоод тэгээд ачаа ачих дээр хамгийн түрүүнд тэр өөрсдийнхөө нүүрсийг зөөгөөд гаргадаг юм байгаа биз.

Хэрвээ тэр “Бодь интернэйшл” энэ тэр гэрээгээ өөрчлөхгүй гээд том том юм яриад сууж байна гэсэн. Би болохгүй бол Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлэн болгочихсон байгаа. Төмөр замын offtake гэрээнүүдийг зогсоох энэ тогтоолын төслийг бэлэн болгочихсон байгаа. Өргөн барина.

Хоёрдугаарт нь, нүүрс худалдах, худалдан авах гэрээний хулгай байж байгаа.

Тэгээд янз бүрийн том том албан тушаалтнууд Эрдэнэс Тавантолгойн Б.Ганхуяг дээр очоод 200 мянган тонн, 300 мянган тонн, 500 мянган тоннын гэрээ зураад өгчих гээд дундаас нь 2-ос 5 доллар авдаг ийм юм байгаа.

Тэгээд энэ нүүрсний хулгай эхлээд маш их эрчтэй гарч ирсэн. Тэгээд Б.Ганхуяг нь хоригдонгуут 19 ч билүү Их Хурлын гишүүн, 2 сайдын нэрийг мөрдөн байцаалтдаа хэлсэн ийм сураг байгаад байгаа юм. Тэгэнгүүт одоо энэ баларсан юм болох юм байна гээд одоо ингээд нэг ийм. Нүүрсний хулгай чинь нэг тийм чимээгүй болох тийм түвшин рүүгээ яваад орж байна шүү дээ.

Тийм учраас хууль хяналтын байгууллагынхан энэ дээр маш хариуцлагатай ажиллах ёстой. Олон түмний нүд харж байгаа шүү гэж хэлмээр байна.

Гуравдугаарх нь, энэ түмний нүдэн дээр гараад байгаа тэр нүүрсний тээврийн хулгай байгаа. Тэгээд яг энэ өнгөрсөн 9 сар, 10 сарын үед нэг банк дизелийн түлш, одоо шатахуунаараа. Нэг банк шатахуун цэнэглээд л түүгээрээ 360 сая төгрөг олж байсан. 360 сая төгрөг. Банк бензинээрээ 360 сая төгрөг олдог бизнес гэж энэ хаана байдаг юм бэ? Ийм луйвар гэж хаана байдаг юм бэ?

Тэгээд үүнийг цэгцлэх ажлыг маш хурдан хийх ёстой. Тэгээд хоосон машинууд маш их гарсан байна гэж ярьдаг. Энэ хоосон машинууд чинь эхлээд шинэ машин ирээд гаалийн татвараа төлөөд ороод ирнэ. Орж ирэнгүүтээ буцаад заавал хятадын хил гарч байж өөрийнхөө тэр нөгөө нэг жин тонныг нь үзүүлнэ. Дээрээс нь янз янзын нууж хаах газрууддаа шалгуулна. Тэгж

байж дараа нь автоматаар хилээр гарах тэр бүртгэлээ хийлгэдэг байхгүй юу,

Тийм учраас энэ дээрээ хуулийн байгууллагынх нь энэ жолооч нарыг хий хардаж энэ хоосон машин гаргасан байгаа тухай асуудлаараа тодорхой мэдээлэлтэй болох хэрэгтэй.

Тэгээд Эрдэнэс Тавантолгой энэ богинын тээврийг цэгцлэхийн тулд саяхан тендер зарласан байна лээ.

Тэгэхээр би нэг зүйлийг л хийгээч ээ гэж байгаа юм. Нэг тонн нүүрсийг 40 мянган төгрөгөөр тээвэрлэх юм бол сард 3 удаа эрх өгчих. Тэр жолоочид. 50 мянгаар тээвэрлэх юм бол 2 удаагийн эрх өгчих. 60 мянгаар тээвэрлэнэ гэж санал өгөх юм бол сард.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах юм. Ажлын хэсэг. Сандагийн Бямбацогт. Зам тээврийн хөгжлийн сайд.

С.Бямбацогт: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр төмөр замууд offtake гэрээгээр хийгдсэн төмөр замууд дээр ажлын хэсэг гарсан. Аудит гарсан.

Мөн тодорхой шалгалтууд хийгдэж байгаа.

Энэ барьсан төмөр замуудыг холбож, Хятадын төмөр замтай холбож, бүрэн хүчин чадлаар нь ашиглах. Мөн барьсан төмөр замууд дээрээ зүтгүүр вагон хөдлөх бүрэлдэхүүнтэй болж аль болох хурдан хугацаанд нүүрс тээвэрлэж, нүүрсний тээврийн зардлыг бууруулах, аль болох экспортынхоо ачааг нэмэгдүүлэх тал дээр Монгол Улсын Засгийн газар, холбогдох байгууллагууд

Зам тээврийн хөгжлийн яам ажиллаж байгаа.

Ер нь асуудлууд байсан уу гэвэл байсан. Энэ асуудлуудыг засаад залруулаад хурдан шуурхай хугацаанд хэвийн голдрилд нь, үндсэн бизнесийнх нь зарчмаар ажиллуулах тал анхаарч ажиллаж байгаа. Өөрөөр хэлэх юм бол аль болох хурдан хугацаанд вагон зүтгүүр оруулж ирж нүүрс тээвэрлэх. Мөн хурдан хугацаанд Гащуунсухайтын төмөр зам Ганцмодыг холбох. Мөн Хангимандалын төмөр замыг холбох энэ ажлуудыг хийхээр шуурхай арга хэмжээ авч ажиллаж байгаа гэдгээ танд хэлье.

Тэр тээвэрчидтэй холбоотой асуудал ярьж байгаа юм. Тэр богинын тээвэр дээр. Нэг банк бензинээр 360 сая гэж. Хэтэрхий өндөр үнэтэй байгаа нь үнэн. Гэхдээ энэ бас яг ингэхийн тулд бөмбөлөг болдог. Бөмбөлөг болохын тулд эмч, тогооч, сувилагчаас авхуулаад байр байшин, халуун хүйтэн ус тийм үү, ингээд маш их хөрөнгө оруулалтууд хийдэг. Үүнтэй холбоотой зардал гардаг. Өдөр болгон гардаггүй. Сардаа нэгээс хоёр удаа, сардаа гурван удаа гардаг гээд бас нэлээд өндөр зардал гардаг юм билээ. Энэ богинын тээвэр дээр. Үүнийг нэг харгалзан үзэх ёстой юм билээ.

Гэхдээ бас энэ бөмбөлөгтэй холбоотойгоор юу гэдэг юм зарим эрх мэдэлтнүүдийн, дарга нарын бөмбөлгүүд нь ган бөмбөлөгүүд хагарахгүй олон удаа гардаг. Зарим ядарсан жолооч нарын бөмбөлөг бол өдөр болгон хагараад гарч чаддаггүй. Маш их зардал гаргадаг мөртлөө. Иймэрхүү ялгавартай асуудлууд байсан. Хууль хяналтын байгууллагууд үүнийг шалгаад тогтоох байх. Тогтоох ч байх гэж бодож байгаа.

Тэртээ тэргүй мэдээлэл нь ил тод байгаа. Үүнийг бид шударга, ил тод болгох ёстой. Ёстой.

Энэ тал дээр үүнийг зөв ойлгомоор байгаа юм. Эрдэнэс Тавантолгой компани ч гэсэн ялгаа байхгүй. Одоо тээвэр хийхдээ хэтэрхий өндөр үнэтэй богинын тээврийг багасгах тал дээр анхаарах ёстой. Хэтэрхий бага үнэтэй уртын тээвэр дээр тодорхой хэмжээг тарифыг нэмэх талаар анхаарах ёстой.

Зам, тээврийн хөгжлийн сайдаас жишиг тариф баталсан байгаа. Энэ тал дээр анхаарах ёстой. Гэхдээ нөгөө нээлттэй, ил тод, шударга тээврээ хийдэг бололцоо, боломжийг бүрдүүлэх ёстой. Өрсөлдөөн байх ёстой. Тэгэхдээ хэтэрхий юу гэдэг юм, доод үнэ гэдэг байдлаар хандаж болохгүй. Хэтэрхий доод үнээр хандчих юм бол тэр Хятадын нүүрс худалдаж авч байгаа томоохон компаниуд нүүрснээсээ ашиг олдог болохоос тээврээс ашиг олдоггүй.

Тэгвэл Монголын энэ хэдэн ядарсан жолооч нар чинь байшингаа, хашаагаа барьцаандаа тавиад 20 хувийн, 25 хувийн хүүтэй зээл аваад тэр зээлийнхээ хүүг төлдөг. Дээрээс нь гэр бүлээ тэжээдэг. Энэ хүмүүс чинь тэр хэтэрхий доод үнээр чинь тээвэр хийж чадахгүй ээ. Энэ нөхцөл байдлыг харгалзан үзэж байж бид тээврээ ярих ёстой.

Тийм болохоор Эрдэнэс Тавантолгой компани цаашдаа үнэ тогтоохдоо энэ шал үнэ, тааз нь энэ коридорыг бий болгож өгөхгүй бол энэ монгол тээвэрчдээс хохирох тийм асуудал байгаа гэдгийг хэлье.

Тэр “Си” зөвшөөрлийн тухайд “Си” зөвшөөрлийг Эрдэнэс Тавантолгой компанид өгсөн байгаа. Урьд нь бөмбөлөг тээврийг Боомтын үндэсний хороо авдаг байсан. Урд нь “Авто тээврийн үндэсний төв” өгдөг байсан. Үүнтэй холбоотой хэл ам нэлээн гардаг байсан. Авлигын асуудал яригддаг байсан.

“Си” зөвшөөрлийг 2022 онд 32 мянган ширхгийг олгосон. Солилцсон нь 38 мянга, олгогдсон нь 28 мянга. Өөрөөр хэлэх юм бол 10 мянгын нөөцтэй байна. Энэ 28 мянгаас “Си” зөвшөөрлөөр хэдэн тонн нүүрс гаргасан бэ гэхээр үндсэндээ 30 орчим сая тонн нүүрс өнгөрсөн 2022 онд экспортолсон байна.

Ингээд үзэх юм бол хангалттай хэмжээний “Си” зөвшөөрлийг олгосон байна. Өнгөрсөн жил. Ирэх жил 2023 онд 50 мянган ширхэг “Си” зөвшөөрлийг олгохоор хоорондоо солилцсон байгаа. Үүнийг үзэх юм бол үндсэндээ бараг 50, 50 сая тонн нүүрсийг гаргах хэмжээний “Си” зөвшөөрлийг хоёр талдаа хангалттай хэмжээний “Си” зөвшөөрлийг олгох бололцоотой болсон байгаа. 2023 онд гэж ойлгож болно.

Тийм болохоор цаашдаа “Си” зөвшөөрөл дагасан хүрэлцээгүй, авлигал гэсэн асуудлууд яригдахгүй.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн 1 минут тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Эрдэнэс Тавантолгой дээд үнэ гээд 42 мянга гээд тавьчихсан байгаа. Нэг тонныг нь.

Тэгэхээр хэрвээ ингэж тавих юм бол нөгөө үндэсний компаниуд чинь бас баларчих гээд байгаа байхгүй юу. Нөгөө

нүүрс худалдан авдаг компаниуд чинь бага үнэ тавьж орж ирээд л тэгээд л нүүрсээ тээвэрлээд яваад өгнө.

Тэгээд дээрээс нь бусад нөгөө жижиг худалдан авагч нар энэ тээврээ хийж чадахгүй. Үндэсний компаниуд балрах ийм нөхцөл байдал руу орчхоод байгаа юм.

“Си” зөвшөөрлөө шууд хажуу талын нэг линк дараад өөрсдөө шууд хэвлээд авчихдаг л юмыг хийхгүй бол “Си” зөвшөөрөл дээр чинь л хамгийн асуудал байгаа. Хэргээр бага тавьж байгаад л. Одоо 10 мянгын зөрүү байна шүү дээ. Тэр чинь уг нь зөндөө “Си” зөвшөөрлөө өгчихсөн бол илүү л экспортлох боломжтой байсан. Тэрийгээ ингээд бага тавьж байгаад тэр дээрээ авлигал, хээл хахуулийн нөхцөл байдал үүсгэдэг. Ийм учраас энэ хил хоорондын хэлэлцээрээр энэ “Си” зөвшөөрлөө тоог нь нэмэгдүүлэх, аль эсвэл байхгүй болгох талаар сайд ажиллаарай гэж хүсье.

Г.Занданшатар: Эхлээд сайд хариулчих. Дараа нь Жигжидийн Ганбат Бүрэн эрхт төлөөлөгч хариулна.

С.Бямбацогт: Тэгэхээр “Си” зөвшөөрөл өнгөрсөн жил 38 мянгыг олгох бололцоотой байсан. 28-ыг олгосон. 30 сая тонн нүүрс гарсан. Өнгөрсөн жил Монгол Улсын Засгийн газар, холбогдох байгууллагууд бүхий л чадлаараа ерөөсөө аль болох нүүрс ахиу гаргахыг бодож гаргасан.

Яг үүнтэй адилхан ирэх жил бас ингэж л ажиллах байх. Ингэхэд 50 мянган “Си” зөвшөөрөл. Ингэж ажиллана гэж төлөвлөж 50 мянган “Си” зөвшөөрөл солилцсон байгаа.

Тийм болохоор таны хэлж байгаа юу гэдэг юм, аль болох бололцоогоороо гаргах, одоо хүнд сурталгүй болох асуудал дээр “Си” зөвшөөрөл асуудалгүй болох байх.

Харин түрүүн тэр яригдсан хоолтой машин, хоосон машин гээд. Хоосон машин гарч бүртгүүлдэг нь үнэн. Гэхдээ үүнийг далимдуулаад ачаатай нүүрснүүд олон гарсан байгаа. Үүнийг хууль хяналтын байгууллага шалгаж тогтоох ёстой.

Тэгэхгүй бүх машин хоосон. Зүгээр бүртгүүлэх гээд шинэ машинууд хоосон гарчихсан юм билээ. Тэрийг та нар нүүрстэй машин хоосон гарчихлаа гэж яриад байж болохгүй. Энэ хоосон, бүртгүүлэх гэж гардаг машиныг далимдуулж цаад талд нь нүүрстэй машиныг хоосон бүртгэл гарсан олон асуудал байгаа шүү. Үүнийг хууль хяналтын байгууллага нь тогтоох ёстой шүү. Тийм.

Г.Занданшатар: Бүрэн эрхт төлөөлөгч. 92. Жигжидийн Ганбат.

Ж.Ганбат: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулья.

Нүүрсийг цахимаар ил тод, нээлттэй биржийн зарчмаар арилжаалахаар 02 сарын 01-нд ингээд ярилцахаар төлөвлөж байна. Үүнтэй холбогдуулан тээвэрлэлтийн асуудлаа Эрдэнэс Тавантолгой компани өөрсдөө хариуцна. Энэ дээр төрийн худалдан авах агентлаг дээр гэрээний ерөнхий нөхцөл гэдгийн хүрээнд тендерээ зарлачихсан.

Би тендерийг зарлахдаа дотоодын уртын тээвэр, улс хоорондын тээвэр, төмөр зам болон дотоодын авто тээвэр гэдэг ийм байдлаар ангилсан.

Б.Пүрэвдорж гишүүний яриад байгаа яах вэ, бид уртын тээвэр дээр 92 мянга 870 гэдэг тариф гаргасан. Богинын тээвэр дээр бид 43 мянга 203 гэдэг тариф гаргасан.

Мэдээж энэ дээр бид бол үндэсний компаниудаа, үндэсний тээвэрлэгчдээ дэмжсэн ийм бодлогыг баримталж байгаа. Нөгөө талдаа яах вэ, мэдээж олон машинтай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөрөнгө оруулалттай компаниуд үүнийг унаагах ийм эрсдэл байгааг үгүйсгэхгүй.

Энэ талд нь бид төрийн худалдан авах агентлагтай яриад хэт доогуур үнэ өгч орсон юмнуудыг.../минут дуусав/

Г.Занданшатар: 92. Жигжидийн Ганбат Бүрэн эрхт төлөөлөгч гүйцээж хариулья.

Ж.Ганбат: Хэт доогуур үнэ ингэж өгч, зохиомлоор үнийг буулгах гэсэн ийм хандлага гарахыг үгүйсгэхгүй.

Бид энэ дээр төрийн худалдан ахуйн агентлагтайгаа хамтраад 10 байна уу, 15 хувиас доошоо орж ирсэн юм бол энэ зохион байгуулалттайгаар үүнийг унаагах гэж байна гэдэг ийм байдлаар зохицуулалт хийж, энэ дээр бас хяналт тавих нь зөв юм гэдэг ийм байр суурьнаас хандаж байгаа.

Өнөөдрийн байдлаар нийтдээ 80-аад тээврийн компаниуд энэ тендерт оролцох хүсэлтээ ирүүлчихсэн байна. Бид нэмэлт сургалтуудыг хийж байна. Зааварчлагаанууд өгч байна. Зарим нь тарифын асуудлууд дээр бас нэмэлт тодруулга ийм асуудлууд өгөөд аль болох энэ тендерийг бид амжилттай, үндэсний компаниуддаа боломж, давуу байдал

өгсөн ийм байдлаар үүнийг зохион байгуулаад бид энэ биржээр нүүрсээ арилжих юмыг амжилттай зохион байгуулах нь түүхийн шийдвэр. Бид хил нөхцөлөөр нүүрсээ үнэ хүргээд хоёр дахин нэмэгдүүлэх ийм боломж байна. Тийм.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой, магадгүй Монголын нийгэмд өмнө нь үүсэж байгаагүй маш том хулгайн асуудал үүссэн.

Бид энэ хулгайтай тэмцэх ёстой. Энэ хулгайн асуудлыг цэгцлэх ёстой. Буруутай этгээдүүдэд хатуу хариуцлага, энэ цээрлэлийг нь хүлээлгэх ёстой гэж харж байгаа.

Тэгэхээр би нэгдүгээрт энэ хулгай нүүрлэх үед ажил алба хийж явсан, хариуцлага үүрч явсан энэ хүмүүс одоо өнөөдөр хэрэв ямар нэг албан тушаал хариуцаж байгаа бол эндээсээ бүгд чөлөөлөгдөх ёстой. Шалгуулах ёстой. Буруутай бол хариуцлагыг нь хүлээгээд гарах ёстой.

Би энд хяналтын гурван механизм өөрөө ажиллаагүй байна гэж харж байгаа. Энэ асуудлыг бид дараа дараадаа үүсгэхгүй байх үүднээс гурван түвшингийн хяналт өөрөө байхгүй болсон байна гэж харж байгаа.

Хамгийн нэгдүгээр асуудал бол компанийн хяналт. Энэ өөрөө юуг хэлэх вэ гэхээр төлөөлөн удирдах зөвлөл. Магадгүй Төрийн өмчийн хороо, Засгийн газрын асуудал байгаа. ТУЗ нь хэн байсан юм бэ, ямар хүмүүс байсан юм бэ, хэн хариуцлага хүлээж байсан юм бэ, хэн

дарга нь байсан юм бэ. Тэр хүмүүс ажлаа хийх ёстой байсан. Одоо хариуцлагаа хүлээх ёстой. Эндээс бултаж болохгүй. Цалинг нь авч тэр ямбыг нь эдэлчхээд өнөөдөр тэр үүрэг хариуцлагаас нь зугтаагаад байж болохгүй гэж харж байгаа.

Хоёрт, хил, гааль, нүүрсний тээврийн хулгай гээд 5 их наядын асуудал яригдаж байгаа. Бараг 5 мянга орчим машин 2010-2011 оны хооронд, 2018-2022 оны 04 сарын 30-ны хооронд гэсэн мэдээллийг бид бүхэнд энэ ерөнхий хяналтын сонсголын тайлангийн үеэр өгсөн.

Тэгэхээр энэ хил хяналтын байгууллагууд, ажил үүрэг хариуцаж байсан хилийн байгууллагынхан, гааль, цагдаа, тагнуулын байгууллагын нөхдүүд ч гэсэн бас энэ асуудалд чөлөөлөгдөөд шалгуулаад хариуцлагаа хүлээх ёстой гэж харж байгаа.

Гуравт, хууль хяналтын байгууллагынхан. Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурор энэ хулгай нүүрлэх үед хариуцлагагүй хандаж байсан бол энэ асуудлууд дээр хариуцлагаа хүлээгээд явах ёстой гэж би харж байгаа.

Үүнтэй холбоотой ер нь бид дараа дараа нь энэ асуудалд нухацтай хандаж, энэ асуудлыг дахиж нүүрлүүлэхгүй байх, хулгайг бий болгохгүй байх энэ орчин бүрдүүлэх ёстой.

Тэгэхээр энд би хамгийн гол асуудал бол энэ тогтолцоотой холбоотой, засаглалтай холбоотой асуудал. Бид энэ төрийн оролцоог хязгаарлах ёстой. Төрөөс хамааралгүй өнөөдөр энэ компаниуд ажилладаг. Өнөөдөр хэрэв төрийн өмчид байх юм бол төрөөс

хамааралгүй ажилладаг байх нөхцөлийг бид бүрдүүлэх ёстой. Чадахгүй бол бид нэг талдаа энэ асуудлыг либеральчлаад, чөлөөт зах зээлийнх нь зарчмаар хувьчлаад зах зээлдээ даатгаад ингээд орох ёстой байгаад байгаа юм. Тэгвэл тэр алхмыг хийе.

Нөгөө талдаа бид энэ төрийн оролцоотой, төрийн хяналттай энэ эдийн засгийн хөгжүүлнэ гэж байхгүй гэдэг нь харагдлаа. Төрийн өмчийн компаниудыг хөгжүүлээд явахгүй гэдэг нь харагдлаа. Төрийн өмч байгаа цагт тэнд хулгай байна гэсэн үг. Нэг талдаа төрийн өмч байвал энэ өөрөө социализм гэсэн үг. Социализм байгаа газар хулгай байна гэсэн үг.

Тэгэхээр бид социализм байгуулах гээгүй юм бол энэ төрийн олон өмчит компаниудаа ер нь болих ёстой. Чөлөөт зах зээлийнх нь зарчмаар явна гэдэг асуудлыг бид Үндсэн хуулиараа тунхагласан. Энэ зарчмаа баримтлах ёстой байгаад байгаа юм.

Тэгэхээр компанийн засаглалыг нь хөгжүүлэх, сайжруулах. Зүгээр жирийн хувийн өмчийн тэр компаниудын 60 мянган аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил тэр эрүүл бүтэц, тогтолцоог нь бид бүрдүүлэх ёстой.

Өнөөдөр ч гэсэн энэ бүрэн эрхт төлөөлөгч буюу БЭТ гэдгийг томилж байгаа асуудал бол энэ хүн бол төрийн захиргааны албан хаагч.../минут дуусав/

Г.Занданшатар: Эхлээд хариулна. Хариулсны дараа л. Тийм. **Ц.Цэрэнпунцаг.** Цэдэндамбын Цэрэнпунцаг. Байнгын хороон дарга хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Г.Тэмүүлэн гишүүний сая ерөнхийдөө гаргаж байгаа саналтай нэг байна.

Яагаад гэвэл энэ чиглэл рүү бид ямар ч байсан ерөнхий хяналтын сонсголын үр дүн бол одоо энэ гарсан алдаа дутагдал, нүх, цоорхойнуудыг хааж, цаашдаа дахиж ийм үйлдэл гаргахгүй байх энэ хаалтуудыг хийх ёстой.

Энэ чиглэлд угаасаа ерөнхий хяналтын сонсголын тайлан хэлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Их Хурлын тогтоол дагаж гаргая гэж байгаа юм. Ингээд төсөл хэлбэрээр гарчихсан байгаа. Энэ бүхнийг Та бүхэн авч төсөл дээр санал өгч идэвхтэй оролцох хэрэгтэй байна.

Яг таны саяын гаргаж ирсэн асуудалтай холбоотойгоор энэ хоёр төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр юу хийх юм бэ гээд энэ тогтоолын төсөл дээр байгаа энэ хоёр, гурван заалтыг танд уншиж өгье.

А.Төрийн өмчит болон түүний оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд улс төрийн болон төрийн өндөр албан тушаалтан хууль бусаар хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх заавар чиглэл өгөхийг хориглох, хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Б.Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн компани болгох, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах, удирдлага, хяналтын үйл

ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангуулан ажиллах.

Ингээд Монгол Улсын иргэдэд Эрдэнэс Тавантолгойг хавьцаат компанийн хувьцааг Монгол Улсын иргэд эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судлан саналаа эрх бүхий байгууллагад оруулж шийдвэрлэх гэсэн ийм гурван зүйл, заалттай ийм чиглэлийг Засгийн газарт өгөхөөр энэ төсөл дээр явж байгаа юм.

Дээрээс нь та мэдэж байгаа. Биржийн хуулийг дагаж гарах Улсын Их Хурлын тогтоол байгаа. Энэ тогтоол дээр бас энэ санаанууд давхацсан.

Сая манайх өчигдөр мэдээ харж байхад 5 гишүүн Их Хурлын даргад бас Их Хурлын тогтоолын төсөл санаачилж өргөн барьж байна лээ. Энэ дээр санаанууд давхцаж байгаа.

Энэ бүгдийг бид нар жигдлээ энэ чиглэлд нь нэг мөр шийдлийг нь гаргаж өгсөн, арга замыг нь гаргаж өгсөн энэ чиглэл рүү ажил хийгдэнэ гэж хэлье.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууна. 1 минут.

Г.Тэмүүлэн: Хэнээс асуухаа сайн мэдэхгүй байна. Сайд нар байхгүй байна. Төрийн өмчийн хорооны дарга байна уу? Байхгүй байна. Уул уурхайн сайд байхгүй байна.

Гол нь яг өнөөдөр жишээ нь бид нар бараг 200, 300 гаруй төрийн өмчийн компаниуд байгаа. Энэ бүх төрийн өмчийн компаниудын ТУЗ-ийн дарга нар чинь хариуцлага хүлээж байх ёстой

хүмүүс чинь, хяналт тавьж байх ёстой хүмүүс чинь бүгд дандаа төрийн албан хаагч нар байгаа. Бүгд дандаа яам, Тамгын газрын газрын дарга нар, Төрийн нарийн бичгүүд байгаад байгаа юм. Урьд нь огт бизнес хийж үзээгүй. Зөвхөн төрөөр ажиллаж байсан хүмүүс. Ийм хүмүүс төрийг авч явна гэж байхгүй шүү дээ.

Тэгэхээр яг өнөөдөр хэдэн компанид, хэчнээн төрийн албан хаагч ТУЗ-ийн гишүүн хийж байна вэ? Хэн хариулах юм бэ? ТУЗ нь хэн байна вэ?

Өнөөдөр Эрдэнэс Тавантолгой компанийн төрийн өмчийн эзэмшигч нь хэн байгаа юм. Хувьцаа эзэмшигч нь. Хуучин Д.Сумъяабазарын үед Уул уурхайн яам байсан байх. Сүүлд нь Төрийн өмчийн хороо болох шиг болсон. Одоо Эрдэнэс Монгол болсон уу, болоогүй юу? Энэ асуултууд дээр хариу өгмөөр байх юм.

Г.Занданшатар: Хэн хариулах юм. Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга хариулья.

Б.Бямбадагва: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулья.

Эрдэнэс Тавантолгой компанийн эзэмшлийн хувь өнөөдрийн байдлаар Эрдэнэ Монгол компанийн 100 хувийн бүртгэлд байгаа.

Төлөөлөн удирдах зөвлөл болон бусад ТУЗ-уудыг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санал болгож томилогдсон байгаа. Холбогдох мэдээллүүд нь Эрдэнэс Монгол компани дээр бүртгэлтэй байгаа.

Г.Занданшатар: Тодорхой юм асуугаад байна шүү. Тодорхой хариулаач.

Үндэсний баялгийн сангийн хууль, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хууль гээд ил тод байдлыг хангах хуулиуд яасан юм.

Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Асуудалд уг нь бид жоохон нухацтай хандаад, хариуцлагатай хандаж, энэ сайд дарга нар энэ асуултуудад уг нь хариулж баймаар байх юм.

Тэгээд би одоо гол асуух гээд байгаа юм нь. Гаалийнхан байна уу? Яагаад энэ хил гааль, нүүрсний тээврийн хулгай 5 их наяд гэж яригдаад байгаа энэ гаалийн бүрдүүлэлтгүй улсын хилээр гарсан, гаалийн мэдүүлэг олдоогүй гээд 3758 машин 2010-2011 оны хооронд гэж байгаа юм. 1748 машин 2018-2022 оны 04 сарын 30-ны хооронд гэж байгаа юм.

Монголын төр яагаад ийм хяналтгүй болчихсон юм бэ? Яагаад энэ дүлий сохор юм шиг байсан юм бэ? Гаалийнхан юу яаж байсан юм, хилийнхэн юу хийж байсан юм, хууль хяналтын байгууллагууд юу хийж байсан юм. Яагаад үүнийг анзаарахгүй өнгөрөөсөн юм. Одоо яагаад энэ тайлан мэдээллийг нь гаргаж нэгтгэж тавиад байгаа юм.

Тэр үед яагаад энэ асуудалд ингэж хариуцлагагүй хандсан юм бэ.

Г.Занданшатар: Эхнээс нь тодорхой хариул. 87. Хуулийн цэргийн газрын дарга, Гаалийн газрын дарга хэн байна. Гаалиас, татвараас. Гааль эхлээд хариул. 85.

Б.Сүхбаатар: Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг

бүртгэх газрын дарга Б.Сүхбаатар. Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулья.

2013 оноос эхлээд Гаалийн ерөнхий газар цагдаагийн байгууллагатай хамтарсан байдлаар удаа дараагийн дотоод шалгалтуудыг хийж ирсэн. Хийж ирсэн.

2018 онд мөн тухайн үеийн Сангийн сайдын 109 тоот тушаалаар байгуулагдсан нүүрсний экспортыг шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

Хамгийн сүүлд 2022 онд мөн хоёр удаагийн ажлын хэсгийг байгуулж ажилласан байгаа юм.

Тэгэхээр энэ тухай тухайн үед байгуулагдсан ажлын хэсгүүдийн дүгнэлтээр илэрсэн зөрчил дутагдлуудыг гаалийн байгууллага дангаараа бүрэн эцэслэн нотолж тогтоох бололцоогүй юм байна. Үүнийг хууль хяналтын байгууллагад зайлшгүй шилжүүлж байж нотолж тогтоох шаардлагатай гэсэн үндсэн дээр.../минут дуусав/

Г.Занданшатар: 85. Гүйцээж хариул.

Б.Сүхбаатар: Тухай тухайн үед шалгасан ажлын хэсгүүдийн дүгнэлтэд дурдагдсан тоо баримтуудыг хүргүүлж байсан. Ажлын хэсгийн шугамаар. Мөн хамтарсан ажлын хэсгийн шугамаар.

Хамгийн сүүлийн байдлаар хууль хяналтын байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийн хүрээнд Гаалийн байгууллагаас 2013-2017 оны хооронд Гашуунсухайтын боомтоор ачаагүй гарсан төлөвтэй 40 мянга 14 тээврийн хэрэгслийн мэдээллийг цагдаагийн байгууллага руу шилжүүлсэн байгаа.

Эдгээрт түрүүн зарим гишүүдийн үгэнд дурдагдаж байсан. Хилээр гарахдаа ачааны тээврийн хэрэгсэл гэж бүртгүүлж гардаг жижиг оврын тээврийн хэрэгслүүд. Жижиг оворын. Мөн импортын ачаа ачиж орж ирэх зориулалттай аж ахуй нэгжүүдийн тээврийн хэрэгслүүд гэх мэтийн хилээр гарахдаа ачааны гэж бүртгэгдээд хоосон гардаг тээврийн хэрэгслүүдийн мэдээллүүд гэх мэтийг ялгаж шүүгээд яг эцсийн байдлаар дээр дурдсан хугацаанд нийтдээ 8 мянга 25 тээврийн хэрэгсэл, 31 мянга 640 удаагийн давтамжаар хилээр нэвтэрсэн мэдээллийг шалгуулахаар цагдаагийн байгууллагад хүргүүлсэн байгаа.

Г.Занданшатар: Болдын Сүхбаатар Гаалийн ерөнхий газрын гаалийн зөрчилтэй тэмцэх хэрэг бүртгэх газрын дарга. Нэрээ хэлээд яваарай. Наадах чинь протокол тэмдэглэгдэж байгаа учраас.

87. Хожгорын Лхагвасүрэн. Бригадын генерал.

Х.Лхагвасүрэн: Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн хариулж байна. Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр Хил хамгаалах байгууллага улсын хил дээр шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулдаг. Энэ нь нэгдүгээрт зорчигчийн бичиг баримтыг шалгаж нэвтрүүлэх.

Хоёрдугаарт нь, тээврийн хэрэгсэлд хил зөрчигчид нуугдаж болзошгүй газар нь үзлэг хийж нэвтрүүлэх.

Гуравдугаарт нь, боомтын аюулгүй байдал.

Дөрөвдүгээрт нь, боомтын дотоод дэг журам гэсэн үндсэн дөрвөн үүрэг хариуцаж байгаа юм.

Энэ шалгагдаж байгаа хугацаа буюу 2011-2014 оны 01 сар хүртэл Хил хамгаалах байгууллага шалган нэвтрэх албыг зохион байгуулсан. 2014 оны 04 дүгээр сарын 01-нээс 2017 оны 02 дугаар сарын 01-ний хооронд одоогийн Гадаад иргэн харьяатын газар шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулсан. 2017 оны 02 сарын 01-нээс хойш манайх шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулж байна.

Тэгэхээр энэ хилээр гарч байгаа зорчигч, тээврийн хэрэгсэл, жолооч гэсэн ийм.../минут дуусав/

Г.Занданшатар: 87. Гүйцээж хариулья. Бригадын генерал Х.Лхагвасүрэн. Хил хамгаалах ерөнхий газрын дарга. 87.

Х.Лхагвасүрэн: Ийм 3 сан бүрдүүлж байгаа юм.

Тэгэхээр өнөөдрийн манай гаргаж өгч байгаа тоо бол он оноороо, боомт боомтоороо үнэн юм.

Энэ бол тээврийн хэрэгсэл аль улсын, ямар дугаартай. Үүнийг жолоодсон жолооч нь аль улсын ямар иргэн, хэн гэдэг вэ гэдгээрээ. Дээр нь шалгасан шалгагч гэсэн ийм бүртгэл одоогийн байдлаар явж байгаа. Энэ мөрдөгдөж байгаа. Энэ дээр ямар нэгэн тоо дарсан, ихэссэн маргаан байхгүй.

Ачааны асуудлыг сая гаалийн байгууллага ярилаа. Ачааг үндсэндээ

манай гаалийн байгууллага мэдүүлэгтэй нь тулгаад шалгаад, тэгээд гаалийн хяналтын бүсээс гаргаж ирээд ингээд явуулдаг юм. Өөр зүйлгүй.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Нууцаас гарсан 5 гэрээ байгаа гэсэн. Offtake-тэй холбоотой. Эрдэнэс Тавантолгой компани бараг өөртэй нь дүйхүйц хэмжээний 10 гаруй төслүүдийг зөвхөн нэг уурхайгаа санхүүжүүлэхээр гэрээжүүлсэн гэсэн асуудлууд яригдаж байгаа.

Тэгэхээр нууцаас гарсан 5 гэрээнээс өөр нууцад байгаа хэдэн гэрээ байгаа вэ? Хэзээ нууцаас гаргах вэ? Хэзээний шийдвэрээр, хэний шийдвэрээр, аль байгууллагын шийдвэрээр нууцад авсан бэ?

Нууцад авсан гэдэг нь нууцад хамааруулсан учраас гүйцэтгэгчийг нь буюу сонгон шалгаруулалтыг ямар нэг тендергүйгээр хийсэн гэсэн үг үү? Шууд хэн нэгнийг гүйцэтгэгчийг сонгосон гэсэн үг үү?

Г.Занданшатар: Хэн хариулах билээ. Жигжидийн Ганбат. Бүрэн эрхт төлөөлөгч. 92.

Ж.Ганбат: Засгийн газар 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 449 тогтоолоор Эрдэнэс Тавантолгой компани дээр байсан нийт 7 гэрээг ил болгосон байгаа. Үүн дээр Тавантолгой Гашуунсухайтын төмөр замын санхүүжилтийн болон төлбөрийг нь нүүрсээр барагдуулах 2 гэрээ, Богд хаан төмөр замын санхүүжилтийн болон төлбөрийг нь нүүрсээр барагдуулах 3 гэрээ. Нөгөө 2 нь тэр яг Эрдэнэс Тавантолгой компанийн өөрийнх нь

хүсэлтийн дагуу Загийн усны хоолой гээд баяжуулах үйлдвэр, усны төсөл. Тавантолгой ордын далд уурхайн хайгуул, судалгааны ажлын гэдэг энэ 2 гэрээ бас нууц байсныг ил болгосон.

Ер нь 6, 7 дахь гээд сая сүүлийн 2 төслийг шууд компани өөрөө хүсэлт гаргаад нууцад хамааруулчихсан ийм байгаа. Энэ бол түрүүний Г.Тэмүүлэн гишүүний хэлдэг шууд худалдан авалт хийх байдлаар ингээд нууцад хамааруулсан ийм юм байна лээ. Сонгон шалгаруулалтгүйгээр.

Нөгөө төмөр замын төслүүд бол стратегийн ач холбогдолтой төслүүд гэдэг байдлаар шийдлүүд нь гаргаад ингээд нууцад хамааруулаад ингээд явсан.

Г.Занданшатар: Жигжидийн Ганбат. Бүрэн эрхт төлөөлөгч. Эрдэнэт толгойн. Гүйцээж хариулья.

Ж.Ганбат: Саяын тэр компани өөрсдөө 2 төслийг өөрсдөө хүсэлт гаргаад нууцад хамааруулчихсан юм.

Ер нь шууд хэлэхэд сонгон шалгаруулалтгүй явуулахын тулд нууцад хамааруулж шууд гүйцэтгэгч сонгодог ийм асуудал байгаа. Ер нь одоогийн энэ хуулийнхаа хүрээнд компани өөрөө хүсэлтээ гаргаад, үүнийг нь тавих дээрээ нууц хамааруулдаг. Үүнийг цаашид гаргахгүй байх нь зүйтэй юм гэдэг ийм байдлаар асуудалд хандаж байгаа.

Нөгөө төмөр замын төслүүд бол угаасаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжтэй, Засгийн газар танилцагдаад ингээд нууцад хамрагдаад ингээд хийгдээд явж байгаа ажлууд байна лээ.

Г.Занданшатар: П.Ганхүү. 94. “Монголын төмөр зам” компанийн захирал.

П.Ганхүү: Г.Тэмүүлэн гишүүний асуултад нэмж тодруулж хариулья.

“Монголын төмөр зам” компанийн байгуулсан 2 гэрээг Засгийн газрын 449 дүгээр тогтоолоор ил болгосон байгаа.

Эхний гэрээ нь Тавантолгой, Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц, дохиол холбоо, эрчим хүч, гүүр хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх гэрээ. Нийтдээ 454.9 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээг “Монголын төмөр зам” компани Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгтэй хийсэн. Энэ гэрээ нууцад байсан. Энэ эхний гэрээ ил болсон.

Хоёр дахь гэрээ нь Тавантолгой, Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ. Энэ гэрээг “Монголын төмөр зам” компани, Зэвсэгт хүчний жанжин.../минут дуусав/

Г.Занданшатар: 94. Гүйцээгээд хариул. Яагаад ингээд таслаад байдаг юм бэ. Хариулж байхад.

П.Ганхүү: Ийм 2 гэрээ байгаа. Үндсэндээ 1 их наяд орчим төгрөгийн ийм гэрээг “Монголын төмөр зам” компани, Жанжин штаб, “Улаанбаатар төмөр зам”-тай дээд, доод бүтцийн ийм 2 гэрээ байгуулсан. Нууцад орсон байсан.

Үүнийг дагалдах гэрээнүүд хийгдсэн байж байгаа. Тавантолгой, Зүүнбаян чиглэлийн төмөр зам 1 их наяд 392 тэрбум гэсэн урьдчилсан төсөвт өртөгтэй. Үүний 750 тэрбумыг нь

Эрдэнэс Тавантолгойд хаалттай бонд гаргаж санхүүжүүлсэн.

Нэмэлт 642 тэрбум төгрөгийн нэмэлт зээлийн гэрээ хийгээд ингээд санхүүжүүлээд явж байгаа. Одоо 100 орчим тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй ийм байна.

Тэгэхээр сая байгуулсан 2 үндсэн гэрээ буюу 454.9 тэрбум төгрөгийн Зэвсэгт хүчний жанжин штабтай байгуулсан гэрээнээс 36.4 хувь буюу 165.4 тэрбум төгрөгийн ажлыг Зэвсэгт хүчний жанжин штаб өөрийнхөө 8 анги бүрэлдэхүүнээрээ хийж гүйцэтгэсэн.

289.5 тэрбум буюу 63.6 хувийг нь 81 гэрээг туслан гүйцэтгэгч компаниудтай байгуулж хийсэн байгаа юм.

“Улаанбаатар төмөр зам” 557.9 тэрбум төгрөгийн энэ гэрээгээ цааш нь хийхдээ 34.8 хувь буюу 194.3 тэрбум төгрөгийг нь өөрөө гүйцэтгэсэн. 65.2 хувь буюу 363.6 тэрбум төгрөгийг 38 гэрээ байгуулж туслан гүйцэтгэгчүүдийг авч хийсэн.

Мөн “Монголын төмөр зам” 359.2 тэрбум төгрөгийн гэрээнийхээ 29.3 хувийн 84 туслан гүйцэтгэгч авч хийсэн байна. Нийтдээ энэ 1.3 их наядын хэмжээнд хийгдсэн. Туслан гүйцэтгэгчийн 203 гэрээ байж байгаа. Өөрөөр хэлбэл энэ нууцад оруулсны дараа энэ Зэвсэгт хүчний жанжин штаб, “Улаанбаатар төмөр зам” туслан гүйцэтгэгчээ шууд гэрээгээр сонгосон байгаа.

Г.Занданшатар: Тэр үнэ ялгаатай гээд л түрүүн асуугаад л байсан.

П.Ганхүү: Тэгэхээр Тавантолгой, Зүүнбаян төслийн тухайд 1 километрийг нь 1 сая орчим доллар буюу 3 тэрбум төгрөг гэсэн ийм тооцоо гарч байгаа. Нийтдээ 462.5 километр дэлгэмэл урттай.

Урьдчилсан төсөвт өртгөөр 1 их наяд 392 тэрбум төгрөг гэсэн ийм тоо гарч байгаа. Харьцангуйгаар хямд баригдсан гэсэн ийм зүйл яригдаж байгаа боловч маш олон зүйлүүд нь дутуу хийгдсэн ийм зүйл. Хэмнэж байна гээд өртөө, зөрлөгүүдийн барилга 12 өртөө, зөрлөгтэй байхаас 6 зөрлөг, 1 өртөөтэй ингэж хийгдсэн байгаа.

Дээр нь өртөө, зөрлөгүүдэд байдаг зайлшгүй байх ёстой багаж, тоног төхөөрөмж гээд 79 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, машин механизмын санхүүжилтийн асуудлаас бас ингээд явцын дунд хасчихсан. Тухайлах юм бол өртөө, зөрлөгийн барилгуудын чанарын гүйцэтгэлийн асуудал байна.

Дээр нь өртөө, зөрлөгүүд говьд тэр 416 километр. Хот суурин газраас алслагдмал газар 44 худаг гаргаад 8-ыг нь ашиглаж байгаа. Бусдыг нь тусгай хамгаалалтын хэрэгцээнд шилжүүлж өгсөн байна. Бүтээн байгуулалтын үед ашиглаж байгаад.

Жишээлэх юм бол энэ усны асуудал дээр усны шүүлтүүрийг нь шидээгүй. Говийн ус хүний эрүүл мэндэд бүрэн нийцсэн ийм ус гарах боломжгүй. Энэ дээр шүүлтүүрийн асуудлыг шийдээгүй орхисон байгаа ч гэдэг юм уу.

Байгаль орчны асуудлаар бүх энэ өртөө, зөрлөгүүд дээр байгаа ариун цэврийн тэр нолийн асуудал нь шууд байгаль руугаа шингэдэг хэлбэрээр ч гэдэг юм уу.

Ингээд дээр нь хөдлөх бүрэлдэхүүний асуудал энэ төсөвт өртөгт нь ороогүй байгаа зэрэг олон зүйлүүд дутуу хийгдсэн байдалтай байгаа учраас ашиглалтад аваад одоо техникийн комисс 2022 оны 12 сарын 27-нд буюу 14 хоногийн өмнө ажилласан.

Тэгээд цаашдаа байнгын ашиглалтад энэ төмөр замыг аваад ашиглахад нэлээд багагүй хэмжээний зардал гарахаар ийм урьдчилсан тооцоо гарч байгаа юм гэдгийг хэлье. Баярлалаа. Хариулж дууслаа.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууна.

Ц.Идэрбат: Нүүрсний хулгайтай үнэхээр Монголын ард түмэн почирдсон ийм л зүйл боллоо л доо. Тэгээд иргэдийн энэ шаардаж байгаа энэ жагсаал бол би органик болсон гэж ингэж харж байгаа.

Тэр эмч нар, багш нар тэр залуучууд эрвийх дэрвийхээрээ л ирж, энэ төр засагтаа үгээ хэлж, ийм бузар булай хулгай байна гэдгийг эсэргүүцэж ингэж хэлсэн.

Дундуур нь бас үймүүлэхийг оролдсон. Хүн болгон л харж байгаа. Энэ хулгайг гаргаж ирж зогсоохын төлөө явсан Ерөнхий сайд руугаа чиглүүлэхийг оролдсон. Гэхдээ Монголын ард иргэд ухаантай учраас энэ нэг их газар аваагүй. Үүнтэй уялдуулаад хэлэлцүүлэг болсон.

Ерөнхий хяналтын сонсгол гэж. Эхнээс нь аваад дуустал суусан. Энэ жагсаалын болж байгаа үйл явц, тавьж байгаа шаардлага, хяналтын сонсгол дээр ирсэн иргэдийн хэлж ярьж байгааг сонсоод байхад монголчууд өнөөдөр нүүрснээс ер нь хэдий хэрийн юм алдсан юм бэ гэдгээ нэг тогтсон тоотой байх

ёстой юм билээ. 40 их наяд л гэнэ, 10 их наяд л гэнэ, 5 их наяд л гэнэ. Тэрийгээ 3 сая 300 мянган хүндээ хуваагаад л тэдийг идчихсэн байна гээд л ингээд л ярьдаг.

Тэгээд хууль хяналтын байгууллагуудын шалгалт шүүлэг дуусаад энэ хохирлыг ер нь яг хэн нэгтгэж Монголын түүхэнд ард иргэдийн боломжоос ийм юмыг бид алдсан, ийм схем байсан, энэ хүмүүс нь ингэж хариуцлага тооцогдсон юм гэж цааш цаашдаа сургамж болох ийм тоо кэйс хэрэгтэй байх гэж ингэж үзэж байгаа юм.

Ер нь одоо ингээд төсөв хэлэлцэхэд ч гэсэн тэтгэврээ нэмэхээр мөнгө байхгүй, хөрөнгө оруулалтаа нэмье мөнгө байхгүй, татвараа багасгаач мөнгө байхгүй, нийгмийн даатгалын шимтгэлээ багасгая мөнгө байхгүй. Тэр битгий хэл НӨАТ-ынхаа буцаан олголтыг нь ганц хоёр хувь нэмчихье гэхээр төсвийн орлого өчнөөнөөрөө тасарна. Боломжгүй гээд л ингээд л байхгүйгээ дуудаад байсан чинь ийм их хулгай явчихсан байхаар чинь энэ Монголын ард иргэд бухимдах нь зүйтэй. Аргагүй. Өнөөдрийн амьдрал ахуй ямар байгаа билээ.

Тэгэхээр миний эхний асуулт бол энэ бүхэн ер нь хэзээ эцэслэгдэж хуулийн хүрээндээ, хугацаандаа хэн үүнийг нэгтгэж Монгол Улсын 3 сая 400 мянган хүнд ямар бодитой хохирол учирсан бэ гэдгийг хэн нэгтгэх юм бэ? Энэ дээр үндэсний аудит байх юм уу, хууль хяналтын байгууллага байх юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нүүрсний хулгай гарсан тогтолцоогоо өөрчилье гээд Засгийн газраас, Их Хурлаас олон хуулиудыг баталж байгаа. Эрүүгийн хууль, Уул уурхайн биржийн хууль гээд Уул уурхайн биржийн хуулийн

хэрэгжилт цаашдаа энэ Монгол Улсын баялаг хяналттай байх тэр 60 доллароор биш 100 гаруй доллароор, 200 доллароор зарах ийм л бололцоог нээх ийм хуулийг анхдагч хууль гэж ингэж харж байгаа юм.

Тэгээд энэ хууль хэзээ мөдгүй хэрэгжиж эхэлнэ. Тэгээд үүнийг хэрэгжүүлэхэд яг ямар бодитой хүндрэлүүд бий болохоор байна вэ? Энэ дээр ямар хүндрэлүүд гарах вэ? Түүнээс яаж сэргийлэх вэ? Энэ дээр Их Хурал, Засгийн газар яаж хамтарч ажиллах ёстой юм.

Энэ хууль ингээд маш үр дүнтэй хэрэгжээсэй гэж үнэхээр туйлын хүсэж байгаа. Энэ цаашдаа Монголын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулах юм.

Дараагийн иргэдийн нэг асуугаад байгаа юм бол энэ төмөр замын гэрээ, тэрний байгуулсан үнэ. Нэг нь тэнгэрт тулсан үнэ гэж ингэж ярьдаг. Нөгөө гүйцэтгэсэн нь болохоор тийм юм байхгүй гэж ярьдаг. Энэ дээр манай Эрдэнэс Тавантолгой хууль хяналтын байгууллагууд үүнийг шалгаж байгаа юу? Яг гэрээний дүнг. Эрдэнэс Тавантолгой энэ дээр ямар байр суурьтай байдаг юм?

Би хоёр талын л юмыг яриад байгаа шүү дээ. Ийм гурван үндсэн асуулт асууя гэж ингэж бодож байна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Сүүлээсээ явъя. Сүүлийн асуултад Эрдэнэс Тавантолгой хариулья. 92. Жигжидийн Ганбат.

Ж.Ганбат: Ер нь манайх Эрдэнэс Тавантолгой компани 2010 оноос үйл ажиллагаа явуулаад 2011 оноос экспортод нүүрсээ ам нөхцөлөөр гаргаж ирсэн байгаа юм.

Ам нөхцөлөөр зарна гэдэг бол бүх тээвэрлэлтийн асуудал, худалдан авагчаа хариуцна. Хямд үнээр аман дээрээс авна.

Одоо Засгийн газраас гарсан Улсын Их Хурлаар батлагдсан Биржийн тухай хуулийн дагуу Засгийн газраас хил нөхцөлөөр нүүрсээ ингээд цахимаар арилжаалах гэж байна.

Хэрвээ хил нөхцөлөөр Монгол Улс нүүрсээ сая 2011 оноос хойшоо зарж чадсан бол бид 4 тэрбум долларын орлого алдчихсан байгаа юм. Бид хил нөхцөлөөр зарж чадсан бол 4 тэрбум долларын орлогыг Монгол Улсад олчих байсан юм.

Ийм учраас бид 02 сарын 01-нд биржээр нээлттэйгээр цахимаар нүүрсээ хил нөхцлөөр арилжаална. Үүнийг ил тод нээлттэй явуулна. Бид тээвэрлэлтээ өөрсдөө хариуцна.

Ингэснээрээ бид өөрөөр хэлбэл тээврийн компаниудаа дэмжсэн, ил тод, нээлттэй болгосон. Ингэж байж бид тээврийн компаниудаас орох орлогоо Монгол Улс бүрэн авдаг болно.

Одоо бол ам нөхцөлөөр явж байгаа учраас худалдан авагч тал тээвэрлэлтээ хариуцаж байгаа учраас бид тээврийн компаниуд хэчнээн төгрөгийн орлого авч байгаа, ямар татвар төлж байгаа нь үе үед маргаан дагуулж ирж байсан. Бүрхэг байгаа. Үүнийг нээлттэй, ил тод болгох байдлаар л бид ажиллаж байгаа.

Ер нь компанийн засаглалын хувьд одоо энэ нүүрсний асуудалтай холбоотой мэдээллийн хэт хаалттай байдлын улмаас хүмүүсийн бухимдал үүссэн шүү дээ.

Эрдэнэс Тавантолгой компани нүүрсийг хямд үнээр борлуулж байсан. Далд хэлбэртэй борлуулж байсан.

Тээвэрлэлт дээрээ хяналт тавьж чаддаггүй байсан. Худалдан авалтын ажиллагаа нь бараг улсын төсвийнхээ 5 хувьтай тэнцэх хэмжээний худалдан авалт хийдэг. Энэ нь далд хэлбэртэй байсан. Энэ дээр нэлээн олон зөрчлүүд байсан. Энэ хууль хяналтын байгууллагуудтайгаа хамтраад шалгаад энэ бүгдийг цэгцэлж байна.

Эцсийн дүндээ төрийн өмчийн компаниудын үйл ажиллагаа ил тод, нээлттэй. Ингэж байж л бид олон нийтэд зөв ойлголт өгнө. Энэ чиглэлд Эрдэнэс Тавантолгой компани үйл ажиллагаагаа сүүлийн хоёр сар чиглүүлээд ажиллаад явж байгаа.

Г.Занданшатар: Бусад асуултад Байнгын хороон дарга хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулья.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль гарсан. Тэгээд хэрэгжилт 07 сарын 01-ээс хэрэгжинэ. Энэ хэрэгжиж эхлэх үед ямар хүндрэлүүд гарах юм бол. Бид хэлж чадахгүй. Хэрэгжээд эхлэхээр ямар асуудал гарах юм.

Энэ урьдчилж бид энэ хуулиа гаргахдаа энэ хүндрэлүүдийг олон талаас нь бодолцож, яг практик амьдрал дээр шаардлагатай бодит үүсэх нөхцөл байдлуудыг бид урьдчилан харж л энэ хуулиа хийсэн.

Хамгийн гол нь энэ дээр уул уурхай юмнаас нэг байр суурьтай байгаа юм. Одоо эд нар энэ хууль хэрэгжих

хүртэл Уул уурхайн яамнаас журам гаргаж энэ бага хэмжээтэй нүүрсээ худалдаалж эхлэх юм.

Тэгээд энэ журмаа гаргаад хэрэгжүүлээд эхлэхээр зэрэг энэ хууль хэрэгжтэл бас яг энэ худалдаа явагдаад эхлэхээр зэрэг бас ямар асуудлууд гарч ирэх нь вэ. Энэ дээр яг гарцаа байхгүй энэ бид нарын гаргасан хууль дээр өөрчлөлтүүд оруулах ийм шаардлагатай нөхцөл байдал үүсэх юм бол бид эргэж авч хэлэлцье гэдэг ийм бас зөвшилцөлтэй, Уул уурхайн яамтай, Засгийн газартайгаа ярьсан ийм зөвшилцөл, ойлголцолд хүрч энэ хуулийг гаргасан. Тэгээд энэ хууль маань хэрэгжээд эхлэхээр энэ дээр тодорхой асуудлууд байгаа бол сайн тал нь, саар тал нь гарч ирэх байх.

Эхний асуулт. Хэн нүүрсний тээвэрлэлт, олборлолт, тэгээд борлуулалттай холбоотой гарсан хулгай зэлгийтэй том асуудлуудыг хэн нь нэгтгэж эцсийн хариуг нь өгөх юм бэ гээд та суугаад байх шиг байна.

Бид мэдээж Их Хурал бол бид энэ асуудлуудыг цааш нь гаргахгүй байх талаар бид энэ хууль эрх зүйн орчныг нь сайжруулах чиглэлд бид Их Хурлаас ажил хийж болно. Энэ чиглэлд бид энэ хяналтын сонголынхоо дүгнэлт дээр нэгдүгээрт нь бичсэн байгаа. Танд би дахиад нэг уншаад танилцуулчихъя.

Энэхүү сонголын үр дүнгээр Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хурлаас нүүрсний хулгайн асуудалтай холбогдуулан шийдвэр гаргах, цаашид ийм байдал гарах үүд хаалгыг нь хаах боломжийг бүрдүүлж, олон нийтийн хяналтыг бий болгож, анхаарлын төвд оруулж чадлаа.

Цаашдаа баялгийн олборлолт, ашиглалт, экспортын асуудлыг ард түмний хяналтад авах нь зүйтэй гэж үзэж байна. Шаардлагатай бол Улсын Их Хурал. Энд хамгийн гол асуудал байгаа юм.

Энэ асуудлаар холбогдох хууль тогтоомжийг нэн яаралтай дэгээр хэлэлцэж, Засгийн газар болон хуулийн байгууллагуудад бүхий л талаар дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах нь зүйтэй гэж үзсэн гэж дүгнэлт гаргасан.

Тийм учраас бид энэ хуулийн байгууллагууд ажлаа хийхэд нь шаардлагатай байгаа тэр мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулах, ил тод, нээлттэй болгох чиглэлд л бид хууль байгууллагын дэмжлэг үзүүлж байж болно.

Одоо энэ дээр ганцхан хууль байгууллагынхан л энэ тэр шударга, тэр хуулийн дагуу ажиллаж, тэр хариуцлага хүлээлгэх нөхдүүдийг нь хариуцлагыг нь хүлээлгэх энэ ажил бол хуулийн байгууллагад л үлдэж байгаа юм. Хуулийн байгууллагатайгаа бид одоо эндээс нь хуулийг яаж хэрэгжүүлж байгаа юм, энэ ажлаа яаж хийж байгаа дээр Их Хурал хянаж ажиллах л энэ л бидний Их Хурлын гол ажил байх ёстой гэж үзэж байгаа.

Г.Занданшатар: Тэр алдагдал гээд байгаа юм. Алдагдсан боломжийн өртөг гээд байгаа юм. Тоонууд зөрүүтэй байна гэж асуусан даа. Гол нь.

Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Орлогын хэлтсийн дарга. Хэчнээн, яг хэдийг алдчихсан юм бэ? Та нар тооцоолсон юм байгаа юм уу? 92. Жигжидийн Ганбат.

Ж.Ганбат: Би түрүүн бас хэлсэн. Яах вэ би дахиад.

Эрдэнэс Тавантолгой компани 2011 оноос борлуулалтаа хийж эхэлсэн. 2011 оноос бид Монгол Улс нүүрсээ ам нөхцөлөөр биш хил нөхцөлөөр зарлаж байсан бол бид 4 тэрбум долларыг Монгол Улс олох боломжийг бид алдсан. Өөрөөр хэлбэл ам нөхцөлөөр хямд үнээр зарж байсан.

Одоо үүнийгээ бид залруулахын тулд Биржийн хууль Улсын Их Хурлаар батлагдсан. Засгийн газраас түр журам гарсан. Бид хил нөхцөлөөр нүүрсээ биржээр нээлттэй, ил тод зарах энэ ажлыг зохион байгуулж байна. Нэгд.

Хоёр дахь нь, ам нөхцөлөөр нүүрс зарахдаа ерөнхийдөө худалдан авагч тал шууд аман дээрээс нүүрсийг авч байгаа. Энэ бол тээвэрлэлтээ бүгдийг нь худалдан авагч тал хариуцаж байгаа. Үүнтэй холбогдуулаад бид тээврийн компаниудын орлого, ашиг, тэд нарын татвар төлөлтийн асуудлыг бид хяналт тавьж чаддаггүй байсан. Үүнтэй холбогдуулаад ийм байна.

Нөгөө талдаа уртын тээвэр, богинын тээвэр гэдэг хоёр асуудал байна. Богинын тээвэр дээр мөн ялгаагүй сая өндөр тарифууд тавьж байсан. Энэ дээр би их хэмжээгээр валютын орох урсгалыг хилийн гадна үлдээж байсан. Энэ бол дандаа худалдан авагч тал дээрээ хариуцаж байсан. Манай Монголчуудад зөвхөн цалинг нь өгнө. Тээврийн компаниудын орлого тэр чигээрээ хилийн гадна үлдэж байсан.

Ийм учраас энэ яг биржээр нээлттэй, ил тод хил нөхцөлөөр зарах. Үүнтэй холбоотой Монгол Улсад оруулж

ирэх орлогууд гэдэг. Энэ дээрээ гол ажиллаж байгаа.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууна.

Ц.Идэрбат: Ер нь бас нэг ийм саналууд байгаа юм.

Ер нь Монгол Улсын экспортод гаргаж байгаа байгалийн баялаг, энэ бүх зүйлүүд дээр бид ер нь ямар тээг саад байна, ямар шударга бус зүйлүүд байна, юуг бид илрүүлж чадахгүй боломжуудаа алдаж байна уу гэдгийг бас бүр нухацтай авч үзэх хэрэгтэй юм болов уу гэж ингэж бодоод байгаа юм.

Жишээ нь, энэ алтан дээр, жишээ нь зүгээр самар дээр гэхэд л Татварын ерөнхий газрын гаргаж өгсөн 2022 оны 10 сарын 07-ны өдрийн танилцуулга дээр Монгол Улс 2021 онд 14.3 мянган тонн самар экспортлоод 360 сая доллар орох боломжтой байтал гаалийн мэдүүлгээрээ 96 саяыг олсон. 270, 280 сая долларынхоо татварын орлогыг бид алдаж байна гээд ингээд гарч байх жишээтэй.

Тэгэхээр ер нь цаашдаа энэ самар, алт, мах, энэ гадагшаа мөнгө болох энэ бүх зүйлүүд дээр ер нь хэдхэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Гааль. 85.

Гаалийн ерөнхий газрын Гэмт хэрэг, зөрчлийн газар. Самар ер нь баахан юм алдаад байгаа юм биш үү. 85.

Б.Сүхбаатар: Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын дарга Б.Сүхбаатар. Ц.Идэрбат гишүүний тодруулгад хариу өгье.

Өнөөгийн хүчинтэй мөрдөгдөж байгаа Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, Татварын тухай хуулиар экспортын бараан дээр Монгол Улс тэг татварын хуулийг мөрддөг.

Гадаад худалдааны статистик мэдээг гаргаж өгөхдөө тухайн самрын экспортын барааны үнэ тодорхойлсон нийт дүнг бид татварын байгууллага гаргаж өгдөг. Хэрвээ экспортын татвар тогтоосон бол хэдий хэмжээний татвар ногдуулж төсвийн бүрдүүлэлтэд орлого оруулах байсан юм бэ гэдгийг тухайн чиглэлийн байгууллагууд нь тогтоосон байх. Энэ дээр гаалийн байгууллага статистик мэдээг нэгтгэж гаргаж өгдөг байгаа.

Г.Занданшатар: Гаалийн ерөнхий газрын Статистикийн газрын дарга чинь хэн нь билээ? 83.

Э.Лхагвасүрэн: Гаалийн үнийг тогтоохдоо гаалийн татвар, тарифын хуульд заасан үнэлгээний 4 аргаар хийж байгаа.

Тэгээд самартай холбоотой бусад мэдээллийг нэгтгэхийн тулд гаалийн мэдүүлгийг үндэслэнэ гэж заасан байдаг.

Тэгэхээр гаалийн мэдүүлэгт заагдсан бичиг баримтад шаардлага хангасан мэдээлэлд үндэслэн гаалийн статистик мэдээ гардаг байгаа.

Г.Занданшатар:
Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би давхардуулахгүйгээр хоёр, гурван зүйл асуугаад орхиё.

Яах вэ, Засгийн газрын кабинетын гишүүн болохоор зэрэг Засгийн газар дээр асуудлаа ярих шаардлага гардаг. Их Хурал дээр ч гэсэн Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар дээрээ та нар асуудал ярь гээд ингээд бид нарт тэр болгон ярих бололцоо олддоггүй нэг ийм нөхцөл бий.

Энэ дагуу бид Засгийн газар дээр асуудлыг нэлээн хүчтэй тавьж байгаа. Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд, энэ Тавантолгой компаниудыг тойрсон нүүрсний тэр эргэлзээтэй хулгай луйвартай холбоотой ийм асуудлуудыг анх гаргаж тавьсан.

Өнөөдөр энэ гаалийн холбогдох хүмүүсүүд хэлээд байна шүү дээ. Энэ цагдаагийн байгууллагатай асуудлыг бид тавьсан. Удаа дараагийн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар саналаа албан тоот бичгээр хүргүүлсэн гээд.

Тэгээд энэ дээр юу харагдаж байна вэ гэхээр үүнийхээ араас яагаад хөөцөлдөггүй юм гэдэг нэг ийм асуулт гараад байгаа юм. Энэ дээр хариулж өгөөрэй.

Дараагийнх нь, энэ асуудлыг хуулийн байгууллагад шилжсэн байхад тэр хуулийн байгууллагууд нь яагаад.

Н.Ганибал гишүүн ээ, би асуултаа асуучихъя.

Яагаад хуулийн байгууллага энэ асуудлыг тавихгүй, өнөөдөр Засгийн газар, Их Хурал нийгмийн хэмжээний асуудал болгож тавьж байж сая нийгмийн анхаарлын төвд оруулж байж энэ асуудлууд ингээд шалгагддаг, яригддаг ийм байдалтай байна.

Энэ дээр хариулт өгөөч ээ гэж. Энэ Тавантолгой тойрсон будилаан, хулгай луйвар бол ерөөсөө тэр offtake гэрээтэй холбоотой. Нөгөөдөх нь бол энэ нүүрс борлуулахтай холбоотой гэрээний асуудал. Тэгээд тэр тээвэрлэлттэй холбоотой байгаа юм.

Дараагийнх нь, энэ бүртгэлгүйгээр нүүрс гаргачихсан гэдэг ийм асуудлууд.

Дараагийнх нь, энэ худалдан авалттай холбоотой. Худалдан авалт бол одоо нийтдээ Тавантолгой компани ажиллаж эхэлсэн цагаасаа хойш 12.5 их наяд төгрөгийн борлуулалтын орлого олоод. Түүнээсээ 7.5 их наяд төгрөгийн худалдан авалт хийчихсэн байна гэж ийм мэдээлэл яваад байгаа юм.

Тэгэхээр үүнийг Эрдэнэс Тавантолгойн бүрэн эрхт төлөөлөгч энэ дээр нэг хариулт өгөөч.

Үнэхээр Засгийн газар онцгой дэглэм тогтоогоод, шуурхай арга хэмжээ авч байж өнөөдөр 2.4 тэрбум доллар луу хүртлээ уруудаж байсан энэ валютын нөөц 3.4 тэрбум болж өссөн ийм дүнтэй. Нүүрс экспортын хэмжээ ямар хэмжээ нэмэгдсэн билээ. Ингээд энэ үр дүнтэй ажиллаж байгаа юм л даа. Хүнээ олж тавих, төрийн өмчийн компаниуд, нийтийн эрх ашгийг төлөөлж байгаа энэ төрийн өмчийн компаниуд, энэ баялгийн менежментийг хийж байгаа энэ компанийн удирдлагад үнэхээр шалгарсан, итгэл даах ийм хүмүүсээ олж тавих л тухай асуудал гараад байна л даа.

Дараагийнх нь, би давхардуулахгүйгээр асуух гээд байгаа юм бол энэ иргэдийн тавьж байгаа. Сая жагсаал цуглааны үеэр тавьсан шаардлага, ерөнхий сонголын үеэр энэ жагсагчдын төлөөлөл оролцоод

дэвшүүлсэн санал. Энэ асуудлууд хаана явж байна? Ямар бодитой үр дүн, хариултыг өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудалд туссан бэ? Энэ жагсаж байгаа улсуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой, энэ хүмүүстэй байнгын эргэх холбоотой ажиллаж байгаа тийм бүтэц байна уу? Энд Улаанбаатар хотоос өгсүүлээд цагдаагийн байгууллага, хуулийн байгууллага. Цаашлах юм бол манай Их Хурал, Засгийн газрын түвшинд ямар бүтэц ажиллаж байна?

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Сая энэ Эдийн засгийн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлт дээр нийт оролцсон иргэдийн гаргасан саналуудыг тоймлож авч үзээд 6 ийм үндсэн чиглэлээр саналуудыг нь бид ингэж 6 үндсэн чиглэлээр саналуудыг нь ангилж бичсэн юм.

Нэгд, нүүрсний хулгайг ил болгох, олон нийтийн мэдэх эрхийг хангах чиглэлээр.

Хоёр дахь нь, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох чиглэлээр.

Гуравт нь, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог сайжруулах, олон нийтийн хяналтыг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх чиглэлээр.

Дөрөвт нь, төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр.

Тавд нь, ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хэлбэрийг сайжруулах чиглэлээр.

Зургаад нь, төрийн байгууллагын тогтолцоог өөрчлөх чиглэлээр гэж ийм ерөнхийдөө зургаан чиглэлээр иргэд маань өөрсдийнхөө санал бодлыг илэрхийлжээ.

Тэгээд үүнтэй холбоотой дүгнэлт гаргаад, тэгээд тодорхой ийм 8 зүйл бүхий шийдвэрлэх арга замуудыг нь тодорхойлох нь зүйтэй юм байна гээд энэ 8 арга замыг бид энэ дээр тус тусад нь түрүүн дүгнэлт дээрээ уншиж танилцуулсан.

Тэгээд энэ чиглэл дээр иргэдийнхээ тавьсан санал, энэ асуудлуудыг бид шийдэх чиглэлд саяын хэлсэн 8 зүйл, заалтыг тусгаад, энэ сонсголынхоо тайлантай холбогдуулаад Их Хурлын тогтоол гаргах нь зүйтэй юм байна гээд Их Хурлын тогтоолын төсөл бичигдсэн байгаа.

Тэгээд энэ бол дараагийн долоо хоногоос Их Хурлаар орж хэлэлцэгдэх байх. Тэгээд энэ дээр ерөнхий хяналтын сонсголын тайлан хэлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай гээд.

Нэгдүгээрт, удирдлага хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, олон нийтийн хяналтын талаар. Дотроо 6 зүйлтэй.

Хоёр, төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр ашгийг нь сайжруулах чиглэлээр дотроо 3 зүйлтэй.

Гуравт, ард түмний мэдэх эрхийг хангах чиглэлээр гээд дотроо 2 зүйл. Нийт 5 заалттай ийм чиглэлүүдээр

Засгийн газарт чиглэл өгөх ийм агуулгатай тогтоолын төсөл явж байгаа.

Хуулийн байгууллагаас нэг дэх, хоёр дахь асуултад хариулах уу. Хуулийн байгууллагынхнаас.

Г.Занданшатар: 84. Максимын Чинбат. Ерөнхий прокурорын орлогч.

М.Чинбат: Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат. Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр нүүрсний олборлолт, экспорт, тээвэрлэлт, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой хэрэг ер нь хэдий үеэс яаж гарсан юм бэ гээд. Бид бас энэ ерөнхий сонсголын юун дээр тодорхой мэдээлэл өгсөн.

Ер нь 2011 оноос хойш ийм гомдол гарч ирсэн. Тухайлбал, би оноор нь хэлж өгвөл 2011 онд саяын нүүрсний худалдан авах, тээвэрлэх, экспорттой холбоотой 1 л гомдол гаргасан.

2012 онд 2 гомдол, 2013 онд 1 гомдол, 2015 онд 1 гомдол гээд.

Ингээд 2017, 2018 онд 6 гомдол. 2019, 2020, 2021 гээд. 2022 онд 15 гомдол гээд. Нийтдээ 40 гаруй гомдлыг цагдаа, Авлигатай тэмцэх газар хүлээн авч тухайн үедээ зохих журмынх нь дагуу шийдвэрлэсэн.

Ингэхдээ гааль, холбогдох байгууллагуудаас гаргаж өгсөн нотлох баримт, мэдээллийн хүрээнд асуудлыг шийдвэрлээд ингээд явж байсан.

Ингээд өнөөдрийн байдлаар 44 хэрэг шалгагдаж байгаа. Энэ жагсаал цуглаан 12 сарын 05, 06-ны үед идэвхжиж эхэлсэн. Үүнээс өмнө нь ер нь

нүүрсний олборлолт, экспорт, тээвэрлэлт, худалдан авах ажиллагаатай холбоотой энэ хэргүүдийн шийдвэрлэлт, явцыг эрчимжүүлэх зорилгоор энэ жагсаал цуглаанаас өмнө эрчимжүүлэх зорилгоор Улсын ерөнхий прокурорын газраас хамтарсан ажлын хэсэг байгуулах тогтоол шийдвэр гарч энэ ажиллагааг Авлигатай тэмцэх газарт цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллагын ажлын хэсгүүдийг байгуулж ажилласан.

Өнөөдрийн байдлаар нийтдээ 44 хэрэг шалгагдаж байна. Энэ дотор хэрэг бүртгэлтийн 27, мөрдөн байцаалтын 17 хэрэг шалгагдаж байна.

Мөрдөн байцаалтын 17 хэрэгт 87 хүнийг эрүүгийн хэрэг үүсгэгч ялагчаар татсан. Эндээсээ 23 хүнд холбогдох 4 хэргийг яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн ийм мэдээлэлтэй байна.

Эрүүгийн хэргийн явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний хор уршгийн асуудлыг шалгаж тогтоодог. Түрүүн Ц.Идэрбат гишүүн бас ярьж байна. Гагцхүү тэр алдагдсан боломж гэдэг асуудал бол санхүү, эдийн засгийн ойлголт. Мэргэжлийн шинжилгээний байгууллагаар тогтоогдох асуудал байгаа юм.

Эрүүгийн хэргийн улмаас бид хохирол, хор уршгийн асуудлыг тодорхой болгож, мөрдөн шалгах ажиллагааны явц, үр дүнгээр энэ нь тодорхой болох асуудал байгаа юм.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 1 минут тодруулья.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр монголчууд ярьдаг шүү дээ. Мөнгө мөртэй гэж.

Тэгэхээр энэ учруулсан хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх, энэ нүүрсний хулгайн хүрээнд жишээлбэл Казахстанд хороолол барьчихсан байна гэж асуудал яригдаж байгаа. Тийм ээ.

Тэгээд энэ асуудлууд дээр одоо бүр эцсийн нь мухарлаж ингэж ажиллах шаардлага байна. Бид хавар Засгийн газраас, мөн Хөгжлийн банктай холбоотой хулгай луйврын асуудлыг гаргаж тавьсан. Ингээд иргэний нийгмийн байгууллага, иргэд, сэтгүүлчид, тэгээд Их Хурлын гишүүд бид энэ дээр шаардаж байж ажлын хэсэг байгуулаад Б.Батгөмөр гишүүнээр ахлуулаад бид 56 хоног ажиллаад, дараа нь Хяналт шалгалтын түр хороо байгуулаад ингээд ажиллаж байгаа.

Тодорхой үр дүн гарсан. Нэг их наяд гаруй төгрөгийн чанаргүй зээлийг эргүүлж төлүүлээд ингээд явж байгаа.

Тэгэхээр зэрэг энэ хохирлыг л барагдуулах хамгийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? 84. Максимын Чинбат Ерөнхий прокурорын орлогч.

М.Чинбат: Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах асуудал бол мөрдөн шалгах ажиллагааны явцаас зайлшгүй үр дүнд хүрэх нэг асуудал байгаа юм. Энэ дээр прокуророос зохих зөвшөөрлийг мөрдөх байгууллагуудад саналынх нь дагуу өгч ажиллаж байгаа.

Ер нь аль болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, шүүхийн шийдвэр гарах, шийдвэр биелэгдэхүйц байх энэ зорилгыг хангах хүрээнд эрүүгийн гэмт хэрэгт ялладагчаар татагдсан хүн, хуулийн

этгээдийн өмч хөрөнгийг битүүмжлэх, хязгаарлал тогтоох энэ арга хэмжээг тухайн бүр нь авч явуулж байгаа.

Өнөөдрийн байдлаар ч гэсэн бидний энэ тоон үзүүлэлт бол нэлээн өндөр дүнтэй ингэж явагдаж байгаа. Хэрэг нэг бүр дээр хохирлын асуудлууд өөр өөрөөр яригдах байх. Энэ дээр Та бүхэн, таны саналыг анхаарч ажиллана.

Г.Занданшатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Баярлалаа.

Тэгээд төрийн өмчтэй компаниуд дээрээ төр хяналт тавьж чадаагүй нь л гай л даа. Цаг хугацаанд нь юу гэдэг юм хилийн цэрэг, гааль, мэргэжлийн хяналт, Үндэсний аудитын газар, тэр ТУЗ нь ч гэдэг юм уу ингээд хяналт тавиад явж байсан бол ийм асуудал гарахгүй л дээ.

Тэгээд төр өөрөө ингээд хяналт тавьж чадахгүй. Хяналтаа алдчихсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нь ч хяналтаа алдчихсан. Хяналт тавьдаггүй. Тэгээд үүнтэй чинь холбогдуулаад л олон жилийн хулгайн асуудал сөхөгдөж байна шүү дээ.

Тэгээд нөгөө хашхирсан хойно нь нэргэв гэдэгтэй адилхан маш олон жилийн хулгайны асуудлыг явж явж л ингээд хууль хяналтын байгууллага дээр очдог. Тэгээд энэ хууль хяналтын байгууллага чинь 10 жилийн өмнөх, 7, 8 жилийн өмнөх энэ асуудлыг чинь одоо ингээд шалгах гээд л, илрүүлэх гээд л. Нөгөө хүмүүс нь солигдчихсон, халагдчихсан гээд. Маш хүндрэлтэй зүйлүүдтэй л ингээд тулгараад байгаа байхгүй юу.

Төр өөрөө ингээд хяналтаа цаг бүрт нь ингэж хийж байсан бол ийм асуудал гарахгүй байсан.

Тийм учраас би юу хэлэх гээд байна гэхээр энэ хяналт шалгалтыг хэрэгжүүлж байсан, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж байсан энэ байгууллагуудыг бас тодорхой хэмжээний хариуцлага тооцох хэрэгтэй. Тэр хилээр одоо юу гэдэг юм нүүрс олон удаагийн давтамжтай, ямар ч гаалийн бүрдүүлэлтгүйгээр хоосон гараад байсан асуудал хүртэл яригдаж байна шүү дээ. Энэ ойлгомжтой л асуудал шүү дээ.

Тэр үед гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байцаагч байж л байх ёстой. Тэр гаалийн хилийн хаалгыг нээж өгсөн хилийн цэргийн хүн байж л байгаа шүү дээ. Тэр үед нь л илрүүлээд тухайн үед нь хариуцлага тооцоод явж байсан бол ийм асуудал гарахгүй л дээ.

Тийм учраас төр хяналтаа тавьж чадсангүй. Хяналт шалгалтын тогтолцоо алдагдсан байна гэдэгтэй би санал нэг байгаад байгаа юм.

Тэгээд татварын хяналт шалгалт, санхүүгийн шалгалт, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хяналт шалгалтууд ер нь сүүлийн 3 жилийн хугацаанд хэдэн удаа шалгасан юм, хэдэн төгрөгийн зөрчлүүдийг илрүүлж байсан юм гэдэг дээр надад тодорхой хэмжээний мэдээлэл өгөх хэрэгтэй байж байна.

Хоёр дахь асуудал, энэ ТУЗ-тай холбоотой асуудлыг бид ярих ёстой. ТУЗ-тай холбоотой асуудлыг. ТУЗ өөрөө цалин хөлс аваад ажиллаж байгаа шүү дээ. ТУЗ өөрөө гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд нь, тухайн компанийн үйл ажиллагаанд нь хяналт тавина гээд ТУЗ ажиллаж байгаа шүү дээ. ТУЗ-ийн бүрэн

эрхийн асуудал бол ерөөсөө хяналт тавих, тэр компанийн үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх ийм л үүрэгтэй ТУЗ ажиллаж байгаа шүү дээ.

Тийм учраас ТУЗ-ийн гишүүдийг нэг бүрчлэн зарлаж, ТУЗ-ийн гишүүдэд бас хариуцлага тооцох асуудлыг ярих хэрэгтэй.

200 гаруй төрийн өмчтэй компани байдаг юм байна. Энэ 200 гаруй төрийн өмчтэй компанид хэчнээн төрийн албан хаагч ажилладаг юм бэ? Хэдэн төгрөгийн цалин авдаг юм бэ гэдэг дээр надад бас нэг мэдээлэл өгөх хэрэгтэй байж байна.

Гурав дахь асуудал бол энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын энэ өөрчлөлтийг яаралтай хийх ёстой юм байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар өөрөө төрийн өмчтэй компаниудаа хагас жил тутам шалгадаг энэ хяналт шалгалтын ийм тогтолцоог тэнд бий болгож өгөхгүй бол цаашдаа явахгүй юм байна. Энэ төрийн өмчтэй том компаниудаа хагас бүтэн жилээр санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нь шалгалтыг нь хийдэг. Тэр уулын ажлын төлөвлөгөө ч гэдэг юм уу, тэр эрүүл ахуйн нөхцөлд нь ч гэдэг юм уу, хил гаалиар гарч байгаа тэр нүүрс ч байдаг юм уу, тэр хүнд нь шалгалт хийдэг ийм тогтолцоог Төрийн өмчийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дээр ийм тогтолцоог цаашдаа хийж явах нь зөв юм байна. Ингэхгүйгээр цаашдаа энэ хулгай алга болохгүй юм байна гэдэг дээр санал байна.

Тэгээд энэ дээр ер нь цаашдаа ямар бодлого барьж ажиллаж байгаа юм бэ гэдэг дээр бас нэг асуулт асууя.

Тэгээд цаашдаа бид энэ төрийн өмчтэй компаниудаа ард иргэддээ л

хувьчлах энэ асуудлаа л яаралтай шийдэхгүй бол цаашдаа явахгүй юм байна даа. Сая Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр хувьчлах аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт гарсан. /минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Т.Энхтүвшин гишүүн хэнээс асуусан. Асуултууд тодорхой байх хэрэгтэй. Үг хэлчихсэн үү? Хэнээс асуусан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас юм байна. ТУЗ-ийн асуудлаар асуусан. ТУЗ чинь Ж.Ганбат дарга. Танай ТУЗ чинь хэн юм? Аль яам юм. Жигжидийн Ганбат хариулья. 92. Бүрэн эрхт төлөөлөгч.

Ж.Ганбат: Эрдэнэс Тавантолгой компанийн ТУЗ-ийн дарга, Засгийн газар Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат дарга ажиллаж байгаа.

Ер нь компанийн засаглалын ТУЗ-ийн хувьд ТУЗ харьяандаа дотоод аудитын алба, нэгжтэй байгаа. Энэ нэгж өөрөөр хэлэх юм бол өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, ТУЗ-ийн ажиллагааг бүрэн боломжоор хангаж байх ийм чиг үүрэгтэй ажилладаг.

Нөгөө талдаа ТУЗ-ийн нарийн бичиг гэж байнгын ажиллагаатай ийм нэгжүүд ажиллаж байгаа. Эд нар яг шат шатандаа байнгын өдөр тутмын хяналтаа тавиад компаниас бүрэн мэдээллээ аваад ТУЗ-ийн хяналт тавих, хуралдах боломжоор нь хангаад явах үндсэн чиг үүрэгтэй ийм байгууллагууд байгаа.

Эд нар яг саяын хэлдгээр үндсэн чиг үүргээ хяналтаа тавиад ингээд нээлттэй ил тод ажиллаад явах юм бол ТУЗ-ийн ажиллах боломжоор нь хангаад явбал ямар нэгэн асуудал үүсгэхгүйгээр яваад байх боломж бүрэн байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт тавьж дууслаа.

Энэ нүүрсний асуудлаарх нээлттэй сонсголын үр дүнгээр ард иргэдээс хэлсэн үг, мэдээ мэдээлэл, сэжиг таамаг бүхий бүх бичлэгийг мөрдөх байгууллагуудад шилжүүлсэн. Нотлох баримтын хэмжээнд үнэлж дүгнэх, мөрдөн шалгах ажиллагаа бол тэр нээлттэй сонсгол дээр яригдсан асуудлуудаар ажлын хэсэг дээр үргэлжилж байгаа, хийгдэж байгаа гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарт, нээлттэй сонсголын үр дүнгээр Улсын Их Хурлын тогтоол боловсруулж ирэх долоо хоногт хэлэлцэнэ.

Гуравдугаарт, өнөөдөр яригдсан асуудал бас ер нь эдийн засгийн санхүүгийн нэр томьёонд алдагдсан боломжийн өртөг гэж алдагдсан боломжийн зардал гэдэг бол нэг зардлыг өөр зардалд зарцуулснаар тэрнээс ямар ашиг, орлого олох боломжийг алдсан юм бэ. Жишээлбэл, 10 жилийн өмнө хэрвээ тэр мөнгө нь байгаад тэр мөнгийг төмөр замд ийм хүүтэй зээлээр барьчихсан байсан бол төмөр зам баригдсанаар жилд 50 сая тонн нүүрс экспортлоод 50 сая тонн нүүрсийг тухайн үеийнх нь ханшаар тооцоолоод тэрнийх нь илүү хэмнэгдсэн зардал, өртгийг алдагдсан боломжийн өртөг ийм алдсан байна. Ийм боломжийг алдсан байна гэж үзнэ.

Энэ бол хор хохирол гэхээсээ илүү гэм, хор хохирол, алдагдсан боломжийн өртөг гэдэг хоёр бол өөр ойлголт. 1992 онд би тийм сургуульд сурчихсан бол, тийм өмч хувьчлаад авчихсан бол ч гэдэг юм уу. Энэ бүхнийг бас алдагдсан боломжийн өртөг гэж тооцдог.

Тэгэхээр энэ бол санхүүгийн хувьд хоёр өөр нэр томьёог хольж ойлгохоор ард иргэдэд бас их буруу зөрүү ойлголт төрүүлэх. Тэр 4 тэрбум доллар ч гэсэн хэрвээ тэгчихсэн байсан бол, хилийн үнээр зарчихсан байсан бол бид тийм боломж алдсан байна.

Тэгэхээр энэ гэм хор, хохирол, алдагдсан боломжийн өртөг гэдгийг санхүүгийн нэр томьёо, шинжээчийн дүгнэлтийг их оновчтой гаргаж байж тайлбарлахгүй бол ард иргэдэд бас буруу зөрүү ойлголтууд өгөөд байж болохгүй.

Ингээд Улсын Их Хурлын тогтоол энэ мөрөөр гаргана. Холбогдох мэдээллүүдийг шилжүүлсэн. Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголын тайланг хэлэлцлээ.

Ерөнхий хяналтын сонсголыг цаашдаа боловсронгуй болгох талаар саналаа бас ажлын хэсэг оруулж ирнэ. Ерөнхий хяналтын сонсголын сонгодог загвар бол олон улсад ард түмнийг төлөөлөх эрх бүхий мандат бүхий Улсын Их Хурлын гишүүд, холбогдох албан тушаалтнуудаас мэдээ мэдээллийг эксперт, шинжээчийн дүгнэлт гаргуулж, тэр нотлох баримт, мэдээ мэдээллийг холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, мөрдөн шалгах сонсгол хийгдэж байгаа бол эксперт, шинжээчийн дүгнэлт гаргуулах гэх мэтчилэн ийм парламентын түвшний хяналтын үйл ажиллагаа, ард иргэдэд бол мэдээлэл ирүүлж болно. Тэр мэдээллийг үндэслэж хянаж нягтлаад шинжээч нар асуулт асуух ийм процесс.

Тийм учраас зорилготой зорилгогүй, зорьж ирсэн, зорьж ирээгүй, санаатай санамсаргүй, бодитой бодигүй мэдээллийг бас ангилах нь өөрөө филтер шүүлт байх ёстой асуудал. Тэгээд үүнийг цаашдаа хяналтын сонголт дээр анхаарах шаардлагатай байгаа юм.

Үүнийгээ боловсронгуй болгох процедур дэгээ сайн анхаарах ёстой. Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар Нүүрсний экспорт, тээвэрлэлтэй холбоотой асуудлаар холбогдох байгууллагуудын тайлан мэдээтэй танилцах ерөнхий хяналтын сонголын тайланг хэлэлцлээ.

Дараагийн асуудалд орно. Ажлын хэсэгт баярлалаа.

Найм.Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох асуудал

Ингээд Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргад Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Лхагвын Мөнхбаатарын нэрийг дэвшүүлж байна.

Лхагвын Мөнхбаатар нь 1977 онд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд төрсөн.

Өнөөдөр даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар цахимаар хэлэлцээд өнөөдөр хэлэлцэх асуудлууд дууссан боловч гурван асуудлыг нэмсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох асуудал байна.

Дараа нь Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонссоно.

Дараа нь Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр тангараг өргөх ёслолын ажиллагааг хийхээр төлөвлөж байна. Ийм гурван асуудлыг нэмсэн.

1985-1995 онд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын 10 жилийн сургууль, 1995-1999 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургууль, 2006-2008 онд Отгонтэнгэр их сургууль, 2015 оноос Монгол Улсын Их Сургуулийн төгсөлтийн дараах докторантад суралцаж байсан байна.

Л.Мөнхбаатар нь 1999-2000 онд Хууль зүйн яамны Эрх зүйн шинэтгэлийн Стратегийн нэгдсэн төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, 2000-2006 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2006-2008 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, 2008-2009 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний бүртгэлийн мэдээллийн улсын төвийн дарга, Улсын ерөнхий байцаагч, 2009-2011 онд Засгийн газрын

хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, 2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2014-2016 онд “Хөвсгөл хөгжил” сангийн тэргүүн, 2016-2020 онд Улсын Их Хурлын гишүүн, 2020 оноос өнөөг хүртэл Улсын Их Хурлын гишүүн, 2022 оноос Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын дэд даргад Монгол Ардын намын бүлгээс нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг дэмжиж өгөхийг Та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Танилцууллаа. Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Лхагвын Мөнхбаатарын сонгох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Лхагвын Мөнхбаатарыг сонгох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

34 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. /алга ташив/

Ес.Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай

Улсын Их Хурлын дэд даргаар Лхагвын Мөнхбаатарын сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх нь дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. /алх цохив/

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйл, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг Улсын Их Хурлын дэд даргаа сонгосугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхгүй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудалд орёе.

Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.

Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын зарим гишүүдийг чөлөөлж, шинээр томилох нь зүйтэй гэж үзлээ.

Засгийн газрын гишүүдийг чөлөөлөх, томилох асуудлыг зохих журмын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулсан болно.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдаар Чимэдийн Хүрэлбаатарыг томилуулахаар танилцуулж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, аж ахуйн яамдын салбар дундын уялдаа холбоог нэгдсэн бодлогоор хангах, хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн идэвхтэй оролцоог бүрдүүлж, эдийн засгийг богино хугацаанд хоёр дахин тэлэх, улсын төсвийг тэгшитгэн хуваах зарчмаас татгалзаж, үр дүн, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурласан хөгжлийн бодлогыг тодорхойлох зэрэг үндэслэлүүдийг харгалзан Эдийн засгийн хөгжлийн сайдыг Шадар сайдын түвшинд томилуулан ажиллуулах нь зүйтэй гэж үзлээ.

Ч.Хүрэлбаатар 1968 онд Увс аймагт төрсөн.

1986 онд Увс аймгийн Улаангом хотын 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 1991 онд Оросын Холбооны Улсын Ленинград хотын Санхүү, эдийн засгийн сургуулийг төлөвлөгөө, эдийн засагч мэргэжлээр, 1998 онд Австралийн Сиднейн их сургуулийг эдийн засагч мэргэжлээр төгссөн.

1991-1992 онд Үндэсний хөгжлийн яаманд эрдэм шинжилгээний ажилтан, 1992-1995 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд багш, 1998- 2000 онд Эдийн засгийн бодлогыг дэмжих төсөлд ахлах эдийн засагч, 2000-2003 онд Монгол Улсын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөх, 2003-2007 онд Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2007-2008 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Түлш, эрчим хүчний сайд, 2008-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2008-2009 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2009-2012 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, 2010-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-2017 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2017-2020 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, 2020-2022 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2022 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайдаар ажиллаж байгаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргээлтийн Үндэсний хорооны даргад

Хүрэлбаатарын Булгантуяаг
томилуулахаар танилцуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлт”-ийн бодлогын “Боомтын сэргэлтийн бодлого”-ыг үндэсний түвшинд хэрэгжүүлж, боомтуудыг авто замаар холбох, олон улсын жишигт нийцүүлэн бүх боомтыг хөгжүүлэх, Гашуунсухайт, Ганцмод, Хангимандал, Шивээхүрэн, Сэхээ боомтуудын нүүрсний экспортыг эрчимтэй нэмэгдүүлэх, нүүрсний экспортыг 45-аас 50 саяд хүргэх томоохон зорилтуудыг хэрэгжүүлж чадна хэмээн итгэж, Сангийн дэд сайдаар ажиллаж байсан туршлагыг нь харгалзан Монгол Улсын сайд, Боомтын сэргээлтийн Үндэсний хорооны даргаар томилуулан ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Х.Булгантуяа нь 1981 онд Архангай аймагт төрсөн.

1998 онд Монгол, Турк хамтарсан гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын дунд сургууль, 2006 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Дундад Хятадын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг Эдийн засгийн бакалавр зэрэгтэйгээр, 2008 онд Америкийн Нэгдсэн Улсын Йелийн Их сургуулийг олон улсын эдийн засаг, хөгжлийн эдийн засгийн магистрын зэрэгтэй төгссөн.

2008-2010 онд Дэлхийн банкны төслүүдэд зөвлөх, төслийн удирдагч, 2010-2012 онд Оюу Толгой хувьцаат компанийн төслийн менежер, бизнес стратегийн ахлах зөвлөх, 2012-2013 онд Петровис хувьцаат компанид Бизнес хөгжлийн газрын дарга, 2013-2016 онд Монгол Ардын намын Намын байгуулалт, хамтын ажиллагаа, төрийн бус байгууллагууд хариуцсан нарийн

бичгийн дарга, 2016-2020 онд Сангийн дэд сайд, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд даргаар сонгогдон ажиллаж байсан.

Бэгзжавын Мөнхбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга хот байгуулалтын сайдын үүрэгт ажлаас чөлөөлж, Цэрэнпилийн Даваасүрэнг томилуулахаар танилцуулж байна.

Орхоны хөндий болон Хөшигийн хөндийд баригдах шинэ хотын бүтээн байгуулалт, нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын хэсэгчилсэн дэд бүтцийг шийдвэрлэж, гэр хорооллын асуудлыг хөгжлийн шинэ шатанд гаргахад Эрчим хүчний сайдаар ажиллаж байсан болон улс төрийн туршлагыг харгалзан үзэж энэхүү томилгоог хийж байна.

Ц.Даваасүрэн нь 1964 онд Хөвсгөл аймагт төрсөн.

1983 онд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1989 онд Зөвлөлт Холбоот Улсын Харьков хотын Политехникийн дээд сургууль, 1994 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийг Бизнесийн удирдлагын менежер мэргэжлээр, 1998 онд Япон Улсын Сайтомогийн их сургуулийг эдийн засагч мэргэжлээр тус тус төгссөн.

1989-1992 онд Төвийн эрчим хүчний системд автоматикийн инженер, 1995-1999 онд Сангийн яамны Валютын харилцааны газарт мэргэжилтэн, 1999-2000 онд Сангийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, 1999 онд Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга, 2000-2005 онд Санхүү, эдийн засгийн яамны Төрийн

сангийн газрын дарга, 2008 онд Боловсрол, шинжлэх ухаан яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга, 2005 онд Монгол Улсын Шадар сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөх, 2008-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2009-2010 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2012-2014 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2017-2021 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд, 2000 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Сэрээжавын Энхболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлж, Содномын Чинзоригийг томилохоор танилцуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог Нийгмийн даатгалын багц хууль, Хуримтлалын нэгдсэн сан, Баялгийн сангийн хуультай уялдуулан шинэ түвшинд гаргаж, салбарын эрх зүйн цогц шинэчлэл хийх, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх оношилгоог эрчимжүүлэх, эрүүл мэндийн салбарт дэвшүүлсэн шинэчлэлүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд улс төрийн туршлага нь бүрэн нийцнэ гэж энэхүү томилгоог хийж байна.

С.Чинзориг нь 1964 онд Өвөрхангай аймагт төрсөн.

1982 онд Өвөрхангай аймгийн Хужирт сумын дунд сургууль, 1986 онд Монгол Улсын Их Сургуулийг төлөвлөгч, эдийн засгийн мэргэжлээр. Отгонтэнгэр сургуулийг мөн тус тус төгссөн.

1986-1988 онд Өвөрхангай аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх захиргааны Төлөвлөгөөний комисст мэргэжилтэн, 1990-1992 онд Өвөрхангай аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх захиргааны хэлтсийн дарга, 1992-1996 онд Өвөрхангай аймгийн Засаг даргын орлогч, 1996-2000 онд Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, 2000-2008 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд, 2008-2010 онд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, Төсвийн ерөнхий менежер, 2010-2012 онд Ерөнхий сайдын Нийгмийн бодлогын зөвлөх, 2013 онд Монгол Ардын намын Нийгмийн бодлого, хөгжлийн газрын дарга, 2014-2015 онд Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайд, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-2018 онд Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга, 2017-2020 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, 2000 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр тус тус ажиллаж байна.

Г.Занданшатар: Одоо Ерөнхий сайд болон томилогдох нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа. Одоо Жамъянгийн Мөнхбат гишүүн асуулт асууна.

Ж.Мөнхбат: Надад асуулт алга. Ер нь яах вэ, зарчмын дагуу л орж ирж байгаа.

Шадар сайд бид нарын баталсан хуулийн дагуу орж ирж байгаа. Ажлаа сайн хариуцлагатай хийнэ гэж итгэж байна.

С.Чинзориг гишүүн өмнө нь Эрүүл мэндийн даатгал, энэ нийгмийн даатгалд байхад Хөдөлмөрийн сайд, Нийгмийн хамгааллын сайдаар 2 удаа, дэд сайдаар 2 удаа ажиллаж байсан учраас энэ салбарын эрүүл мэндийн даатгалыг хөл дээрээ босгох ажлыг сайн хийнэ гэж итгэж байгаа.

Сэрээжавын Энхболд гэдэг сайд маш сайн ажилласан. Мэргэжил арга зүйн туслалцаа зөвлөгөө өгч хоёулаа хамтарч бие биеийгээ нөхөж дэд сайдаар ажиллах ийм шийдвэр гарсан байна.

Ц.Даваасүрэн сайдын хувьд өмнө нь Эрчим хүчний сайд хийж байсан хүн. Хариуцлагатай сайн ажиллана гэж ойлгож байгаа.

Боомтын сайдаар ажиллаж байгаа Х.Булгантуяа томилогдож байгаа. Х.Булгантуяа сайдын хувьд би энэ экспортыг нэмэгдүүлэх, валют олж ирэх, импортын үнийг буулгах энэ маш чухал боомтын сэргэлтийн асуудал Х.Булгантуяа сайд дээр ирж байгаа. Тэгээд хятад хэлтэй хүн өөрөө. Монгол Улсын тээврийн 85, 86 хувь нь Хятадын хил боомттой холбоотой байдаг. Экспорт, импортын.

Тийм учраас сайн ажиллах байх. Өмнө нь Сангийн яаманд энэ боомтын асуудал байсан. Хариуцаж байсан.

Тэгэхээр Сангийн дэд сайдаар ажиллаж байх үедээ бас энэ асуудлыг хариуцаж байсан дэд сайдын хувьд хариуцлагатай сайн ажиллана гэж итгэж байгаа.

Тийм учраас эмэгтэйчүүдийн жендэрийн төлөөлөл талаасаа ч гэсэн, олон юмыг ингээд харахад энэ Засгийн

газрын бүтэц, бүрэлдэхүүнд орж бондын сэргэлтийн асуудлыг хариуцаж ажиллах ийм том хариуцлагатай ажил бол энэ Х.Булгантуяа гишүүний өмнө ирж байна.

Тэгээд Монгол Ардын намын бүлгийн дэд дарга, намын нарийн бичгийн дарга гээд ийм хариуцлагатай ажлуудыг хийж, хий хор нь гарч төлөвшсөн ийм шинэ боловсон хүчин, шинэ залуу эмэгтэй улс төрч энэ ажил дээр ирж ажиллах нь зөв ч байсан байж магадгүй гэж ингэж бодож байгаа.

Тэгээд энэ дашрамд энэ боомтын сэргэлтийн сайдаар ажиллах саналыг тавьж байсан Ерөнхий сайддаа бас би албан ёсоор талархал илэрхийлье. Тэгээд бүх сайдуудад амжилт хүсье дээ.

Г.Занданшатар: Үг хэллээ. Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт яваад, тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд асуудал оруулж ирж байна гэж ойлгож байна.

Тэгээд шинээр томилогдож байгаа сайд, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг сайдаас тодорхой асуултуудыг асууя.

Сая энэ дэлхий даяар КОВИД-ын маш хүнд цаг хугацааг давж гарч ирсэн. Үүнтэй адилхнаар Монгол Улс энэ КОВИД-ын хүндрэлтэй цаг хугацааг давж гарч ирсэн. Тэгээд энэ КОВИД-ыг яг нуруундаа үүрээд, улаан гараараа тэмцэж, улаан бүс рүү орж өдөр шөнөгүй ажиллаж гарч ирсэн хүмүүс бол энэ эрүүл мэндийн салбарынхан байгаа.

Тэгэхээр энэ чухал хүнд ачаа үүрч байсан энэ салбарынханд чинь одоо жоохон тийм хайр халамж, зөв бодлого,

нийгмийн асуудлууд тал дээр нь зөв дэмжлэг их хэрэгтэй байгаа.

Тэгэхээр энэ тал дээр таныг бодлого барьж цаашдаа энэ цагаан нөмрөгтэй баатрууд, эрүүл мэндийн салбарынхан. Ганц эмч, сувилагч нар биш. Тэнд ажиллаж байгаа энэ үйлчилгээний ажилтнуудыг бас хүнд цаг үед давж гарч ирсэн дээр нь нэлээн дэмжиж ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна. Тэгээд танд амжилт хүсье.

2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа ээлжит бус хуралдаад эрүүл мэндийн салбар дээр энэ гүйцэтгэлийн санхүүжилт гээд нэг эрх зүйн шинэ юу оруулж ирсэн. Концепц оруулж ирсэн. Энэ дагуу нэлээн хугацаа өнгөрлөө. Хоёр жил хагасын хугацаа өнгөрлөө.

Тэгээд энэ хуулийн төслийг та яг хуулийн концепцынх нь хувьд дэмжиж ажиллах уу гэдэг нэг асуулт асууя.

Тэгээд энэ хуулийн энэ асуудлыг бид бас өмнөх сайд, өмнөх сайдын багт нэлээн удаан ярьж ирсэн л дээ. Орон нутаг дээр, ялангуяа суман дээр энэ асуудал яг хэрэгжиж өгөхгүй байна. Суман дээр энэ санхүүжилтийн тогтолцоо, тэр цахим тогтолцоо, **e-health**, **e-hospital** гээд энэ тогтолцоонууд, программ хангамжууд чинь амьдрал дээр нэлээн буухад хүнд байна. Үүнийг амьдралд нь буух тал дээр сурталчилгаа тал дээр, сургалт тал дээр.

Тэгээд тэр гүйцэтгэл бичиж санхүүжилтээ авч, цаашдаа яг бие даасан байдлаар энэ сумдын эрүүл мэндийн төвүүд амьдарч явах тал дээр нэлээн зүйлүүдийг ярьж хэлсэн. Бас ахиц гараагүй гэж хэлэхгүй. Гарсан. Тэгэхдээ л үсрэнгүй бодитой, тийм яг хуульд

нийцүүлсэн ийм ахицууд гараагүй. Сумын эрүүл мэндийн төвүүд яг гүйцэтгэлд бичээд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтүүдээ авч чадахгүй байгаа. Суманд амьдарч байгаа иргэд энэ үйлчилгээгээ авч чадахгүй байгаа.

Тэгэхээр энэ дээр та сайдын хувиар ямар бодлого барьж ажиллах вэ гэдэг ийм хоёр асуултыг асууя.

Х.Булгантуяа гишүүн дээр сайд болж байгаа юм байна. Тэгээд маш хүнд ийм ажил гэж ингэж бодож байгаа. Маш их хэл амтай. Авлига, хээл хахууль нэлээн яригддаг. Саяын энэ нүүрсний хулгай гээд нэг айхтар юмнууд явсан. Энэ зүйлийн гол бай хэсэг нь энд байна гэж ингэж хүмүүс ярьж байгаа ийм салбар.

Тэгэхээр энэ дээр зоригтойхон шиг ажиллаад тос усыг нь ялгаж өгөх ажил гарч байгаа. Тэгээд амжилт хүсье.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн хариулья.

С.Чинзориг: Ц.Туваан гишүүний асуултад хариулья.

Бид сүүлийн 3 жил ерөнхийдөө дэлхий нийт даяараа ч тэр, Монгол Улс ч тэр маш хүнд амаргүй нөхцөлд л ажиллаж амьдарч ирлээ л дээ. КОВИД-ын нөхцөлд.

Тэгээд энэ бүтэн 3 жилийн хугацаанд энэ КОВИД-ын нөхцөлд иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалах үүргээ чин шударгаар гүйцэтгэж ирсэн эрүүл мэндийн байгууллагын хамт олонд талархаж байгааг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Хэдийгээр хүнд амаргүй нөхцөлд байсан ч гэсэн өргөсөн тангарагтаа үнэнч байж, ард түмнийхээ эрүүл аюулгүй, эрүүл мэндээ сахин хамгаалах ажил үүргээ амжилттай гүйцэтгэж ирсэн гэж би дүгнэдэг.

Би өмнө нь Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдаар ажиллаж байхдаа эрүүл мэндийн салбарынхантай ажил үүргийн хувьд нэлээн холбоотой ажиллаж ирсэн. Ялангуяа эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалингийн тогтолцоог ажлын байрных нь нөхцөлд үнэлгээ хийх замаар хамгийн өндөр ачаалалтай ажилладаг сувилагчид, мэс заслын эмчээс авхуулаад ингээд ялгавартай, ялгамжтай цалинтай болгох ийм цалингийн тогтолцоог нэвтрүүлж байсан.

Хоёр дахь асуудал нь та бүхэнтэй хамтраад эрүүл мэндийн салбарт хийгдэх энэ гүйцэтгэлээр санхүүжүүлэх асуудлыг хууль эрх зүйн орчинг нь бүрдүүлэхэд оролцож байсан.

Тийм учраас цаашдаа өмнө нь хийж байсан болоод одоо хэрэгжүүлж байгаа ажлуудыг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна гэж л бодож байна.

Ерөнхий сайд намайг энэ албанд томилохдоо төрд ажиллаж байсан туршлага, ялангуяа эрүүл мэндийн салбарын санхүүгийн тогтолцоо, менежментийг сайжруулахад бодитой үр дүн гаргах болов уу гэж итгэл хүлээлгэж томилсон болов уу гэж бодож байна.

Тийм учраас цаашдаа Их Хуралтайгаа хамтраад эрүүл мэндийн салбарын эрх зүйн шинэчлэлийг хийх, ялангуяа эрүүл мэндийн даатгалын

гүйцэтгэлийн санхүүжилтийг төгс төгөлдөр болгох талаар нэлээн ажиллах шаардлага байгаа.

Би өнөөдөр шууд сайдад очих гэдэг сураг сонсоод гүйцэтгэлийн санхүүжилтийг үгүйсгэх тийм боломж байхгүй. Нэгэнт Их Хурлаас хэрэгжүүлж эхэлсэн энэ гүйцэтгэлээр санхүүжилт олгох зарчмыг хэрэгжүүлнэ.

Гэхдээ төгөлдөршүүлэх, боловсронгуй болох юм байгаа гэдэгтэй би санал нэг байна. Ялангуяа эмнэлгийн байгууллагууд чинь шат шатандаа үзүүлж байгаа үйлчилгээ, объём хэмжээ нь, нэр төрөл нь өөр. Клиник эмнэлгүүд нэг өөр, аймгийн нэгдсэн эмнэлгүүд өөр, дүүргийн эмнэлгүүд өөр, сумын эмнэлэг өөр, өрхийн эмнэлэг үзүүлж байгаа үйлчилгээ нэр төрөл нь өөр өөр шатлалаар өөрөө ялгамжтай.

Тийм учраас энэ шатлал тус бүрд нь тохирсон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох ёстой гэж бодож байна.

Өнгөрсөн жил бид Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо боловсронгуй болгох хүрээнд тантай хамт бас ажлын хэсэгт орж ажилласны үр дүнд бидэнд дутуу бодсон юм байна гэж ярьж байгаад, үзэж байгаад сумын эмнэлэг болоод өрхийн эмнэлэгт олгох санхүүжилтийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж өгсөн. Энэ бас бодит үр дүнгээ өгч байгаа байх гэж бодож байна.

Тийм учраас гүйцэтгэлээр санхүүжүүлэх энэ санхүүжилтын тогтолцоог цааш нь улам төгөлдөршүүлэх, боловсронгуй болгох талаар анхаарч ажиллана. Таны хэлж байгаа тэр сургалт, сурталчилгаатай

холбоотой асуудал дээр анхаарах юм бий байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдаас Засгийн газрын шинэ сайдуудыг томилж байгаа юм байна.

Ч.Хүрэлбаатар, С.Чинзориг, Ц.Даваасүрэн нар үнэхээр олон жил парламентад суусан туршлагатай. Засгийн газрын кабинетэд ажилласан ийм туршлагатай учраас энэ хүмүүс энэ хүнд цаг үед Засгийн газрынхаа бодлогыг, улс орныхоо ачааг үүрээд явна гэдэгт итгэл дүүрэн байна.

Ингээд Х.Булгантуяа сайд өнөөдөр Боомтын сайдаар нэр дэвшиж орж ирсэн. Х.Булгантуяа бол бас ингээд эдийн засгийн талаар өндөр мэдлэгтэй. Сангийн яамыг бас тодорхой хэмжээнд удирдаж явсан хүний хувьд үүнийг зөв зүйтэй авч явах байх гэсэн ийм итгэлтэй байна.

Тэгэхдээ өнөөдөр хамгийн их хэл ам дагуулсан, улс орны бодлогыг тодорхойлогч хүчин зүйл болсон боомтын сэргэлт өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн амин сүнсний асуудал. Өнөөдөр энэ нүүрсний тээвэрлэлт, түүнтэй холбоотой хил, боомтуудын тээвэр, ложистик асуудал гээд тэнд байгаа тээвэрчдийн асуудал гээд олон том шийдлүүд эрсэн, нийгмийг бухимдалд оруулсан, эдийн засгийг ч гэсэн чирч гарах ийм эрсдэл эерэг үзүүлэлтүүд байгаа. Энэ дээр ялангуяа энэ боомтын нэвтрүүлэх чадварыг хөгжүүлэх талаар Азийн хөгжлийн банк, бусад энэ сангуудаас энэ дээр онцгой

анхаарч ажиллах шаардлагатай байгаа. Энэ талаар ер нь ямар бодолтой байна вэ?

Дээр нь өнөөдөр энэ хил, гаалийн нэвтрүүлэх чадвар, тэнд ажиллаж байгаа хил, боомтын байгууллагуудын уялдаа холбоо гэдэг асуудал их хүнд байгаа. Энэ дээр олон шийдэл байгаа. Энэ дээр ер нь ямар байр суурьтай байна вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Ерөнхий сайдаас нэг зүйлийг асууя гэж бодож байна. Эдийн засгийн хүнд нөхцөл, бусад нөхцөл байдлуудаас улс орны асуудал хүнд байгаа гэдгийг бид ойлгож байгаа. Нэн ялангуяа өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас төрийн албаны шинэчлэл, төрд ажиллах хүмүүсийн нийгмийн асуудлыг онцгой анхаарах ийм зайлшгүй шаардлагатай байгаа.

Энэ дээр дэс дараатай, хөнжлийнхээ хэрээр цалин мөнгийг нь нэмэх асуудлуудыг дэс дараатай авах шаардлагатай байгаа юм. Нэн ялангуяа өнөөдөр энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлага, түүний хамгийн анхан шатны нэгж болсон багийн дарга нар, багийн нийгмийн ажилтан гэдэг өнөөдөр энэ Монгол Улсын Засгийн газрын чинь хамгийн доод нэгж болсон энэ хүмүүс өнөөдөр 500, 600 мянган төгрөгийн цалин авч байна.

Энэ дээр хамгийн түрүүн энэ асуудлыг шийдэх нь өнөөдөр төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаашлаад ажиллах урам зоригийг нь хангах. Ялангуяа энэ багийн дарга гэдэг энэ хүмүүс бол үнэхээр энэ Засгийн газрын хамгийн доод талын нэгж.

Гэтэл өнөөдөр 500, 600 мянган төгрөгийг цалин аваад тэтгэврийн доод

хэмжээний, тэр нийгмийн ажилтан гээд өнөөдөр тэр багууд дээр байдаг энэ хүмүүсийн асуудал дээр бүр Засгийн газар онцгой анхаарах ийм шаардлага байгаа.

Ийм боломж байна уу? Ийм хуулийн төсөл, эрх зүйн орчин бүрдүүлэх талаар Засгийн газарт, Улсын Их Хурлынхаа гишүүний бүрэн эрхийн хэмжээнд хууль эрх зүйн ийм дэмжлэг хүссэн асуудал тавигдвал дэмжих талаар таны байр суурийг сонсмоор байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулья.

Ерөнхий сайдын хувьд Засгийн газар нэг л зүйлийн төлөө бид явж байгаа. Энэ бол далд эдийн засгийг ил болгох. Манай Монгол Улсын экспорт буюу гадагшаа зарагддаг гол бүтээгдэхүүн бол шулуухан хэлэхэд нэгдүгээрт нүүрс, хоёрдугаарт зэс дээр тогтож байгаа.

Энэ агуулгаараа Эрдэнэт тойрсон бөөн асуудал болсон. Явж явж энэ асуудал шүүх дээр ирсэн. Шүүх удахгүй энэ Эрдэнэтийн 49 хувь луйвар байсан эсэхийг эцэслэн шийдэх байх.

Төрөөс мөнгө аваад хувьдаа авчихсан улс төрийн хэсэг бүлэглэл илчлэгдэх байх. Тэр дотор нь Ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын дарга байсан нөхдүүд нь оролцоод явж байсан асуудал ил болоод энэ схем илчлэгдэх байх.

Оюу Толгойтой холбоотой асуудал нэлээн маргаан дагуулсан. Энэ

асуудал ингээд цэгцрээд явж байгаа. Ингээд зэсийнх судал үндсэндээ одоо энэ далд эдийн засаг, булхай луйвраас ингээд ил гарч байгаа юм.

Би энэ дээр аль нэг нам гэхгүй, огт улс төр хийхгүй явж байгаа юм. Яагаад гэхээр энэ Монгол Улсын л асуудал.

Үүний дараа ингээд нүүрс рүү орж байгаа юм. Нүүрстэй холбоотой онцгой дэглэм тогтоогоод ямар үр дүн гарч байгааг Та бүхэн харж байгаа байх. 40-өөд хоногийн дотор валютын нөөц 3.3 тэрбум болчихож байгаа биз. 2.5 байж байгаад.

Одоо ингээд нүүрс тээвэр хилийн аман дээр хэдэн төгрөгөөр зарах вэ, эсвэл хил дээр хэдэн төгрөгөөр зарах вэ гэдэг ийм том асуудал үүснэ. Энэ дээр Их Хурал, Засгийн газартай хамт байхыг би чин сэтгэлээсээ хүсэж байгаа. Буруу зөрүү мэдээллүүд зөндөө гарна.

Зөвхөн энэ асуудал цэгцрэхэд Монгол Улсын эдийн засаг нэлээдгүй их том хэмжээгээр тэлнэ. Нүүрс 45-аас 50 сая тоннд хүрэх боломжтой болж эхэлнэ.

Тийм учраас л энэ нүүрс тойрсон том асуудлууд болж байна. Энэ бүх асуудлууд ингээд шийдэгдчихвэл Монгол Улсын эдийн засаг маш богино хугацаанд сэргэнэ. Яах вэ, 3 жил хил хаалттай байлаа. Энэ бүтэн сайн өдөр урд хил нээгдэнэ. 3 жилийн дараа. Ингээд мэдээж бага багаар үе шаттай энгийн амьдралдаа бид эргэж орох энэ зүйл рүү 2023 онд орох байх.

Хасах 4.7 хувийн эдийн засаг сая оны эцэст 4 хувийн өсөлттэй гарлаа. Валютын нөөц эерэг гарлаа. Ингээд эдийн засаг харьцангуй гайгүй болоод ирвэл бид төрийн албан хаагчдын цалин

нэмэх асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ. Үүнийг төлөвлөсөн байгаа. Үүнийг шийдвэрлэнэ.

Ер нь төрийн албан хаагчид өндөр цалинтай, маш чадварлаг хүмүүс ажиллах энэ төрийн бүтээмжийн том реформыг бидний хувьд хийх ёстой гэж бодож байгаа.

Тийм учраас Ш.Адьяа гишүүний тавьж байгаа энэ саналууд яригдаж байгаа. Төрийн бүх шатны цалингийн систем нэг болно.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй цалин, тэтгэвэр шууд уялддаг болно. Үндэсний баялгийн сангийн хууль болон Хуримтлалын нэгтгэсэн сангийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын хууль, Нийгмийн даатгалын хууль хоорондоо уялдана. Сингапурын загвар руу орно. Үүнийг бид хамтдаа ярилцаад энэ хавар нэлээн тийм том хэмжээний реформ хийгдэнэ.

Энэ бол Монгол Улсын л асуудал учраас өмнө нь яригдаж байсан ололт дээрээ тулгуурлаад алдаагаа засаад хамтдаа л хийх нь илүү их тийм чухал юм гэж бодож байгаа юм.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна. Байж байгаарай. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Нэр дэвшигч.

Х.Булгантуяа: Боомтын сэргэлтийн бодлого бол “Шинэ сэргэлтийн бодлого”-ын яг гол цөм нь болж явж байгаа.

Таны хэлж байгаа яг үнэн. Энэ боомтын бүтээн байгуулалт, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, хяналт шалгалт, энэ бүгдийг сайжруулахгүйгээр Монгол

Улсын эдийн засаг тэлж, энэ авлига, хээл хахуулийн асуудал цэгцрэхгүй юм билээ.

Тийм ч учраас 2016, 2017 оноос авхуулаад бид Азийн хөгжлийн банк, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр 6 боомт дотор бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа. Улсын төсөв дээр ч гэсэн дээ бас нэлээдгүй мөнгө тавигдаж энэ ажлууд явагдаж байгаа. Та бүхэн Улсын Их Хурал, бид бас энэ төсвүүдийг нь баталж, ялангуяа энэ хилийн боомттой холбоотой асуудлууд дээр дандаа дэмжиж ирсэн.

Одоо энэ бүтэн сайн өдөр сая Ерөнхий сайд хэллээ. Хятад Улстай ингээд хилийн боомтоо нээх гэж байна гээд.

Манай Замын-Үүдийн цогцолборын бүтээн байгуулалтын ажил дуусгавар болоод нээлтээ хийх гэж байна. Одоо 6 бүтээн байгуулалтын ажил хийгдээд зарим нь ингээд 100 хувьдаа гүйцэтгэлтэй, 70, 80 хувьтай зарим нь ингээд явж байна. Ахиад 11 боомтууд дээр бүтээн байгуулалтын ажил хийхээр судалгаа, төлөвлөгөөний ажил хийгдэж байгаа юм билээ.

Тэгэхээр энэ бүгд дээр, ялангуяа олон улсын байгууллагууд ч гэсэн дээ, Улсын Их Хурал ч гэсэн дээ гадаадын зээл, тусламжийг батлахдаа аль болохоор эдийн засгийг тэлдэг, иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлөхүйц ийм төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж гэж бид их ярьж байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд олон улсын байгууллагууд ч гэсэн дээ хилийн боомтуудын бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхдээ маш дуртай байх юм билээ. Ингэж байж л Монгол Улсын

эдийн засаг сайжирна, экспорт нэмэгдэнэ, авлига хээл хахууль багасна гэдэг өнцгөөсөө дэмжиж ажиллах их сонирхолтой юм билээ.

Тэгээд тэр бүгд дээр Та бүхэнтэй хамтран ажиллана гэж бодож байна.

Г.Занданшатар: Одоо Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр сая хоёр удаагийн том том хэлэлцүүлгүүдэд эхнээс нь аваад дуустал суулаа л даа. Нэгдүгээрт, нүүрсний сонсголын асуудал байна.

Хоёрт, энэ зөвлөлдөх уулзалт дээр эрдэмтдийн бага хурал хийсэн. Тэгэхэд хүмүүс ийм юм ярьж байна. Одоо энэ Улсын Их Хурлыг ингээд сонсоод байхаар ерөөсөө хөгжил нэг их ярихгүй юм. Орлого ярихгүй юм. Сайн сайхан юм ярихгүй юм. Нөгөө л хулгай л ярих юм гээд.

Тэгэхээр одоо би бас энэ Х.Булгантуяа сайдыг эдийн засагч хүн, эмэгтэй хүн энэ чиглэлээр хүнд сурталгүй сайн ажиллах байх гээд би дотроо баяртай байна. Эдийн засагч хүнтэй бас нэг юм, одоо энэ эдийн засгийн бодлого ярихад болж байна.

Одоо өнөөдөр байдал ямар байгаа вэ гэхээр боомтууд дээр бүгдээрээ нэг нэг нууц ноёнтогтой, ханилгуудтай. Тэгээд л Засгийн газар нь тогтоолуудаа гаргах юм аа. Энэ боомтыг ингэе. Боомтын сэргэлт гээд энэ дээр зөндөө их зүйлүүд гарах юм. Тэгээд тэр нь хэрэгждэггүй.

Очихоор яадаг вэ гэхээр одоо тэр хэд хэдэн боомт дээр тийм зүйл гарч байна шүү дээ. Ерөөсөө өөрсдөө монопол юугаа тогтоогоод л, тэгээд л бусад өөр

гарцуудыг хааж байгаад л өөрсдийнхөө тэр нүүрсний хулгайг хийж байна шүү дээ. Тэгээд л орон нутгийн иргэдийг турхираад л, хэвлэл мэдээллийг турхираад л ингээд л гацдаг.

Одоо энэ боомтын нэвтрэх чадвараа маш хурдтай нэмэгдүүлэх ёстой. Би өөрт чинь тэр **Параг Ханна /Parag Khanna/-гийн “Холболтын газар зүй” /Connectography/** гээд номыг бүр бэлэглэе гэж бодож байна.

Энэ дээр улс орнуудын зүгээр энэ хил хязгаар гэхээсээ илүү эдийн засгийн газар зүй чинь хамгийн чухал болчихсон.

Тэгэхээр холбогдсон орнууд л хөгждөг гэдгийг дэлхий харуулчихлаа шүү дээ. Ялангуяа жижиг орны хувьд холболтын системээ сайн хийж чадвал хамгийн хурдан хөгжинө. Өнгөрсөн жилүүдэд бид энэ боломжоо төдийлөн сайн ашиглаж чадсангүй.

Одоо дандаа бүх юм шүүмжлээд яах вэ. Агаарын зам дээр үнэхээр дэвшилттэй сайн зүйлүүд хийж байна. Маш олон онгоц нисдэг болчихлоо шүү дээ. Одоо Турк руу л гэж байна, Сингапур, Солонгос хаана хаана. Энэ чинь өөрөө энэ улс орны л холболтын ач холбогдлыг л харуулж байгаа шүү дээ. Битүү нисэж байна шүү дээ. Тэр чинь л өөрөө улс орон хөгжиж хөдөлгөөнд орж байгаа.

Тэгэхээр энэ нүүрсний гарч байгаа энэ боомтуудаа маш хурдан цэгцэл. Хятадууд нь хөрөнгөө оруулъя гээд сууж байх юм. Хувийн компаниуд нь хөрөнгөө оруулъя гэхээр хэд хэдэн ханлигууд нь болохгүй ээ. Би үүнийг чинь мэдэж байгаа. Үүнийг барьчихвал миний тэр гацна гэдэг. Ингээд нэг ийм барьцааны зүйл байна шүү дээ. Би одоо Боомтын түр

хороонд байгаа бүх зүйлийг нь мэдэж байна.

Тэгэхээр би танд юу хэлэх гээд байна вэ гэхээр та Сангийн яаманд ажиллаж байсан болохоор дандаа хэмнэх юм Сангийн яамныхан бодох гээд байдаг. Юмаа зоригтой оруулж ир. Энэ тэлэлтийн бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, гадаадын хөрөнгө оруулалт, энэ боомтын сэргэлтээ цогцоор нь зоригтой юмнуудаа оруулаад ир. Бид дэмжье. Энд чинь л манай улс орны эдийн засгийн хөгжлийн түлхүүр явж байгаа.

Хувийн хэвшлийнхэнтэйгээ уулз. Хувийн хэвшлийнхнийг чинь зүгээр шантаажилж мөнгө олж амьдардаг маш их хэвлэл мэдээлэл бий болчихсон шүү дээ. Орон нутгийнх нь иргэд нь ч бий болчихсон. Ерөөсөө том бүтээн байгуулалтыг гацааж байдаг тийм бүлэг хүмүүс.

Тэгэхээр үүнтэй тэмцэх ёстой. Тэгээд би танд итгэж байна. Үүнийг сайн хийж чадна.

С.Чинзориг сайдаас нэг юм асуух гэсэн юм. Одоо бид нар энэ эрүүл мэндийн албан журмын даатгалаа ямартай ч ингээд нэг явуулаад эмнэлгүүдээ ингээд хариуцаад ингээд яваад байна.

Энэ сайн дурын эрүүл мэндийн даатгал дээр нэлээд зүйлийг хиймээр байна. Та бас энэ дээр сайн анхаарч ажиллаж өгөөрэй. Энэ дээр бид тэр хууль дээр нэлээд заалт оруулахгүй бол. Ганцхан үг л байгаа. Сайн дурын даатгал байж болно гээд л нэг л өгүүлбэр.

Хоёр дахь асуудал бол та энэ хувийн хэвшлийн эмнэлгүүдээ нэг жоохон дэмжмээр байна. Хувийн

хэвшлийн эмнэлгүүд чинь маш хүнд байдалтай болчихсон.

Монголд үүдэн эмнэлэг л гээд 20 жил, 30 жил зах зээлд орчхоод байхад л 80 хувь нь үүдэн эмнэлэг гээд л нэг жижигхэн өрөөнд л сууж байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ дээр анхаарах хэрэгтэй. Уламжлалын салбарын эмнэлгүүдээ бас дэмжих хэрэгтэй байна. Би Ц.Даваасүрэн сайдад нэг л зүйлийг хэлмээр байна. Та бол хот төлөвлөлтийн сайд. Өнөөдөр хот төлөвлөлт Монгол Улсын хамгийн хоцрогдсон асуудал.

Тэгэхээр энэ дээр та олон удаа сонгогдсон.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. С.Одонтуяа гишүүн үг хэлсэн. Тийм ээ. Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Өнөөдөр нэр нь дэвшигдээд сонгож байгаа Их Хурлын дэд дарга, Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, хил, боомт хариуцсан сайдад дэмжиж байна. Ажлын амжилт хүсье.

Би эмч хүний хувьд бас хэд хэдэн асуудал тавья гэж бодож байна. Би 35 жил энэ эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа юм. Нийтдээ 22-оос 23 сайд солигдсон байна. 6 нь мэргэжлийн бус сайд байна. Муу ч хийсэн сайд байна. Сайн ч хийсэн сайд байна.

Тэгээд би С.Чинзориг сайдыг Эрүүл мэндийн даатгалд урьд нь ажиллаж байсан, даатгалын сайд байсан. Нийгэм хамгааллын. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтыг мэдэж байгаагийн хувьд бас дэмжээд ажиллачих байх гэж бодож байна.

Ялангуяа эмнэлгийн гүйцэтгэлийн санхүүжилт дээр нэлээн анхаарч ажиллахгүй бол яг хотын клиникийн төв эмнэлгүүд дээр болж байна. Хөдөөд бас болохгүй байна. Хүн амын тоогоор санхүүжилтийн юугаар ярьж байна.

Тийм учраас энэ асуудал дээр нэлээн анхаарч ажиллаарай. Тоног төхөөрөмж байхгүй байна. Мэргэжилтэн байхгүй байна. Үүнийг бэлдэх тал дээр анхаарч ажиллана уу гээд хэлмээр байна.

Нөгөө талаар эмч, сувилагч, асрагч нар дутагдаж байна. Ерөнхий сайд аа, энэ талаар цалингийн сүлжээгээ хоёр дахин нэмчихвэл гүйтгэлийн санхүүжилт дээр нь энэ нэмэгдчихвэл үнэхээр боломж байна. Энэ нүүрсний хулгайчдын идсэн мөнгийг харахад цалин нэмэх боломж байгаа юм байна шүү дээ. Үүнийг та нэг анхаарал аваач ээ, Ерөнхий сайд аа.

Дараа нь энэ эмийн үнэ өндөр байна. Энэ дээр нэг анхаарч ажиллана уу гэдгийг хэлмээр байна.

Шинжилгээний төв лаборатори Монгол Улсын аюулгүй байдлын үүднээс ер нь хамгийн чухал нь энэ байгаа. Янз бүрийн эм орж ирж байна. Энэ лабораторийн шинэчлэл дээр бид улсын аюулгүй байдлын үүднээс ард иргэд, эрүүл мэндийн хэрэглэж байгаа эмийг шинжлэх тал дээр үүнийг шинэчлээд жаахан дэмжих шаардлага байна.

Дараа нь энэ түргэн тусламж дээр дандаа фургоны юм уу, нэг 69 өгдөг. Та нар бодоод үз л дээ. Тархи нь доргисон, цус харвасан, яс нь хугарсан хүнийг авч явахад үнэхээр хүндрэлтэй. Энэ парк шинэчлэл дээр цаашдаа анхаараад нөгөө Ланд Крузер юм уу, өөр машин өгөхгүй бол зүгээр одоо пургон дотор та нар

өөрсдөө суугаад үз л дээ. Арай ч дээ. Үүнийг бас цаашдаа энэ тал дээр анхаарах бодлого байна уу? С.Чинзориг дарга аа. Сайд аа.

Нөгөө талаар төр ба хувийн хэвшлийн эмнэлэг дээр анхаарахгүй бол одоо хувийн эмнэлгүүд дүүрэн байна. Хэрвээ хувийн эмнэлгүүд одоо янз бүрийн юутай холбоотой яачихвал улсын эмнэлгийн ачаалал ихсэх хандлага байна.

Тийм учраас энэ төр, хувийн хэвшлийн юун дээр таны хамтарч ажиллах ямар арга барил байна вэ? Энэ талаар асууя.

Хил, гааль, боомт, чөлөөт бүс дээр нэлээн анхаарч ажиллахгүй Х.Булгантуяа сайд аа. Энэ Хөшөөтийн уурхай дээр гарсан тэр нүүрсний хулгай бол энэ гаалийн байцаагч нартай холбоотой шүү. Энэ дээр. Хил, гаальтай.

Тэр урд байсан сайд нь 20 гаалийн байцаагчийг ажлаас халаад дахиж 20 сая төгрөгөөр бараг хахуулиар ажилдаа буцааж авсан байна. Баримт нь над дээр байж байна.

Тийм учраас энэ талаар та хамтарч ажиллаж энэ талаар хяналт шалгалт хийж сайн ажиллана уу гэсэн хүсэлт байна.

Нөгөө талаараа энэ авлига хил, гааль дээр маш их байна. Энэ дээрээ анхаарлаа хандуулахгүй бол зөвхөн саяын нөгөө байцаагч нарыг бодоход 20-ыг нь нэг өдөр алчихаад дахиж 20 сая төгрөгийг хахуульд авсан байна шүү дээ. Урд гаалийн дарга нь. Энэ тал дээр анхаарч ажиллана уу гэдгийг хэлмээр байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна. Дараа нь С.Чинзориг, Х.Булгантуяа.

Л.Оюун-Эрдэнэ: Би бас түрүүн хэлсэн. Бид энэ уул уурхай тойрсон далд эдийн засгийг ил болгох ийм амаргүй 30 жилийн тогтолцоотойгоо одоо тэмцэж байна.

Зэс дээр ахиц гарсан. Одоо нүүрс. Та сая хөндлөө. Төрийн албан хаагчид авлигалаас ангид байх ёстой. Цалин нь өндөр байх ёстой. Зөв. Үүнийг бид нэг шаталсан ийм тогтолцоо руу оруулна. Төрийн албан хаагчдын цалин өндөр байх энэ зүйлийг хийнэ.

Харин төрийн албан хаагчидтай холбоотой хэрэглээнээсээ хэтэрсэн тансаг хэрэглээтэй, хувийн хэвшлээс хэт хамаагүй өндөр орлогоо нотолж чадахгүй байгаа ийм төрийн албан хаагчидтай бас Засгийн газар хатуу тэмцэнэ. Удахгүй Засгийн газар шийдвэр гаргаж тодорхой хугацаа өгнө. Тэр хугацааны дараа авлигаар хөлжсөн хэт өндөр хэрэглээтэй байгаа төрийн албан хаагч дээр хяналт тавьж эхэлнэ. Нийтэд зарлана. Ялангуяа энэ газартай холбоотой асуудлуудыг ил болгож гаргана. Үүнийг цахимжуулна.

Нүүрсний дараа би шулуухан хэлчихье. Төмөр замын компаниуд дээр Засгийн газар онцгой анхаарал хандуулна. Өнөөдөр намайг сонсож байгаа тээвэр логистик, боомттой холбоотой, төмөр замтай холбоотой дарга нарт хандаж хэлэхэд болгоомжтой байгаарай. Тун удахгүй дараагийн дэлбэрэлт энэ салбар дээр болж магадгүй шүү. Үүнийг хэлчихье.

Байгаль орчны яамны газар зардаг нөхдүүд болгоомжтой байгаарай. Бас дараагийн дэлбэрэлт энэ салбар дээр

болж магадгүй шүү. Үүний цаана байгаа улс төрчдийн нэрсийг зарлаж магадгүй.

Ингээд л манайд бусад асуудлууд цэгцэрнэ.

Монголбанкны газрын дарга нарт хандаж хэлэхэд банк бус санхүүгийн байгууллагуудаа одоо больцгоо. Бүгдийг нь зарлана гэж бодож байгаа. Энэ асуудлуудыг цэгцэлнэ.

Удахгүй Засгийн газрын хуралдаанаар шийдвэр гаргаад Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд бид өөрсдөө энэ бүх ашиг сонирхлоос ангид байх ийм хуулийг хамтдаа хэлэлцэнэ. Үүнийг Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн дэмжиж баталж өгөхийг хичээнгүйлэн хүсье.

Ингэвэл хамтдаа бид хяналт тавьчихна. Бүх алдаануудыг цэгцэлнэ. Энэ бүх далд эдийн засаг, төрийн албан хаагчдын цалинг нэмэх шатлалын мерит зарчим болж очих ёстой. Ингээд л бүх юм цэгцэрнэ гэж бодож байгаа.

Би дахиад хэлье. Өнгөрсөн хугацаанд гарсан алдааг хэн нэгэнтэй ч юм уу наах нь огт миний сонирхол биш. Гагцхүү цаашдаа ололт дээрээ тулгуурлаад, алдаагаа засаад цоо шинэ 30 жил эхлэх нь л бидний хамтын зорилго. Үүнийг хамтдаа хийх ёс зүйн өндөрлөг дээр хамтдаа байх нь л бидний хамгийн чухал зүйл шүү гэдгийг хэлье.

Тэгээд Б.Бейсен гишүүний саналуудыг тэмдэглээд авлаа. Баярлалаа танд.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн. Нэр дэвшигч хариулна.

С.Чинзориг: Б.Бейсен гишүүний асуултад хариулья.

Б.Бейсен гишүүн та бол өөрөө эмч хүн. Энэ эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой асуудлыг маш сайн мэдэж байгаа байх гэж.

Үүнийг цаашдаа бид боловсронгуй болгох шаардлагатай. Миний урьдчилж харж байгаагаар хоёр асуудлаас болоод хүндрэл гараад байгаа юм болов уу гэж бодож байгаа.

Нэг дэх асуудал нь, бид эрүүл мэндийн салбарт иж бүрнээр нь шинэчлэлийнхээ хууль эрх зүйн орчныг бүрдүүлж чадаагүй. Тэгсэн атлаа урьдчилаад түрүүлээд санхүүжилтийнх нь шинэ аргад шилжчихсэн. Үүнтэй холбоотой байгаа байх гэж нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал нь, энэ гүйцэтгэлийн санхүүжилт эхлэхээр чинь ялангуяа аймгийн эмнэлгүүд гэхэд хоорондоо өрсөлдөх яг ижил гарааны нөхцөл бүрдээгүй байна. Яг тэнд оношилгоо хийдэг, шинжилгээ хийдэг, эмчилдэг тоног төхөөрөмж нь ижил нэг нөхцөлд очиж чадаагүй. Боловсон хүчний нөөц чадавх нь ч гэсэн ижил нөхцөлд очиж чадаагүй байна. Үүнээсээ хамаараад санхүүжилтээ авч чадаж байна уу, чадахгүй байна уу гэдэг асуудлууд гараад байгаа.

Тийм учраас энэ эмнэлгүүдийг яг тэр шат шатлалтай нь эмчилгээ, үйлчилгээ, оношилгоо үзүүлэх тэр нөхцөл боломжийг нь бүрдүүлэх, боловсон хүчнийг нь бэлтгэж чадавхжуулах энэ асуудлыг яаралтай хийх ёстой гэж. Ингэж чадах юм бол энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн асуудал иж

бүрнээрээ төгөлдөрших, боловсронгуй болох болов уу гэж л бодож байна.

Тэр цалинтай холбоотой асуудал, түргэний машинтай холбоотой асуудлыг бид ажлаа авч үзэж байгаад ер нь судалж шийдэх ёстой байх гэж бодож байна. Шаардлагатай бол Засгийн газарт Ерөнхий сайдад асуудал оруулж танилцуулж, ер нь асуудлаа шийдэх нь гарах болов уу гэж бодож байна.

Өмнө нь би түрүүн хэлсэн. Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдаар ажиллаж байхдаа эрүүл мэндийн салбарт ажлынх нь ачаалал, үр дүнгээс хамаарсан цалингийн систем нэвтрүүлсэн. Энэ системээ улам боловсронгуй болгох, сайжруулах, эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх ийм чиглэлийн арга хэмжээ авч таарна. Эмийн үнэ өндөр байгаатай би санал нэг байна. Өнгөрсөн долоо хоногийн чуулган дээр ч би хэлсэн. Статистикийн ерөнхий газраас авсан мэдээллээр эм тарианы үнэ нэг жилийн хугацаанд 40.6 хувь нэмэгдсэн гэсэн ийм асуудал байна лээ.

Тэгэхээр энэ дээр ер нь цаашдаа энэ эмийн үнэ болоод нөгөө талдаа эмийн чанартай холбоотой асуудал дээр нэлээн хяналтыг сайжруулах асуудлууд байх болов уу, гарах байх гэж бодож байна.

Хувийн эмнэлгүүдээ дэмжиж ажиллана. Хувийн хэвшлийн энэ эмнэлгийн байгууллагууд чинь тодорхой хэмжээнд орчин үеийн оношилгоо шинжилгээний иж бүрэн тоног төхөөрөмжтэй болчихсон, боловсон хүчин нөөцтэй болчихсон. Энэ хувийн хэвшлийг бид дэмжиж ажиллана.

Зүгээр санхүүжилтийн асуудал дээр нь ямар асуудал байна вэ гэдгийг хамтарч салбарынхантайгаа тодорхойлох

хэрэгтэй байх. Нэг хэсэг нь ялангуяа томоохон хувийн эмнэлгүүд нь бас нөгөө хувийн үйлчлүүлэгчээс нь зардал авахыг нь хязгаарлачихсан. Тэр дээр бас жаахан таарамжгүй ханддаг асуудлууд байх шиг байгаа юм. Тэр нь байх ёстой юу, байхгүй юу гэдэг асуудлыг. Гэхдээ энэ чинь клиник эмнэлгүүдтэй адилхан үйлчилгээ үзүүлж байгаа бол адилхан тарифтай болгочихсон асуудлууд нөгөө талдаа байгаа гэдгийг маш сайн ойлгож байна.

Тийм учраас хувийн эмнэлгүүдийг түшиглэж ажиллаж байж л энэ эмнэлгийн үйлчилгээ, чанартай хүртээмжтэй хүрэх асуудал, бодлого явуулахгүй бол төр дангаараа энэ эрүүл мэндийн салбарын үйлчилгээг хүрэх хүрээний гэдэг асуудал бол амжихгүй гэж бодож байна. Ийм зүйлийг таны асуултад хариульч.

Тэр түргэний унаатай холбоотой асуудлаар би санал нэг байгаа юм. Би ч гэсэн өөр орон нутгаас сонгогдсон гишүүн. Энэ сүүлийн үеийн фургон чинь чанаргүй болчихсон юм байна лээ. Юм л бол дандаа фургон нэг духын резин гээд л нэг юм ярьдаг.

Тэгээд дээр нь тэр хүнд өвчтэй хүнийг алсын газар замд тээвэрлэх ямар ч боломж байхгүй гэж.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. 4 сайдын асуудал яригдаж байна.

Миний хувьд Ч.Хүрэлбаатар сайд, Х.Булгантуяа сайд, С.Чинзориг сайд нараас асуух зүйл алга.

Би Ц.Даваасүрэн гишүүнийг сайдаар томилж байгаа дээр л эмзэглэж байна. Яагаад гэвэл Ц.Даваасүрэн гишүүн

бол энэ танхимд юугаар танигдсан гэхээр хувийн шантажийн улс төрөөр танигдсан. Бусад гишүүд рүүгээ дайрч довтолдог, доромжилдог, гүтгэдэг.

Тэгээд тэр ажлаа сайн хийснийхээ үр дүнд ингээд сайд болж байгаа юм байна.

Одоо Эрчим хүчний сайд байсан гэж байгаа юм. Эрчим хүчний хэдэн зээлүүд нь Хөгжлийн банк дээр огт ямар ч төлөгдөл хийгээгүй. Барьцаа хөрөнгө байхгүй. Эгийн голын цахилгаан станц төслийг удирдаж байгаа хэдэн нөхдүүдийн цалинг л санхүүжүүлсэн тийм зээл.

Тэгээд ер нь эрчим хүчний салбарт ямар дэвшил гарсан юм. Энэ нийслэл чинь одоо ингээд цахилгаан дулаанаар тасрах гээд л, арай гэж нэг энэ өвлийг давж байна шүү дээ. Нэг ч шинэ цахилгаан станц баригдаагүй. Гаднын хөрөнгө оруулалттай цахилгаан станцын төслүүдийг бүгдийг нь зогсоосон.

Ер нь гаднын хөрөнгө оруулалтыг байнга жадлан эсэргүүцдэг тийм гишүүн шүү дээ. Тэгээд одоо барилгын салбарыг яах юм. Тэр Хөшигийн хөндий гээд маш чухал төсөл байж байна. Хархорум хот ингээд Орхон голын хөндийг шинээр байгуулна гэж ярьж байна.

Одоо энэ төслүүд чинь бүгдээрээ эхлэхгүй. Төсвөөсөө хэтэрнэ. Хугацаа алдана. Бүтээн байгуулалт нь явдаггүй ийм л нөхцөл байдалд хүрнэ гэж би эмзэглэж байна. Болгоомжилж байна.

Ер нь Ц.Даваасүрэн гишүүн одоо энэ Ерөнхий сайдын энэ засгийн бүх юмыг эсэргүүцэж ирсэн хүн. Одоо ингээд бүрэлдэхүүнд нь гишүүн болоод ороод суух гэж байна. Энэ бол зарчмын хувьд

хүлээн зөвшөөрч боломгүй асуудал гэж би бодож байна.

Хөгжлийн банкны асуудал дээр л манлайлж гарч ирж, бусад гишүүд хүмүүс рүү дайрч орж ирсэн. Гэтэл энэ бизнес нь явж байгаа хувийн хэвшлийн зээлдэгч нар нь зээлээ төлчихсөн. Гэсэн мөртлөө тэр хэдийг яллагдагчаар татаад л ингээд л явж байгаа шүү дээ. Төрийн өмчийн зээлүүд нь яасан төлөгдөхгүй явж л байна.

Тийм болохоор би Ц.Даваасүрэн гишүүнийг Барилга, хот байгуулалтын сайдаар томилогдож байгаа буруу сонголт байна л гэж хэлмээр байна. Надад асуулт алга.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Монгол Улс парламентын засаглалтай улс. Парламент өөрөө иргэдийг төлөөлж байгаа бага ард түмэн. Парламент дотроос Засгийн газар төрдөг. Энэ бол өөрөө сонгодог парламентын засаглалын үнэт зүйл юм.

Энэ агуулгаараа парламентад сонгогдсон байдал бууу улс төрийн капитал бол өөрөө хамгийн чухал шалгууруудын нэг болдог. Японд ч тийм, Англид ч тийм. Та бүхэн үүнийг бүгдээрээ мэдэж байгаа.

Тийм учраас Ерөнхий сайдын хувьд энэ л капиталыг барих нь зүйтэй гэдэг ийм жишгийг барьсаар ирсэн. Цаашдаа ч барина. Өмнө нь бас гарч байсан нэг алдаа бидний засах ёстой зүйл Ерөнхий сайд зөвхөн өөрийн үзэл бодлыг шууд биелүүлдэг тойрон хүрээлэгчдийг бүрдүүлэх гэж хэт хичээдэг байснаас болж алддаг байсан.

Би цаашдаа энэ сонгогдох дараалал, улс төрийн капитал гэдэг зүйлийг цаашдаа ч харгалзан үзэх ийм зарчим руу л явахыг хүсэж байгаа. Энэ өөрөө бас шинэ 30 жилийн эхлэл юм аа л гэж харж байгаа.

Энэ агуулгаар гэр хороолол, барилга хот байгуулалт гээд энэ бүх зүйл шулуухан хэлэхэд дэд бүтэцтэй холбоотой. Энэ дэд бүтэцтэй холбоотой энэ асуудлыг шийдэж байж Улаанбаатар хотын хэт төвлөрлийн асуудал ч тэр, гэр хорооллын асуудал ч тэр шийдэгдэх боломжтой.

Энэ агуулгаараа өнөөдөр Монгол Улсын парламент дотроос сонгогдсон нийт гишүүдийн дундаас тооцож үзэхэд хэдхэн л хүн энэ шалгуурыг хангаж байгаа юм.

Тийм учраас энэ сонголтыг хийсэн. Парламент бол төлөөллийн нийлбэр. Кабинет бол капиталын нийлбэр гэдэг энэ зарчмыг Ерөнхий сайд цаашдаа ч барина гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Хөгжлийн банк болон бусад асуудлууд байгаа. Мэдээж парламентын гишүүд хоорондоо мэтгэлцэх. Энэ бол парламентын үнэт зүйл бөгөөд бүрэн эрхийн асуудал.

Удахгүй сонголт болно. Б.Энхбаяр гишүүн энэ сонголыг удирдаж явна.

Би дахиад л хэлэхэд зээл аваад зээлээ зориулалтын дагуу зарцуулагдаагүй, дамжуулан зээлсэн асуудлууд, улсынхаа нэрээр бонд аваад бүлэглэлийн зарчмаар хувааж хувьдаа завьшсан асуудал битгий цаашдаа үргэлжлээсэй л гэж бодож байгаа юм. Энэ бүх асуудал удахгүй парламент дээр

дахиад л ил тод яригдах ёстой зүйл. Яагаад энэ асуудлуудын хойноос ингээд хөөцөлдөөд байгаа вэ гэхээр ганцхан л зүйл байгаа. Цаашдаа ийм алдаа битгий давтагдаасай л гэж.

Тэгэхээр мэдээж парламентын мэтгэлцээн аль нэг талд нь Ерөнхий сайдын хувьд байр сууриа илэрхийлэх эрхгүй. Парламентын чөлөөт мэтгэлцээн цаашдаа ч байх ёстой. Энэ бүх асуудал дээр гишүүд маань илүү бие биеийнхээ үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж, илүү нэгдмэл эрх ашгаар улсаа гэсэн агуулгаар хандаж явах нь чухал болов уу л гэдэг ийм зарчмаар надаас асуусан гэж бодож Ерөнхий сайдын хувьд сонголт дээрээ тайлбар хэлж байгаа гэдэг агуулгаар Г.Амартүвшин гишүүн ээ, зөвөөр хүлээж авах байхаа гэж найдаж байна.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Г.Амартүвшин гишүүний ярьсан зүйл дээр тайлбар өгөх нь зүйтэй.

Тэгэхээр шантаажилж гүтгэсэн гэж. Би өөрийг чинь ерөөсөө шантааж гүтгээгүй. Шадар гурван цэрэг 30 гаруй тэрбум төгрөгийн асуудал гээд ингээд л бид ажлын хэсэг шалгахаас өмнө ийм асуудал гарсан. Өөрөө захирал байсан хүн. Тийм зээл гарсан нь үнэн.

Авлигатай тэмцэх газраас 4 гишүүн оруулж ирсэн. Тэрний нэгэнд өөрийн чинь нар орж ирсэн нь үнэн. Тэр надад ямар ч хамаарал байхгүй шүү дээ.

Тийм л учраас би өөрийг чинь энэ парламентад суух эрх байна уу л гэж хэлсэн. Энд л өөрөө яах вэ, юм санаа л яваа юм байна.

Тэр шантаажлаад Засгийн газарт орлоо гэсэн маягтай юм хэлж байх шиг байна. Өмнө нь Засгийн газрын өмнөх бүрдэлтийг хийх, томилгоо хийхэд би нүүрэн дээр нь. Ерөнхий сайд энд байж байна. Надад санал тавьсан. Би тэр үед хэлсэн шүү дээ. Мэргэжлийн бусад ажиллаж чадах сайд нартаа боломж олгоё. Баярлалаа гээд л гарсан шүү дээ.

Тэгээд би тэр үед яагаад тэгвэл болоогүй юм. Энэ удаа бол Ерөнхий сайд надад ингэсэн. Одоо энэ Хархорум хот ингээд өчигдөр уржигдархан шийдвэр гарлаа. Та дандаа хойшоо суугаад байна. Үгүй тэгээд хойшоо суугаад байх юм бол хэн наадахыг чинь хийх юм гэхээр надад хариулт олдоогүй.

Тийм учраас би тэр хэлээд байгаа бүтээн байгуулалтын ажилд нь оролцёё.

Юу бүтээв гэж. Энэ Улаанбаатарын утааг бууруулах шахмал түлшний үйлдвэрийг чинь би удирдан зохион байгуулж бариулсан юм шүү дээ. Чи бид хоёрын хийсэн сайн хоёр төсөл бий. Тестрийн 90 мегаваттын хүчин чадлаа нэмэгдүүлээгүй байсан бол өнөөдөр бүүр харанхуй. Өнөөдөр чи бид хоёр энд хуралдаж чадахгүй байсан байхгүй юу.

Амгалан одоо явж байгаа юм билээ. Дорнодын ТЭЦ-ийн өргөтгөл, зүүн бүс. Одоо тэнд чинь хөрөнгө оруулалт хийгддэг болно шүү дээ. Ямар ч нэмэлт эх үүсвэр байхгүй байсан учраас тэнд чинь хөрөнгө оруулалт хийж болдоггүй байсан. Одоо тэнд уул уурхайн компаниуд ажиллаж эхэлдэг болсон байна.

Дарханы 50, Эрдэнэтийн 50, 100 мегаваттын хүчин чадлыг бий болгосон. Ингэж ярих юм бол миний хувьд нийтдээ

200 мегаваттын шинэ хүчин чадал бий болсны хүчинд өнөөдөр ингэж явж байгаа.

Одоо ингээд ирэх жил нарны батарей хуримтлуурын 150 мегаватт цагийн станц орно. Би л эхлүүлсэн энэ үед. Манай Ч.Хүрэлбаатар сайд хөрөнгийг нь шийдэж өгөөд.

Ингээд хийсэн юмнууд бол одоо бас байна. Зүгээр би нэг бас зүйлийг ойлголоо. Өмнө нь ингээд би нөгөө одоо сайдын албан тушаалд санал болгохоор баярлалаа гэсэн л дээ.

Тэгэхээр намайг дараа нь хүмүүс юу гэсэн гээд тэгэхээр өө наадах чинь хараа сайд болж чадаагүйдээ хорсоод ингээд байгаа юм гээд л яг энэ Г.Амартүвшин шиг ярьсан байхгүй юу.

Одоо ингээд сайд болчихоор юу гээд байна вэ гээд тэгэхээр наадах чинь одоо ингэж ярьсаар байгаад сайд болчхож байгаа байхгүй юу гээд.

Тэгээд би хаагуур нь явах юм. Болчихоор ярилаа гэнэ. Болохгүй болохоор болсонгүйдээ шантаажиллаа гэнэ. Энэ хорвоог чинь хаагуур нь би алхах юм тэгээд одоо.

Тэгэхээр энд ганц л юм бий. Цаг хугацаа чи бид хоёрын үнэн зөвийг харуулна. Амьдрал харуулна. Өөр надад хэлэх юм алга.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: С.Чинзориг гишүүнийг Эрүүл мэндийн сайдаар томилж байгаад дэмжиж байгаа.

Тэгэхдээ таныг энд очоод мэдээж яг тийм мэргэжлийн юм дээр бол нэг их тийм айхтар хүлээлт энэ Засгийн газраас тавихгүй байгаа байх.

Хамгийн гол нь одоо энэ салбарт ажиллаж байгаа тэр хүмүүсийн нийгмийн асуудлыг, цалин цавууны асуудлыг, тэтгэврийн асуудлыг.

Дээрээс нь энэ салбарт ажиллаж байгаа. Ялангуяа хөдөө орон нутагт тэр хөр цасанд, хөхөө өвлийн хүйтэнд, тэр тэсгэм халуунд явдаг тэр хүмүүсийн л амьдрал ахуйг нэг нааштай аятайхан болгоод тодорхой хэмжээгээр санхүүжилтийн асуудал нэлээн өндөр түвшинд явдаг ийм салбар. Энэ салбарын хөрөнгө оруулалтыг нь зөв болгоод тэр зардлыг нь тодорхой хэмнээд, түүнийхээ үр дүнд энд амьдарч ажиллаж байгаа тэр хүмүүсийн нийгмийн асуудлыг л зөв болгоодох гэдэг л ийм л даалгавар өгч байгаа байх.

Тэгээд үүнийгээ таныг бас яг энэ салбарт нийгмийн асуудлыг шийдвэрлэх салбарт ажиллаж байсан учраас үүнийг л илүү хийх байх гэж харж байна.

Эрүүл мэндийн даатгалын асуудал байгаа. Одоо энэ дээр чинь заримдаа ингээд мессеж ирэх юм. Би бол нэг эмнэлэгт очоод хэдэн тариа тариулсан л даа. Ховд аймагт. Тэгээд үйлчилгээ нь таны Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төлбөрт 900 мянган төгрөг ирэхээр болсон гэхээр би ямар өндөр үнэтэй юм бэ дээ л гэж бодоод өнгөрч байсан. Яг түүнтэй адилхан олон хүмүүс тийм яриа гарч байна.

Өөрөөр хэлбэл өндөр Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг хүмүүст өндөр бүтээгдэхүүнийг нь яагаад нэг тийм мессеж явуулахаар тоохгүй

өнгөрөөд. Гэтэл нөгөө бага төлж байгаа хүмүүс дээр тэр өндөр ирэхээр хүмүүсийн дургүйцэл хүрээд байх шиг байна.

Тийм учраас яг энэ эрүүл мэндийн үйлчилгээн дээр байгаа энэ төлбөрийн асуудал дээрээ Эрүүл мэндийн даатгалаас төлөгдөж байгаа тэр төлбөр дээрээ бас нэг анхаарахгүй бол хүмүүсийн дургүйцэл тэр дээр зарим талаар гарч байж магадгүй шүү гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт нь, Х.Булгантуяа сайд мухар төмөр замуудын асуудал байна. Өөрөөр хэлбэл өргөн төмөр замаас салаалсан болон холбогдсон төмөр зам байх юм бол өргөнөөр тавина. Энэ чинь нөгөө төмөр замын бодлого, бичиг баримт төрийн хүрээнд ярьж байна шүү дээ.

Хэрвээ уул уурхайн ордоос хилийн боомт руу төмөр зам тавих юм бол аль царигаар төмөр зам тавихыг Засгийн газрын оруулж ирснээр Их Хурал шийднэ гэсэн ийм бодлого, бичиг баримт заагдсан байж байгаа.

Тэгээд энэ дагуу уг нь Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэл төмөр замыг нарийн царигаар тавина гэж 2014 онд Их Хурлын тогтоол гаргасан боловч тэрийг нь Үндсэн хуулийн цэц дээр хүчингүй болгуулсан. Буцаагаад тийшээ ямар царигаар тавихыг нь Их Хурлаар оруулж ирж шийдээгүй байхгүй юу даа. Энэ бол Их Хурлын бүрэн эрхэд халдсан үйлдэл байгаа.

Тийм ч учраас өнөөдөр энэ зам чинь хаана, яаж холбогдохоо мэдэхгүй байна. Өөрөөр хэлбэл нарийн царигаар тавих боломжтой байхад нь өргөнөөр аваад ирэхээр нь хятадууд гайхаад байгаа байхгүй юу даа.

Тийм учраас нэлээн удна. Тийм учраас ийм алдааг давтахгүй байх шаардлагатай байна. Бичигтийн боомт руу, Шивээхүрэнгийн боомт руу төмөр замууд тавигдана. Ялангуяа Нарийнсухайтаас Шивээхүрэнгийн боомт руу төмөр зам тавигдах тэр шийдвэр нарийн царигаар Засгийн газрын шийдвэр гарсан байж магадгүй гэж би үзэж байгаа.

Гэтэл үүнийг ямар царигаар тавихыг нь Их Хурлаар оруулж ирэх ёстой байхгүй юу даа.

Би уул уурхайн ордоос Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу.../минут дуусав/

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулья.

Үнэн үнэн. Энэ их харамсалтай зүйл. Х.Баттулга Ерөнхийлөгч өргөн цариг гээд Зам тээврийн сайд, Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч очоод нарийн царигаар тавина гээд.

Ингээд 15, 16 жил төмөр замаа гацаагаад маш их хэмжээний боломжийг алдаад гадаад харилцааны хувьд ч тэр, эдийн засгийн хувьд ч тэр олон улсад онигоо болсон.

Юутай ч бөөн асуудал болж болж Гашуунсухайтын төмөр зам нь дууслаа. Хангимандалын төмөр зам дууслаа.

16 жил хэрэгтэй биш байсан юм билээ. Барья гэвэл 8 сарын дотор барьж болдог л юм билээ.

Одоо Шивээхүрэнг холбох хэрэгтэй. Бичигтийг холбох хэрэгтэй. Энэ дээр хувийн хэвшлийнхэнтэй хамтарч ажиллах ёстой. Энэ дээр заавал төр урдуур нь давхиж ороод төмөр зам барих гэж гүйгээд байх шаардлагагүй. Би бас С.Одонтуяа гишүүнтэй ч санал нэг байна.

Хэдүүлээ яг эдийн засгийн хувьд энэ либералчлалыг хийх хэрэгтэй. Хувийн хэвшлээ дэмжих ёстой. Төр бүх зүйлийн урдуур орж гүйгээд байдгаа болих хэрэгтэй. Төр гүйсэн бүхэн ер нь гацдаг. Өнгөрсөн хугацааны асуудал тийм л юм болсон.

Тэгэхээр энэ боомтын сэргэлтийн сайд гэдэг ийм асуудлыг гаргаж ирж Үндэсний хороог удирдаж салбар дундын зохицуулалтыг л хийх гэж байгаа. Тун ойрхон байгаа.

Өргөн царигийг хэрвээ Монголын нутаг дээгүүр өргөн царигаар тавьсан бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар нарийн царигаар холбоёо гэдгийг тохирсон. Хил холболтын цэг 3 газар тохирсон байгаа.

Тэгэхээр одоо ингээд хил нээгдээд энэ хил холболтын цэгүүд тун удахгүй хийгдчихнэ. Цаашдаа бид нэгэнтээ л Их Хурал өргөн цэрэг гэхихсэн учраас өргөн царигаар төмөр замаа барьж байгаагаа нарийн царигтайгаа холбох терминал энэ стандарт руугаа л явах нь зүйтэй болов уу гэж бодож байгаа юм.

Эндээс бид аль аль нь л суралцах эрхтэй болж байгаа юм. Засгийн газрын ажил руу Ерөнхийлөгч нар зөвлөмж гаргаж давхиж орохоо болих хэрэгтэй. Аж ахуйн ажлыг хэтэрхий Их Их Хурал дээр татаж авч шийдвэр гаргадагаа бас бидний хувьд тооцох ёстой.

Нэг гүйцэтгэх засаглалтай, нэг хэл амтай гадагшаа харьцах ёстой байх. Нэг цонхоор. Тэгэхгүй бл юу болдгийн том жишээ бол энэ.

Би дахиад хэлэхэд энэ дээр би аль нэг нам ч гэдэг юм уу, улс төрчийг гэж огт бодохгүй байгаа. Яагаад гэхээр энэ хамтдаа л гаргасан алдаа. Хамтдаа л засаад урагшлаад явах нь хамгийн чухал зүйл байх гэж бодож байгаа юм.

Тийм учраас би бас Их Хуралд хандаж Ерөнхий сайдын хувьд хариуцлагатайгаар хэлэхэд энэ тээвэр логистикийн экспорт дээр ирэх хоёроос гурван жил үсрэнгүй хөгжлийн жил байх болно. Боомтын сэргээлтийн хувьд.

Нүүрсний экспорт одоо байгаагаас хэд дахин нэмэгдэнэ. Далд эдийн засаг цэгцэрнэ. Гагцхүү энэ нүүрстэй холбоотой, зэстэй холбоотой, банк, санхүүгийн байгууллага энэ бүх зүйлтэй холбоотой. Дээрээс нь хууль хяналтын байгууллагад орчихсон энэ далд схемийг л бид задлах ёстой. Одоо задарч ч байна.

Энд заавал бид ялалт байгуулах ёстой. Их Хурал, Засгийн газар хамтарч. Тэгээд эдийн засаг маш богино хугацаанд хамгийн багадаа хоёр дахин тэлнэ. Энэ их тийм 2030 онд гэсэн зүйл биш. Энэ ерөөсөө хоёроос гуравхан жилийн дотор хийгдэнэ.

Тийм учраас энэ дээр л бид хамтраад амь нь тэмцэж байгаа зарим нэг авлигачдын атаа хорсолтой улс төрийн акцад Их Хурал, Засгийн газар автахгүйгээр зарчимтай тууштай явчих ёстой.

Маш удахгүй үр дүн гарна. Энэ дээр бидний хувьд ингээд л хамтраад ажиллана, захаас үр дүн гарч байгаа байх

гэж бодож байна. Гэхдээ би аль ч зүйл дээр цээжээ дэлдэхгүй. Би зөвхөн тоо ярина.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууя. 1 минут.

Б.Пүрэвдорж: Яг тийм акцаас айдаггүй учраас би уул уурхайн боомтоос төмөр зам тавихдаа тухайн орны царигаар барих Улсын Их Хурлын тогтоолын төслийг би өргөн барьчихсан байж байгаа.

Үүнийг өнөөдөр Эдийн засгийн байнгын хороо гацааж байгаа шүү гэдгийг хэлье. Үүнийг барьчих юм бол бидний экспорт маш их нэмэгдэнэ гэдгийг Ерөнхий сайдын тэр саналтай би нэг байна.

Ингээд хамгийн сүүлд нь Монгол Ардын намынхан 4 сайдаа, Шадар сайдаа оруулаад өнөөдрийн 3 сайдаа оруулаад ингээд 4 сайдаа томиллоо. Манай Ардчилсан намынхан засагт орох тухай нэг хэсэг гүйсэн. Одоог хүртэл, өнөөдрийг хүртэл 4 сайд чинь байгаа шүү дээ. Та нар ороод ирэхэд бэлэн байна гэсэн тийм ярианд нь итгэсэн хэвээрээ байсан. Одоо тийм юм байхгүй боллоо.

Манай намынхан эв нэгдлээ хангаад урагшаа алхаж, дараа дараагийнхаа сонгуульд амжилттай орох цаг боллоо.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ орой амгаланг айлтгая.

Монгол Улсын Засгийн газраас Ерөнхий сайд шинэ сайд нараа

томилохдоо эмэгтэй гишүүнийг боомт хариуцсан сайдаар томилж байгаад юуны өмнө эмэгтэй гишүүний хувьд талархлаа илэрхийлье гэж бодож байна.

С.Чинзориг сайдыг эрүүл мэндийн салбарыг хариуцах болсонд бас дахин талархлаа илэрхийлье.

Нийгмийн бодлогын Байнгын хороон дээр С.Чинзориг сайд яг эрүүл мэнд рүү чиглэсэн асуудал дээр голлон анхаарч, өөрөө үгээ хэлж, байр сууриа илэрхийлж байсан. Яг энэ дээр эмнэлгийн санхүүжилтийн асуудал, хүний нөөцийн асуудал, ачааллын асуудал энэ дээр өмнө нь ярьчихсан учраас би давхардуулалгүйгээр энэ асуудал дээрээ та нэгэнт өөрийн ярьдаг зүйлээ ажил хэрэг болгоод явахад анхаарах байх гэж бодож байна.

Зүгээр нэг зүйлийг нэмээд хэлье. Өрхийн эрүүл мэндийн төв буюу эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа энэ аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагаан дээр илүүтэй их анхаарахгүй бол эрүүл мэндийн яамнаас тодорхой бодлогын хэмжээнд дэмжлэг тусалцаа дутсаны улмаас хоёр дахь шатлалын эмнэлгийн ачаалал өнөөдөр маш их байгаа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Өнөөдөр агаарын бохирдлоос шалтгаалаад хүүхдийн эмнэлгүүд ачааллаа даахгүй байгаа. Үнэхээр нөгөө гудас тавьдаггүй, яадаг уу, ийдэг вэ гэдэг асуудал өнөөдрийг хүртэл хэвээрээ байгаа.

Энэ дунд би юуг хэлэх гээд, яагаад агаарын бохирдлыг онцолж байна вэ гэвэл түүрүүн Ц.Даваасүрэн сайд хэллээ.

Сайжруулсан түлшний үйлдвэрийг барьж байсан гэж.

Сайжруулсан түншлийн үйлдвэр яг тухайн үеийнхээ ажиллаж байсан технологиор ажиллаж байна уу, үгүй юу гэдэг дээр нэг хяналт тавиарай гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Яагаад өнөөдөр уушги хатгалгаа тийм ээ, бронхит нэмэгдээд байна вэ. Яагаад өнөөдөр утаан дунд бид амьдраад байна вэ гэдэг дээр яамд нийслэлтэйгээ хамтраад нэг анхаарал тавиач ээ. Энэ дээр нэг хүч өгөөч ээ гэдэг зүйлийг хэлэхийг хүссэн юм.

Нөгөөтээгүүр Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт байхгүй байгаа. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар маань өнөөдрийг хүртэл цалингаа авч чадахгүй, жагсаал цуглаан хийхдээ хүрсэн байгаа гэдгийг Та бүхэн мэдэж байгаа байх. Энэ дээр анхаараач ээ. Энэ дээр сум дундын эмнэлгүүдийн асуудал ч гэсэн өнөөдөр хүний нөөцгүй байгаа. Захирлаа хийдэг, эмчээ хийдэг, цэвэрлэгчээ хийдэг, санхүүгээ гэдэг энэ сумын эрүүл мэндийн эмнэлгүүд чинь бас ажиллах боломжгүй байгаа. Дийлэхгүй байна гэдэг зүйлийг хүртэл ярьж байсныг бас бид Байнгын хороон дээр ирж байсан.

Ярьдаг зүйлээ дахиад ярья. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдэж чадахгүй байна. Хууль эрх зүй байгаа юу гэвэл байгаа. Түүний биелэлт дээр хяналт байхгүй байгаа. Хэрэгжүүлж чадахгүй байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв байгаа. Өнөөдөр тийм ээ, бүрэн хүчин чадлаар ажиллах чадахгүй байгаа. Яагаад гэвэл тэнд ажиллах хүний нөөц байхгүй. Хүүхдүүд маань гудамжинд бараг л

хэвтсээр байгаа. Ээж нар хүүхдүүдээ тэврээд жагсаж байсан тохиолдол байгаа. Дахиад тэд жагсахгүй гэх баталгаа алга байна.

Тэгэхээр энэ дээр анхаарч өгөөч ээ. Ургийн гажиг нэмэгдсээр байгаа. Утааны бохирдлоосоо болдог байх. Төрсний дараах хяналтаасаа бид алдаж байна. Энэ дээр нөгөө л өрхийн эмч нар маань мэдлэг чадвар нь дутуу юу. Яагаад ингээд тийм ээ, нөгөө шарлалтаас үүдсэн ургийн гажиг бий болоод байна вэ. Энэ дээр анхаарч өгөөч ээ.

Цахим эрүүл мэнд хөтөлбөр хангалттай биш байна. Өчигдөр Өрхийн эрүүл мэндийн төв дээр очоод ээжийнхээ эмийг бичүүлэх гэсэн программ байхгүй, сүлжээ тасарсан учраас бичих боломжгүй. Энэ байдал байсаар байгаа шүү.

Дахиад ярьдаг зүйлээ ярья. Геронтологийн үндэсний төв. Санхүүжилтийг нь тодорхой хэмжээнд шийдсэн. Өнөөдөр түр байрыг хангаж өгье гэсэн ийм зүйлийг Б.Энхбат сайд хэлж байсан. Геронтологийн үндэсний төвийн барилгынх нь асуудлыг шийдвэрлэж өгөөч ээ.

Удахгүй Бүгд Найрамдах Хятад Ард Улс хилээ нээнэ гэж байна. Иргэдийн чөлөөт урсгал нэмэгдэх байх. Хятадаас орж ирж байгаа иргэд маань асуумж бөглөөд орж ирэх юм байна. Хятад руу гарах гэж байгаа монгол иргэд маань Пи Си Ар өгөх юм байна. Яагаад ийм ялгавартай байгаа юм бэ.

Бид КОВИД-ын аюулыг давж туулаагүй байгаа шүү. КОВИД мутацид орсноор биднийг эрсдэлд оруулсаар байгаа. Тэгвэл энэ дээр яаж хяналт тавих вэ? Эрүүл мэндийн сайд С.Чинзориг оо.

Энэ дээр та тайлбар өгнө үү. Дараа нь тэгээд асууя.

Г.Занданшатар: Эхлээд Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ.

Дараа нь С.Чинзориг сайд бэлдэж байгаарай.

Л.Оюун-Эрдэнэ: Урьд нь бид хил 3 хоног хаагдсан тухай асуудал Монгол Улсын түүхэнд байсан байсан. 3 жил хаалттай байсан тохиолдол өнгөрсөн 30 жилд бараг байгаагүй байх.

Тийм учраас хил хязгаар хаалттай байгаагаас болж өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн дээр хомсдол үүсэж, хомсдол нь үнийн өсөлт болж, иргэдийн бодит орлогод нөлөөлж цар тахалтай их тийм төвөгтэй л цаг хугацаа болж өнгөрч байна.

Бид Ази, Номхон далайн бүсээс бараг нэг жилийн өмнө. Одоо та бүхэн санаж байгаа бол бид 02 сарын 14-ний өдөр хатуу хөл хориог цуцалж байсан. Одоо ингээд нэг сар гарчихсан явж байна. Одоо л Ази, Номхон далайн бүсийн ихэнх улсууд хатуу хөл хориогоо цуцалж байна.

Тэгэхээр бид вакцинжуулалтыг хурдан зохион байгуулж, дасан зохицож, эрүүл мэнд, эдийн засаг тусдаа зүйл биш. Эрүүл мэнд, эдийн засаг нэг зүйл юм гэдэг энэ стратеги бол эргээд бодоход бас тийм ч буруу байгаагүй. Зөв байжээ гэдэг нь харагдаж байгаа юм.

Одоо ингээд удтал хүлээсэн хил, гаалийн асуудлууд ингээд үе шаттай цэгцрэхээр болж байна. Энэ дээр бид өнөөдөр Засгийн газар хуралдаад хэд хэдэн асуудлуудыг шийдсэн. Энэ бол эхлээд шинжилгээ өгөх цахим

мэдээллүүдийг солилцоно гэдэг ийм асуудлыг Шадар сайд болон шинээр томилогдох Х.Булгантуяа сайд нар хариуцаж ажиллахаар болж байгаа.

Нэг үгээр хэлбэл мэдээлэл эхлээд солилцоно. Тэр дээр аль аль талдаа Пи Си Ар-ын шинжилгээ өгсөн дүгнэлтүүдийг ингээд солино гээд.

Хоёрдугаарт, дөнгөж нээгдэж байгаа учраас бас ийм бөөгнөрөл болох, хэт их иргэд зорчих ийм асуудлууд нэлээн гарна. Үүнийг байнга мэдээллээр өгөөд эхний ээлжид 300, тэгээд 500, 1000, 1500 гээд цаашлаад энгийн байдал руу орох энэ асуудлуудыг хоёр улсын Засгийн газар үе шаттай зохион байгуулна.

Тэгээд ингээд бага багаар энэ асуудлуудыг одоо бидний хувьд эрүүл мэнд болон бусад асуудал дээр илүү эрсдэлгүйгээр зохион байгуулахаар түр журам гаргаж ажиллахаар болж байгаа.

Үүнийг цаашлаад Шадар сайд, Х.Булгантуяа сайд хоёр гурав дахь өдрийн Засгийн газрын хуралдааны дараа энэ журмыг оруулаад нэлээдгүй тийм олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр парламентын гишүүддээ, мөн аймаг, нийслэлийн, дүүргийн дарга нартаа, мөн иргэддээ маш их тийм сайн ойлголт өгөхгүй бол энэ дээр ойлголт болон мэдээллийн нэлээдгүй их тийм зөрүү гарч магадгүй байна.

Б.Жаргалмаа гишүүний хэлж байгаа энэ асуудал ч гэсэн чухал байна. С.Чинзориг сайд ч бас энэ дээр томилогдоод анхаарал хандуулна гэдэгт итгэлтэй байна.

Г.Занданшатар: С.Чинзориг сайд нэмэх үү. Содномын Чинзориг.

С.Чинзориг: Жаргалмаа гишүүний асуудлууд нэлээдгүй цаашид анхаарах ёстой саналууд байна гэж ойлгож байна.

Ялангуяа бид Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг дэмжихтэй холбоотой асуудал, санхүүжилтийн асуудлууд байгаа. Энэ асуудлыг ажлаа аваад тэгээд хамгийн түрүүнд судалж, Өрхийн эмнэлгүүдийн холбоо, өрхийн эмнэлгүүдийн төлөөлөлтэй уулзаж шийдэх тийм гарц гаргалгаа нь юу байна вэ. Санхүүжилтийг нь олгох зайлшгүй шаардлагатай бол тэр санхүүжилтийг нь олгох талын арга хэмжээ авч ажиллах ёстой гэж бодож байна.

Миний ойлгосон урьдчилсан мэдээллээр хоёр янзын мэдээлэл яваад байгаа юм билээ. Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүд чинь сум, дүүргийнхээ Засаг даргатай гэрээ байгуулан ажилладаг. Засаг даргатай байгуулсан гэрээг нь дүгнэхээр 85-аас дээш хувь нь шаардлага хангасан байна гэсэн гэрээний биелэлттэй юм шиг.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай нөгөө санхүүжилт авах гэрээ байгуулдаг. Тэндээ гэрээгээ дүгнэхээр 80-аас доошгүй хувь нь шаардлага хангахгүй байгаа юм шиг. Тэгээд ийм хоёр талд гэрээ байгуулсан, дүгнэгдсэн асуудлууд нь хоёр өөрөө гарчихаад ингээд мөнгөө авч чадахгүй байгаа асуудлууд гараад байгаа юм билээ.

Тэгэхээр үүнийг хуулийн хүрээнд нь тэр гэрээнийх нь хүрээнд судлаад шийдвэрлэх шаардлагатай бол одоо шийдвэрлэж таарах байх гэж бодож байна.

Бусад асуудлууд, боловсон хүчинтэй холбоотой асуудлууд байна. Хүнд хэлбэрийн өвчтэй хүүхдийн асуудлууд, ургийн гажигтай холбоотой асуудлууд, Цахим эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаа гэсэн. Геронтологийн төв гээд энэ одоо бас олон жил ярьж байгаа. Бид ноднин бас танаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад тодорхой хэмжээгээр Байнгын хорооны шийдвэр гараад ашиглалтад оруулах ёстой, санхүүжилтийг нь шийдэх ёстой гэж ингээд явсан. Тэгээд одоогоор шийдэгдээгүй байгаа. Энэ асуудалд анхаарал хандуулж, шийдвэрлэх талаараа хөөцөлдөж ажиллана.

Сая Ерөнхий сайдад ч хариулчихлаа. Хятад Улс хилээ нээж байгаатай холбоотойгоор Онцгой комисс дээр нэлээн төвлөрч асуудал ярих байх гэж бодож байна.

Мэргэжлийн байгууллагын хувьд Эрүүл мэндийн яам удирдлагуудад саналаа өгч, энэ харилцан иргэд чөлөөтэй хил зорчихтой холбоотой асуудал дээр саналаа өгсөн болов уу гэж л бодож байна.

Сая Ерөнхий сайд тодорхой мэдээлэл өгсөн. Би бол тодорхой, шулуухан хэлэхэд яг энэ талаар мэдээлэл байхгүй байна.

Таны ярьж байгаагаас яг тийм байна уу, үгүй бол тийм ялгаатай байна уу. Нэг улсын иргэн нь асуулгаар хил нэвтэрдэг, нэг улсын иргэн нь болохоор Пи Си Ар өгч хил нэвтэрдэг ийм ялгамжтай байж болохгүй болов уу гэж л бодож байна.

Нөгөө талдаа бас эдийн засгаа дэмжих хэрэгтэй. Ялангуяа бараа,

бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг саармагжуулахад, энэ хил нээх чухал. Гэхдээ эрүүл мэндийг хамгаалах асуудал чухал.

Хятад Улс сүүлийн 3 жил хатуу хөл өрөөтэй байж байгаад хилээ нээж байгаа учраас бид жаахан нэлээн болгоомжтой хандах ёстой гэсэн ийм би хувь хүний хувьд бодолтой байна. Шаардлагатай манай талаас тэр Пи Си Ар шинжилгээ зайлшгүй хариутай байх ёстой гэсэн ийм шаардлагууд байх болов уу гэж бодож байна.

Тийм учраас ажлаа авчхаад мэргэжлийн улсуудынхаа үгийг сонсч байгаад Онцгой комисстой нэлээн хамтарч ажиллах ийм шаардлагатай гэж үзэж байна.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн 1 минут тодруулъя.

Б.Жаргалмаа: Ерөнхий сайддаа баярлалаа. **С.Чинзориг** сайддаа баярлалаа.

Тэгээд өнөөдөр Монгол Улсын Засгийн газрын нийт 20 сайдаас 4 сайд нь л дан дээлтэй, бусад нь давхар дээлтэй байна.

Тэгээд Ерөнхий сайдын түрүүний хэлсэнчлэн нэг хүчээр нэг цонхоор ажиллах энэ боломж бүрдэж байгаа юм чинь бидний хийж хэрэгжүүлж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газраас гарч байгаа шийдвэр бодит амьдрал дээр шууд үр дүнгээ өгөх тэр

боломж наашилж байгаа гэж би харж байна.

Сая хэлсэн би ургийн гажгийн эрт илрүүлгийн 4 төвийг байгуулна гэдэг энэ төсвийг 2023 оны төсөвт хийчихсэн байгаа.

Тэгэхээр энэ ургийн гажгийн эрт илрүүлгийн төвүүдээ яаралтай ажиллуулж эхлээч ээ. Юунаас үүдсэн. Хорт хавдар, цусны хавдар гээд маш олон нярайн эрсдэлүүд маш ихээр байгаад байгаа шүү. Энэ дээр анхаарч ажиллаач ээ гэдэг хүсэлтийг тавих гэсэн юм.

Мөн нярайн шарлалттай холбогдуулан Өрхийн эрүүл мэндийн төв дээрээ бас анхаараарай. Мөн нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн энэ иргэдээ мэдээлэлжүүлэх, эрүүл мэндийн боловсролыг нь сайжруулах тал дээр илүү.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцууллаа. /алх цохив/

Одоо Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөх тул танхимын бэлтгэлийг хангах хүртэл нэгдсэн хуралдааныг түр завсарлуулъя. Хэдэн минут засварлах вэ? 40 минутын.

ЗАВСАРЛАГА

Арав.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа

Тангараг өргөх ёслолын ажиллагааг танилцуулъя.

Эхлээд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна.

Түүний дараа Засгийн газрын гишүүд тангараг өргөнө. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Засгийн газрын гишүүд дараах дарааллаар тангараг өргөнө.

Эхлээд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар тангараг өргөнө.

Дараа нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Хүрэлбаатарын Булгантуяа тангараг өргөнө.

Дараа нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн тангараг өргөнө.

Дараа нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг тангараг өргөнө.

Гишүүн тангараг өргөх ёслолын ажиллагаанд бэлтгэе. Танхимд цугларъя. Б.Пүрэвдорж гишүүн бүлгийн гишүүдээ дууд. Х.Булгантуяа яасан. Дууд. Д.Тогтохсүрэн даргыг дууд. Баярлалаа.

Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагааг эхэлье.

Эхлээд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүнээр томилсон

тухай захирамжийг уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргад Хүрэлбаатарын Булгантуяаг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга хот байгуулалтын сайдаар Цэрэнпилийн Даваасүрэнг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Содномын Чинзоригийг томиллоо.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр шинээр томилогдсон Та бүхэн дэлхий дахинд тулгамдаж буй цар тахал, геополитикийн хямралт цаг үед хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг шийдвэрлэж, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг бий болгох зорилго бүхий “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилтуудыг амжилттай ханган хэрэгжүүлэхийн төлөө, шударга ёсыг тогтоохын төлөө, цоо шинэ 30 жилийг эхлүүлэхийн төлөө хичээнгүйлэн ажиллана гэдэг Ерөнхий сайдын хувьд бүрэн итгэж байна.

Сайд нарынхаа ажлын гүйцэтгэлийг жил бүхэн үнэлж, хариуцлага тооцох зарчмыг Ерөнхий сайдын хувьд баримталж олон нийтийн үнэлгээтэй уялдуулан ажиллах болно гэдгийг дахин онцолъё.

2023 он цар тахал бүрэн дуусаж, эдийн засаг сэргэсэн жил байх болно гэдэгт итгэл дүүрэн байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Засгийн газрын гишүүд тангараг өргөнө.

Эхлээд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар Таныг тангараг өргөхийг урьж байна.

Ч.Хүрэлбаатар: Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлагыг хүлээнэ.

Г.Занданшатар: Одоо Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Хүрэлбаатарын Булгантуяа Таныг тангараг өргөхийг урьж байна.

Х.Булгантуяа: Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын

Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

Г.Занданшатар: Одоо Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн Таныг тангараг өргөхийг урьж байна.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

Г.Занданшатар: Одоо Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг Таныг тангараг өрөхийг урьж байна.

С.Чинзориг: Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Миний бие энэ тангаргаасаа
няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

/Монгол Улсын Төрийн дууллыг
чуулганы танхимд эгшиглүүлэв./

Г.Занданшатар: Монгол Улсын
Засгийн газрын гишүүд Улсын Их
Хуралд тангараг өргөлөө.

Төр, ард түмэндээ тангараг
өргөсөн Та бүхэнд баяр хүргэж, төр

түмнийхээ төлөө зүтгэж, төрийн хуулийг
биелүүлэх Та бүхний ажилд өндөр
амжилт хүсэж баяр хүргэе. /алга ташив/

Тангараг өргөх ёслолын ажиллагаа
үүгээр өндөрлөснийг мэдэгдье. /алх
цохив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар
хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн
хуралдаан өндөрлөж байна. /алх цохив/

Хуралдаан 7 цаг 46 минут үргэлжилж, 19 цаг 56 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД